



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ

МЭДЭЭЛЭЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН ЭМХЭТГЭЛ
(2022 ОН, ДУГААР №2)

УЛААНБААТАР ХОТ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

ЕРӨНХИЙ РЕДАКТОР

Д.Зүмбэрэлхам

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга,
Хууль зүйн доктор (Ph.D)

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

РЕДАКТОР

С.Нэргүй

Шүүхийн захиргааны сургалт,
судалгааны төвийн дарга

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв
Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Тасганы овоо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн байр,
70008024

DDC
070.4
Б-48

ISBN: 978-99962-3-728-7

АГУУЛГА

ШҮҮХ СУДЛАЛ

ШҮҮХИЙН СУРГАЛТ

Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа
Билиг дээд сургуулийн захирал, Б.Өлзийсайхан /Ph.D/ 9

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Судлаач, Б.Өнөрмаа /Ph.D/ 23

ҮНДСЭН ХУУЛИЙН ТОГТВОРТОЙ ҮЙЛЧЛЭХ ХУГАЦАА, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Судлаач, Ж.Алтансүх /LL.M/ 30

ШҮҮГЧИЙН ИНДЭР

ШҮҮХЭЭС ГАРАХ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙГ

БАТАЛГААЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ, АЧ ХОЛБОГДОЛ

Дархан-Уул аймаг дахь Сум дундын иргэний хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч, Д.Алтантуяа 58

ШҮҮГЧИЙГ ТАТГАЛЗАН ГАРГАХ, ШҮҮГЧ ТАТГАЛЗАН

ГАРАХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ, ХЭРЭГ ХЯНАН

ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Архангай аймаг дахь Захиргааны хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч, А.Түвшинтулга /LL.M/ 70

АВЛИГЫН ХЭРГИЙН ШҮҮХ БА

ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА

Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан
шатны шүүхийн шүүгч, Ц.Мөнх-Эрдэнэ /LL.M/ 82

ГЭМТ ХЭРГИЙН ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААНЫ

ТУЛГУУР ЗОХИЦУУЛАЛТ БА ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ

АРГА ЗҮЙ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч, Г.Ганбаатар /LL.M/ 90

ЗАМ ТЭЭВРИЙН ГЭМТ ХЭРГИЙН

ЗҮЙЛЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч, Б.Батаа /LL.M/ 113

ШҮҮГЧ ТАНЫ МЭДЛЭГИЙН САНД

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ГУРАВДАГЧ ЭТГЭЭДИЙН ОРОЛЦОО, ТҮҮНИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ	
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, Э.Мөнхдаваа /LL.M/	123
ШҮҮХИЙГ ТОЙРГИЙН ЗАРЧМААР БАЙГУУЛАХАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ (АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ЖИШЭЭ ДЭЭР)	
Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслах, Г.Цэрэндэжид	139
ШҮҮГЧИЙН САХИЛГЫН ЗӨРЧЛИЙГ ШАЛГАЖ ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛ БА ЁСЗҮЙН ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ, ХАРИЛЦАН ХАМААРАЛ /ШУДАРГА ЁСНЫ ХЭМЖҮҮР/ Дотоод хэргийн их сургуулийн магистрант, О.Бадмаараг	153

ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

TABLE OF CONTENTS

JUDICIAL STUDIES

JUDICIAL TRAINING

Ulziisaikhan B. /Ph.D/, prof. Director, Bilig Institute,
University of the Humanities 9

CONCEPT OF DISCRIMINATION AND ITS STATUTORY REGULATION

Unurmaa B. /Ph.D/, Researcher 23

LONLEGIVTY OF CONSTITUTION, COMPARATIVE RESEARCH

Altansukh J. /LL.M/, Researcher 30

JUDGES' PLATFORM

MEASURES AND SIGNIFANCE OF ENSURING ENFORCEMENT OF COURT DECISIONS

Altantuya D. Judge, Inter-Soum Court for Civil cases of
Darkhan-Uul province 58

GROUNDNS AND REGULATIONS TO DISQUALIFY A JUDGE, SELF-RECUSAL, AND SOME ISSUE ON CASE PROCEEDINGS

Tuvshintulga A. /LL.M/, Judge, First Instance Court for
Administrative cases of the Arkhangai province 70

ANTI-CORRUPTION COURT AND INTERNATIONAL BEST PRACTICES

Munkh-Erdene Ts. /LLM/, Judge, First Instance Court for
Criminal cases of Bayangol district 82

KEY REGULATIONS ON STATUTE OF LIMITATIONS, AND METHODOLOGY FOR LAW PRACTICE, SOME ISSUES FOR CONSIDERATION

Ganbaatar G. /LL.M/, Judge, First Instance Court for
Criminal cases of Songinokhairkhan district 90

SOME ISSUES OF THE CLASSIFICATIONS OF THE TRAFFIC CRIME

Bataa B. /LL.M/, Judge, First Instance Court for
Criminal cases of Songinokhairkhan district 113

INFORMATION FOR JUDGES

**PARTICIPATION AND DEFINITION OF THIRD PARTY IN
ADJUDICATION OF ADMINISTRATIVE CASES**

Munkhdavaa E./LL.M/ Lecturer, School of Law, NUM 123

**SOME ISSUE ON THE COURT ESTABLISHMENT ON CIRCUIT
PRINCIPLE/ON THE EXAMPLE OF FIRST INSTANCE COURT/**

Tserendejid G. Judge Assistant, First Instance Court for
Administrative cases of the Arkhangai province 139

**JUDICIAL MISCONDUCT AND PREMISES AND
INTERDEPENDENCE OF ETHICAL THEORY
/MEASURE OF JUSTICE/**

Badmaarag O. /LL.M Candidate/, University of Internal Affairs 153

CHRONOLOGY OF EVENTS

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС

Эрхэм шүүгч, шүүхийн захиргааны ажилтан, судлаач, уншигч та бүхэнд “Шүүх эрх мэдэл” эмхэтгэлийн 2022 оны II улирлын дугаарыг толилуулж байна.

Энэ удаагийн дугаарын шүүх судлалын буландаа Үндсэн хуулийн эрх зүй, мөн шүүхийн сургалт, ялгаварлан гадуурхах асуудлыг тус тус хөндсөн өгүүлэл, нийтлэлийг багтаалаа.

“Шүүгчийн индэр” буланд хөөн хэлэлцэх хугацаа, зам тээврийн гэмт хэргийн зүйлчлэл, татгалзал, шүүхийн шийдвэрийг баталгаажуулахтай холбоотой өгүүлэл багтсан нь шүүхийн практикт нэг мөр ойлголт, тогтоход чухал ач холбогдолтой болсон байна.

Энэ удаагийн дугаарт шүүгчдээс гадна шүүхийн захиргааны ажилтнаас ирүүлсэн бүтээлүүд багтсан нь сайшаалтай байна. Ялангуяа тойргийн шүүхийн асуудлыг хөндсөн шүүгчийн туслахаас ирүүлсэн өгүүлэл нь цаг үеийн шаардлагаар анхаарал татахуйц болжээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/-ын 14.3 дахь хэсгийг баримтлан, мөн шүүхийг зохион байгуулах асуудлаар шүүгч, захиргааны ажилтнаас авсан санал асуулга, бусад тоон мэдээлэлд тулгуурлан олон төрлийн судалгааны ажлыг шат дараатайгаар хийгээд байна. Эдгээр судалгааны үр дүнг шүүгч, захиргааны ажилтан, уншигч олонд энэхүү эмхэтгэлээрээ дамжуулан тухай бүр хүргэх ажлыг 2022 онд төлөвлөж байгааг сонордуулахад таатай байна.

Ерөнхий эрхлэгч
Д.Зүмбэрэлхам (Ph.D)
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга



ШҮҮХИЙН СУРГАЛТ

*Б.Өлзийсайхан,
Хууль зүйн доктор /Ph.D/, проф.
Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа
Билиг дээд сургуулийн захирал*

УДИРТГАЛ

Монгол Улс 1992 онд батлагдсан Үндсэн хуулиар төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэж гурав хуваарилж, тэнцвэрт байдлыг хадгалан харилцахаар суурь хэм хэмжээг тунхаглаж, нийгмийн бүхий л салбарт өөрчлөлт шинэчлэлт¹ хийхээр Үндсэн хуулийн хавсралт хууль (БНМАУ-ын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөхөд шилжих тухай)-ийн Гуравдугаар зүйлд Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх /шүүх, прокурорын байгууллагыг шинэчлэн байгуулах/, тухайн байгууллагын тогтолцоог шинэчлэх ажлыг 1993 онд багтаан хийж гүйцэтгэхээр хуульчилсан байна. Ийнхүү Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн үйл явц Улсын Бага Хурлын 1992 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төлөвлөгөө батлах тухай (Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөх ажлыг зохион байгуулах)”-д Монгол Улсын Үндсэн хуульд заасан нэн тэргүүнд шаардлагатай хуулиудыг батлан гаргах тухай жагсаалтын 6/Монгол Улсын шүүхийн байгууламжийн тухай хууль, 7/Монгол Улсын шүүхийн ерөнхий зөвлөлийн тухай хуулийг боловсруулан батлахаар зааж, нэр дурдсан зарим хуулийг 1993 онд баталсан нь тухайн салбарын хуулийн шинэчлэл, түүнтэй зэрэгцэн шинэчлэгдэх шүүгч, шүүхийн захиргааны ажилтны ажлын байранд нэн шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэх, мэргэшүүлэх сургалт, тухайн сургалтад хичээл заах сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулах хэрэгцээ шаардлага буй болжээ. Ийнхүү шүүхийн сургалт (шүүгч болон шүүхийн захиргааны ажилтныг дадлагажуулах, мэргэшлийг нь дээшлүүлэх)-ыг Шүүхийн тухай 1993 (53 дугаар зүйлийн 53.4.3/шүүхийн статистик, шүүхийн практикийг судлан дүгнэлт хийх, шүүх, шүүгчийг холбогдох мэдээллээр хангах, сургалт, семинар зохион байгуулах;), 2002 (15 дугаар зүйлийн 15.4.Шүүхийн мэргэжлийн удирдлага² нь хуулийг тайлбарлах, сургалт явуулах, шүүхийн практикийг

¹ Өөрчлөлт шинэчлэлт (хоршоо үг) Аливаа зүйлийг улам сайжруулахын тулд хийж буй өөрчлөлтийн нарийвчлан бодож боловсруулсан арга ухаан. Баярсайхан, Б. (2011). Монгол хэлний тайлбар толь. Уб, 910 дахь тал.

² Улсын дээд шүүхийн 1993 оны 55 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах журам”-д шүүхийн мэргэжлийн удирдлага нь доод шатны шүүхээс тодорхой хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд хөндлөнгөөс нь оролцохгүйгээр хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх, хэрэг маргааныг үнэн зөв шударгаар шийдвэрлэх, шүүн таслах ажиллагааны мэдлэг, ур чадвар, дадлага эзэмшүүлэх, холбогдох хууль тогтоомж, гарын авлага, арга зүйн удирдлага, мэдээллээр хангах, шүүн таслах ажиллагааны алдаа, дутагдлыг илрүүлэн арилгах арга хэмжээний цогц мөн. Шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажил нь 1) хууль тайлбарлахад; 2) тодорхой хэрэг хянан шийдвэрлэхэд; 3) шалган туслахад; 4) шүүхийн шийдвэрийг хянахад; 5) сургалт явуулахад; 6) шүүхийн практикийг нэгтгэн судалж зөвлөмж, тойм гаргахад; 7) бусад гэсэн хэлбэртэй байж болно гэж заасан. Харин Шүүхийн тухай (2002) хуулийн 15

нэгтгэн судалж, зөвлөмж гаргах хэлбэртэй байна. 41 дүгээр зүйлийн 41.1.Бүх шатны шүүхийн шүүгч жил тутам 14 хоногоос доошгүй хугацаагаар мэргэшлээ дээшлүүлж, давтан сургалтад хамрагдах эрхтэй. 41.2.Шүүгчийн мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах ажлыг Ерөнхий зөвлөл зохион байгуулна. 69 дүгээр зүйлийн 69.5.5.шүүгчийг шаардлагатай хууль тогтоомж, холбогдох мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах;), 2012 (Шүүхийн захиргааны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4.шүүгч болон шүүхийн захиргааны ажилтныг дадлагажуулах, мэргэшлийг нь дээшлүүлэх сургалтыг Хуульчдын холбоо, Төрийн албаны зөвлөл болон сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах; 31 дүгээр зүйлийн 31.1.Шүүхийн захиргааны ажилтан Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан мэргэжлийн тогтмол сургалтад заавал хамрагдана. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1. Шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг³, мэргэшлээ дээшлүүлж байх үүрэгтэй бөгөөд жил бүр сургалтад хамрагдаж байна. 25.2. Шүүгч мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдах хугацаанд түүнд шүүгчийн цалин хөлсийг хэвээр олгоно. 25.3. Шүүгчийн мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөл зохион байгуулна.) 2021 (Шүүхийн тухай хуулийн холбогдох зүйл) оны хуулиар тус тус шинэчлэн найруулж баталсан бөгөөд эдгээр хуульд шүүхийн сургалт зохион байгуулах, хугацаа, сургалтын болон судлаачаар ажиллах хугацаанд шүүгчийн эдийн засгийн баталгааг хангах ахиц дэвшил бүхий хэм хэмжээг хуульчилжээ.

Энэхүү өгүүлэлд шүүхийн сургалтын 30 жилийн туршлагыг тоймлон, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүнг чиг баримжаа болгон шүүхийн сургалтыг арга зүй, технологийн хувьд шинэтгэхэд харгалзан үзэх зарим санааг судлаачийн хувьд танилцуулж байна.

1. ШҮҮХИЙН СУРГАЛТЫН ТУРШЛАГА

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 7/... Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно гэж иргэний үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулснаар Монгол Улсад төрийн болон төрийн бус өмчийн боловсролын байгууллага үйл ажиллагаа эрхэлж байна⁴. Ийнхүү манай улсад хууль зүйн мэргэжлийн боловсролыг төрийн болон төрийн бус өмчийн албан ёсны байгууллагаар дамжуулж,

дугаар зүйлийн 15.4-т зааснаар хууль тайлбарлах, сургалт явуулах, шүүхийн практикийг нэгтгэн судалж, зөвлөмж гаргах хэлбэртэй байна гэжээ.

³ Мэдлэг гэж боловсролын үйлчилгээ болон амьдралын туршлагаасаа олж авдаг хүн, нийгмийн талаарх харилцан уялдаатай ойлголт бодит мэдээлэл. Монголын боловсролын нэвтэрхий толь. Боть 1.(2021) Уб, 374 дэх тал.

Мэдлэгийн төрөл: 1. Тоо баримтын мэдлэг, 2. Төсөөллийн мэдлэг, 3. Арга ухааны мэдлэг, 4. Дээд эрэмбийн мэдлэг эдгээр ангиллыг үндэслэн Блумын таксономыг шинэчлэн гаргасан бөгөөд суралцахуйн үр дүнд суралцагч ямар түвшний мэдлэг эзэмшихийг тодорхойлоход хэрэглэнэ. Бадарч, Д. (2021). Дээд боловсролын онол, арга зүй (парадигмын шилжилт, багшлахуй, суралуахуй). Уб., 233 дахь тал.

⁴ 2020-2021 оны хичээлийн жилд Төрийн болон төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын 88 байгууллага үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 21 байгууллага (их, дээд сургууль)-д эрх зүйн бакалаврын хөтөлбөр хэрэгжиж байна.// БШУЯ-ны 2021 оны 6/5442 тоот албан бичиг.



суралцагчийн⁵ ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангаж, боловсролын зохион байгуулагдсан үйл ажиллагааг албан боловсролоор⁶ олгож байна. Аливаа мэргэжлийг албан болон албан бус сургалтаар эзэмшүүлж байгаа ч хүн төрөлхтний түүхэн дэх хүнтэй хамгийн олон цагаар ажилладаг мэргэжил болох багш, эмч, хуульч зэрэг байгалийн болон нийгмийн шинжлэх ухааны, энэхүү эрин үед техникийн шинжлэх ухааны салбарын болон салбар дундын мэдлэг эзэмших, ашиглах хэрэгцээ шаардлага аль хэдийнээ үүсэж, тулгамдсан асуудлаа шийдвэрлэх арга замаа эрэлхийлсээр байгааг хуулийн салбарт ч туршин нэвтрүүлсээр байна.

Шүүхийн сургалтыг ажлын байран дахь сургалт, ажлын байрнаас гадуурх сургалт⁷ гэж хэлбэрийн хувьд ангилан зохион байгуулж иржээ. Харин энэхүү өгүүллийн хүрээнд хууль зүйн боловсролыг албан, хуульчийн мэргэжлийн болон тодорхой ажил, албан тушаал эрхэлж буй нөхцөлд мэргэшил дээшлүүлэх бол албан бус сургалтаар эзэмшиж буйг тодотгож байгаа болно.

1992 оны Үндсэн хууль батлагдсанаас хойш 6 жилийн дараа буюу УИХ-ын 1998 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-т хууль зүйн мэргэжлийн боловсон хүчний сургалтын тогтолцоог боловсронгуй болгох, тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хууль зүйн дээд сургуулийг боловсон хүчин, материаллаг бааз, санхүүгийн хувьд бэхжүүлэх, хууль зүйн дунд мэргэжилтэй хуульчдын боловсролыг дээшлүүлэх, хууль зүйн дунд сургуулийг боловсон хүчнээр хангах, Хуульчдыг сонгон шалгаруулах тогтолцоог бүрдүүлэх зэрэг ажлыг төлөвлөсөн нь өнөөгийн эрх зүйн тогтолцооны урьдач шанг татсан бөгөөд энэ талаар Хууль зүйн доктор, профессор Б.Чимид: Эрх зүйн хэм хэмжээг шинэтгэн тогтоож, зөв ойлгож, үр нөлөөтэй хэрэгжүүлдэг болгох нь нийгмийн бодит хэрэгцээ мөн гэж тодотгоод үүнийг эш үндэс болгон эрх зүйн шинэтгэлийг өргөн утгаар 1/Хууль тогтоомжийг шинэтгэх, 2/Хуулийн биелэлтийг хангах, хууль хэрэглэх тогтолцоо, арга ажиллагааг шинэтгэх, 3/Хууль зүйн мэргэжлийн боловсролыг шинэтгэх, 4/Хууль зүйн эрдэм шинжилгээний ажлын зохион байгуулалт, арга зүйг шинэтгэх, 5/Нийгэмд эрх зүйн шинэ ухамсар төлөвшүүлэх гэж 5 бүлэгт хуваан авч үзжээ⁸. Шүүхийн сургалт нь эрх зүйн шинэтгэлийн үйл явцтай уялдсан хэдий ч анхаарч үзэх,

⁵ *Суралцагч* гэж сэдвийн хүрээнд шүүхийн сургалтад хамрагдаж буй шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг ойлгоно.

⁶ Боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.Иргэн нь боловсролыг албан болон албан бус сургалтаар эзэмшиж болно.

⁷ Ажлын байран дахь сургалт (work-based learning) - ердийн ажлын орчин нөхцөлд явагдах мэргэжлийн сургалт. Энэ сургалтаар ажилтныг чадавхжуулах, мэргэшүүлэх, шинэ мэдээллээр хангах үйл ажиллагааг ажлаас нь хөндийрүүлэлгүйгээр зохион байгуулах үйл ажиллагаа.

Ажлын байрнаас гадуурх сургалт (training outside the workplace) - ердийн хөдөлмөрийн нөхцөлөөс гадуур хэрэгждэг мэргэжлийн сургалт. Ажилтан ажлаас чөлөөлөгдөн мэргэжлийн сургалтын байгууллага, эсвэл өөр байгууллага дээр очиж суралцах, томилолтоор явж суралцах, мэргэжлийн байгууллагад очиж суралцах зэрэг багтана. Монголын боловсролын нэвтэрхий толь. Боть 2.(2021) Уб., 543 дахь тал.

⁸ Чимид Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал. Уб., 2017. 113 дахь тал.

цаашид системчлэх хэрэгцээ шаардлага үүсэж ирснийг зарим сургалтын туршлагаас харж болох юм.

НҮБ-ын 1985 оны 40/32, 40/46 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийн байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчим”-ын 10 дугаар зүйлд “Шүүхийн албан тушаалд сонгогдсон этгээд ёс зүйтэй, шударга зарчимч байхын зэрэгцээ хууль зүйн салбарт ажилласан дадлага туршлагатай, зохих сургалтаар чадвар эзэмшсэн байна”, 18 дугаар зүйлд “Шүүгч зөвхөн ажил үүргээ гүйцэтгэх ур чадваргүй болсон бол, мөн зан үйлийн шалтгаанаар албан тушаалаасаа түр болон бүрэн чөлөөлөгдөнө.” гэж заасан бөгөөд “шүүгч мэргэжлийн хувьд ажил үүргээ гүйцэтгэх чадваргүй” гэдгийг шүүгч эрүүл мэндийн шалтгааны улмаас шүүгчийн албан тушаалыг цаашид хаших боломжгүй байх нөхцөлийг хамруулдаг. Харин шүүгч мэргэжил, ур чадварын хувьд тэнцээгүй, түүнийг сургалтад хамруулж, өөрийгөө хөгжүүлэх боломж олгосон боловч дахин тэнцэхгүй бол үүнийг “шүүгчийн хувьд өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх, ур чадвараа нэмэгдүүлэх” шүүгчийн ёс зүйн зөрчил гэж үзэж, шүүгчийн ёс зүйн хороо асуудлыг хэлэлцдэг байна. Шүүхийн хараат бус байдлыг хамгаалах, баталгаажуулахад чиглэсэн олон арга хэмжээний нэг нь шүүхийн сургалт юм. Бусад бүх эрх зүйн болон гадны нөхцөлийг хангасан ч шүүгч, прокурор, өмгөөлөгч гээд бүх оролцогчид мэргэжлийн өндөр ёс зүйтэй байхгүй бол шүүх хараат бусаар үйл ажиллагаа явуулах боломжгүй⁹. Энэ нь шүүхийн сургалтын гол агуулга, үр дүнтэй уялдан хэлбэржиж ирсэн.

Шүүхийн бие даан ажиллах нөхцөлийг бүрдүүлэхдээ, Шүүхийн ерөнхий зөвлөл нь Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, НҮБ-ын Хүний эрхийн төсөл, Дэлхийн банкны Шүүх эрх мэдэл төсөл, Ханнс-Зайделийн сан, Японы Жайка байгууллагын дэмжлэгтэйгээр нийт шүүхийг шаардлагатай техник, тоног төхөөрөмж, гарын авлагаар хангах, шүүхийн байрыг засварлах, зарим орон нутгийн шүүхийг байраар хангах зэрэг шүүхийн шүүгч, ажилтны албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангах чиглэсэн ажлыг хийсэн байна¹⁰. Тус үүргийн хүрээнд ХЗҮХ (Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн тусгай сургалтын 2004-2007 тайлан)-ээс Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран Хууль зүйн үргэлжилсэн сургалтын хүрээнд Шүүхийн анхан, дунд шатны тусгай сургалтыг 2004 оноос эхлэн зохион байгуулж сургалтын агуулгад Хуульчийн ёс зүй, Шүүгчийн ёс зүй хичээлийг оруулсан нь урьдчилан сэргийлэх идэвхтэй зохион байгуулалтын ажил болсон.

⁹ Гангабаатар, Д. (2016). Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал. Уб., 71 дэх тал.

¹⁰ Оюумаа, В. (2011). Монгол Улсын эрх зүйн шинэтгэл: Олон Улсын байгууллага, гадаад орнууд, олон улсын байгууллагын төслийг дэмжлэг. //Эрдмийн ертөнц (Academiae). Уб., 136-139 дэх тал.



Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөрийн¹¹ хүрээнд Монголын нийт хуульчдын мэргэшил дээшлүүлэх сургалтын тогтолцоог бэхжүүлж, хуулийн мэргэжил бүрт зориулсан тусгай хөтөлбөр боловсруулан сургалт зохион байгуулах, манай улсын хууль зүйн салбарын хүний нөөцийг чадавхжуулахад онцгой анхаарч олон хувилбарт сургалтын хөтөлбөрийг санал болгосон бөгөөд Шүүгчийн сургалтын ихэнх нь гадаадын донор тухайлбал, Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг, Соросын сан, Азийн хөгжлийн банкнаас голлон, Ханнс-Зайделийн сангийн дэмжлэгтэйгээр явагджээ¹² гэж тэмдэглэсэн байна.

Шүүхийн тухай 1993, 2002, 2012 оны хуулиар шүүхийн сургалтыг 1/ Шүүгчийн анхан шатны сургалт (ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн “Эрх зүйн боловсрол” академитай хамтран зохион байгуулж, Үндсэн хууль дахь шүүх эрх мэдлийн суурь зарчмууд, шүүгчийн хараат бус байдал, шүүгчийн ёс зүй, хууль тайлбарлан хэрэглэх ерөнхий онол, арга зүй, хэргийн хөдөлгөөний программ, түүний хэрэглээ, шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал, материаллаг болон процессын онцлогийг тодорхойлсон суурь мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх); 2/Хуулийн хэрэглээ (ШЕЗ, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим, Ханнс-Зайделийн сангийн “Эрх зүйн боловсрол” академитай хамтран Захиргааны хэргийн шүүгчдэд Захиргааны ерөнхий болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал, шинэлэг зохицуулалт, захиргааны хэргийн шүүх хуралдааныг удирдах, захиргааны хэргийн шүүхийн нотлох чиг үүрэг, шүүхийн шийдвэр боловсруулалт зэрэг сэдвийн хүрээнд шүүгчдийн онол, практик, хууль хэрэглээний мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх); 3/ Шүүгчийн чадвар хөгжүүлэх (Шүүгчид судалгаа, эрдэм шинжилгээний ажлын шинэ санаа, санаачилгаа бодитоор хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх, шүүгч бие даан суралцах нөхцөл боломжийг бүрдүүлэх); 4/ Шүүгчийн мэргэжлийн хөгжлийг дэмжих (Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO)-тай Монгол Улсын хууль, шүүхийн байгууллага хамтран ажиллах санамж бичиг байгуулсны үндсэн дээр “Монгол Улс дахь жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх: хууль зүйн салбарын чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх нь” сэдэвт сургалтыг анхан болон давж заалдах шатны эрүү, иргэний хэргийн шүүгчдэд зохион байгуулсан); 5/ Сургагч багш бэлтгэх, чадваржуулах (Шүүгчийн сургалтыг удирдан чиглүүлж, ажиллах сургагч багш нарын хүний нөөцийг бүрдүүлэх, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулах) гэсэн төрлөөр зохион байгуулж¹³

¹¹ Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр нь Монгол Улсын Засгийн газарт Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тусалцаа үзүүлэх зорилготой АНУ-ын Олон улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр хэрэгжсэн төсөл юм. Уг төсөл нь 2001 оны 4 дүгээр сараас үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

¹² USIAD Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөрийн төлөвлөгөө, тайлан (2004).

¹³ Шүүхийн ерөнхий зөвлөл (2017). Монгол Улсын шүүхийн тайлан 2016 он. Уб., 92-95 дахь тал.

иржээ. Шүүгчид зориулсан сургалтад гадаадын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр зохион байгуулдаг сургалт багагүй хувийг эзэлдэг бөгөөд энэхүү сургалтын үр нөлөөг тухайлан судлан үзэх хэрэгцээ буйг энэ дашрамд дурдъя.

Шүүхийн тухай багц хууль мөрдөгдөж эхэлснээс хойш ШЕЗ-ийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс 2015 онд Шүүхийн сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд Шүүгчийн ёс зүйн сургалтыг оруулсан нь хэсэг хугацаанд зөвхөн Хуульчийн ёс зүйн хичээлийн хүрээнд сэргээгдэж байсан мэргэжлийн ёс зүйн мэдлэгийг нарийн мэргэшсэн ёс зүйн мэдлэгээр баяжуулахаар дахин төлөвлөж, төлөвшүүлснийг дурдах нь зүйтэй.

ШЕЗ-өөс хуульчийн үргэлжилсэн багц цаг олгох “Ёс зүй ба мэргэжлийн ёс зүй”, Шүүгчийн ёс зүй ба хуульчийн ёс зүй тэдгээрийн онцлог”, “Шүүгчийн зан төлөв (Judicial temperament)¹⁴-ийн төрөл, шинж”, “Шүүгчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр эрдэмтэн, судлаачид сургалтыг удирдан явуулсан бөгөөд сургалтын хүрээнд цаашид дэлгэрүүлэн судлах сонирхолтой сэдвийн санал авахад сургалтад оролцсон нийт шүүгчдийн 80 орчим хувь нь “Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад биеэ авч явах соёл, зан төлөв, ёс зүй, шүүгчид зайлшгүй байх ёстой сайн зан төлөвийг хэрхэн төлөвшүүлэх, шүүгч ажлын ачааллаас үүссэн стресс, сэтгэл зүйн дарамтаас хэрхэн ангижрах, шүүгчийн харилцаа, хандлага” сэдвүүдээр нарийвчлан сургалт авах санал¹⁵ өгч байжээ. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018, 2019, 2020¹⁶ оны шүүхийн сургалт, шүүгч, ажилтны хөгжил чиглэлийн хүрээнд зохион байгуулсан ажлын хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны 84 дүгээр тогтоолоор “Шүүхийн сургалтын үндсэн хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд энэхүү баримт бичгийн дагуу шүүхийн сургалтын тогтолцоо нь бэлтгэл сургалт, шүүгчийн болон шүүхийн захиргааны ажилтны сургалт гэсэн үндсэн 3 төрөлтэй байна. Шүүгчийн сургалт заавал болон чөлөөт сонголттой байна. “Үндсэн хууль ба хүний эрх”, “Шүүгчийн ёс зүй” сургалтад шүүгч жил бүр заавал хамрагдахаар баталж, тус хөтөлбөрийн хүрээнд шүүгчийн сургалтын удирдах сургагч багшийг чадавхжуулах сургалтыг ХБНГУ-ын Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах” төсөл (Иргэний эрх зүйн сургагч багш), АНУ-ын Сангийн яамны Техник туслалцааны албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх баг (УДШ-ийн Эрүүгийн эрх зүйн сургагч багш), Ханнс зайдел сангийн Эрх зүйн боловсрол академитай хамтран (захиргаа, эрүүгийн эрх зүй сургагч багш,) ХБНГУ-ын Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран захиргааны ажилтан бэлтгэх сургалтын сургагч багш, Азийн сангийн “Залуу

¹⁴ Шүүгчийн сэтгэл зүйн төрлөхийн шинж чанар гэж ойлгох.

¹⁵ Шүүгчийн ёс зүйн суурь сургалтын тайлан. www.judcouncil.mn

¹⁶ Монгол Улсын шүүхийн тайлан (2018, 2019, 2020)



хуульчдыг чадавхжуулах замаар шүүх эрх мэдлийн тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд шүүхийн сургагч багшийн заах арга зүйн сургалтыг тус тус зохион байгуулсан байна. Шүүхийн сургалтыг 1/ Шүүгчийн анхан шатны сургалт (шүүгч бэлтгэх сургалт¹⁷-шинээр томилогдсон шүүгчийн сургалт), 2/ Шүүгчийн заавал судлах, хууль хэрэглээний сургалт (захиргаа, иргэн, эрүү), 3/Шүүгчийн чадвар хөгжүүлэх сургалт, 4/Шүүгчийн мэргэжлийн хөгжлийг дэмжих, 5/Сургагч багш бэлтгэх, чадваржуулах гэсэн төрлөөр, мөн шүүхийн сургалтын нэг бүрэлдэхүүн хэсэг болох шүүхийн захиргааны ажилтны сургалтыг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2014 онд баталсан “Шүүхийн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд “Шүүхийн захиргааны ажилтан бэлтгэх” сургалтыг зохион байгуулж ирсэн туршлагыг ийнхүү дурдаж болох юм.

II. ШҮҮХИЙН СУРГАЛТЫН ШИНЭТГЭЛ

Үндсэн хуульд оруулсан 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр 2012 оноос 4 хуулиар зохицуулж ирсэн харилцааг Шүүхийн тухай хууль(шинэчилсэн найруулга)-иар нэгтгэн зохицуулахаар баталж, шүүхийн сургалтыг шүүгчийг мэргэшүүлэх сургалт, шүүхийн захиргааны ажилтны мэргэжлийн сургалт гэж зааглан зохион байгуулж ирсэн туршлагыг үргэлжлүүлэн зарим дэвшил бүхий зохицуулалтыг нэмж хуульчилсан байна. Шүүхийн тухай хуулиар Шүүгчдийн зөвлөгөөнөөс шүүгчдийг мэргэшүүлэх сургалтын санал гарган, Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнд хүргүүлэн, хүрээлэн сургалтын хөтөлбөрийг орон тооны бус хөтөлбөрийн хороогоороо боловсруулан, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Шүүхийн ерөнхий зөвлөлтэй зөвшилцөн батална гэж зохицуулсан¹⁸. Хуулийн энэхүү зохицуулалт нь манай улсад шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж буй анхан, давж заалдах болон хяналтын шатны¹⁹ нийт 117²⁰ шүүхийн тус бүрийн шүүгчдийн зөвлөгөөнөөс шүүгчийг мэргэшүүлэх чиглэл болон ямар агуулга, хэлбэрээр сургалт авах талаарх саналыг нэгтгэн боловсруулалт хийх ажлыг Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн хариуцан зохион байгуулж буй нь шүүхийн мэргэжлийн удирдлагын байгууллага шүүгчийн мэргэшүүлэх сургалтыг шинэ түвшинд гаргахад дорвитой алхам хийх дэвшилтэт зохицуулалт гэж харж байна. Шүүхийн сургалтад хамрагдаж буй шүүгч болон шүүхийн захиргааны ажилтан нь төрийн жинхэнэ албан хаагч²¹ энэ утгаар Үндсэн хуулийн Дөчин зургадугаар зүйлийн 2-т Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч ... Үндсэн хууль,

¹⁷ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 13 дугаар зарлигаар баталсан “Шүүгчийг сонгон шалгаруулах журмын 2.11-т Анхан шатны шүүхийн шүүгчийн шалгалтад тэнцсэн нэр дэвшигч шүүгчийн бэлтгэл сургалтад хамрагдана” гэж заасныг 2020 оны 19 дүгээр зарлигаар шинэчлэн баталсан “Шүүгчийг сонгон шалгаруулах журам”-д шүүгч бэлтгэх сургалтын зохицуулалтыг хассан.

¹⁸ Шүүхийн тухай хууль (2021)-ийн 19, 24 дүгээр зүйл.

¹⁹ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны тайлан.

²⁰ Монгол Улсын шүүхийн тайлан (2020). Уб., 42 дахь тал.

²¹ Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 13 дугаар зүйлийн 13.1.1.

бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана. Төрийн ашиг сонирхлын нэг хэсэг нь Үндсэн хуулийн эрхэм зорилгод тусгасан хөгжлийн зураглал, тийнхүү хөгжилд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч шүүгч, туслан дэмжих чиг үүрэг бүхий шүүхийн захиргааны ажилтан хэрхэн мэргэшин чадавхиж хувь нэмэр оруулахыг "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогоос²²: *Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүнд*

I үе шат (2021-2030): Эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэртэй байдал, түүнд тавих хяналтыг оновчтой болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, тогтвортой, хяналттай засаглалыг төлөвшүүлэх үе. 3. Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинө.

II үе шат (2031-2040): Хариуцлагатай, үр нөлөөтэй засаглалыг бэхжүүлэх үе. 3. Иргэдийн итгэлийг бүрэн хүлээсэн шүүхтэй болно.

III үе шат (2041-2050): Урт хугацааны, тогтвортой бодлогыг дэмжсэн түншлэгч засаглалыг бий болгох үе. 3. Хариуцлагатай, иргэн төвтэй шүүх төлөвшсөн байна гэсэнтэй уялдуулан эш авч сургалтын хөтөлбөрийг боловсруулбал зохилтой. Нэгэнт хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүнд дээрх байдлаар тодорхойлсон нь Шүүх эрх мэдлийн шинэтгэлийг эрчимжүүлэхэд шүүхийн сургалтаар дамжуулан хэрэгжүүлэх ажил цөөнгүй буйг илтгэж байна.

Шүүхийн сургалтын хэрэгцээг тодорхойлохдоо нийтлэг хэд хэдэн хандлага болон аргыг хэрэглэн тодорхойлж болно. Тухайлбал, хандлагын хувьд *нэгдүгээрт*, бодит байдал болон байвал зохих түвшингийн зөрүүгээр; *хоёрдугаарт*, бид ямар мэдлэгийг илүүд үзэж байгаагаас хамааруулах; *гуравдугаарт*, наад захын стандартыг хангахад юу дутагдаж байгааг харгалзана.

Сургалт нь хүний нөөцийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд арга дадал, ур чадварт зориуд сурган эзэмшүүлж тэдний бэлтгэлийг ямагт дээд хэмжээнд байлгахад тусалдаг²³ гэж үздэг байна. Сургалтын хэрэгцээг тодорхойлох аргын хувьд санал асуулга явуулах, ярилцлага хийх, шүүхийн практикийг судлах гэх мэт байна. Шүүгчийн сургалтын хэрэгцээг судлах нь юуг хэнд, хэзээ заах төлөвлөгөөг боловсруулахад зайлшгүй шаардлагатай бөгөөд ялангуяа шүүх шиг хязгаарлагдмал төсөвтэй байгууллагын тухайд аль сургалтыг илүү ач холбогдолтой гэж үзэхийг урьдчилан шийдвэрлэх шаардлагатай²⁴ юм. Шүүгчийн мэргэшсэн байдал болон эрх зүйн хөгжлийн чиг баримжаанд анхааран шүүгчийн салбар дундын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд

²² УИХ-ын 2020 оны Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай "Алсын хараа-2050" 52 дугаар тогтоол.

²³ Дорж, Т. (2018). Менежмент. Уб., 316 дахь тал.

²⁴ Хууль зүйн үндэсний төв (2006). Захиргааны хэргийн шүүхийн менежмент. Цуврал 9. Уб., 75-77 дахь тал.



чиглэгдсэн сургалтыг олон улсын сайн туршлагаас суралцан зохион байгуулах хэрэгцээ бол цаг ямагт үүсэж байна. Шүүхээс үзүүлж буй шударга ёсны үйлчилгээний чанарыг хэмжих нэг үзүүлэлт, арга хэрэгсэл нь шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг үнэлэх тогтолцоо болохыг олон улсын туршлага харуулж байна. Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг үнэлэх ажиллагааны үндсэн зорилго нь тухайн шүүгчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, шүүгчийн зан төлөвийн стандартыг төлөвшүүлэх замаар мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг сайжруулахад оршино²⁵. Үүнийг шүүхийн сургалтаар төлөвшүүлэх, түвшин ахиулах боломж бий. Гагцхүү шүүгчийн зан төлөвийн стандарт, мэргэшлийн түвшинг үнэлэх шалгуур нь шүүгчид тавих болзол, шаардлага төдийгөөр байгаа нь сөрөг талтай. Иймд нэгэнт шүүгчид тавих болзол, шаардлагыг хангаад томилогдон ажиллаж буй шүүгчийн хувьд шүүгчийн мэргэшүүлэх сургалтаар ёс зүйн болон мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах агуулгыг нөхөх хэрэгцээ шаардлага үүсэж ирсэн. Иймд шүүхийн тухай хуулийн шинэтгэлтэй уялдуулан шүүхийн сургалтын шинэтгэлийг дорвитой хийх шаардлага буй. Үүнийг боловсролын салбарт сайн туршлага болгон хэрэгжүүлж буй зарим арга зүй, технологитой уялдуулж холимог байдлаар сургалтын хөтөлбөр боловсруулах, түүнчлэн сургалтад хамрагдагсдын ялгаатай байдлыг анхаарч судалснаар сургалтын үр дүнг тооцоолох боломж бүрдэх юм.

Шүүхийн сургалтыг үе хоорондын ялгаатай байдал онцлогт тохируулан сургалт удирдах-сургалтад оролцох арга зүйг нэвтрүүлэх хэрэгцээ бий гэж үзэж байна. Шүүхэд 1/Ажлыг төсөөлснөөс давж тултал нь хийдэг, бусдыг тийм байлгахыг хүсэгч буюу төгс байхыг хүсэгчид (Boomers үе буюу 58-76 насныхан), 2/Дасан зохицох чадвартай, өөртөө найдагчид (Gen X үе буюу 46-57 насныхан), 3/Өөртөө итгэх илтгэл өндөр ч ирээдүйдээ санаа зовогчид (Millennial Y үе буюу 25-45 насныхан), 4/Дижитал технологийн уугуул буюу шинэ үеийнхэн (Gen 2020 Z үе буюу 25-аас доош насныхан)²⁶ шүүгч, шүүхийн захиргааны ажилтнаар ажиллаж байна. Энэ нь 2, 3 дахь үеийнхэн дийлэнх олох бол 1, 4 дэх үеийнхэн бага хувийг эзэлж байгаа хэдий ч 4 дэх үеийнхэн дараагийн 5-10 жилд хүч түрэн орж ирэх болно. Өөрөөр хэлбэл суралцагчдын хүлээн авах арга барил өөр өөр байгааг харгалзаж үзэж, сургалтын талаарх саналыг асуулгын аргаар авч хэвшсэн нь давуу болон сул талтай буйг анхаарч, сургалтын хөтөлбөрийн шинэтгэл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн зохион байгуулалт, оролцогчдын эрэлт хэрэгцээг танин мэдэх олон талын оролцоог хангах нь зүйтэй байна. Энгийн нүдээр шүүхийн сургалтын хөтөлбөрт эрх зүйн хөгжлийг дагасан хичээл нэмэх, сонгон судлах боломжоор гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтыг өргөтгөх шаардлага

²⁵ Туяа, М. (2014). Шүүгчийн мэргэжлийн түвшинг үнэлэх ажиллагаа түүний зорилго, үр нөлөө. // Шүүх эрх мэдэл. Уб., №1. 15 дахь тал.

²⁶ Сүрэнчимэг, Д. (2022). "Үе хоорондын ялгаа багшийн ажилд" сэдэвт илтгэлээс. БШУЯ-ны Ёс зүйн жилийн нээлт.

байна гэж үзэж болох ч энэ нь тухайн сургалтад хамрагдаж буй суралцагчийг мэргэшүүлэх, чадавхжуулах тал дээр төвлөрөх зорилготойг анхаарах учиртай. Иймд шүүхийн сургалтыг зохион байгуулахад оролцогч талуудыг судлах, судалгааны үр дүнгээс хамааран боловсролын салбарт ашиглаж буй зарим түгээмэл арга зүйг ашиглах нь зохимжтой. Тухайлбал, сургагч багш, мэргэших сургалтад хамрагдаж буй шүүгчийн үе хоорондын хамаарлыг судлан үзэж, сургалтын арга зүйг туршин боловсруулж болох юм.

Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн орон тооны бус хөтөлбөрийн хороо нь тухайн сургалтын хөтөлбөрийг захиалагч талын эрэлт хэрэгцээнд нийцсэн мэдлэг эзэмшүүлэх, чадавхжуулахад чиглэсэн сурах, сургах үйл ажиллагааны агуулга зохион байгуулалтыг тодорхойлсон цогц баримт бичиг болох сургалтын хөтөлбөрийг боловсруулах чиг үүрэгтэйгээр хуульчилсан. Аливаа сургалтын хөтөлбөр (training program) нь тогтоосон хугацаа, тодорхойлсон нөөцийг ашиглан боловсролын стандартаар шаардсан үр дүн, чанарт хүрэх арга зүй, технологийн шийдлийг илэрхийлсэн сургалтын удирдамж²⁷ баримт бичиг²⁸ байдаг. Шүүгчийн сургалтын хөтөлбөрийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ерөнхий зөвлөлтэй зөвшилцөн батлахаар хуульчилсан нь мэргэжил арга зүйн болон зохион байгуулалтын ач холбогдолтой зохицуулалт юм. Хөтөлбөрийн хорооны боловсруулсан сургалтын хөтөлбөрийн чанар, үр дүнг урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүнг харгалзан үзэж, сургалтын үр дүнг тарамдуулахаас аль болох зайлсхийх нь зүйтэй. Сургалтын хөтөлбөрт үндэслэн хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын хэрэглэгдэхүүн, сургагч багшийн мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах нь чухал ач холбогдолтой юм. Энэ нь хөтөлбөрийн зорилго, тухайн зорилгод хүрэхийн тулд оролцогч талуудад тавих шаардлага, зохион байгуулалт, үр дүн гэсэн цогц үйл ажиллагааг шаарддаг. Сургалтын хөтөлбөр боловсруулах хэд хэдэн загварыг дээд боловсролын салбарт ашиглаж байна. Үүнд: 1/Тэйлорын сургалтын хөтөлбөр зохиох шинжлэх ухаанч загвар нь няхуур судалж, системтэй боловсруулж, хэмжиж болох үр дүнг төлөвлөх ажлыг үе шаттай гүйцэтгэдэг, тодорхой зорилгод чиглэсэн. 2/Уокерын сургалтын хөтөлбөр зохиох зөвшилцөх загвар нь сургалтад оролцогч талуудтай зөвшилцөхөд онцгой анхаарч төлөвлөх, боловсруулах бүхий л үе шатанд оролцуулснаар нийтээр хүлээн зөвшөөрүүлж, хэрэгжүүлэхэд чиглэсэн. 3/Эйснерийн бүтээлч загвар нь сургалтын хөтөлбөр зохиогч өөрийн үзэл бодол, туршлага, зөн билигтээ тулгуурлан уран сайхан сэтгэлгээ болон системийн хандлагыг хэрэглэдэг бөгөөд байнга бүтээлчээр сайжруулах хэрэгцээ үүсдэг. 4/ Прагматик загвар

²⁷ Удирдамж (нэр) тодорхой ажил хэргийг гүйцэтгэхэд удирдлага болгон ажиллавал зохих заавар. Баярсайхан, Б. (2011). Монгол хэлний тайлбар толь. Уб., 1249 дэх тал.

²⁸ Монголын боловсролын нэвтэрхий толь. Боть 2.(2021) Уб., 543 дахь тал.



нь тухайн сургалтын хөтөлбөрийн үр дүнд бий болох эцсийн бүтээгдэхүүний тодорхойлолтыг хэрэглэгчидтэй ойр байж боловсруулдаг тул амьдралд хэрэглэхэд илүү тохиромжтой, суралцагчид сэтгэл ханамж өндөр байдаг²⁹. Сургалтын хөтөлбөр боловсруулах чиг үүрэг бүхий бие даасан нэгжийг хүрээлэн мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллаж буйн хувьд шүүхийн сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа харгалзан үзэж болох юм. Мөн сургалтын хөтөлбөрийн талаарх тодорхойлолтыг Wesley Null “Curriculum” (2017) хэмээх бүтээлдээ: 1/Либерал хөтөлбөр-ухаалаг сэтгэлгээг дэмжсэн, хувь хүний итгэл, ур чадвар, сахилга батыг бэхжүүлэхэд чиглэнэ. 2/Системт хөтөлбөр-хэмжих хэмжүүртэй, үр ашигтай байх нийтлэг асуудалд онцгой анхаарсан. 3/Экзистенциалист хөтөлбөр-суралцагчдад сонирхож буй агуулгыг сонгохыг зөвшөөрдөг, бүтээлч чанар, хувь хүн байхын утга учир, өөрийгөө илэрхийлэх байдлыг чухалчилна. 4/Радикал хөтөлбөр-нийгэм ямар байх ёстой тухай нийгмийн болон ёс суртахууны үзэл баримтлалыг олгодог. 5/Прагматик хөтөлбөр-өөрчлөлтийг үр дүнтэй хийх, тодорхой зорилтуудыг биелүүлэхэд чиглэнэ. 6/ Зөвлөлдөж хэлэлцэх (делибиратив) хөтөлбөр-практик ур чадварыг чухалчилж, мэдлэгийн шинэ хандлагыг нээх зориулалттай³⁰ гэжээ. Эдгээр хөтөлбөрөөс тухайн сургалтад аль хэв шинжийн хөтөлбөрийг сонгох эсхүл холимог байдлаар боловсруулалт хийх эсэхээ сонгох нь нээлттэй. Шүүхийн сургалтын хөтөлбөрийг боловсруулан тасралтгүй зохих түвшинд шинэчлэн сайжруулж ирсэн нь сайшаалтай хэдий ч сургалтаас ямар үр дүн хүлээх, тэдгээрийг хэрхэн дүгнэх нь одоо хир нь тодорхойгүй байна. Тухайлбал, ажлын байран дээр нэн тэргүүнд шаардлагатай ур чадвартай холбоотойгоор сургалт (ёс зүйн, гадаад хэлний, сэтгэл заслын, мэдээллийн технологийн, Монгол хэл, бичгийн найруулга зүй, зөв бичгийн дүрмийн)³¹-ыг саналын дагуу хувь хүний хөгжлийн сургалтын хүрээнд зохион байгуулдаг ч үр дүнг ямар шалгуур үзүүлэлтээр үнэлэх вэ гэсэн асуулт урган гарч ирнэ. Энэ нь тухайн сургалтын хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн хичээлийн агуулга, хүргэх хэлбэр, технологитой шууд холбоотой. Харин онолын болон хууль хэрэглээний сургалтын үр дүн нь үнэлэгдэхүйц байдгаараа ялгаатай бөгөөд эрх зүйн шинэтгэлийн бодит тусгал болохын хувьд хөдөлгөөнт шинжтэй тухайн сургалтын хөтөлбөрийг төрлийн хувьд нийтлэг болон тусгай, хэлбэрийн хувьд танхим болон зай(цахим³²)-н гэж ялгамжтай төлөвлөх боломжтой зэрэг нь эрхийн тухай сэтгэлгээг эзэмдэхийн тулд сэтгэж сургадаг боловсрол эзэмших хэрэгтэй болохоос, зөвхөн мэдрэмж

²⁹ Бадарч, Д. (2021). Дээд боловсролын онол, арга зүй (парадигмын шилжилт, багшлахуй, суралцахуй). Уб., 235-236 дахь тал.

³⁰ Жилээ, Ж. (нар). (2020). Сургалтын хөтөлбөрийн харьцуулсан судалгаа. Уб., 14 дэх тал.

³¹ Өлзийсайхан, Б. (2018). Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд шүүхийн захиргааны үүрэг: Эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт// Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2018. 168 дахь тал.

³² Шүүхийн 2020 оны зарим сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан нь шүүгчид хүссэн үедээ сургалтыг давтан үзэх, мэдлэгээ сэргээх чухал ач холбогдолтой сургалтын шинэлэг хэлбэр байсныг онцлох нь зүйтэй гэжээ.// Монгол Улсын шүүхийн тайлан (2020). Уб., 70 дахь тал.

юуг тойрон эргэлдээд бүтэхгүй³³ гэсэн эрх зүйн философийн онол сургаалыг эш үндэс болгон олон суурьтай хэрэглээг чухалчлах хичээлийн хөтөлбөрийг сургалтын хөтөлбөрт оруулах талаар нарийвчлан судлах нь зохистой юм.

Шүүхэрхмэдлийн хувьд онолгүй хууль хэрэглээ гэж байх учиргүй бөгөөд харилцан адилгүй онолын мэдлэг бүхий шинээр томилогдсон шүүгчийн³⁴ сургалтын хөтөлбөрт заавал судлахаар тусгах нь хууль хэрэглээний мэдлэг бүтээхэд тустай.

Шүүгчийн онолын мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн хүрээлэнд судлаачаар ажиллах³⁵, түүнчлэн шүүгчийн цалин хөлсийг хэвээр олгох, шүүгчээр ажилласанд тооцох шинэлэг зохицуулалт нь шүүх эрх мэдлийн байгууллагын хүний нөөцийг чадавхжуулахад бодит дэмжлэг болно гэсэн хүлээлт буй. Шүүхийн сургалтыг зохион байгуулж ирсэн өмнөх туршлагад Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл болон бусад байгууллага, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн болон бусад дэмжлэгээр хэрэгжүүлж байсныг сургалтын байгууллагатай³⁶ хамтран зохион байгуулна³⁷ гэж хуульчилжээ. Энэхүү зохицуулалтын дагуу Хууль зүйн үндэсний хүрээлэн³⁸, Монголын хуульчдын холбоо³⁹ болон бусад байгууллагын хамтын ажиллагааг хязгаарлах нөхцөл үүсэж болзошгүй юм. Учир нь сургалтын байгууллага гэсэн статус бүхий байгууллагад өмнө нь сургалт хамтран зохион байгуулж ирсэн байгууллагууд хамаарахгүй байх нөхцөл байдал үүссэн явдал юм.

ДҮГНЭЛТ

Шүүхийн сургалтыг өмнөх туршлагаас үзэхэд ажлын байран дахь сургалт, ажлын байрнаас гадуурх сургалт гэж 2 хэсэгт хуваан зохион байгуулж ирсэн. Эдгээр сургалт нь мэдлэгийн суурь стандартыг шаардахгүй бөгөөд тухайн албан тушаалын нийтлэг шаардлагад нийцүүлэн нийгмийн хөгжлийн захиалга, албан тушаал эрхэлж буй хүний албаны буюу мэргэшлийн, хувийн буюу хувь хүний хөгжлийн хэрэгцээг хангахуйц боловсролын үйлчилгээний чанарын түвшинг тогтоох, үйл ажиллагааны онцлог, оролцогч талуудын мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлоход чиглэдэг байна.

1. Шүүхийн сургалтад оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг тодорхойлохдоо санал асуулга явуулах, ярилцлага хийх, шүүхийн практикийг судлан сургалтын хөтөлбөрийн шинэтгэл хийж ирсэн хэдий ч сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүн

³³ Баттогтох, Б. нар (2021) орч. Гегель. Эрх зүйн философи Уб., 297 дахь тал.

³⁴ Шүүхийн тухай хууль (2021)-ийн 37, 48 дугаар зүйл.

³⁵ Шүүхийн тухай хууль (2021)-ийн 24 дугаар зүйлийн 24.4.

³⁶ *Сургалтын байгууллага* гэж боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлдэг хуулийн этгээд, Монголын боловсролын нэвтэрхий толь. Боть 2.(2021) Уб., 543 дахь тал.

³⁷ Шүүхийн тухай хууль (2021)-ийн 72 дугаар зүйлийн 72.1.6.

³⁸ Монгол Улсын Засгийн газрын тухай хууль (1993)-ийн 20 дугаар зүйлийн 20.5.7 дахь заалт.

³⁹ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль (2012)-ийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт, 44, 45 дугаар зүйл



хангагдсан эсэхэд дүн шинжилгээ хийж ирсэн нь тодорхойгүй. Сургалтын үр дүнд эзэмших мэдлэгийн ангилалд тохирсон сургалтын хөтөлбөр боловсруулалт бус харин нийтлэг буюу суурь ухагдахууныг ойлгож, мэдэх баримтын мэдлэг олгоход чиглэжээ. Энэ нь суралцагчдын онолын болон хууль хэрэглээний мэдлэгийг үнэлэх боломжгүй нөхцөлд хүргэж болохыг үгүйсгэхгүй юм.

2. Шүүхийн сургалтад хамрагдаж буй шүүгч, шүүхийн захиргааны ажилтны мэдээлэл хүлээн авах, боловсруулалт хийх, мэдлэг бүтээх чадвар нь харилцан адилгүй байх бөгөөд энэ нь боловсролын салбарт тулгамдаж буй зайлшгүй анхаарах учиртай үе хоорондын ялгаатай байдалтай холбоотой гэж үзэж байна.
3. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүгчийн сургалтын хөтөлбөрийг боловсруулан сургалтыг зохион байгуулж ирснийг шүүхийн мэргэжлийн удирдлага буюу Улсын дээд шүүхэд хуулиар харьяалуулсан нь шүүгчийн мэргэшүүлэх сургалтаар онолын болон хууль хэрэглээний (дээд эрэмбийн) мэдлэг эзэмших арга зүйг шинэ түвшинд хүргэнэ гэсэн хүлээлтийг үүсгэж байна.
4. Сургалтын хөтөлбөрийг боловсруулж ирсэн туршлагаас ажиглахад Уокерын сургалтын хөтөлбөр зохиох зөвшилцөх, Прагматик загварыг түгээмэл ашигласан байна. Сургалтын хөтөлбөрийн тодорхойлолтыг харгалзан үзвэл агуулгын хувьд Либерал, Экзистенциалист, Радикал, Прагматик, Зөвлөлдөж хэлэлцэх (делибиратив) хөтөлбөрийг холимог байдлаар хэрэгжүүлж иржээ гэж дүгнэж болохоор байна.

САНАЛ

1. Шүүхийн сургалтын хөтөлбөр нь дараах үндсэн шаардлагыг хангахуйц байдлаар боловсруулагдсан байвал зүйтэй байна. Үүнд:
 - а/ Суралцагч сурч, мэдлэг эзэмших хүсэл тэмүүллийг бий болгохуйц зорилго, агуулга бүхий байх;
 - б/ Сургалтыг гүрдүнтэй зохион байгуулах орчин, хэрэглэгдэхүүнийг бүрдүүлсэн байх;
 - в/ Сургалтаар олж авах ур чадварыг хэвшүүлэхэд ачаалал бүхий хүндрэлтэй нөхцөл байдал үүсвэл үе шаттайгаар зохион байгуулах боломжтой хувилбарыг санал болгохуйц байх;
 - г/ Суралцагчаас мэдлэгийн орц, гарцын судалгааг авч, эргэх холбоог сайжруулах боломжтой байх.
2. Суралцахуйн үр дүнг сайжруулахын тулд сургалт удирдах багш болон суралцагчаа судлан, сургалтыг холимог (blended), Хосолмол

- (hybrid), тонгоруу (flipped) гэсэн арга зүйгээс сонгон (1/шинээр томилогдсон, 2/ ажил, албан тушаал өөрчлөгдсөн, 3/мэргэшил, ур чадвар дутагдсан зэрэг) сургалтын хэрэгцээг бүрэн зураглаж, сургалтын үр дүнг үнэлж, сургалтын хөтөлбөрийг сайжруулахад ашиглах;
3. Шүүхийн сургалтыг хамтран зохион байгуулж ирсэн Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын хуульчдын холбоо зэрэг байгууллага нь хуулиар сургалтын байгууллагад хамаарахгүй байх тул сургалт, судалгааны хамтын ажиллагааг оновчтой тодорхойлох боломжийг судлан тус тусдаа зохион байгуулж буй сургалтын уялдаа холбоог сайжруулах;
 4. Сургалтын зай (цахим)-н хэлбэрийг идэвхтэй ашиглаж, боловсролын салбарт өргөнөөр ажиглаж буй хэлэлцүүлгийн мэдээллийн систем (Discussion Mining System), нийтэд зориулсан нээлттэй сургалтын платформоос сонгон онолын сургалтад ашиглах;
 5. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг боловсролын зэрэг (магистр, доктор) ахиулах дотоодын болон гадаадын хөтөлбөрт суралцах, зочин судлаачаар ажиллахад нь дэмжлэг үзүүлэн суралцах хугацаа (Магистр-3, Доктор-5 жил)-аар сургалтын гэрээг үндэслэн нийгмийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тухайн шатны шүүхийн төсвөөс олгох, шүүгч, ажилтнаар ажилласанд тооцох;
 6. Шүүгчийн албан тушаалд ажиллах шаардлага хангасан хүнийг хуульчдаас шилж олоход дэмжлэг үзүүлэх, АНУ, Франц зэрэг оронд шүүгч бэлтгэх, шүүгчийг мэргэшүүлэх төрлийн сургалтыг бие даасан нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн институт зохион байгуулдаг туршлага байна. Энэ нь зөвхөн шүүгчээр ажиллаж буй тохиолдолд хамрагдах бус харин шүүгчид өрсөлдөхийн тулд нарийвчилсан хөтөлбөрөөр сургалтад хамрагдах боломжийг судална гэж ойлгож болно. Энэ туршлагыг Монголд шүүхийн захиргааны ажилтан бэлтгэх сургалтаар нэвтрүүлээд явж байна. Цаашид чанаржуулах, төгсөгчдийг нь мөшгөх судалгаанд хамруулан орц, гарцыг тодорхойлсноор шүүгчийг ч мөн бэлтгэх сургалтыг тодорхой хугацааны давтамжаар зохион байгуулах саналыг дэвшүүлж байна.



ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Б.Өнөрмаа

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./

Удиртгал

Ялгаварлан гадуурхах хандлага нь хүний үндсэн эрх, эрх чөлөөнд халддаг бөгөөд хүнийг ямар нэгэн нийгмийн бүлэгт харьяалагддагийнх нь төлөө ялгаварлан гадуурхах, ялгаварлан гадуурхалтаа туйлширсан байдлаар илэрхийлж буй үйлдэл түгээмэл байна. Тэр ч утгаараа ялгаварлан гадуурхах хандлага нь хүний эрхэм чанар, хувь хүний онцлогийг үгүйсгэдэг ба хүн бүр хуулийн тэгш хамгаалалтад байх эрхийг зөрчиж байдаг. Бодит нөхцөл байдалд бусдыг ялгаварлан гадуурхах үйлдэл, хандлага, үг хэллэг зэрэг хүмүүсийн илэрхийлэл түгээмэл байгаа нь нууц биш. Хүнийг хүйсийн баримжаа, бэлгийн чиг хандлагаас нь болж ялгаварлан гадуурхсаны улмаас чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаад улс руу явах, оршин суух боломжгүй болох эсхүл нийгэм болон цахим орчинд өөрийгөө болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжгүй болох, намын харьяаллаас болж ажлаасаа халагдан ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхээ эдэлж чадахгүй байх зэрэг олон тохиолдлыг энд дурдаж болно.

1. Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн тухай ойлголт, тодорхойлолт

Ялгаварлан гадуурхах үйлдэл: Нийгмийн тодорхой бүлгийн гишүүнийх нь хувьд хүмүүстэй бусад хүмүүсийн адил эрх тэгш хандахгүй байх үйлдлийг ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ гэнэ. Боловсрол, ажил хөдөлмөр эрхлэлт, бүх төрлийн үйлчилгээ авахад ямар нэг нийгмийн бүлэгт харьяалагдах мөн чанараар нь буюу хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа гэх мэт хүчин зүйлсээр хүмүүсийг ялгаварлан гадуурхах гэдэг нь тухайн хүнийг эрхээ эдлэх тэгш боломж олгохгүй байхыг хэлдэг. Бусдыг ялгаварлан гадуурхах нь хувь хүний дургүйцэл эсхүл үзэн ядах сэдэлтэй байдаг.

Үзэн ядах сэдэлт: Үзэн ядалт гэдэг латин гаралтай "Одиум"¹ гэсэн үг бөгөөд хүнд дайсагнах, дургүйцэх мэдрэмж болон илэрхийллийг хэлдэг. Үзэн ядалт нь хор хөнөөлтэй, аюултай үр дагаврыг бий болгодог ба үзэн ядалтын улмаас хүний амь нас ч хохирч болох бөгөөд энэ нь тухайн хүний хийсэн үйлдэл, зан үйлээс үүдэлтэй байдаг. Монгол улсын Эрүүгийн хуульд зарим

¹ <https://de.wiktionary.org/wiki/Odium>

төрлийн хэрэгт “үзэн ядалт”-ыг сэдэлт² гэж тодорхойлсон бөгөөд бие даасан гэмт хэргийг мөн хуулийн 14.1 дүгээр зүйлд “Ялгаварлан гадуурхах” гэмт хэрэг гэж хуульчилсан.

Ялгаварлан гадуурхах гэмт хэрэг: Эрүүгийн хуулиар хориглосон үйлдэл (“үндсэн гэмт хэрэг”) ба хохирогчийг тодорхой мөн чанараар нь ялгаварласан ялгаварлалтад үндэслэсэн (“ялгаварлан гадуурхах сэдэлт”) үйлдлийг хэлнэ.

Ялгаварлан гадуурхах сэдэлт нь хохирогчийн ямарваа нэг бүлгийн харьяаллыг нь илтгэх гүн, үндсэн мөн чанар болох үндэс угсаа, шашин, хэл, хүйс, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, мэргэжил гэх мэт мөн чанараар нь ялгаварлах сэдэлт юм.

2. Олон улсын хэм хэмжээ:

- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966)
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966)
- Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (1965)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (2006)
- Хүүхдийн эрхийн тухай конвенц (1990)
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1979)
- Алагчлахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай 111 дүгээр конвенц (1958)
- Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай конвенц (1960)
- Хөгжих эрхийн тухай тунхаглал (1986)
- Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийг олон улсын хүний эрхийн эрх зүйд ашиглах тухай Жогжакартагийн зарчим (2006)
- Хүний эрхийн боловсрол, сургалтын талаарх тунхаглал (2011)

² ЭХТА-ийн 10.1 дүгээр зүйлийн 2.14. “үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол”



Хүүхдийн эрхийн тухай конвенц	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц
Оролцогч улсууд хүүхдийн, түүний эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагчийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс, угсаа, нийгмийн гарал, эд хөрөнгө, эрүүл мэнд, төрсөн болон бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчлахгүй энэхүү Конвенцид заасан бүх эрхийг харьяалалдаа байгаа хүүхэд бүрийн хувьд хүндэтгэн хангана.	Оролцогч улсууд нь хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас бүх хэлбэрээр алагчлах явдлыг хориглох бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ямарваа хэлбэрийн алагчлалд өртөхөөс хамгаалах адил тэгш, үр дүнтэй хууль зүйн хамгаалалтыг бий болгоно.
Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц	Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц
Энэхүү Конвенцид “арьс үндсээр алагчлах” гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёл болон нийгмийн амьдралын бусад салбарт хүний эрх, үндсэн эрх чөлөөг тэгш хүлээн зөвшөөрөх, эдлүүлэх, хэрэгжүүлэхэд саад хийх, үгүйсгэх зорилго бүхий арьс үндэс, арьсны өнгө, ураг төрөл, үндэсний буюу угсаатны гарал үүслийн үндсэн дээр ялгаварлах, онцлох, хязгаарлах буюу дээрд үзэхийг хэлнэ.	Энэхүү Конвенцийн зорилгоор “эмэгтэйчүүдийг алагчлах” гэсэн нэр томъёо нь гэрлэлтийн байдлаас үл хамаарч эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэний болон аливаа бусад салбарт эмэгтэйчүүдийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, эдлүүлэх, хэрэгжүүлэхэд саад хийх, эсхүл үгүйсгэх үр дагавар, эсхүл зорилго бүхий хүйсээр ялгаварлах, үгүйсгэн гадуурхах буюу хязгаарлахыг хэлнэ.
Шведийн олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны агентлагийн “жендерт суурилсан хүчирхийлэл”-ийн тодорхойлолт	
Эмэгтэй хүн, охин, эрэгтэй хүн эсвэл хөвгүүний эсрэг үйлдсэн, тухайн хүндээ <u>бие махбодын, бэлгийн, сэтгэлзүйн эрүүл мэнд, хөгжил, эсвэл түүний илэрхийлэлд</u> нь сөрөг үр дагавар үүсгэсэн аливаа хор хөнөөл эсвэл шаналал. Хүчирхийллийн шалтгаан нь жендерт суурилсан эрх мэдлийн тэгш бус байдал, жендерт суурилсан ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэй байна.	
НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай тунхаглал, Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх, тэмцэх тухай Истанбулын конвенц дахь “эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл” (ЭЭХ)-ийн тодорхойлолт	
1) Хүний эрхийн зөрчил 2) Ялгаварлан гадуурхсан үйлдэл 3) Эмэгтэй хүнд бие махбодын, бэлгийн эсвэл сэтгэлзүйн хор хөнөөл, шаналлыг албадах, эрх чөлөөг нь хязгаарлах зэрэг аюул заналхийлсэн үйлдлийг оролцуулан нийтэд илээр, мөн хувийн амьдралд нь эсэхээс үл хамааран нэгэнт учруулсан, эсвэл учруулахуйц шинжтэй хүчирхийлсэн үйлдэл	

НҮБ-ын “эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл”-ийн тодорхойлолт

Эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын эрх мэдлийн тэгш бус түүхэн харилцааны илрэл нь эрчүүд эмэгтэйчүүдийг дарангуйлах, ялгаварлан гадуурхах, эмэгтэйчүүдийг бүрэн дүүрэн хөгжихөд саад болдог ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээр дамжуулан эрэгтэйчүүдийн дор туслах байр сууринд эмэгтэйчүүдийг аваачдаг нийгмийн ноцтой механизмуудын нэг

3. Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн эсрэг үндэсний хэм хэмжээ

Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван дөрөвдүгээр зүйл.

1. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.
2. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.

Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.1 дүгээр зүйл.

Ялгаварлан гадуурхах

1. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.бүлэглэж;

2.2.хүч хэрэглэж;

2.3.албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Ялгаварлан гадуурхах үйлдэл эс үйлдэл

Тодорхой хувь хүнийг мөн чанараар нь ялгаварласны улмаас эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол гэмт хэрэгт тооцогдож байна. Эс үйлдэхүйгээр ялгаварлан гадуурхах гэдэг нь тухайлбал Хөдөлмөрийн тухай хуулийн 111



дүгээр зүйлд 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах, мөн хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ажлын цагийг богиносгох, ээлжийн амралтыг уртасгах, аж ахуйн нэгжид хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулахаар заасан боловч энэ үүргээ биелүүлэхгүй байх.

5. Ялгаварлан гадуурхалт үйлдэгдэж буй нөхцөл байдал

2019-2021 оны хооронд ялгаварлан гадуурхах үйлдэлд өртсөн тухай 6 гомдол мэдээлэл цагдаагийн байгууллагад бүртгэгдсэнээс 1 гомдолд хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шүүхээр шийдвэрлүүлэхээр шийдвэрлэжээ. Энэ төрлийн гэмт хэрэг огт үйлдэгдэхгүй байна уу эсхүл илрүүлж чадахгүй байна уу?

- Ялгаварлан гадуурхах гэмт хэрэгт өртсөн боловч үүнийгээ шалгуулж чадахгүй, гомдол гаргаж чадахгүй байгаа шалтгаан нь тухайлбал бэлгийн цөөнх нь насан туршдаа нийгэм болон гэр бүлээс ирэх шахалт, доромжлолоос айсан сэтгэл зүйн дарамттай байдаг тул нийгэмд тэр болгон ил гарч өөрсдийгөө илэрхийлдэггүй бөгөөд хувийн нууц нь алдагдана гэсэн айдас /гэр бүл, найз нөхөд, ажлын газрын хүмүүс өөрийнх нь талаар мэдэх боломжтой/
- Өгсөн мэдүүлэг тайлбар нь бусдад задрах магадлалтай, эрх бүхий албан тушаалтнуудын харилцаа, хандлага /гомдол хүлээн авахгүй байх, зүй бус үгээр доромжлох, харьцах, үл хүндэтгэх/,
- Эрүүгийн хэрэг хянан шалгах ажиллагааны талаарх болон хүний эрхийн талаарх ойлголт дутмаг (эрхийг нь танилцуулах ажиллагаа хэлбэрийн төдий явагддаг),
- Тэгш хандана гэсэн итгэл үнэмшилгүй бөгөөд хохирогчийн хувь хүний илэрхийллийг хүндэтгэхгүй байх айдсаас улбаатай байх.

Бодит нөхцөл байдалд бусдыг ялгаварлан гадуурхах үйлдэл, хандлага, үг хэллэг зэрэг хүмүүсийн илэрхийлэл түгээмэл байгаа нь нууц биш. Манайд түгээмэл үйлдэгддэг ялгаварлан гадуурхалтын төрөл:

1. Бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхах /бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа өөр хүмүүсийг доромжлох, төрийн албан хаагчдын ялгаварлан гадуурхах хандлагаас айж гэмт халдлагад өртсөн ч гомдол гаргаж чаддаггүй³/
2. Жендерийн ялгаварлан гадуурхалт / ихэнхдээ эмэгтэйчүүдийг сул дорой эсвэл эрчүүдээс доогуур гэж үзэх хандлага/

³ ЛГБТТөвтэй нууцлалын гэрээ байгуулж авсан бодит кейсүүд

3. Хөдөлмөрийн ялгаварлан гадуурхалт /50-иас дээш настай хүмүүсийг хөгшин гэж үзэн ажилд орох боломжийг нь бууруулдаг/
4. Цалин хөлсний ялгаварлан гадуурхалт / Статистикийн хорооноос гаргасан мэдээнээс авч үзвэл 2021 оны байдлаар дундаж цалин эрэгтэйчүүдийнх 1.4 сая, эмэгтэйчүүдийнх 1.2 сая төгрөг, Оюутолгойн монгол ажилчид сард 2-5 сая гадаад ажилчид 20-40 саяын цалин авдаг гэх мэдээлэл⁴/
5. Гадаад төрхөөр ялгаварлан гадуурхах /царайны төрх, таргалалт г.м байдлаас болж бусдын доог тохуу болох/
6. Хөгжлийн бэрхшээл, өвчний улмаас ялгаварлан гадуурхах /Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээлснээр дэлхийн хамгийн гадуурхагдсан бүлгүүдийн нэг бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс юм. Тахир дутуу хүмүүсийг бие махбод бус нийгмээр хязгаарладаг гэж үздэг⁵. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг 2019 оны жилийн эцсийн байдлаар НХХЯ-наас судалж үзэхэд⁶ 13 яамд хөгжлийн бэрхшээлтэй 8 хүн ажилладаг бөгөөд 6 яам хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулдаггүй гэжээ. Хот дотор тэргэнцэртэй хүмүүс нийтийн тээврээр зорчих ямар ч нөхцөл бүрдээгүй буюу тусгай тоноглолтой автобус байхгүй мөн эдгээр хүмүүс барилга байгууламжийн орчинд нэвтрэх боломж хязгаарлагдмал байна/
7. Шашны ялгаварлан гадуурхалт /Шашны итгэл үнэмшил, тэдгээрээс улбаатай зан заншлын хувьд хүнийг гутаан доромжлох/
8. Хэлний ялгаварлан гадуурхалт /Хувь хүн эсвэл нийгмийн бүлгийг тэдний хэл яриа, аялга, аялгууны улмаас доромжлох/
9. Эдийн засгийн ялгаварлан гадуурхалт /Энэ нь хүмүүсийн хооронд мөнгө эсвэл эд хөрөнгийн хэмжээгээр ялгааг бий болгодог бөгөөд нийгмийн анги давхаргад үндэслэн ялгаварлан гадуурхахад хүргэдэг/
10. Нийгмийн давхаргаар ялгаварлан гадуурхах /Энэ нь тодорхой хувь хүмүүсийг нийгэмд авч болох ашиг тусаар нь ялгаж гадуурхдаг. Эдийн засаг, нийгмийн ялгаварлан гадуурхалт нь орлогын тэгш бус байдал эсвэл боловсролын боломжоос үүдэлтэй⁷/
11. Сургуулийн орчин дахь ялгаварлан гадуурхалт /Сургуулийн сурагчид үе тэнгийнхнийхээ дунд бие махбодын болон сэтгэл зүйн хүчирхийлэлд өртөж буй хандлага/

⁴ УИХ-с томилогдсон Оюутолгой ХХК-г шалгах ажлын хэсгийн дүгнэлтээс

⁵ <https://mn.warbletoncouncil.org/tipos-de-discriminacion-3016#menu-14>

⁶ НХХЯ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа 2020, 54 дэх тал

⁷ <https://mn.warbletoncouncil.org/tipos-de-discriminacion-3016#menu-14>



ДУГНЭЛТ

Ялгаварлан гадуурхах хандлага нь хүний үндсэн эрх, эрх чөлөөнд халддаг бөгөөд хүнийг ямар нэгэн нийгмийн бүлэгт харьяалагддагийнх нь төлөө ялгаварлан гадуурхах, ялгаварлан гадуурхалтаа туйлширсан байдлаар илэрхийлж буй үйлдэл түгээмэл байна. Тэр ч утгаараа ялгаварлан гадуурхах хандлага нь хүний эрхэм чанар, хувь хүний онцлогийг үгүйсгэдэг ба хүн бүр хуулийн тэгш хамгаалалтад байх эрхийг зөрчиж байдаг.

Хүнийг хүйсийн баримжаа, бэлгийн чиг хандлагаас нь болж ялгаварлан гадуурхсаны улмаас чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаад улс руу явах, оршин суух боломжгүй болох эсхүл нийгэм болон цахим орчинд өөрийгөө болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжгүй болох, намын харьяаллаас болж ажлаасаа халагдан ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхээ эдэлж чадахгүй байх зэрэг олон тохиолдлыг энд дурдаж болно.

Нийгмийн хандлагыг өөрчлөх, хүний эрхийн тухай ойлголтыг системтэйгээр түгээх үүднээс ялгаварлан гадуурхалтад өртөж буй нийгмийн хэсгийн талаар бодит мэдээлэл, статистикт тулгуурлан та бүхэнд цуврал нийтлэлээр хүргэх болно.

ҮНДСЭН ХУУЛИЙН ТОГТВОРТОЙ ҮЙЛЧЛЭХ ХУГАЦАА, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Ж.Алтансүх
Хуульч, судлаач

Өнөөгийн НҮБ-д бүртгэлтэй 193 улсаас¹ Их Британи, Израиль, Саудын Араб, Шинэ Зеланд гэх мэт цөөхөн орноос бусад 180 гаруй улсад төрөөс үндсэн хуулийг баталжээ.² Харьцуулсан үндсэн хуулийн эрх зүйн судалгааны төслийн хийсэн³ тоон мэдээллээс үзвэл 1787-2005 оны хооронд дэлхий даяар 935 үндсэн хууль батлагдсан. Эдгээрээс 746 үндсэн хууль нь хүчингүй болж байжээ.⁴ Түүнчлэн 1787 оноос хойших 230 гаруй жилийн хугацаанд зөвхөн 14-15 тооны үндсэн хууль /1.5 хувь/ буюу 100-аас дээш жилийн хугацаагаар өнөөг хүртэл хүчин төгөлдөр мөрдөж иржээ.⁵ Үүнээс үзвэл дэлхийн ихэнх улсуудад үндсэн хуулийг тодорхой хугацааны давтамжтайгаар өөрчлөн, шинэчилж ирсэн болохыг харуулж байна.

Дэлхийн улсуудын үндсэн хуулийн үйлчлэх хугацааг тухайн улсын онцлог болон бүс нутгаар нь судалж үзвэл үндсэн хуулийн үйлчлэх хугацаа харилцан адилгүй байдаг ажээ. Тухайлбал, Хойд Америк ба Баруун Европын бүс нутагт үндсэн хуулийн үйлчлэх хугацаа ардчилал сул хөгжсөн бусад орнуудтай харьцуулахад өндөр байдаг статистик тоон мэдээлэл бий. Тухайлбал Америкийн Нэгдсэн Улс 230, Нидерландын Вант Улс 206, Норвеги Улс 206, Белги Улс 189 жил, Канад Улс 153, Люксембург Улсад 152 тус тус жилээр тогтвортой үйлчилж иржээ.⁶

Харин Латин Америкийн бүс нутгийн орнуудыг авч үзвэл үндсэн хуулийн хэрэгжилт сул, үйлчлэх хугацааны хувьд ихээхэн тогтворгүй ажээ. Тухайлбал, Доминиканы Бүгд Найрамдах Улс анх тусгаар тогтнолоо зарласнаас хойш нийтдээ 33 тооны үндсэн хуулийг шинээр баталж байжээ. Энэ нь дэлхий дээр хамгийн олон удаа үндсэн хуулиа шинээр баталсан улсад тооцогдож байна. Үүний дараа Венесуэль Улс 25, Гайти Улс 21, Эквадор Улс 23 гэх мэт тооны үндсэн хуулийг баталж байжээ.⁷ Түүнчлэн Жишгийн эрх зүйн болон шашны эрх зүйн тогтолцоотой зарим орнууд болох Их Британи, Шинэ Зеланд, Израиль, Саудын Араб гэх мэт улсуудад өнөөг хүртэл албан ёсны үндсэн хууль батлаагүй байна.⁸ Үүнээс харахад үндсэн хуулийн насжилт,

¹ <https://www.un.org/en/member-states/>

² Zachary Elkins, Tom Ginsburg, and James Melton, *The Endurance of National Constitutions* (Cambridge University Press, 2009), 6.

³ <https://www.constituteproject.org/?lang=en>

⁴ Elkins, Ginsburg, and Melton, *The Endurance of National Constitutions*, 51.

⁵ 'Netherlands_Implications_Report.Pdf', 1.

⁶ 'Netherlands_Implications_Report.Pdf', 1.

⁷ <https://www.constituteproject.org/?lang=en>

⁸ Luis, 'Constitutions around the World', 1.

үйлчлэх хугацаа нь тухайн бүс нутгийн тогтвортой байдал, тухайн улсын өвөрмөц онцлогоос хамаарч ялгаатай байдаг ажээ.

Энэхүү нийтлэлээр үндсэн хуулийн хэрэгжих хугацааг тодорхой бүс нутгаар бүсчлэн харуулах, мөн үндсэн хуулийн тогтвортой үйлчлэх хугацаа, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар харьцуулалт хийхийг зорилоо. Энэ нь өнөөгийн Монгол Улсад хэлэлцэгдэж буй Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар олон нийтэд нэмэлт мэдээлэл хүргэхэд тодорхой ач холбогдолтой болов уу.

Нэг. Үндсэн хуулийн үйлчлэх хугацаа, ерөнхий ойлголт

Үндсэн хуулийн үйлчлэх хугацаа ямар байвал зохилтой талаар судлаачдын дунд онолын болон практикийн зарим хэлэлцүүлэг өрнөж байсан. Тухайлбал, өнөөгийн дэлхий дээрх хамгийн урт настай үндсэн хууль болох АНУ-ын үндсэн хуулийг батлалцсан *James Madison*: Үндсэн хууль бол удаан хугацаанд, тогтвортой үйлчлэх ёстой гэсэн байр суурьтай байсан. Харин *Thomas Jefferson* үндсэн хуулийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн тогтмол өөрчилж, шинэчлэх ёстой гэжээ.

Тэрээр үндсэн хууль бол мөнхийн баримт бичиг биш бөгөөд тухайн ард түмний хүсэл зоригийн дагуу тогтмол өөрчлөгдөн шинэчлэгдэх ёстой гэж үзсэн. Түүнчлэн үндсэн хуулийг тухайн ард түмний [шинэ] үе бүр өөрчлөн батлах ёстой бөгөөд өнгөрсөн үеийн иргэдийн баталсан үндсэн хуулиар ирээдүй, хойч үеийн амьдралыг шийдвэрлэх ёсгүй гэж үзсэн. Мөн түүнчлэн үндсэн хуулийн хэрэгжих хугацааг ойролцоогоор 19 жилээр тогтоох боломжтой гэсэн саналыг дэвшүүлж байсан. Улмаар түүний зүгээс өнгөрсөн үеийн төлөөлөл ирээдүй хойч үеийн амьдралыг шийдвэрлэх нь зохистой юу? Өнгөрсөн үеийн баталсан үндсэн хуулиар ирээдүйд үүсэх эрх зүйн харилцааг зохицуулах нь шударга зүйл үү? гэх мэтээр өөрийн үзэл санааг илэрхийлж байжээ.⁹

Харин *James Madison*-ы хувьд эсрэг байр суурьтай байсан. Тэрээр [үндсэн] хуулийн хүчин чадал нь түүний тогтвортой үйлчлэх хүчин чадвараар илэрдэг. Хуулийн тогтвортой үйлчлэх шинж чанар нь түүний тогтоосон хэм хэмжээг байнга дагаж мөрдөх дадал зуршилд байдаг гэж үзсэн. Түүнчлэн хэрэв хуулийг ойр ойрхон өөрчлөөд байвал хуулийг мөрдөж байгаа иргэдэд тодорхойгүй нөхцөл байдал үүсэж, улмаар тухайн хуулийг мөрдөх сэдэл байхгүй болно. Энэ нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлнө. Мөн үндсэн хууль бол тухайн нийгмийн суурь зохицуулалтын эрх зүйн баримт бичиг болохын хувьд тогтвортой үйлчлэх ёстой гэж үзсэн. Иймээс үндсэн хуулийг байнга өөрчлөх нь түүний хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж, улмаар үндсэн хуулийн үйлчлэл тогтворгүй болно. Энэ нь цаашдаа үндсэн хуулийн

⁹ Elkins, Ginsburg, and Melton, 1.

хямралд хүргэж болзошгүй гэж үзжээ.¹⁰ Дээрхээс үзэхэд дэлхийн анхны үндсэн хуулийг бүтээлцсэн эрхмүүд үндсэн хуулийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг ямар байх талаар онолын хувьд ялгаатай байр суурийг илэрхийлж байсныг харуулж байна.

Харин орчин үед энэхүү ойлголтыг судлаачид хэрхэн авч үзэж байгааг сонирхож үзвэл судлаачид үндсэн хуулийг тогтвортой үйлчлэх ёстой гэсэн хандлагатай байна. Тухайлбал, Профессор *Jean M. Yarbrough*: “Аливаа төрийн туйлын зорилго бол иргэдийн сайн сайхан амьдрах нөхцөл бололцоог хангаж өгөх явдал. Хэдий тийм боловч төрийн тогтолцооны бүх хэлбэр ямар нэгэн байдлаар авлига, ашиг сонирхлын зөрчилд аажмаар гулсан ордог. Үүнээс хамгаалах зорилгоор төрөөс тодорхой хууль тогтоомжийг баталж, хэрэгжүүлдэг. Энэхүү баталсан хууль тогтоомж нь өмнөх үе, ирээдүй хойч үеэс шалтгаалахгүйгээр төрийн туйлын зорилго байсаар ирсэн. Иймд төрөөс иргэддээ хандаж тогтоосон хэм хэмжээ бол туйлын зүйл бөгөөд үүнийг заавал тодорхой нэгэн /нэг үе/ төлөөлөлд хамааруулах шаардлагагүй” гэжээ.¹¹ “Хэрэв үндсэн хууль тогтвортой, сайн хэрэгжиж байгаа нөхцөлд үндсэн хуулийн хэрэгжих хугацааг зохиомлоор дуусгавар болгох шаардлага бий юу? гэх зэргээр үзэл санаагаа илэрхийлж байжээ.¹²

Ийнхүү үндсэн хуулийн хэрэгжих хугацааны талаар эрдэмтэн, судлаачдын дунд маргаантай хандлага байдаг боловч дэлхийн зарим орны үндсэн хуульд энэ талаарх зохицуулалтыг тусгаж ирсэн цөөн тооны практик бий. Тухайлбал, Франц Улсын 1793 оны “Хүний болон иргэний эрхийн тухай тунхаг” бичгийн 28 дугаар зүйлд “Ард түмэн үндсэн хуулиа шинэчлэх, өөрчлөх эрхтэй. Тухайн ард түмний аль нэгэн үе ирээдүйн хойч үеийн эрхийг хязгаарлах ёсгүй”¹³; Фижи Улсын 1990 онд батлагдсан Үндсэн хуулийн 161 дүгээр зүйлд “... Үндсэн хуулийг баталсны дараа 10 жил тутамд хэрэгжилтэд хяналт тавина”¹⁴; Зүүн Тимор Улсын Үндсэн хуулийн 154 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийг хэрэгжиж эхэлснээс хойш 6 жилийн дараа парламент өөрчилж болно”¹⁵; Папуа Шинэ Гвиней Улсын 1975 оны Үндсэн хуулийн 260 дугаар зүйлд “Үндсэн хуулийг батлан хэрэгжиж эхэлснээс хойш 3 жилийн дараа парламентаас өөрчлөлт оруулж болно”¹⁶ гэх мэтээр үндсэн хуульдаа тусгажээ. Үүнээс үзвэл үндсэн хуулийн хэрэгжих хугацааг тухайн үндсэн хуульд өөрт нь тусгайлан тусгаж ирсэн цөөн тооны практик үйлчилж байжээ.

¹⁰ Elkins, Ginsburg, and Melton, *The Endurance of National Constitutions*, 17.

¹¹ ‘American Virtues: Thomas Jefferson on the Character of a Free People’; Elkins and Ginsburg, *The Endurance of National Constitutions*, 13.

¹² Elkins, Ginsburg, and Melton, *The Endurance of National Constitutions*, 13.

¹³ ‘Declaration Rights of Man 1793’, sec. 28.

¹⁴ ‘Constitution of the Sovereign Democratic Republic of Fiji’, sec. 161.

¹⁵ ‘East_Timor_2002.Pdf’, sec. Article 154, section 2.

¹⁶ ‘Constitution of Papua New Guinea, (1975)’, sec. 260.



Үүнээс үзвэл үндсэн хуулийн хэрэгжих хугацааг механик байдлаар тогтоох нь үндсэн хуулийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Нөгөө талаар үндсэн хуулийн үйлчлэл тогтвортой бөгөөд тухайн нийгмийн суурь харилцааг үр дүнтэй зохицуулж байвал тэрхүү үндсэн хуулийг тодорхой хугацаанд байнга өөрчлөх шаардлагагүй гэж үзэж байна.

Тухайлбал, Freedom House-ийн гаргасан тоон мэдээллээс үзвэл¹⁷¹⁸ ардчилал амжилттай хэрэгжсэн 10 гаруй улс болох АНУ 231, Норвеги Улс 206, Нидерланд Улс 206, Белги Улс 189, Канад Улс 153, Люксембург Улс 152, Австрали Улс 119, Япон Улс 74, Итали Улс 73, ХБНГУ 71, Франц Улс 62 жил тус тус тогтвортой үйлчилж байна.

Нөгөө талаар ардчилал тогтвортой бус, авторитари дэглэм бүхий Латин Америкийн бүс нутагт үндсэн хуулийн тогтвортой байдал сул байдаг болохыг харж болно. Тухайлбал, тус бүс нутгийн орнуудын ихэнх нь 2-10 жилийн давтамжтай үндсэн хуулиа өөрчилж ирсэн ажээ. Тухайлбал, Доминиканы Бүгд Найрамдах Улс нийтдээ 33, Венесуэль Улс 25, Гайти Улс 21, Эквадор Улс 23 удаа үндсэн хуулийг шинээр баталж байсан.¹⁹ Үүнээс үзвэл ардчилал тогтвортой хөгжих эсэх нь үндсэн хуулийн тогтвортой байдалд нөлөөлөх нэг томоохон хүчин зүйл болохыг харуулж байна. Өөрөөр хэлбэл үндсэн хуулийн тогтвортой байдал ба ардчилал хоёр хоорондоо шууд хамааралтай гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Ингээд дэлхийн улсуудын үндсэн хуулийн дундаж насжилт, тогтвортой үйлчлэх хугацааг тодорхой бүс нутгийн болон тодорхой улсын жишээгээр дор авч үзье.

Хоёр. Дэлхийн улсуудын үндсэн хуулийн дундаж насжилт, тогтвортой үйлчлэх хугацаа

Дэлхийн улсуудын үндсэн хуулийн үйлчлэх хугацааг судалж үзвэл тухайн улс бүрд ялгаатай байсныг харж болно. Zachary Elkins, Tom Ginsburg, James Melton нарын 2005 оноос хойш хэрэгжүүлж байгаа “Харьцуулсан үндсэн хуулийн эрх зүйн судалгааны төсөл”-ийн мэдээллээс үзвэл үндсэн хуулийн хэрэгжих хугацаа дунджаар 19 жил байгаа ажээ.²⁰ Энэ нь нийт улсуудын үндсэн хуулийн үйлчилж байсан хугацааг дундажлан авч үзсэн тоон мэдээлэл юм. Иймээс энэхүү судалгаагаар үндсэн хуулийн үйлчлэх хугацааны талаарх үр дүнг нарийвчлан тодруулах үүднээс тодорхой бүс нутгаар нь дэлгэрүүлэн авч үзэхийг зорилоо. Ингээд энэхүү хэсэгт дэлхийн улсуудын үндсэн хуулийн үйлчилж буй ерөнхий хугацааг тодорхой бүс нутгаар нь дэлгэрүүлэн авч үзье.

¹⁷ <https://freedomhouse.org/report/freedom-world/2019/democracy-retreat>

¹⁸ 'Feb2019_FH_FITW_2019_Report_ForWeb-Compressed.Pdf'.


¹⁹ <https://www.constituteproject.org/>

²⁰ Elkins, Ginsburg, and Melton, *The Endurance of National Constitutions*, 2.

2.1. Баруун Европ болон хойд Америкийн бүс нутаг

Баруун Европ ба хойд Америкийн бүс нутаг бол үндсэн хуулийн тогтвортой байдал харьцангуй өндөр бүс нутаг юм. Энэхүү бүс нутагт АНУ, Канад, ХБНГУ, ИБУИНВУ, Франц зэрэг дэлхийн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын хувьд нөлөө бүхий орнууд оршдог байна.

Өнөөгийн байдлаар энэхүү бүс нутагт ойролцоогоор 24 улс оршиж байгаагаас үндсэн хуулийн тогтвортой үйлчлэх хугацаа дунджаар 90-ээс дээш жил болж байгааг харж болно. Үүний шалтгааныг судлаачид гол төлөв улс төрийн байдал тогтвортой, эдийн засгийн өндөр хөгжил, ардчилал амжилттай хөгжиж байгаатай холбон авч үздэг ажээ. Иймээс энэхүү бүс нутгийн ихэнх оронд үндсэн хуулийн үйлчлэх хугацаа дунджаар 100-аас дээш жил тогтвортой үйлчилж иржээ. Ингээд энэхүү бүс нутгийн орнуудын үндсэн хуулийн үйлчлэх хугацааг дор зургаар нарийвчлан харуулъя.



Зураг 1. Баруун Европ болон хойд Америкийн бүс нутгийн орнуудын үндсэн хуулийн үйлчлэх хугацаа

Энэхүү зургаас үзвэл АНУ, Норвеги, Нидерланд, Люксембург, Канад, Белги, Австри гэсэн орнууд дунджаар 100-аас дээш жилийн хугацаагаар тогтвортой мөрдөж иржээ.

Үүний шалтгааныг судалж зарим нэгэн орноор жишээ татвал:

АНУ нь дэлхийн хамгийн анхны үндсэн хуультай улсад тооцогддог бөгөөд 1787 онд анх үндсэн хуулиа баталж байжээ. Тус улсын үндсэн хууль



230-аад жил тогтвортой үйлчлэх хугацаанд нийтдээ 27 удаа нэмэлт орсон.²¹ АНУ-ын үндсэн хуулийн тогтвортой хүчин төгөлдөр үйлчилж байгаа шалтгааныг судлаачид дараах хүчин зүйлтэй холбон тайлбарладаг. Үүнд 1/ Тус улс үндсэн хуулиа боловсруулан батлахдаа олон нийтийн оролцоог хангаж, нийгмийн олон ялгаатай үзэл хандлага дээр зөвшилцөн баталсан;²² 2/ Тус улсын нутаг дэвсгэр дээр бичмэл болон бичмэл бус үндсэн хуулийн зэрэгцээ эрх зүйн тогтолцоо оршдог;²³ 3/ Нэмэлт оруулах журмын хувьд хатуу үндсэн хуульд тооцогддог;²⁵ 4/ Ардчилсан тогтолцоо тогтвортой хөгжиж байгаа; 5/ Нийгмийн дотоодын цөөн тооны зөрчилд орж байсныг эс тооцвол гадны аливаа халдлага, цэргийн эргэлт гарч байгаагүй, мөн нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал тогтвортой;²⁶ 6/ Төрийн байгууллага, албан хаагч, иргэдийн дунд үндсэн хуулийг дээдлэх сахих, хэлбэрэлтгүй дагаж мөрдөх эрх зүйн соёл, ухамсар бүрэлдсэн зэрэг хүчин зүйл нөлөөлжээ.

Канад Улс бол газар зүйн байршил Америк тивд оршдог, 1867 онд өөрийн тусгаар тогтнолоо зарлахаас өмнө ихэвчлэн Франц, ИБУИНВУ-ын колони орон байсан.²⁷ Тусгаар тогтнолоо зарласантай холбогдуулан 1867 онд үндсэн хуулиа баталсан. Өнөөгийн байдлаар 150 орчим жил үндсэн хууль нь тогтвортой үйлчилж байгаа бөгөөд нийтдээ 31 удаагийн нэмэлт хийсэн.²⁸ Канадын Үндсэн хуулийн эх сурвалжуудад хууль болон үндсэн хуулийн зарчмууд, эрх зүйн заншлын хэм хэмжээ зэрэг олон тооны эх сурвалж хамаардаг байна. Канад Улсын үндсэн хуулийн тогтвортой хүчин төгөлдөр үйлчилж байгаа шалтгааныг судлаачид гол төлөв үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам хатуу байдагтай холбон авч үздэг байна. Мөн үүнээс гадна АНУ-ын эрх зүйн тогтолцоотой адил бичмэл болон бичмэл бус үндсэн хуулийн эх сурвалжтай холбон авч үздэг ажээ.²⁹

Норвеги Улс бол Европын хойд хэсэгт оршдог бөгөөд өөрийн өвөрмөц эрх зүйн тогтолцоог хадгалсан орон юм. Тус улсын хувьд ардчилал өндөр хөгжсөн ба улс төрийн хувьд харьцангуй тогтвортой орны тоонд багтдаг. Freedom House-ийн гаргасан судалгаагаар тус улс дэлхийн ардчилал, хүний эрхийн шалгуур үзүүлэлтээр тогтмол дээгүүр ордог бөгөөд улс төр, эдийн засаг, хууль дээдлэх ёс зэрэг шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан орны нэгд тооцогддог байна.³⁰ Норвеги Улсын Үндсэн хууль 1814 онд батлагдсан бөгөөд өнөөгийн байдлаар 206 жил хүчин төгөлдөр үйлчилж байна. Энэ

²¹ Luis, 9.

²² Elkins, Ginsburg, and Melton, *The Endurance of National Constitutions*, 21.

²³ Elkins, Ginsburg, and Melton, 44–45.

²⁴ Elkins, Ginsburg, and Melton, 177–78.

²⁵ Elkins, Ginsburg, and Melton, 74.

²⁶ Elkins, Ginsburg, and Melton, 162.

²⁷ Luis, 'Constitutions around the World', 9.

²⁸ <https://constituteproject.org/ontology/chronology?lang=en>

²⁹ Albert, 'The Difficulty of Constitutional Amendment in Canada', 91.

³⁰ <https://freedomhouse.org/country/norway/freedom-world/2020>

хугацаанд 81 удаа нэмэлт хийсэн.³¹ Тус улсын үндсэн хуулийн тогтвортой байдалд нэг талаас түүхэн урт хугацааны турш үндсэн хуулиа бүхэлд нь өөрчлөн шинэчлэхээс илүүтэйгээр тухайн цаг үеийн шаардлагад нийцүүлэн бага багаар, ойр ойрхон давтамжтайгаар нэмэлт, өөрчлөлт хийсэн. Түүнчлэн ардчилал, хүний эрх, төрийн эрх мэдлийн хуваарилалт зэрэг суурь зарчмын өөрчлөлтийг үндсэн хуульдаа аажмаар тусгаж ирсэн уламжлалтай холбон авч үздэг байна.³²

Нидерланд Улсын хувьд түүхэндээ 6 удаа буюу 1795, 1798, 1801, 1805, 1806, 1814 онд үндсэн хуулиа шинэчлэн баталж байсан. Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөж буй үндсэн хуулийн хувьд 1814 онд батлагдсан бөгөөд одоогоор 206 жил хүчин төгөлдөр үйлчилжээ. Тус улсын хувьд ардчиллын урт хугацааны түүхэн уламжлалтай боловч хөрш зэргэлдээ орнуудад газар нутгаа алдах, Европын орнуудын олон удаагийн дайн болон дотоодын зарим хямралт байдалд тохируулан үндсэн хуулийн томоохон өөрчлөлтийг хийж байсан. Үндсэн хуулийн үйлчлэх хугацаа ийнхүү тогтвортой байсан голлох шалтгааныг судлаачид дараах хүчин зүйлтэй холбон тайлбарлажээ. Энэ нь 1/ Тус улсын төрийн тогтолцооны суурь асуудалтай холбоотой томоохон өөрчлөлтийг хийхдээ нийгмийн өргөн төлөөллийг оролцуулсан зөвшилцөл дээр тулгуурласан; 2/ Нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хувьд харьцангуй хатуу; 3/ Үндсэн хуулийн агуулга, бичвэрийн хувьд нийгмийн суурь харилцааг зохицуулахад чиглэсэн буюу бэлгэдлийн шинжтэй зохицуулалт бага тусгасантай холбоотой гэж үздэг байна.³³ Үүнээс үзвэл Баруун Европын бүс нутгийн орнуудад үндсэн хуулийн тогтвортой байдал тухайн бүс нутгийн улс төрийн тогтвортой байдал, эдийн засгийн өндөр хөгжил, ардчиллын тогтвортой хөгжил зэрэг голлох хүчин зүйлээс шалтгаалжээ.

Хэдийгээр баруун Европын улсуудад үндсэн хуулийн тогтвортой байдал бусад бүс нутагтай харьцуулахад харьцангуй өндөр боловч энэ бүс нутгийн зарим оронд үндсэн хуулийн тогтворгүй байдал үүсэж байсан. Тухайлбал, Франц Улс анхны үндсэн хуулиа 1791 онд баталснаас хойш нийтдээ 15 удаа шинээр үндсэн хуулиа баталсан. Энэ хугацаанд төрийн тогтолцооны өөрчлөлт мөн гадаад болон дотоодын олон хүчин зүйлээс шалтгаалсан үндсэн хуулийн өөрчлөлт хийжээ.³⁴

Үндсэн хуулийн тогтвортой байдлын үзүүлэлтийн тухайд 1791-1815 оны хооронд ихээхэн тогтворгүй байсан бөгөөд энэ нь тухайн үеийн улс төрийн тогтворгүй байдлаас шалтгаалж байсан. Үүний шалтгааныг тухайн үеийн бүгд найрамдах засаглалын тогтолцоог дэмжигч радикал бүлгүүд ба үндсэн хуульт хаант төрийн тогтолцоог дэмжигч язгууртнуудын зөрчилдөөн

³¹ <https://www.constituteproject.org/>

³² '(PDF) Norway's Constitution in a Comparative Perspective', 223.

³³ http://comparativeconstitutionsproject.org/files/Netherlands_Implications_Report.pdf?6c8912

³⁴ Luis, 'Constitutions around the World', 14.



голлох нөлөө үзүүлж байсантай холбон үздэг. Тус улс 1815-1875 оны хооронд /1830, 1852, 1870, 1875/ улс төрийн тогтолцооны өөрчлөлт, тэр дундаа төрийн бүгд найрамдах засаглалд шилжих шилжилтийн нөлөөгөөр үндсэн хуулийн тогтворгүй байдал үргэлжилсэн. Ийнхүү удаан хугацааны улс төрийн тогтворгүй байдал, зөрчлийн улмаас үндсэн хуулийн тогтворгүй байдал үүссэний дараагаар буюу 1875-1940 оны хооронд 65 жилийн хугацаанд үндсэн хуулийн тогтвортой байдал үргэлжилжээ. Үүний дараа Дэлхийн II дайны үед 1940, 1946 онуудад үндсэн хуулиа дахин өөрчилж, улмаар 1958 онд одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй үндсэн хуулиа баталжээ.³⁵

Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөж буй үндсэн хуулийн тухайд 60 гаруй жилийн хугацаанд тогтвортой үйлчилж байгаа боловч энэ хугацаанд 16 удаа нэмэлт, өөрчлөлт орсон. Судлаачид Франц Улсын үндсэн хуулийн тогтворгүй байсан шалтгааныг ихэнхдээ улс төрийн тогтворгүй байдал, тэр дундаа улс төрийн дэглэм, төрийн байгуулал өөрчлөгдсөнтэй холбоотой авч үздэг байна.

2.2. Зүүн Европын бүс нутаг


Зүүн Европын бүс нутагт өнөөгийн байдлаар ОХУ, Чех, Польш, Унгар, Болгар, Украин зэрэг 20 гаруй улс оршиж байна. Эдгээр орны хувьд нийгэм, соёл, эдийн засаг, шашин шүтлэг зэрэг ялгаатай эрх зүйн соёлтой боловч 1990-ээд оноос хойш /ЗХУ задарсан/ тусгаар тогтнолоо зарласан нийтлэг зүйлээр ижилсэж байна. 1980-аад оны сүүлээр эхэлсэн ЗХУ-ын задрал, түүнтэй холбоотой үүссэн өөрчлөн байгуулалтууд нь дэлхийн улс төрийн газрын зурагт томоохон өөрчлөлт оруулсан. Үүнээс үүдэн Зүүн Европын бүс нутгийн улс төрийн нөхцөл байдал үндсээрээ өөрчлөгдсөн байдаг.

Тухайлбал, Дэлхийн II дайны дараагаас ЗХУ-тай нягт хамтарч байсан Польш, Унгар, Бүгд Найрамдах Ардчилсан Герман, Болгар, Чехословак, Румын зэрэг улс 1989 онд тусгаар тогтнолоо зарласан. Улмаар 1990 онд Албани, Югаслав тусгаар тогтнолоо зарлаж, 1991 оноос Балтын тэнгисийн эрэг орчмын улсууд болох Латви, Литви, Эстони тусгаар тогтнолоо зарласан. Мөн үүнээс гадна 1991 онд Словень, Хорват, Македониа тусгаар тогтносон.³⁶ Энэхүү бүс нутгийн орнууд тусгаар тогтнолоо зарласны дараахан дунджаар 1 жилийн хугацааны дотор үндсэн хуулиа боловсруулан баталсан ажээ. Эдгээр орны үндсэн хуулийн тогтвортой үйлчилж буй хугацаа өнөөгийн байдлаар 24 жил орчим байгааг дор графикт харуулав.

³⁵ Rogoff, 'A COMPARISON OF CONSTITUTIONALISM IN FRANCE AND THE UNITED STATES', 60.

³⁶ OECD, 'Constitutions of Central and Eastern European Countries and the Baltic States'.

Зураг 2. Зүүн Европын бүс нутгийн орны үндсэн хуулийн үйлчилж буй хугацаа



Дээрх зургаас үзвэл Зүүн Европын орнуудын үндсэн хуулийн хэрэгжих хугацаа ЗХУ задарсан онтой давхцаж байгааг харуулж байна. Ингээд эдгээр орноос жишээ болгон Польш Улсын үндсэн хуулийн хэрэгжих хугацаа, түүнд нөлөөлж байсан хүчин зүйлийн талаар тоймлон хүргэе.

Польш Улсын тухайд Европ тивийн анхны, АНУ-ын дараа дэлхийн хоёр дахь бичигдмэл үндсэн хуультай улсад тооцогддог. 1791 оноос хойш нийтдээ 9 удаа /1791, 1815, 1919, 1921, 1935, 1947, 1952, 1992, 1997/ үндсэн хуулиа өөрчилж, шинээр баталсан байна.³⁷ 1791 онд баталсан анхны үндсэн хуулийн тухайд тухайн үеийн Польшийн улс төрийн томоохон зөрчил дунд, ялангуяа гадаадын орны эзлэн түрэмгийллээс өөрийн тусгаар тогтнолоо олох, бататгах зорилгын хүрээнд батлагдсан. Энэ үед тухайн үеийн Хаант Орос, Прусс, Швед, Австри болон Унгарын хаант засаглалын нөлөөгөөр газар нутгийн тал хувийг алдаж, тусгаар тогтнолоо алдахад хүрч байсан цаг үетэй давхцадаг. Тус үндсэн хууль 5 жил хүчин төгөлдөр мөрдөж байсан боловч 1795 онд түдгэлзсэнээр эрх зүйн хүчин чадлаа алдаж 1815 онд дахин сэргээжээ.³⁸

Дэлхийн I дайны дараа буюу 1919, 1921 онд тус тус үндсэн хуулиа дахин баталсан. Энэхүү үндсэн хуулийн онцлог нь тухайн үеийн дайны дараах улсаа эмхлэн цэгцлэх, дотоодын хууль тогтоомжийн бодлогоо боловсруулан төлөвлөхөд чухал үүрэг гүйцэтгэжээ. Түүнчлэн тус үндсэн хууль нь Польш Улсын түүхэнд анх удаагаа хаант засгийг халах, төлөөллийн ардчиллын

³⁷ <https://constituteproject.org/ontology/chronology?lang=en>

³⁸ Cole, 'Poland's 1997 Constitution in Its Historical Context', 16.



зарчмыг нэвтрүүлснээрээ онцлогтой байв. Үүний дараа 1926 онд тус улсын Маршал Pilsudski зэвсэгт хүчний оролцоотойгоор төрийн эргэлт гаргаснаар дэлхийн хоёрдугаар дайн эхлэх хүртэл Маршал Pilsudski-ийн хяналт дор нэг намын удирдлагатай төрийн тогтолцоо үйлчилж байсан. Энэ хугацаанд тэрээр 1926 онд улс төр, эдийн засгийн бүх эрхийг хяналтандаа оруулах өөрчлөлтийг 1926 онд хийсэн. Түүнчлэн 1935 онд өөрийн бүрэн эрхээ баталгаажуулсан шинэ үндсэн хуулийг боловсруулан баталж байжээ.³⁹

Үүний дараа Дэлхийн II дайны үеэр ЗХУ ба Герман Улсын хоорондын нууц гэрээгээр /Molotov-Ribbentrop Pact of 1939/ Польшийн тусгаар тогтнолыг үгүйсгэсэн. Үүнтэй зэрэгцэн Герман Улсын удирдагч Адольф Гитлер 1939 онд Польш Улс уруу халдаж, эзэлснээр 1935 оны үндсэн хуулийн үйлчлэл дуусгавар болжээ. Энэ хугацаанд Польшийн Засгийн газар Франц Улсыг Гитлерийн Герман Улсад эзлэгдэх хүртэл Франц улсад орогнож, улмаар Лондон хот руу нүүсэн. Үүний дараа Польшийн Засгийн газар дэлхийн хоёрдугаар дайны дараа Герман Улсыг дайнд ялагдсаны дараа албан ёсоор нутагтаа буцаж ирсэн.⁴⁰

Дэлхийн II дайны дараа буюу 1947, 1952 онуудад Польш Улс үндсэн хуулиа дахин шинээр баталсан. Тус үндсэн хуулийн тухайд Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Орос Улс /ЗСБНХОУ/-ын нөлөөгөөр бүтээгдэж, социалист, коммунист хэв шинжийг хадгалсан агуулгатай болсон. Үүний дараа 1976, 1982, 1989 онд нэмэлт, өөрчлөлт хийж 1989 онд ЗСБНХОУ задрах хүртэл хүчин төгөлдөр үйлчилсэн. ЗСБНХОУ задарсны дараа ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих зорилготой шилжилтийн агуулгатай “бага” үндсэн хуулийг 1992 онд баталж, 1997 онд өнөөгийн үндсэн хуулиа баталжээ.⁴¹

1992 онд батлагдсан үндсэн хуулийн тухайд өмнө үйлчилж байсан социалист агуулгатай үндсэн хуулиас зарчмын хувьд эрс ялгаатай байсан бөгөөд ардчилсан тогтолцоог төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой болсон. Уг үндсэн хуулиар төрийн дээд эрх мэдэл болох Ерөнхийлөгч, Засгийн газар, Парламент хоорондын эрх мэдлийн хяналт, тэнцвэрийг хуваарилах, хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн өөрчлөлтийг хийсэн. 1992 оны шилжилтийн үндсэн хуулийг баталснаар ардчилал, хүний эрх, зах зээлийн эдийн засагт чиглэсэн төрийн тогтолцооны шинэчлэлийг хийхэд чухал үүрэг гүйцэтгэжээ.⁴² Үүний дараа 1997 онд анх удаагаа бүх нийтийн санал хураалт явуулж, санал хураалтад оролцсон иргэдийн 52.7 хувийн саналаар үндсэн хуулиа шинээр баталжээ. 1997 оны үндсэн хуулийн онцлогийн тухайд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн хяналт, тэнцвэрийг хангах, улмаар

³⁹ Cole, 'Poland's 1997 Constitution in Its Historical Context', 23–24.

⁴⁰ Cole, 'Poland's 1997 Constitution in Its Historical Context', 25.

⁴¹ Cole, 28.

⁴² Cole, 31.

хүний эрхийг баталгаажуулах, мөн орчин үеийн үндсэн хуульт ардчиллыг бий болгоход чухал ач холбогдолтой болсон.⁴³

Үүнээс үзвэл уг улсын үндсэн хуулийн хэрэгжилт, үйлчлэх хугацаанд гадны хүчин зүйл болох хөрш орны эзлэн түрэмгийлэл, зэвсэгт халдлага, Зүүн Европын бүс нутгийн улс төрийн тогтворгүй байдал гол төлөв нөлөөлсөн болох нь харагдаж байна.

2.3. Латин Америк ба Карибын бүс нутаг

Дэлхийн улсуудаас хамгийн олон удаагийн давтамжтайгаар үндсэн хуулиа өөрчилсөн бүс нутаг бол Латин Америкийн улсууд юм. Тус бүс нутагт Бразил, Чили, Доминикан, Куба, Гайти, Мексик, Венесуэль зэрэг 30 гаруй орон оршдог. Энэ бүс нутгийг ихэнхдээ ИБУИНВУ, Франц, Испани, АНУ зэрэг дэлхийн томоохон гүрнүүд колоничилж байсан боловч дийлэнх нь XVIII-XIX зуунд өөрийн тусгаар тогтнолоо зарласан. Иймээс эдгээр орон ихэвчлэн өнгөт хувьсгал, цэргийн эргэлт, улс төрийн дэглэмийн өөрчлөлт хийн өөрийн тусгаар тогтнолоо зарласан байдаг. Тухайлбал, Гайти Улс нь Францаас салж тусгаар тогтносонтой холбоотойгоор 1801 онд анхны үндсэн хуулиа баталжээ. Доминиканы Бүгд Найрамдах Улс нь Испани, Франц зэрэг улсын колони орон байсны дараа 1844 онд тусгаар тогтнолоо зарласан. Эквадор Улс нь Колумби ба Венесуэль Улсын колони орон байсны дараагаар 1822 онд тусгаар тогтносон. Куба Улс нь Испани Улсын колони байсны дараа 1868 онд өөрийн тусгаар тогтнолоо зарласан гэх мэт.⁴⁴


Профессор *Gabriel L. Negretto*-ийн хийсэн судалгаагаар 1900-2015 оны хооронд тус бүс нутагт нэг орон дунджаар 10.8 тооны үндсэн хууль баталжээ. Үүнийг Баруун Европын бүс нутагтай харьцуулбал үндсэн хуулийн тогтворгүй байдал 3 дахин өндөр байсныг харуулж байна.⁴⁵ Түүнчлэн тус бүс нутгийн орнуудын үндсэн хуулийн хэрэгжих хугацааг авч үзвэл 42 жил болж байгаа боловч Аргентин, Мексик, Коста Рика Улсаас бусад оронд үндсэн хуулийн үйлчлэл харьцангуй тогтворгүй байсныг харуулж байна.

⁴³ Cole, 'Poland's 1997 Constitution in Its Historical Context', 34.

⁴⁴ Luis, 'Constitutions around the World', 12-13.

⁴⁵ Түүний тооцоолсноор 1789-2015 оны хооронд Баруун Европын бүс нутагт оршиж буй 16 орон дунджаар 52 үндсэн хууль баталжээ. Үүнийг дундажлан авч үзвэл нэг улс дунджаар 3.2 үндсэн хууль баталжээ. <https://www.idea.int/publications/catalogue/constitution-building-processes-latin-america>

Зураг 3. Латин Америк ба Карибын бүс нутгийн орнуудын үндсэн хуулийн үйлчлэх хугацаа



Энэхүү зургаас үзвэл Аргентин, Мексик Улсуудад үндсэн хуулийн тогтвортой байдал өндөр, харин Доминиканы Бүгд Найрамдах Улс, Гайти, Боливи, Венесуэль, Эквадор, Куба зэрэг оронд үндсэн хуулийн үйлчлэх хугацаа харьцангуй сул байгааг харуулж байна. Энэхүү бүс нутгийн үндсэн хуулийн үйлчлэл ямар учраас тогтворгүй байсан талаар дор дэлгэрүүлэн авч үзье.

Латин Америкийн бүс нутгийн орнуудад үндсэн хуулийг бүтээх үйл явц 1940-1990 оны хооронд эрчимтэй өрнөсөн. Энэ бүс нутагт ихэвчлэн цэргийн болон авторитар дэглэмээс ардчилалд шилжих процесс болсноос шалтгаалан үндсэн хуулийг өөрчлөх, шинээр батлах үйл явдал өрнөжээ. Тухайлбал, Эквадор Улсад 1978 онд, Бразил Улсад 1985-1988 оны хооронд, Венесуэль Улсад 1958-1961 оны хооронд цэргийнхэн ба ардчиллыг дэмжигчдийн хооронд үндсэн хуулийн зөвшилцөл хийгдсэн байдаг.⁴⁶

Профессор *Gabriel Negretto*-ийн судалгаандаа Латин Америкийн улсуудын үндсэн хуулийн тогтворгүй байдалд хүргэж буй голлох хүчин зүйлд 1/ Үндсэн хуулийн өөрийн дизайн, тэр дундаа үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах журам тодорхойгүй; 2/ Улс төрийн дэглэмийн өөрчлөлт хийх эрх зүйн орчин тодорхойгүй; 3/ Улс төрийн хүчнүүдийн тайван замаар эрх мэдлээ шилжүүлэх шилжилтийн журам бүрхэг байсан зэрэг томоохон хүчин зүйл нөлөөлсөн гэж дурджээ. Түүний цуглуулсан мэдээллээр 1946-2000 оны хооронд Латин Америкийн орнуудын үндсэн хуулийн өөрчлөлтийн 66 хувь нь улс төрийн тогтворгүй байдал, ялангуяа цэргийн эргэлт, иргэдийн зөрчилдөөн, хувьсгалт тэмцэл нөлөөлсөн

⁴⁶ <https://www.idea.int/publications/catalogue/constitution-building-processes-latin-america>

гэж үзжээ.⁴⁷ Үүнээс үзвэл Латин Америкийн бүс нутгийн орнуудын үндсэн хуулийн тогтворгүй байдалд улс төрийн хүчнүүдийн зөрчил, ялангуяа цэргийн эргэлт, иргэний дайн, хувьсгалт тэмцэл нөлөөлсөн болох нь харагдаж байна. Латин Америкийн бүс нутгийн орнуудаас Гайти улсыг төлөөлөл болгон дор дэлгэрүүлэн бичье.

1492 онд Итали Улсын гаралтай далайчин Христофер Колумб Карибын тэнгисийн эргийн ойролцоо Хиспаниола /Hispaniola/ хэмээх арлыг нээсэн. Тус арлыг нээж илрүүлснээр Испаничууд өөрийн нутаг дэвсгэр хэмээн зарлаж, колоничлох бодлого явуулсан. Гэсэн хэдий ч 16 дугаар зуунаас Франц Улс уг арлын зарим хэсэгт өөрийн хяналтаа тогтоосноор уг аралд Испани болон Францын хоёр өөр хэл, соёл бүхий /Доминканы Бүгд Найрамдах Улс ба Гайти/ Улс бий болох эхлэл тавигдсан. Тухайн үед Испани болон Франц Улсууд уг арлыг эзэмшихийн төлөө өрсөлдөж байсан бөгөөд үүндээ нутгийн иргэдийг талцуулах бодлого явуулсан. Үүний нөлөөгөөр Доминиканы Бүгд Найрамдах Улс ба Гайти гэх улс бүрэлдэж, тухайн орнууд дайтах, найрамдах, нэгдэх зэргээр хамт оршин тогтнож байгаад 18 дугаар зуунаас тус тусын тусгаар тогтнолоо зарласан түүхтэй.⁴⁸ Ийнхүү хоёр өөр орон болон хуваагдсантай холбоотойгоор эдгээр орон өөрийн үндсэн хуулиа боловсруулан батлах үйл явц эхэлсэн.

Профессор Zachary Elkins нарын хийсэн судалгаагаар Латин Латин Америкийн бүс нутгийн орнуудад үндсэн хуулийн тогтворгүй байдал бусад бүс нутагтай харьцуулахад өндөр байдаг тухай дээр дурдсан билээ. Тухайлбал тэдгээр эрдэмтдийн судалснаар дэлхий дээр 2005 оны байдлаар 935 үндсэн хууль батлагдаж байсны 7 хувь нь Гайти болон Доминиканы Бүгд Найрамдах Улсад батлагдаж байжээ. Өөрөөр хэлбэл эдгээр улсад үндсэн хуулийн үйлчлэх хугацаа 7-8 жил тутамд өөрчлөгдөж байжээ.⁴⁹ Ингээд Гайти Улсын талаар дор товч жишээ болгон авч үзье.

Гайти Улсын анхны хувьсгалт үндсэн хууль 1801 онд батлагдсан. Үүний дараа 1804 онд өөрийн тусгаар тогтнолоо зарлаж, 1805, 1806 онд тус тус үндсэн хуулиа шинээр өөрчилсөн. Эдгээр үндсэн хуульд хүний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, арьсны өнгө ялгаварлан гадуурхахгүй байх, хувийн өмчийн халдашгүй байдал зэргийг баталгаажуулсан. Түүнчлэн 1805 оны Үндсэн хуулиар Сенатын гишүүдийг 24 тоотой бөгөөд нийтдээ 9 жилийн хугацаагаар томилохоор тусгаж байжээ. Мөн Сенатын гишүүдийн гол үүрэг бол хууль тогтоохоос гадна гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын гишүүдийг 4 жилийн хугацаагаар томилох үүргийг хүлээж байсан.⁵⁰

⁴⁷ https://www.researchgate.net/publication/292476039_The_durability_of_constitutions_in_changing_environments_Explaining_constitutional_replacements_in_Latin_America

⁴⁸ Wise and Díaz-Garayúa, 'The Island of Hispaniola'.

⁴⁹ Elkins, Ginsburg, and Melton, *The Endurance of National Constitutions*, 179.

⁵⁰ Elkins, Ginsburg, and Melton, 181.



Хэдий тийм боловч 1806 оны үндсэн хуульд өмнөх удирдагчийн залгамжлагч Henri Christophe Үндсэн хуулийн ассамблейг хуралдуулж Сенатын зарим бүрэн эрхийг Тус улсын Ерөнхийлөгчид шилжүүлэх өөрчлөлтийг хийсэн. Энэ нь үндсэн хуулийн үйлчлэл тогтворгүй болох эхлэл тавигдсан. Үүнийг эсэргүүцэж тус улсын өмнөд бүс нутагт Alexandre Petion өөрийн тусдаа үндсэн хуулийг зарлан тунхагласан. Үүний дараа 1816 онд Үндсэн хуулийг дахин шинээр баталсан. Энэ нь 1806 онд батлагдсан үндсэн хуулийн загвар дээр тулгуурлаж байсан бөгөөд Ерөнхийлөгчийн бүрэн эрх 4 жил байх тухай заалтыг өөрчилж бүх насаараа томилогдох эрхтэй болгон өөрчилсөн. Үүний үр дүнд Сенатаас Alexandre Petion-ийг бүх насаар нь томилж, өөрийн залгамжлагчаа тодруулах эрхийг олгосон боловч тэрээр 1816 онд нас барсан. Үүний дараа түүний залгамжлагчаар Jean-Pierre Boyer тодорч өмнөх удирдагч нарын адил бүх насаараа Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, мөн өөрийн залгамжлагчаа тодруулах эрх мэдэлтэй болсон байна.⁵¹

Түүний хувьд эрх мэдлээ авсны дараагаар 1820 онд нутгийн зүүн хэсэгт орших Доминиканы Бүгд Найрамдах Улсыг өөрийн захиргаанд нэгтгэсэн боловч Гайти болон Доминиканы хамтарсан цэргийн хүчинд ялагдаж, улс төрийн тогтворгүй байдал дахин бий болсон. Үүний улмаас үндсэн хуулийн тогтворгүй байдал үргэлжилж, Гайти Улс 1843, 1849 онд үндсэн хуулиа дахин өөрчилсөн.

Ийнхүү Ерөнхийлөгч болон Сенатын эрх хэмжээг хэрхэн хуваарилах асуудлыг шийдэж чадалгүй явсаар 1911 онд улс төрийн тогтворгүй байдал дахин газар авч 4 жилийн хугацаанд зургаан Ерөнхийлөгч томилогдож эдгээрийн ихэнх нь бусдад алагдах эсхүл гадагшаа хүчээр цөлөгджээ. Энэ хугацаанд өмнөх Ерөнхийлөгч Jean-Pierre Boyer болон бусад Ерөнхийлөгч нарын Францад тавьсан өр төлбөрүүдээ барагдуулахад боломжгүй болж, тусгаар тогтнолоо алдах нөхцөл байдал үүсжээ. Үүний дараа Герман, АНУ, Их Британи зэрэг улсууд тус улсад аажмаар нөлөөгөө тогтоох үүднээс эдийн засгийн болон цэрэг зэвсгийн тусламж үзүүлж ирсэн. Ийнхүү нэгдүгээр дайны үеэс буюу 1915-1934 оны хооронд 19 жилийн хугацаанд АНУ тус улсад нөлөөгөө тогтоожээ.⁵²

Ингээд 1932, 1935 онд үндсэн хуулиа дахин өөрчилсөн боловч эдгээр үндсэн хуульд хууль тогтоох болон шүүх эрх мэдлийг Ерөнхийлөгчид дэмжлэг үзүүлэх, хавсарга байдлаар тусгасаар иржээ. Улмаар 1946 онд Dumarsais Estime цэргийн эргэлт хийж үндсэн хуулиа дахин өөрчилж, эрх мэдлийн хуваарилалт, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хугацааны хязгаарлалт тогтоож, иргэний болон улс төрийн эрхийг хуульчлан сэргээсэн. Гэсэн хэдий боловч

⁵¹ Elkins, Ginsburg, and Melton, 181–82.

⁵² Elkins, Ginsburg, and Melton, 181–82.

1949 онд тэрээр өөрийн сонгогдох эрхээ нэмэгдүүлэхийг оролдож, үүнийг улс төрийн өөр нэгэн хүчин эсэргүүцсэн.

Ийнхүү 1950 онд өөр нэгэн цэргийн эргэлт гарсны улмаас тэрээр дахин сонгогдож чадаагүй. Үүний дараа 1950 оноос Генерал Paul Magloire-ийн диктатур эхэлж 1956 онд түүнийг хүчээр огцруулсан. Хэсэг хугацааны дараа 1957 оны 9 дүгээр сард сонгууль явуулж, Dr. Francois Duvalier-ыг 7 жилийн хугацаатай дахин сонгогдох боломжгүй байхаар томилсон. Тэрээр Ерөнхийлөгч байх хугацаандаа өөрийгөө бүх насаар сонгогдох боломжтой болгох өөрчлөлтийг 1964 оны үндсэн хуульд тусгаж чадсан боловч 1971 онд нас барсан. Түүнийг нас барсны дараа түүний хүү болох 19 настай “Baby Doc” хочтой, Jean-Claude Duvalier залгамжилсан аж. 1983 оноос түүнийг эсэргүүцсэн эсэргүүцэл эхэлж, 1986 оны хоёрдугаар сард тэрээр огцорч, цөлөгджээ.⁵³

Ингээд 1987 онд ардчилсан шинэ үндсэн хуулийг батлах эхлэл тавигдсан. Уг үндсэн хуулиар хоёр танхимтай парламенттай, Ерөнхийлөгчийг сонгох бөгөөд Ерөнхий сайд, кабинетийн гишүүд, сайд нар, дээд шүүхийн шүүгчдийг Парламентаас Ерөнхийлөгчтэй зөвшилцөж байхаар тогтоосон. Хэдийгээр ардчиллын элементийг агуулсан үндсэн хуулийг 1987 онд баталж чадсан боловч бүх нийтийн сонгуулиар сонгогдсон харизмтай улс төрч, сүмийн номлогч Jean-Bertrand Aristide 1990 онд үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийсэн байна. Үүнийг цэргийнхэн эсэргүүцэж 1991 онд цэргийн эргэлт гарч өмнөх үндсэн хуулийн үйлчлэлийг зогсоожээ. Үүний дараа 1994 онд АНУ-ын зэвсэгт хүчин тус улсын газар нутагт нэвтэрч өмнөх Ерөнхийлөгч болох сүмийн номлогч Jean-Bertrand Aristide-ыг буцаан томилсон байна. Ингээд түүний бүрэн эрх 1996 онд дуусаж, бүрэн эрхийн хугацаа нь дууссан Ерөнхийлөгчийн улс төрийн түнш Rene' Preval Ерөнхийлөгчөөр сонгогдсон. Ийнхүү Гайти Улсад анх удаагаа бүх нийтээр сонгогдсон Ерөнхийлөгч нар бие биедээ тайван замаар эрх мэдлээ шилжүүлэх үйл явдал 200 жилийн дараа тохиожээ.⁵⁴

Үүнээс үзэхэд Латин Америкийн бүс нутгийн орнууд, тэр дундаа Гайти Улсын туршлагаас харахад Үндсэн хуулийн тогтвортой байдалд Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа болон Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг тайван замаар шилжүүлэх асуудал маш чухал ач холбогдолтой болохыг харуулж байна. Түүнчлэн үндсэн хуулийг боловсруулан батлахдаа цаашид нэг намын, нэг улс төрчийн, мөн цэргийн диктатур үүсэхгүй байхаар тооцоолж батлах шаардлагатай болохыг харуулж байна.

2.4. Ойрх дорнод ба Хойд африкийн бүс нутаг

Ойрх дорнод ба Хойд африкийн бүс нутагт 19-20 орчим улс /дэлхийн хүн амын 6 хувь/ байдаг боловч энэ бүс нутагт дэлхийн нийт газрын тосны 60

⁵³ Elkins, Ginsburg, and Melton, 181–82.


⁵⁴ Elkins, Ginsburg, and Melton, 182.

хувь, байгалийн хийн 45 хувийг эзэлдэг. Ийм учраас энэ бүс нутаг нь дэлхийн газрын тосны нийлүүлэлтэд тогтвортой үүрэгтэй оролцож, улмаар дэлхийн эдийн засгийн тогтвортой байдалд ч мөн чухал үүрэгтэй оролцдог бүс нутаг гэж тооцогддог байна.⁵⁵

Энэхүү бүс нутгийн орнуудын онцлог бол газрын тосны нөөц баялгаа хэрхэн зохистой ашиглах, уг нөөцөд хэн хяналтаа тогтоох тухай асуудал байдаг. Үүнээс шалтгаалан улс төрийн тогтвортой байдал, тэр дундаа үндсэн хуулийн тогтвортой байдал хангагддаг. Тухайлбал, Саудын Араб, Кувейт, Арабын Нэгдсэн Эмират Улс, Катар, Иран зэрэг оронд эдийн засгийн өндөр чадавхтай, үүнийгээ дагаад үндсэн хуулийн тогтвортой байдал бий болсон байдаг. Харин эсрэгээрээ газрын тосны нөөц баялгаа зөв ашиглаж чадаагүй дотоодын үймээн самуун, иргэний дайны хөлд нэрвэгдсэн Ирак, Йордан, Ливи, Сири, Палестин, Афганистан зэрэг оронд үндсэн хуулийн үйлчлэх хугацаа тогтворгүй, сул байдаг ажээ.⁵⁶

Мөн түүнчлэн энэхүү бүс нутгийн орнуудын өөр нэгэн онцлог бол эдгээрийн ихэнх нь Исламын шашны хатуу итгэл үнэмшил дээр суурилсан эрх зүйн тогтолцоотой холбоотой. Мөн үүнээс гадна үндсэн хуулийн шинжтэй эрх зүйн баримт бичгээ Исламын шашинд нийцүүлэн баталсан байдаг.⁵⁷ Иймээс эдгээр орны улс төрийн тогтвортой байдал дээр дурдсан байгалийн асар их баялаг болон нэг Исламын шашны хоёр өөр урсгалын хоорондын зөрчлийг хэрхэн шийдвэрлэж байгаа эсэхээс голчлон хамаарч байна. Үүнээс үүдэн тухайн улсын үндсэн хуулийн тогтвортой байдал хамаардаг ажээ.

Зураг 4. Ойрх дорнод ба Хойд африкийн бүс нутгийн орнуудын үндсэн хуулийн үйлчлэх хугацаа



⁵⁵ 'MENA Region Countries List 2020 Update'.

⁵⁶ Chen, 'Middle East and North Africa (MENA)'.

⁵⁷ Энэхүү бүс нутагт Израйил Улсаас бусад оронд Исламын шашны Сунни болон Ши'a урсгалыг баримталдаг байна. <http://istizda.com/mena-region/>

Энэхүү зургаас үзвэл тус бүс нутгийн орнуудын үндсэн хуулийн үйлчлэх хугацаа дунджаар 32 жил болж байгаа боловч Ливан, Кувейт, Йордан, Израйль,⁵⁸ Турк, Арабын Нэгдсэн Эмират Улсад үндсэн хуулийн тогтвортой байдал харьцангуй өндөр байгааг харж болно. Харин дотоодын үймээн самуун, иргэний дайны хөлд нэрвэгдсэн Ирак, Ливи, Сири, Палестин, Афганистан зэрэг оронд үндсэн хуулийн тогтвортой байдал сул байгааг харуулж байна.

Freedom House-ийн 2019 оны судалгааны тайланд Ойрхи дорнод ба Хойд африкийн бүс нутгийн орнуудаас зөвхөн Тунис ба Израйл Улс ардчилсан бөгөөд эрх чөлөөтэй гэсэн ангилалд хамаарч байсан аж. Харин эдгээрээс бусад орны тухайд ардчилал сул, ихэнхдээ авторитар дэглэмд хамаарчээ. Тухайлбал, Морокко, Кувейт, Йордан, Катар, Саудын Араб зэрэг оронд өнөөг хүртэл хүчтэй хаант засаг хэвээр байсаар байна. Хааны зүгээс бүх нийтээс сонгогдсон парламентын гишүүдэд шахалт үзүүлэх замаар засгийн газрын кабинетийн гишүүдийг томилоход оролцох явдал гарсаар байдаг.⁵⁹

Энэхүү бүс нутгийн орнуудын үндсэн хуулийн тогтвортой байдал ба үйлчлэх хугацаа тухайн орнуудын төрийн тэргүүн болох хаан эсхүл тухайн дэглэмийн удирдагч нараас ихээхэн шалтгаалдаг. Өөрөөр хэлбэл тухайн улсын диктатурыг тогтоож байгаа удирдагч нарын бүрэн эрхийн хугацаа дуусах, өөрчлөгдөх байдалтай холбогддог байна. Тухайлбал, Ливи Улсын их удирдагч Каддафи 1977 оноос төрийн эрхийг гартаа авсан боловч 2011 онд арабын хаврын улс төрийн тогтворгүй байдлын нөлөөгөөр эрх мэдлээ алдсан. Иракийн их удирдагч Саддам Хусейн 1979 оноос диктатур тогтоож байсан боловч 2003 онд эрх мэдлээ алдсан зэрэгтэй холбоотойгоор үндсэн хуулийн өөрчлөлт оруулсан. Өнөөгийн Сири Улсад энэ байдал давтагдах магадлал өндөр болж байна.

Үүнээс үзэхэд Ойрх дорнод болон Хойд Африкийн бүс нутгийн орнуудын үндсэн хуулийн тогтворгүй байдал эдгээр орны исламын шашны өөрийн өвөрмөц онцлогоос гадна тухайн улсуудын улс төрийн дэглэм, тэр дундаа бүс нутгийн өөрийнх нь онцлог болох байгалийн нөөцөө хэрхэн зөв ашиглах, түүний маргаантай байдал, улс төрийн шахалт зэргээс шалтгаалдаг болох нь харагдаж байна.

2.5. Төв ба Өмнөд африкийн бүс нутаг /Sub-Saharan Africa/

Төв ба Өмнөд африкийн бүс нутаг нь газар зүйн байршлын хувьд сахарын цөлөөс урагш орших Африк тивийн 40 гаруй улсыг хамааруулдаг.⁶⁰ Энэхүү бүс нутгийн орнуудын ихэнх нь Их Британи, Франц, Герман, Португали, Итали

⁵⁸ Израйл Улсад албан ёсны бичигдмэл үндсэн хууль байхгүй боловч 1948 оноос хойш Үндсэн хуулийн үйлчлэл бүхий 14 хууль хүчин төгөлдөр мөрдөж байна.

⁵⁹ https://freedomhouse.org/sites/default/files/2020-02/FIW_2020_REPORT_BOOKLET_Final.pdf

⁶⁰ Ойрх дорнод ба хойд африкт хамаарах Алжери, Жибути, Египет, Ливи, Морокко, Сомали, Судан, Тунис зэрэг Исламын шашинтай, араб хэлээр гол төлөв ярьдаг орнууд энэ бүс нутагт хамаардаггүй.



зэрэг орны колони байсан бөгөөд 1950-1960 оны үед тусгаар тогтнолоо зарлажээ.⁶¹ Энэхүү бүс нутгийн орнууд тусгаар тогтнолоо зарласнаас хойших хугацаанд үндсэн хуулиа батлах эхлэл тавигдсан. Энэ үйл явц 1960-аад оноос эхэлсэн ба үндсэн хууль боловсруулан батлах үйл явц өмнөх колончлогдож байсан эсхүл бусад гаднын орны нөлөө, оролцоотойгоор хийгдэж байсан.⁶² Тухайлбал, Их Британийн Колони байсан орнууд Английн парламентын Вестминстер загварыг ашиглах нь түгээмэл байсан бол Францын колони байсан орнууд 1958 оны Францын үндсэн хуулийг загвар болгон ашиглажээ.⁶³

Африкт тивд үндсэн хууль батлах эхний үйл явц 1960-аад оноос эхэлсэн боловч 1970-1980 оноос улс төрийн авторитари дэглэм ба нэг намын ноёрхлын нөлөөгөөр удаан үргэлжлээгүй. Үүнд тухайн үеийн эдийн засгийн хямрал, улс төрийн тогтворгүй байдал нөлөөлж байв. Тухайлбал 1974 оны олон улсын газрын тосны хямрал гэх мэт.⁶⁴ Үүний дараа 1989 оноос ЗХУ задарсантай холбоотойгоор дэлхий дахинд хүйтэн дайн дуусаж, ардчилал, зах зээлийн эдийн засгийн хүчин зүйл африк тивийн орнуудад мөн адил нөлөөлөв. Үүний үр дүнд үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах үйл явц хүчтэй өрнөжээ. Түүнчлэн 2010 оноос Хойд Африкийн бүс нутгийн /Арабын хавар/ улс төрийн тогтворгүй байдал Африкийн орнуудын үндсэн хуулийн тогтвортой байдалд нөлөөлж эхэлсэн. Тухайлбал, 2010 оноос Кени Улс, Өмнөд Судан, Зимбабве /2013/ зэрэг улсууд үндсэн хуулиа шинэчлэн өөрчилжээ. Түүнчлэн өнөөгийн байдлаар үндсэн хуулиа өөрчлөх талаар Танзани, Замби, Либери, Малави, Гана, Нигери зэрэг улс хэлэлцүүлэг өрнүүлж байна.⁶⁵

Африкийн орнуудад 1990-ээд оноос хойш явуулж буй үндсэн хуулийн өөрчлөлт нь ардчилал, хүний эрх, өмчийн эрх зэрэг үндсэн хуулийн суурь зарчмыг тусгаж байсан онцлогтой боловч практикт үүнийг хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэл бэрхшээл тулгарч байгаа аж. Тухайлбал, ардчиллын олон ургальч үзэл, тэр дундаа олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрөх, сонгуулийн ил тод, нээлттэй тогтолцоог нэвтрүүлэх зорилт тулгамдсан асуудал болж байна. Мөн Африкийн улсуудын өөрийн өвөрмөц байдал, тэр дундаа тухайн орон нутгийн угсаатны хуваагдал, овог хоорондын зөрчил зэрэг асуудлаас үүдэн үндсэн хуулийн суурь зарчмыг хангахад томоохон сорилт тулгарсаар байна.⁶⁶ Түүнчлэн Африкийн орнуудын үндсэн хуулийн өөрчлөлтийн өөр нэгэн сорилт бол Ерөнхийлөгчийн бүрэн эрх, түүний хугацааны хязгаарлалт, мөн зэвсэгт хүчний эрх зүйн байдал, үндсэн хуулийн байгууллагуудын хараат бус байдал, түүнийг томилох, сонгох, огцруулах үйл

⁶¹ <https://www.encyclopedia.com/social-sciences/encyclopedias-almanacs-transcripts-and-maps/africa-british-colonies>

⁶² Hessebon, "THE FOURTH CONSTITUTION-MAKING WAVE OF AFRICA: CONSTITUTIONS 4.0?", 186.

⁶³ "Hessebon - THE FOURTH CONSTITUTION-MAKING WAVE OF AFRICA CON.Pdf", 187.


⁶⁴ Hessebon, "THE FOURTH CONSTITUTION-MAKING WAVE OF AFRICA: CONSTITUTIONS 4.0?", 188.

⁶⁵ Hessebon, 188-89.

⁶⁶ Hessebon, 196.

ажиллагаа тулгамдсан асуудал болсоор байна.⁶⁷ Африкийн орнуудын үндсэн хуулийн үйлчлэх хугацааг дор зургаар харуулъя.

Зураг 5. Төв ба Өмнөд африкийн бүс нутгийн орнуудын үндсэн хуулийн үйлчлэх хугацаа



Энэхүү зургаас үзвэл Төв ба Өмнөд Африкийн улсуудын үндсэн хуулийн үйлчлэх хугацаа дунджаар 22 жил байгаа болохыг харуулж байна. Гэсэн хэдий боловч Ботсвана, Камерун, Мавриани, Руанда, Свазиленд улсад үндсэн хуулийн үйлчлэх хугацаа арай өндөр буюу 40-өөс дээш жил байгаа болохыг харуулж байна. Нөгөө талаар Төв Африкийн Бүгд найрамдах Улс, Бүгд Найрамдах Конго Улс, Нигери, Этиофид 6-8 удаа үндсэн хуулиа шинэчлэн өөрчилжээ. Энэ нь 1950-1960 оноос хойш тус тус тусгаар тогтносон хугацаатай харьцуулбал үндсэн хууль ихээхэн сул байсныг харуулж байна.

Үүнд африкийн ихэнх орнуудын үндсэн хуулийн эрх зүйн соёл бүрэлдээгүй, төрийн тэргүүний бүрэн эрхий хугацааны хязгаарлалт, томилох, сонгох журам сул, мөн үндэстэн, угсаатны хоорондын зөрчил, зэвсэгт хүчин, тэр дундаа цэргийн эргэлт гарах нөхцөл боломжийг үндсэн хуулийн аргаар зохицуулах чадвар сул байгаатай холбон авч үздэг байна.⁶⁸

2.6. Өмнөд Азийн бүс нутаг


Өмнөд Азийн орнуудад Бангладеш, Бутан, Энэтхэг, Мальдив, Балба, Шри Ланка зэрэг орон хамаардаг. Нутаг дэвсгэрийн хувьд дэлхийн гадаргын 3.5 хувийг эзэлдэг боловч дэлхийн нийт хүн амын тавны нэг амьдардаг онцлогтой. Шашин шүтлэгийн хувьд Буддизм, Хинди, Исламын шашин

⁶⁷ African Constitutions', 191.

⁶⁸ 'African Constitutions'.

зонхилдог. Эдгээр орноос жишээ татвал Энэтхэг, Пакистан, Шри Ланка зэрэг орнуудыг Их Британи Улс колончилж байсан онцлогтой. Гэсэн ч 1947 оны үед өөрсдийн тусгаар тогтнолоо тус тус зарласан онцлогтой.⁶⁹ Улс төрийн дэглэмийн хувьд Пакистан Улс цэргийн дэглэмтэй, Балба Улс хаант засагтай, Энэтхэг, Шри Ланка Улс ардчилсан дэглэмтэй.⁷⁰ Энэхүү бүс нутгийн үндсэн хуулийн үйлчлэх хугацаа дунджаар 33 жил байгаа боловч үндсэн хуулийн тогтвортой байдал Энэтхэг Улсад хамгийн өндөрт /71 жил/ тооцогдож байна. Ингээд энэхүү бүс нутгийн орнуудын үндсэн хуулийн үйлчлэх хугацааг дор зургаар харуулъя.

Зураг 6. Өмнөд Азийн бүс нутгийн орнуудын үндсэн хуулийн үйлчлэх хугацаа



Энэхүү зургаас үзвэл Энэтхэг, Бангладеш, Пакистан, Шри Ланка зэрэг улсад үндсэн хууль 40-өөс дээш жил үйлчилж байгааг харж болно. Харин Бутан, Мальдив, Балба зэрэг улс 2000 оноос хойш үндсэн хуулийн шинэчлэл явагдсан болох нь харагдаж байна. Ингээд эдгээр орны үндсэн хуулийн үйлчлэх хугацааны талаар дор товчхон авч үзье.

Энэтхэг Улсын хувьд Их Британийн колоничлолоос 1946 онд гарч, 1947 онд тусгаар тогтнолоо зарласан тухай дээр дурдсан. Ийнхүү тусгаар тогтнолоо зарласнаас хойш 2 жил гаруй хугацаанд үндсэн хуулиа боловсруулах ажил өрнөж, 1949 оны 11 дүгээр сард баталсан аж. Үндсэн хуулиар холбооны улсын болон Парламентын Вестминстер загварыг сонгож авсан. Тус улсад үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хувьд харьцангуй уян хатан шинжтэй зохицуулалтыг сонгосон бөгөөд анх баталснаас хойш нийтдээ 104 удаа нэмэлт, өөрчлөлт хийжээ.⁷¹ Ийнхүү судлаачид тус улсын үндсэн хуулийн тогтвортой байдлыг нэг талаас тухайн үндсэн хуулийн өөрийн онцлог болох уян хатан үндсэн хуультай холбон тайлбарладаг бол нөгөө талаас үндсэн хуулийн үндсэн бүтцийн онолтой холбон авч үздэг байна.

⁶⁹ Malla and Hassan, 'Mapping the Transformative Constitutionalism and the Participation and Representation of Minorities in South Asia', 2.

⁷⁰ 'CONSTITUTIONAL RESILIENCE IN SOUTH ASIA'.

⁷¹ 'Constitutional History of India'.

Шри Ланка Улсын хувьд Их Британи Улсын харьяанд байхдаа 1931, 1947 онд хоёр удаа үндсэн хуулиа баталж байв. Эдгээр үндсэн хуулийн тухайд Их Британи Улсын эрх зүйн тогтолцооны загварыг жишиг болгож байсан боловч 1972 оноос өөрийн өвөрмөц онцлогт нийцсэн үндсэн хуулийг 1978 онд баталжээ. Энэхүү үндсэн хууль өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд хүн амын дундах голлох үндэстний эрх ашгийг харгалзан баталсан байдаг. Үндсэн хууль батлагдсанаас хойших 40 гаруй жилийн хугацаанд нийтдээ 10 орчим нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэхүү үндсэн хуулийн хувьд төрийн зонхилох шашнаар буддын шашныг тунхагласан бөгөөд иргэний суурь эрхийг хангах, төрийн үүрэг, оролцооны талаар тусгасан. Улс төрийн тогтолцооны хувьд өнгөн талдаа хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл болгон хуваарилсан боловч гүйцэтгэх эрх мэдэл, тэр дундаа Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг илүү тусгасан байна. Ерөнхийлөгчийн хувьд Ерөнхий сайд, түүний кабинетыг томилоход оролцох мөн Дээд шүүхийн ерөнхий шүүгч болон бусад шүүхийн шүүгчдийг томилоход өргөн эрх мэдлийг олгосон байна.⁷² Үүнээс үүдэн төрийн тогтолцоон дахь авлига, албан тушаалын гэмт хэргүүд өсөж, иргэдийн эрх, эрх чөлөөг зөрчих явдал түгээмэл байдаг аж.⁷³

Бангладеш Улсын тухайд хагас зууны турш /1971 он хүртэл/ Пакистан Улсын нэг хэсэг болж байгаад 1971 онд өөрийн тусгаар тогтнолоо зарлажээ. 1972 онд анх үндсэн хуулиа баталж, 1986, 2014 онд шинэчлэн найруулга хийжээ. Тус улс тусгаар тогтнолоо зарлахаас өмнөх 9 сарын хугацаанд өөрийн улсын эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөх тэмцэл хийж байсны улмаас эдийн засгийн болон улс төрийн олон саад бэрхшээл тулгарч байжээ. 1972 оны үндсэн хуулийн тухайд ардчилал, чөлөөт зах зээлийн хэв шинжийг бүрдүүлэн баталж, үүний дагуу анхны сонгуулиа хийсэн байна. Сонгуулийн үр дүнд “*Awami League*” улс төрийн хүчин парламентын 300 төлөөлөгчийн 292 суудлыг авч дийлэнх олонх болов. Энэ хугацаанд улсын эдийн засаг суларч, төрийн шат шатанд авлига, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг өсөж иргэдийн итгэл суларч эхэлсэн.⁷⁴ Үүний дараа улс төрийн хүчнүүдийн дундах томоохон зөрчил гарч Ерөнхий сайд *Sheikh Mujibur Rahman* алагдаж, түүний оронд Зэвсэгт хүчний командлагч Генерал *Ziaur Rahman* Ерөнхийлөгчөөр сонгогдсон байна. Ийнхүү урт удаан хугацааны цэргийн болон нэг намын дарангуйлал эхлэх үйл явц эхэлсэн. Үүний нөлөөгөөр үндсэн хуулийн үйлчлэлийг 1982 онд түдгэлзүүлж 1986 онд сэргээсэн. Ийнхүү удаан хугацааны улс төрийн тогтворгүй байдлын дараа 1991 оноос ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих оролдлого хийсэн боловч энэ нь шашин хоорондын зөрчил болон бусад олон шалтгаанаас болон бүтэлгүйтсэн ажээ.⁷⁵

⁷² ‘Constitutional History of Sri Lanka’.

⁷³ ‘SAHR_Citizens_Voices_Report_2016_revised-3.Pdf’, 21.

⁷⁴ Rizvi, ‘Democracy & Constitutionalism in South Asia’, 27.

⁷⁵ ‘Bangladesh Profile - Timeline’.



Үүнээс дүгнэн үзвэл Өмнөд Азийн бүс нутгийн үндсэн хуулийн тогтворгүй байдал нь тухайн бүс нутгийн хүн амын дотоод зөрчил болох шашин хоорондын зөрчил, ядуурал, улс төрийн тогтворгүй байдал, нэг намын болон цэргийн дарангуйлал зэргээс шалтгаалж ирсэн болох нь харагдаж байна.

2.7. Төв ба Зүүн Азийн бүс нутаг


Төв ба Зүүн Азийн бүс нутагт БНХАУ, Япон, Солонгос зэрэг бүс нутагтаа төдийгүй, дэлхийн эдийн засагт нөлөө бүхий орнууд оршдог. Энэхүү бүс нутгийн орнуудын тухайд дэлхийн I, II дайны дараагаар тусгаар тогтнолоо зарлаж, үүнтэй холбоотойгоор үндсэн хуулиа баталж байснаараа онцлогтой. Дэлхийн хоёрдугаар дайнаас өмнө Азийн зарим орон болон Франц, Их Британи, АНУ, Голланд, ОХУ зэрэг орны колони орнууд байсан. Тухайлбал, Вьетнам, Камбож, Лаос зэрэг улс Франц, Малайз, Мьенмар, зэрэг улс Их Британийн, Индонез Улс Голландын, Филиппин Улс АНУ-ын гэх мэтээр колоничлогдож байжээ.⁷⁶

Энэхүү бүс нутгийн үндсэн хуулийг авч үзвэл Баруун Европын бүс нутгийн орнуудтай харьцуулахад харьцангуй хожуу үндсэн хуулиа баталж байснаараа онцлогтой. Тухайлбал, Төв ба Зүүн Азийн орнуудаас хамгийн анх Япон Улс 1889 онд, БНХАУ 1911 онд, Монгол Улс 1924 онд, Тайланд Улс 1932 онд тус тус үндсэн хуулиа баталж байжээ. Энэхүү бүс нутгийн орнуудын үндсэн хуулийн үйлчлэх хугацаа дунджаар 43 жил болж байгаа бөгөөд хамгийн тогтвортой үндсэн хуультай орны тоонд Япон, Тайван, БНСУ, Бруней зэрэг орон хамаарч байна. Харин үндсэн хуулийн тогтвортой байдал сул орнуудад Тайланд Улс /13/, БНХАУ /10/, Камбожи /6/, Филиппин /6/ зэрэг орон хамаарч байна.⁷⁷ Ингээд үндсэн хуулийн үйлчилж буй хугацааг зургаар харуулъя.

⁷⁶ 'Southeast Asia, 1900 A.D.–Present | Chronology | Heilbrunn Timeline of Art History | The Metropolitan Museum of Art'.

⁷⁷ <https://www.constituteproject.org/ontology/chronology?lang=en>

Зураг 7. Төв ба Зүүн Азийн бүс нутгийн орнуудын үндсэн хуулийн үйлчлэх хугацаа



Дээрх зургаас үзвэл Төв ба зүүн азийн бүс нутгийн орнуудаас Бруней, Индонези, Япон, Өмнөд болон Хойд Солонгос, Малайз, зэрэг оронд үндсэн хуулийн үйлчлэх хугацаа харьцангуй тогтвортой байгааг харуулж байна. Ингээд Азийн бүс нутгийн орнуудаас Япон болон Бүгд Найрамдах Солонгос Улсыг төлөөлөл болгон дор товч авч үзье.

Япон Улсын тухайд Азийн орнуудаас хамгийн анх үндсэн хуулиа баталсан орны нэгээр тооцогддог. Тус улс түүхэндээ хоёр удаа буюу 1889, 1946 онд үндсэн хуулиа шинэчлэн баталсан байна. Эдгээр үндсэн хуулийн тухайд анх батлагдсанаас хойших хугацаанд ямар нэгэн нэмэлт, өөрчлөлт ороогүй онцлогтой. Үндсэн хуулийн үйлчлэх хугацааны тухайд анхны үндсэн хууль 58 жил, хоёрдахь үндсэн хууль 74 үйлчилж байна. Тус улсын үндсэн хуулийн үйлчлэх хугацаа, тогтвортой байдлын талаар судлаачид дараах тайлбарыг өгдөг. Тухайлбал, 1/ Япон Улсын ард иргэд, ялангуяа үндсэн хуулийн эрх зүйн судлаачдын дунд үндсэн хуулийг өөрчлөх эсхүл өөрчлөхгүй байх гэсэн эсрэг хоёр байр суурь байсаар ирэв. Иймээс иргэдийн дундах энэхүү эсрэг тэсрэг байр сууринаас шалтгаалан үндсэн хуулийг өөрчлөх асуудал хойшлогдсоор иржээ.⁷⁸ 2/ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам харьцангуй хатуу байдаг. Жишээлбэл, үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэхдээ парламентын дээд, доод 2 танхимын гуравны хоёр буюу түүнээс дээш саналаар хэлэлцэх, тухайн саналыг ард нийтээр хэлэлцүүлж, үр дүнг эзэн хаан ёсчлон баталгаажуулах гэх мэт өндөр шаардлага тавигддаг.⁷⁹ 3/ Япон Улс дэлхийн I, II дайнд оролцож ихээхэн хохирол амссан билээ. Үүний

⁷⁸ Тухайлбал, Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлд, тус улсын нутаг дэвсгэр дээр дайн хийх асуудлыг бүр мөсөн хориглосон асуудал дээр иргэд, олон нийт ялгаатай байр суурь илэрхийлсээр иржээ.

⁷⁹ Arend Lijphart 36 улсын үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн журамын талаар судалсан тоон судалгаандаа Япон Улсыг хамгийн хатуу журамтай гэсэн ангилалд оруулжээ.



улмаас үндсэн хуулийн халдашгүй байдал, түүнд өөрчлөлт оруулах асуудалд олон нийт ихээхэн болгоомжтой ханддаг байна. Тухайлбал, 1946 оноос хойш иргэдийн дунд явуулсан хэд хэдэн судалгаагаар иргэд үндсэн хуулийг өөрчлөх шаардлагагүй гэсэн хариултыг өгч байжээ. Үүнээс үзвэл Японы Улсын иргэдийн дунд үндсэн хуулийг өөрчлөх асуудалд ихэд болгоомжтой ханддаг болохыг харуулж байна. 4/ Тус улсад үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам хатуу байдаг боловч үндсэн хуулийн тайлбар гаргах замаар үндсэн хуулийн тогтвортой байдлыг хангадаг. Өөрөөр хэлбэл шүүхийн жишиг тайлбар үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам хатуу байх сөрөг талыг эерэг талаар нөхөж зохицуулдаг. 5/ Үндсэн хуулийн тогтвортой байдал үндсэн хуулийн бүтэц, тогтолцоо, агуулга, бичвэрээс ихээхэн хамааралтай байдаг. Тухайлбал, үндсэн хууль нь зөвхөн төрийн байгууллагын хоорондын үйл ажиллагаа, иргэдийн эрх, үүргийн талаарх ерөнхий суурь зарчмыг тусгасан байна. Үүнээс бусад хууль зүйн нарийн зохицуулалтыг үндсэн хуулиас бусад салбарын хуулиар болон шүүхийн тайлбараар нөхөж зохицуулсан байдаг байна.⁸⁰

БНСУ-ын тухайд үндсэн хуулийн эрх зүйн хөгжил харьцангуй өвөрмөц онцлогоор хөгжиж иржээ. Харьцуулсан үндсэн хуулийн эрх зүйн үүднээс авч үзэхэд дэлхийн ихэнх оронд цэргийн болон авторитар дэглэм нэгэнт тогтсон бол цаашдаа ардчилалд тайван замаар шилжихэд төвөгтэй нөхцөл байдал үүсдэг. Харин БНСУ-ын тухайд анх үндсэн хуулиа батлан хэрэгжүүлэх үедээ цэргийн болон авторитар дэглэмтэй байсан боловч ардчилалд аажмаар шилжсэн нь судлаачдын анхаарлыг татдаг.

Мөн үүнээс гадна Дэлхийн I, II дайн дэлхийн болон бүс нутгийн хувьд ихээхэн өөрчлөлтийг дагуулсан тухай дээр дурдсан. БНСУ-ын тухайд дэлхийн II дайны дараа буюу 1945 оны 8 дугаар сарын 15-нд тусгаар тогтнолоо зарласан. Үүнтэй холбоотойгоор тус улс өөрийн үндсэн хуулиа баталсан онцлогтой. Тус улсад үндсэн хуулийг батлах процесс нэлээд удаан буюу 3 жил орчим үргэлжилсний эцэст 1948 онд баталсан байна. Үндсэн хуулийг батлагдах хүртэлх хугацаанд АНУ-ын зэвсэгт хүчний шууд оролцоотойгоор төрийн эрх мэдлийг удирдаж байсан бөгөөд үндсэн хуулийг боловсруулахад мөн адил мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж байжээ.⁸¹

Өнөөгийн байдлаар тус улсын үндсэн хууль 72 жил үйлчилж байгаа бөгөөд энэ хугацаанд нийтдээ 9 удаа нэмэлт, өөрчлөлт хийжээ. Эдгээр өөрчлөлтийн тухайд дийлэнхдээ улс төрийн дэглэмийн өөрчлөлт, тэр дундаа төрийн эрх мэдлийн өөрчлөлттэй холбоотойгоор хийж байв. Тухайлбал, БНСУ-ын анхны Ерөнхийлөгч *Rhee Syngman* сонгогдсоныхоо дараа 1952, 1954 оны үндсэн хуулийн өөрчлөлт хийжээ. Уг өөрчлөлтөөр тэрээр өөрийн эрх мэдлээ нэмэгдүүлэх оролдлого хийж, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаанд

⁸⁰ Yokodaido, 'Constitutional Stability in Japan Not Due to Popular Approval'.

⁸¹ Won-Soon, 'Democratization in Korea and Its Influence on the Constitution'.

өөрчлөлт оруулсан байна. Үүний үр дүнд Ерөнхийлөгчөөр сонгогдох боломж нэмэгдүүлжээ. Гэсэн хэдий боловч 1960 оны олон нийт болон оюутнуудын бослого, тэмцлээр огцорчээ. Үүний дараа 1960 онд үндсэн хуульд дахин нэмэлт, өөрчлөлт оруулж төрийн тогтолцоог эмхэлж, зохион байгуулалтад оруулах оролдлого хийсэн боловч амжилт олоогүй. Үүний дараа 1962 онд Пак Жон Хи Ерөнхийлөгч зэвсэгт хүчний оролцоотойгоор төрийн эргэлт хийж, засгийн эрхэнд гарав. Тэрээр засгийн эрхэнд гарсны дараа Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаанд даруй өөрчлөлт оруулж, улмаар шүүх эрх мэдэлд хяналт тогтоож, бүх шатны шүүгч нарыг томилох болов. Ийнхүү Пак Жон Хи Ерөнхийлөгч нийтдээ 18 жилийн хугацаанд төрийн эрх мэдэлд хяналт тогтоосны эцэст 1979 он нас баржээ.⁸²

Үүний дараа 1980 онд дараагийн цэргийн эргэлт гарч 1980 онд үндсэн хуульд дахин нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Уг өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааг өөрчилж Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа, долоон жилийн хугацаагаар өөрчилж, 1972 онд түдгэлзүүлсэн байсан үндсэн хуулийг сэргээв. Үүний дараа иргэдийн дунд ардчилал, хүний эрхийн баталгааныхаа төлөө тэмцсэн өргөн хүрээтэй жагсаал болж үндсэн хуульд өөрчлөлт оруулжээ. Энэхүү өөрчлөлтөөр Парламентын ардчиллыг сонгож, Ерөнхийлөгч зөвхөн нэг удаа таван жилийн хугацаагаар сонгогдох, хууль тогтоох эрх мэдлийн байгууллагын эрх хэмжээг бататгах, хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангах зэрэг чухал өөрчлөлтийг тусгажээ.⁸³

Ийнхүү Төв болон Зүүн азийн бүс нутгийн орнуудын үндсэн хуулийн үйлчлэх хугацаа нь тухайн бүс нутгийн тогтворгүй байдал, тэр дундаа хөрш орнуудын нөлөөлөл, колончлолын бодлого нөлөөлсөн болох нь харагдаж байна. Мөн түүнчлэн тухайн улсын улс төрийн дэглэм, Ерөнхийлөгчийн бүрэн эрх, түүний хугацаанд нөлөөлсөн нь харагдаж байна.

ДҮГНЭЛТ

Нэг. Үндсэн хуулийн үйлчлэх хугацаа, түүний тогтвортой байдал нь дотоод болон гадаад олон хүчин зүйлээс шалтгаалдаг болохыг харуулж байна. Тухайлбал, 1/ Тухайн бүс нутгийн тогтворгүй байдал, тэр дундаа хөрш орнуудын эзлэн түрэмгийлэл, дэлхийн томоохон гүрнүүдийн колоничлох бодлого; 2/ Цэргийн болон авторитар дэглэмийн нөлөөгөөр удирдагч солигдох, төрийн эргэлт гарах; 3/ Ардчилал, чөлөөт зах зээлийн эдийн засагт аажмаар шилжих, шилжилт; 4/ Дэлхийн даяаршил, эрх зүй, соёл, технологийн нөлөө; 5/ Тухайн цаг үеийн шаардлагаас шалтгаалан хүлээн зөвшөөрөгдсөн улс төрийн хүчний манлайлал дор үндсэн хуулийн өөрчлөлт хийх; 6/ Улс төрийн дотоод хямрал, зөрчил; 7/ Эдийн засгийн хямралт байдал үүсэх; 8/ Тухайн улс тусгаар тогтнох, эсхүл бусад оронд эзлэгдэх, газар нутгаа алдах; 9/ Хүн амын олон янзын төлөөлөл болох угсаатны болон шашны ялгарал

⁸² 'Constitutional History of Korea'.

⁸³ 'Constitutional History of Korea'.



хоорондоо зөрчилдөх; 10/ Тухайн улсын болон бүс нутгийн улс төрийн үзэл суртлын нөлөөлөл; 11/ Үндсэн хуулийг өөрчлөх талаарх гаднын улсын нөлөөлөл, тулгалтад автах; 12/ Тухайн улсын үндсэн хуулийн бичвэр, бүтэц, агуулга аажмаар өөрчлөгдөж, анхны үзэл баримтлал өөрчлөгдөх; 13/ Үндсэн хуулийн шүүхийн тайлбар гаргах замаар анхны үзэл баримтлал өөрчлөгдөх; 14/ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам хатуу болон уян хатан байдлаас шалтгаалах зэргийг дурдаж болно.

Хоёр. Үндсэн хуулийн хэрэгжих хугацаа ямар байх тухай асуудал судлаачдын дунд сонирхол татсаар байдаг.⁸⁴ Үндсэн хуулийн хэрэгжих хугацааг механик байдлаар тогтоох асуудлыг үндсэн хуулийн тогтвортой хүчин төгөлдөр үйлчлэлд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл үндсэн хуулийн үйлчлэл тогтвортой бөгөөд тухайн нийгмийн суурь харилцааг үр дүнтэй зохицуулж байвал тухайн үндсэн хуулийг заавал өөрчлөх шаардлагагүй гэсэн байр суурийг илэрхийлж байна.

Гурав. Үндсэн хуулийн үйлчлэх хугацааг тодорхой бүс нутгаар нь судалж үзвэл тухайн бүс нутаг бүрийн онцлогоос шалтгаалан тогтвортой үйлчлэх хугацаа ялгаатай байна. Тухайлбал, Баруун Европын бүс нутагт 91 жил, Зүүн Европын бүс нутагт 24 жил, Латин Америкийн бүс нутагт 42 жил, Ойрх Дорнод ба Хойд Африкт 32 жил, Төв ба Өмнөд Африкийн бүс нутгийн орнуудад 23 жил, Өмнөд Азийн орнуудад 34 жил, Төв ба Зүүн Азийн орнуудад 43 жил болж байна. Ийнхүү үйлчлэх хугацааны ялгаатай байдал нь тухайн бүс нутгийн өөрийн онцлогоос хамаарч байна. Үүнийг товчлон дүгнэвэл:

1. Баруун Европ болон хойд Америкийн бүс нутгийн ихэнх орнуудад улс төрийн нөхцөл байдал тогтвортой, мөн эдийн засаг өндөр хөгжсөн, мөн ардчилал тогтвортой, үндсэн хуулийг дээдлэх эрх зүйн соёл тогтсон учраас үндсэн хуулийн үйлчлэх хугацаа бусад бүс нутагтай харьцуулахад өндөр байна.
2. Зүүн Европын бүс нутгийн орнуудын тухайд геополитикийн хувьд ЗХУ задарсан, үүнтэй холбоотойгоор улс төрийн үзэл суртал өөрчлөгдсөн, мөн дэлхийн I, II дайны нөлөөгөөр бүс нутгийн тогтворгүй байдал үүссэн, тухайн улсууд тусгаар тогтнолоо зарласан зэрэг шалтгаанаар үндсэн хуулийн өөрчлөлт хийгдсэн болох нь харагдаж байна.
3. Латин Америкийн улсуудын үндсэн хуулийн тогтворгүй байдалд нөлөөлж буй голлох хүчин зүйлд а/ Үндсэн хуулийн өөрийн дизайн, тэр дундаа үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам, шинээр батлах тухай асуудал тодорхойгүй; б/ Улс төрийн дэглэмийн өөрчлөлт хийх эрх зүйн орчин тодорхойгүй; в/ Улс төрийн хүчнүүдийн тайван замаар

⁸⁴ Тухайлбал, АНУ-ын үндсэн хуулийг бүтээлцсэн эрхмүүдийн төлөөлөл болох Thomas Jefferson үндсэн хуулийн хэрэгжих хугацааг дунджаар 19 жилээр тогтоох боломжтой гэсэн саналыг дэвшүүлсэн тухай дээр дурдсан. Энэ нь Zachary Elkins, Tom Ginsburg, and James Melton нарын судалгаагаар мөн батлагдсан билээ. Үүнтэй холбоотойгоор дэлхийн зарим улсуудад үндсэн хуулийн хэрэгжих хугацааг тухайн үндсэн хуульд өөрт нь тусгайлан тусгаж ирсэн цөөн тооны практик хэрэгжиж иржээ.

эрх мэдлээ шилжүүлэх шилжилтийн журам бүрхэг; г/ Гаднын томоохон орнуудын колоничлох бодлого зэрэг хүчин зүйл нөлөөлжээ.

4. Ойрх Дорнод ба Хойд Африкийн бүс нутгийн орнуудын тухайд тухайн бүс нутгийн өвөрмөц онцлог голлон нөлөөлсөн юм. Тухайлбал, Исламын шашны дотоодын томоохон хоёр урсгалын хоорондын зөрчлийг хэрхэн шийдвэрлэх, тухайн бүс нутгийн газрын баялгийн зүй зохистой хуваарилалт, мөн эдгээр орны ихэнх удирдагч /цэргийн болон улс төрийн дарангуйлагч/ нарын бүрэн эрхийн хугацаа дуусах, өөрчлөгдөх журам тодорхойгүй байдал гэх мэт.
5. Төв ба Өмнөд Африкийн бүс нутгийн орнуудын тухайд үндсэн хуулийн эрх зүйн соёл бүрэлдээгүй, төрийн тэргүүний бүрэн эрхийн хугацааны хязгаарлалт, томилох, сонгох журам сул, мөн үндэстэн, угсаатны хоорондын зөрчил, зэвсэгт хүчин, тэр дундаа цэргийн эргэлт гарах нөхцөл боломжийг үндсэн хуулийн аргаар зохицуулах чадвар сул байгаа зэрэг шалтгаанаас үүдэн үндсэн хуулийн тогтворгүй байдал үүсэж байна.
6. Өмнөд Азийн бүс нутгийн хувьд тухайн бүс нутгийн хүн амын дотоод зөрчил болох шашин хоорондын зөрчил, ядуурал, улс төрийн тогтворгүй байдал, нэг намын болон цэргийн дарангуйлал бий болохоос сэргийлсэн эрх зүйн орчин сул зэрэг хүчин зүйл үндсэн хуулийн тогтворгүй байдалд нөлөөлсөн болохыг харуулж байна.
7. Төв болон Зүүн азийн бүс нутгийн орнуудын тухайд дэлхийн I, II дайнаас үүдэлтэй бүс нутгийн тогтворгүй байдал, мөн түүнчлэн улс төрийн үзэл суртлын хуваагдал, үүнтэй холбоотой улс төрийн дэглэмийн өөрчлөлт, Ерөнхийлөгчийн бүрэн эрх, түүний хугацааны өөрчлөлт зэрэг хүчин зүйлүүд нөлөөлсөн болох нь харагдаж байна.

Дөрөв. Freedom House болон судалгааны олон байгууллагын дүгнэлтээр ардчиллыг амжилттай хэрэгжүүлж буй орнуудад үндсэн хуулийн үйлчлэх хугацаа урт, үндсэн хуулийн тогтвортой байдал сайн хангагдаж байна. Өөрөөр хэлбэл үндсэн хуулийн тогтвортой байдал ба ардчилал хоёр хоорондоо шууд хамааралтай болохыг харуулж байна. Нөгөө талаар ардчилал тогтвортой бус, дарангуйлагч дэглэм, хүчтэй Ерөнхийлөгчийн засаг бүхий улсуудад үндсэн хуулийн үйлчлэх хугацаа богино, үндсэн хуулийн тогтвортой байдал сул болох нь ажиглагдаж байна. Үүнээс дүгнэн үзвэл ардчилал тогтвортой хөгжих нь үндсэн хуулийн тогтвортой байдалд нөлөөлөх нэг томоохон учир шалтгаан болохыг нотлон харуулж байна.

Дээр ангилан авч үзсэн улсуудын түүхэн туршлага, орчин үеийн хөгжил, төлөвшлийн үйл явцаас үзвэл Парламентын ардчиллыг төлөвшүүлэх, хөгжүүлэх нь үндсэн хуулийн уян хатан байдал хийгээд тогтвортой байдалд нөлөөлөх гол хүчин зүйл гэж үзэж байна.



ШҮҮХЭЭС ГАРАХ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙГ БАТАЛГААЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ, АЧ ХОЛБОГДОЛ

Д.Алтантуяа

Дархан-Уул аймаг дахь СДИХАШШ-ийн шүүгч

Иргэний хууль тогтоомж нь иргэний эрх үүргийг ямар нэгэн хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчимд үндэслэгддэг. Тийм ч учраас иргэний хууль тогтоомжид бусдын зөрчигдсөн эрхийг сэргээсэн шүүхийн шийдвэр баталгаатай байх биелэгдэх боломжийг хангах үндэслэлийг хуулиар зохицуулсан.

Үүнд: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлд шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч нэхэмжлэгчийн хүсэлтээр тодорхой арга хэмжээ авч болохыг хуульчилжээ.

Уг арга хэмжээ нь шүүхээс гарах шийдвэр баталгаатай байх, зөрчигдсөн эрхийг сэргээсэн шүүхийн шийдвэр баталгаатай биелэгдэх нөхцөлийг урьдчилан бэлтгэж байгаа хэрэг юм. Гэвч шүүхээс хуульд заасан дээрх арга хэмжээг авч байгаа хуулийн зохицуулалт хэр оновчтой байгаа, шүүхээс ямар арга хэмжээг түлхүү авч хүсэлтийг хангасан, цаашид энэ арга хэмжээг авахад юуг анхаарвал зохих, энэ арга хэмжээний ач холбогдлын талаар тусгахыг зорилоо.

Нэг. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээний ач холбогдол

Тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэж гарсан шүүхийн шийдвэр болгон хэргийн оролцогчдын зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бодитойгоор сэргээх баталгаа болж чаддаггүй.¹ Иймд хууль тогтоогчоос шийдвэрийн биелэлтийг баталгаатай байх зөрчигдсөн эрхийг хангахын тулд энэхүү шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг хэргийг шийдвэрлэх хугацаанд авч болохоор хуульчилж өгсөн нь зөрчигдсөн эрхийг бодитойгоор сэргээх баталгаа болж өгдөг.

Өөрөөр хэлбэл, шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагч маргааны зүйлийг нуух, устгах, бусдад шилжүүлэх зэргээр цаашид өөр төрлийн эрхийн зөрчил үүсэх, маргаан дуусахгүй үргэлжлэх зэргээс урьдчилан сэргийлэх зорилготой юм.

¹ А.К.Ескендиоров, Практика применения мер обеспечения иска, https://online.zakon.kz/Document/?doc_id=30092681#-pos=4;-116

Жишээ нь: Иргэн “А” худалдах, худалдан авах гэрээний үнэ төлөгдөөгүй үндэслэлээр иргэн “Б”-д шилжүүлэн өгсөн автомашинаа буцаан авахаар нэхэмжлэлийн шаардлага гаргасан тохиолдолд тухайн маргааны зүйл болох автомашиныг битүүмжлэх, эсхүл тухайн автомашиныг бусдад худалдахгүй, бэлэглэхгүй, шилжүүлэхгүй байхыг хариуцагчид даалгах арга хэмжээг авах нь ирээдүйд шүүхийн шийдвэр биелэгдэх боломжийг хангах юм.

Хоёр. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах үндэслэл

Хүний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх шүүхийн үндсэн зарчмыг хэрэгжүүлэх гол хэрэгсэл нь шүүхийн шийдвэр байх бөгөөд уг шийдвэр нь бодитой биелэгдэх явдал юм. Энэхүү илтгэлийн сэдвийн хүрээнд хамаарч буй шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ нь шүүхийн шийдвэр бодитой хэрэгжих нэг нөхцөл юм.

Шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байгаа эсэх нь иргэд, олон нийт, судлаачдын дунд маргаан дагуулсан сэдэв байгаа боловч шүүхээс гарсан шийдвэр биелэхгүй байгаа нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийг бууруулж буй нэг хүчин зүйл гэж үздэг. Үүнээс үзэхэд шүүхийн шийдвэр зайлшгүй биелэгдэх нь өргөн утгаараа зөрчигдсөн эрхийг хангах нэг гол нөхцөл болдог.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасан шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чухал асуудал юм. Хуулийн зохицуулалтын агуулгаас үзэхэд уг арга хэмжээг шүүгч өөрийн санаачилгаар бус, харин нэхэмжлэгчийн хүсэлтээр хариуцагчид холбогдуулан авахаар заасан.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн онолын тайлбарт, “нэхэмжлэгч” гэдгийг нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэл гаргасан оролцогчийг хамааруулан тайлбарласан байх² боловч бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдийг шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авхуулах тухай хүсэлтийг гаргах эрхтэй гэж үзэж болно.³ Учир нь шүүх бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдийн шаардлагыг ч нэхэмжлэлийн нэгэн адил шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд хангаж шийдвэрлэсэн тохиолдолд тухайн шийдвэрийн биелэлтийн асуудал яригдах нь гарцаагүй юм.

Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг анхан шатны шүүхийн шүүгч авах эрхтэй гэж ойлгох нь хуульд нийцэх боловч судлаач Йоахим Кают уг арга хэмжээг зөвхөн анхан шатны шүүх төдийгүй

² Б.Ундрах, Ц.Амарсайхан, А.Доржготов, Д.Тунгалаг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, 2014, х.198

³ Д.Зундуй, Н.Чинбат, БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуулийн тайлбар, 1984, 130 дахь тал



мөн давж заалдах, хяналтын шатны шүүх авч болно⁴ хэмээн үзсэн байдаг.

Энэхүү арга хэмжээг ямар төрлийн нэхэмжлэлд хэрэглэх талаар, хүсэлт гаргагч хүсэлтийнхээ үндэслэлийг хэрхэн нотлох талаар нарийвчлан хуульчлаагүй. Хүсэлт гаргагчийн хувьд, уг арга хэмжээг авахгүй бол шүүхийн шийдвэр биелэгдэх боломжгүй болох эрсдэлтэй гэдгийг нотлох учиртай. Харин шүүх хүсэлтэд зааж буй арга хэмжээ нь нэхэмжлэлийн шаардлагад уялдаатай эсэх, мөн үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, орлого олох эх үүсвэрийг хаах, түүнчлэн бүтээгдэхүүн түргэн муудаж, чанараа алдах зэрэг нөгөө талд хохирол буюу сөрөг үр дагаварт хүргэх⁵ эсэхийг шалгаж уг хүсэлтийг шийдвэрлэнэ. Үүнийг нэхэмжлэгч хүсэлтээ үндэслэлтэй бөгөөд шаардлагатай болохыг итгэл үнэмшил төрүүлэхүйц үндэслэж чадсан гэж үзвэл авахаар⁶ буюу арга хэмжээг авах зайлшгүй шаардлагатай гэх байдал нотлогдсон тохиолдолд авна.

Гурав. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авхуулах хүсэлтийг шийдвэрлэсэн байдал

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.1-69.1.5-д хариуцагчийн эд хөрөнгө буюу мөнгийг битүүмжлэх, хариуцагчаас эд хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн тодорхой ажиллагаа явуулахыг хориглох, хариуцагчийн дансны зарлагын хөдөлгөөнийг зогсоох, нэхэмжлэлээр шаардсан мөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд урьдчилан оруулах, тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгах гэсэн арга хэмжээнүүдийг хуульчилсан. Эдгээр арга хэмжээ авхуулах тухай хүсэлтийг шүүхээс хэрхэн шийдвэрлэсэн байдлын талаар энэхүү илтгэлд зориулан хийсэн судалгааг танилцуулъя.

Дархан-Уул аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн биелэлт баталгаажуулах арга хэмжээний талаар 2020-2021 онуудад гаргасан захирамжуудыг судлав.

Дархан-Уул аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх 2020 онд нийт 1380 хэрэг маргаан шийдвэрлэсэн байх ба хэргийг оролцогчийн зүгээс шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг давхардуулан авхуулах тухай нийт 32 хүсэлт гаргаснаас шүүх 62,5 % буюу 20 хүсэлтийг хангаж, үлдэх 12 хүсэлт буюу 37,5 %-ийг хангахгүй орхиж шийдвэрлэжээ. Хангаж шийдвэрлэсэн хүсэлтийн 45 % буюу 9 нь хариуцагчийн эд хөрөнгө буюу мөнгийг битүүмжлэх арга хэмжээ, 10% буюу 2 нь хариуцагчийн дансны зарлагын хөдөлгөөнийг зогсоох арга хэмжээ, 5 % буюу 1 нь хариуцагчаас эд хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн тодорхой ажиллагаа явуулахыг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр

⁴ Йоахим Кают, Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, 2015, 57 дахь тал


⁵ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 69 дүгээр зүйлийн 69.5 дахь заалт

⁶ Йоахим Кают, Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, 2015, 55 дахь тал

хориглох арга хэмжээ, 40 % буюу 8 нь тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгах арга хэмжээ тус тус эзэлж байна.

2021 онд нийт 1442 хэрэг маргаан шийдвэрлэсэн⁷ байх ба хэргийн оролцогчдын зүгээс шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авхуулах тухай нийт 17 хүсэлт гаргаснаас шүүх 88,2 % буюу 15 хүсэлтийг хангаж, үлдэх 2 хүсэлт буюу 11,8 %-ийг хангахгүй орхиж шийдвэрлэжээ. Хангаж шийдвэрлэсэн хүсэлтийн 41,2 % буюу 7 нь хариуцагчийн эд хөрөнгө буюу мөнгийг битүүмжлэх арга хэмжээ, 29,4 % буюу 5 нь хариуцагчийн дансны зарлагын хөдөлгөөнийг зогсоох арга хэмжээ, 11,8 % буюу 2 нь хариуцагчаас эд хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн тодорхой ажиллагаа явуулахыг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр хориглох, 17,6 % буюу 3 тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгах арга хэмжээ тус тус эзэлж байна.

Зураг 1. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах ажиллагаа, хуулийн зүйл, хэсгээр



Дээрх зургаас харахад хэргийн оролцогчоос гаргасан шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авхуулах хүсэлт өмнөх оноос буурсан хэдий ч шүүх нэхэмжлэгчийн гаргасан хүсэлтийг дийлэнх хэсгийг хангаж шийдвэрлэсэн байх ба нэхэмжлэгчийн гаргасан хүсэлтийг хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан шүүх давхардуулан авах шаардлагагүй гэж, хариуцагчийн гаргасан хүсэлтийн үндэслэл тодорхойгүй зэрэг үндэслэлүүдээр хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн байна.

⁷ Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, Монгол Улсын Шүүхийн 2018 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны тайлан, <http://www.judoinstitute.mn/main/236--2018-.html>, 36 дахь тал



Мөн шүүхээс авч буй арга хэмжээний дийлэнх хувийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.1, 69.1.3, 69.1.5-д заасан арга хэмжээ эзэлдэг болох нь харагдаж байна. Иймд илтгэлийн дараах хэсэгт эдгээр арга хэмжээтэй холбоотой асуудлуудыг өөрийн орны болон гадаадын улсын туршлага, хууль тогтоомжтой харьцуулан үзлээ.

Мөн хэргийн оролцогч нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.4 дэх хэсэгт зааснаар нэг арга хэмжээг өөр арга хэмжээгээр солиулах тухай хүсэлт гаргах, мөн хуулийн 70 дугаар зүйлийн 70.3 дахь хэсэгт зааснаар арга хэмжээ авсны улмаас учирсан хохирлын талаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй боловч дээрх хугацаанд холбогдох хүсэлт, нэхэмжлэл гаргах эрхээ хэрэгжүүлсэн хэргийн оролцогч байхгүй байна.

Үүнийг нэг талаас шүүхээс авсан шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ нь хуульд нийцсэн, нэхэмжлэлийн шаардлагатай уялдаатай байсан, нөгөө талаас хэргийн оролцогч хуульд заасан эрхээ хэрхэн хэрэгжүүлэхээ мэддэггүй, эсхүл өмгөөлөгч нар дээр дурдсан хуулийн зохицуулалтыг тэр бүр хэрэглэдэггүйтэй холбон тайлбарлаж болох юм.

Дөрөв. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай захирамжийг биелүүлэхтэй холбоотой практикт гардаг бэрхшээл, гадаад улс орны туршлага

Дээр дурдсан арга хэмжээний төрөлтэй холбоотой практикт гарч бэрхшээлийг шүүхээс шалтгаалсан, хэргийн оролцогчоос шалтгаалсан, шийдвэр гүйцэтгэх байгууллагаас шалтгаалсан, бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шалтгаалсан гэж энэхүү ажиллагаанд оролцогчдын хүрээгээр нь дөрөв ангилж болох юм. Нөгөө талаас практикт гарч буй бэрхшээлийг хууль тогтоомжийг боловсронгуй болгох замаар багасгах, арилгах боломжтойг үгүйсгэхгүй юм.

Эдийн засаг, нийгмийн харилцааны хувьд ижил төстэй хөрш орнуудын жишээг харьцуулан авч үзлээ. Мөн ОХУ, БНХАУ-ын хувьд эрх зүйн бүлийн хувьд онцлогтой байдаг учир эдгээр улс орныг сонгосон болно.

а/. Манай улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авхуулах тухай хүсэлтийг шийдвэрлэх хугацааг тодорхойлоогүй.

Хэргийн ачаалал, бусад хүчин зүйлийн улмаас дээрх хүсэлтийг шийдвэрлэсэн хугацаа харилцан адилгүй байна. Шүүгч шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах тухай хүсэлтийг нэн даруй шийдвэрлэх нь эд хөрөнгө, маргааны зүйлийг санаатайгаар нуун далдлах,

бусдад шилжүүлэх, үгүй хийх эрсдэлээс сэргийлэх ач холбогдолтой. Иймд хуулиар энэ хугацааг хуульчлан тогтоох нь тодорхой байдлыг бий болгох юм.

ОХУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах тухай хүсэлтийг хүлээн авсан өдөрт нь багтаан шийдвэрлэхээр журамласан байх ба ийнхүү шийдвэрлэхдээ хариуцагч болон бусад оролцогчдод хүсэлтийг танилцуулахгүйгээр шийдвэрлэхээр зохицуулжээ.⁸ Харин БНХАУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах тухай хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 48 цагийн дотор шийдвэрлэх, мөн шаардлагатай гэж үзвэл шүүх өөрийн санаачилгаар уг арга хэмжээг авч болохоор зохицуулсан байна.⁹

Баталгаажуулах арга хэмжээний тухай хүсэлтийг хариуцагч болон хэргийн бусад оролцогчдод танилцуулах шаардлагагүй байдлаар хуульчилсан нь өмнө дурдсан эрсдэлээс урьдчилан сэргийлэх, уг ажиллагааны онцлогийг харгалзан үзсэн байхаас гадна шүүх өөрийн санаачилгаар арга хэмжээ авч болохоор зохицуулсан нь эрх зүйн мэдлэггүй этгээдийн эрх ашгийг хамгаалах ач холбогдолтой байж болох нь эдгээр улсуудын туршлагаас харагдаж байна.

б/ Манай улсын хууль арга хэмжээ авсан захирамжийн биелэлтийг хэрхэн хангуулах, албадан хэрэгжүүлэх асуудлыг нарийвчлан зохицуулаагүй байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсэгт шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамжийг гарсан өдрөөс нь эхлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар биелүүлэхээр зохицуулсан боловч үүнтэй холбоотой механизм, дараалал хугацаа зэргийг хуульчлаагүй нь амьдрал дээр уг заалт хэрэгжихэд хүндрэлтэй, нэг мөр биш байх нөхцөлийг бүрдүүлдэг байж болно.

Тодруулбал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.1-д заасан хариуцагчийн эд хөрөнгө буюу мөнгийг битүүмжлэх арга хэмжээ нь эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, тэдгээрийн шилжилт хөдөлгөөнийг хариуцсан эрх бүхий байгууллагад хамааралтай, 69.1.3-т заасан хариуцагчийн дансны зарлагын хөдөлгөөнийг зогсоох арга хэмжээ нь банк, эрх бүхий хуулийн этгээдэд хамааралтай, харин 69.1.2, 69.1.4, 69.1.5-д заасан хариуцагчаас эд хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн ажиллагаа явуулахыг хориглох, нэхэмжлэлээр шаардсан мөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд урьдчилан оруулах, тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгах зэрэг арга хэмжээнүүд нь хариуцагчид илүүтэйгээр хамааралтай байхад зөвхөн

⁸ ОХУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 141-р зүйл

⁹ БНХАУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 92, 93-р зүйл



“шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журам”-аар биелүүлэхээр зохицуулсныг боловсронгуй болгох шаардлагатай юм.

ОХУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авсан захирамжийг нэн даруй биелүүлэхээр заасан байх ба захирамжийг албадан гүйцэтгэх хуудсыг нэхэмжлэгч талд, харин шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авсан захирамжийн хуулбарыг хариуцагч талд гардуулах үүргийг шүүхэд хүлээлгэжээ.¹⁰ Мөн хуулийн 428 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт шүүгч захирамжийг албадан гүйцэтгэх хуудсыг цахим хэлбэрээр зохих этгээдэд хүргүүлж болохоор зохицуулсан нь өмнө дурдсан “нэн даруй” гэх хугацаа биелэгдэх боломжийг олгосон байна. Түүнчлэн шүүхийн зүгээс шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авсан тухайгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх эрх бүхий төрийн болон орон нутгийн байгууллагад хүргүүлэхээр зохицуулсан нь цаг хугацаа хэмнэсэн, төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоог хангасан ач холбогдолтой зохицуулалт болжээ.¹¹

ОХУ-ын нэгэн адил БНХАУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авсан захирамжийг “нэн даруй” биелүүлэхээр зохицуулжээ.¹² Мөн шүүхийн зүгээс эд хөрөнгийг битүүмжлэх, царцаах, эд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хаах талаар арга хэмжээ авсан тохиолдолд тухайн эд хөрөнгийн өмчлөгч буюу эзэмшигчид энэ тухай мэдэгдэхээр журамласан байна.¹³

в/ Арга хэмжээ авсан захирамжийг эс зөвшөөрч гомдол гаргасан тохиолдолд уг гомдлыг шийдвэрлэх хүртэлх хугацаанд захирамжийн үйлчлэл зогсох эсэхийг манай хуульд мөн зохицуулаагүй.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1, 171 дүгээр зүйлийн 171.1 дэх хэсэгт тус тус зааснаар хэргийн оролцогч нь шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авсан захирамжид гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй бөгөөд шүүх уг гомдлыг 14 хоногийн дотор шийдвэрлэдэг. Дээрх хугацаанд буюу гомдлыг хянан шийдвэрлэх хүртэлх хугацаанд холбогдох захирамжийн үйлчлэл зогсох эсэхийг хуулиар зохицуулаагүйн улмаас гомдлыг хянан шийдвэрлэсний дараа шийдвэр гүйцэтгэх байгууллагад захирамжийг хүргүүлэх, мөн гомдлыг хянан шийдвэрлэх хугацаанд эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхтэй холбоотой ажиллагаа хийж захирамжийн ач холбогдлыг алдагдуулах боломжийг хариуцагчид олгож болзошгүй.

¹⁰ ОХУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 142-р зүйл

¹¹ ОХУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 140-р зүйлийн 4 дэх хэсэг

¹² БНХАУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 92, 93-р зүйл

¹³ БНХАУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 94-р зүйл

ОХУ болон БНХАУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авсан захирамжид хэргийн оролцогч мөн адил гомдол гаргах эрхтэй.¹⁴ гэсэн хэдий ч хэргийн оролцогчийн зүгээс ийнхүү гомдол гаргасан нь шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авсан захирамжийн биелэлтийг зогсоох үндэслэл болохгүй талаар аль аль улсын хуульд тусгайлан зааж өгсөн нь шүүхээс явуулж буй ажиллагааны зорилго, мөн чанарт нийцсэн зохицуулалт болжээ.¹⁵

Түүнчлэн ОХУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 140 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авсан захирамжийг эс биелүүлбэл буруутай этгээд буюу иргэнийг 5,000 хүртэлх рубль, албан тушаалтныг 30,000 хүртэлх рубль, байгууллагыг 100,000 хүртэлх рубль-ээр торгох арга хэмжээг авахаар зохицуулсан байна. Үүнийг Монголбанкнаас зарласан 2021 оны 02 сарын 24-ний өдрийн ханшаар хөрвүүлбэл иргэнийг 193,400 хүртэлх төгрөг, албан тушаалтныг 1,160,400 төгрөг, байгууллагыг 3,868,000 хүртэлх төгрөгөөр торгохоор байна.¹⁶

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйл, 70 дугаар зүйлд шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авсан захирамжийг эс биелүүлбэл ямар хариуцлага хүлээлгэх талаар тусгайлан зохицуулаагүй хэдий ч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.2-т заасны дагуу торгууль ногдуулах боломжтой.

Үүнээс гадна хөрөнгийн мэдүүлгээ зориуд буруу гаргасан, эд хөрөнгөө нуун дарагдуулсан, бусдад шилжүүлсэн, үрэгдүүлсэн, дүр эсгэн биелүүлсэн, битүүмжилсэн хөрөнгийг дур мэдэн захиран зарцуулсан, дүр үзүүлэн гэрээ байгуулсан хариуцагчийн үйлдэлд Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хариуцлага ногдуулах боломжтой гэж үзэж байна. Учир нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.2.6-д иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамжид үндэслэн явуулахаар заасан байх тул холбогдох захирамжийг гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хамаарах бөгөөд улмаар Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйл буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх зүйл ангид хамаарах юм.

¹⁴ ОХУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 145 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, БНХАУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 99-р зүйл

¹⁵ ОХУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 145 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, БНХАУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 99-р зүйл

¹⁶ Монгол банкнаас зарласан 2021 оны 02 сарын 24-ний өдрийн рублийн ханш, 1 рубль = 38.68 төгрөг, <https://www.mongol-bank.mn/dblistofficialdailyrate.aspx>



Тав. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авсан захирамжийг шийдвэр гүйцэтгэх байгууллагаас биелүүлэх

Өмнө дурдсанчлан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсэгт шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамжийг гарсан өдрөөс нь эхлэн шийдвэр гүйцэтгэлийн журмаар биелүүлэхээр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6-д уг ажиллагааг энэ талаарх шүүгчийн захирамжид үндэслэн явуулахаар тус тус заасан.

Иймд хэдийгээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.1-69.1.5-д заасан арга хэмжээ нь хариуцагчид өөрт нь чиглэсэн арга хэмжээ байх боловч бүртгэлийн байгууллага, банк, эрх бүхий хуулийн этгээд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын оролцоо зайлшгүй юм.

Хуульд уг арга хэмжээг шууд хэрэгжүүлэх бүртгэлийн, төлбөр тооцооны зэрэг байгууллага болон албадлага хэрэглэх эрх бүхий шийдвэр гүйцэтгэгчийн талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй хэдий ч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарчим, бусад зохицуулалтын хүрээнд дараах байдлаар уг ажиллагааг явуулж болохоор байна.

а/ Зохих шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авсан захирамжийн “захирамжлах” хэсэгт заагдсан ажиллагааг нэн даруй хийж гүйцэтгэх, хийгдэх ажиллагаа ойлгомжгүй, утга агуулгын хувьд зөрүүтэйн улмаас түүнийг биелүүлэхэд хүндрэлтэй бол энэ талаар шүүхэд мэдэгдэж, захирамжийг буцаан хүргүүлэх нь зүйтэй. Энэ тохиолдолд захирамжийг биелүүлэх боломжгүй нөхцөл байдлыг тодорхой дурдаж, албан бичгээр харилцах нь төрийн байгууллагууд өөр хоорондоо албан бичгээр харилцах зарчимд нийцнэ.

Мөн шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээний үнийн дүн нэхэмжлэлийн үнийн дүнгээс хэтрэхгүй байх ёстой учир хэд хэдэн арга хэмжээг нэгэн зэрэг авахаар шийдвэрлэсэн байгаа бол тэдгээр арга хэмжээний нийт үнийн дүнг анхаарах шаардлага үүсдэг.

б/ Хариуцагчийн эд хөрөнгө буюу мөнгийг битүүмжлэх ажиллагааны хувьд захирамжийн талаар урьдчилан мэдэгдэх бус харин захирамжид заасан ажиллагааны талаар танилцуулан энэ талаар тэмдэглэл үйлдэх, танилцахаас татгалзвал энэ талаар тэмдэглэлд тусгайлан тусгах зэрэг онцлогтой хэрэгжих юм.

Хэрэв захирамжид битүүмжлэх эд хөрөнгийг шууд буюу нэг бүрийн эсхүл төрлийн шинжээр нь тодорхойлон заасан бол зөвхөн уг хөрөнгийг битүүмжлэх бөгөөд нэхэмжлэлийн үнийн дүнд хүрэхгүй байгаа зэрэг үндэслэлээр нэмж эд хөрөнгө буюу мөнгө битүүмжилж болохгүй. Энэ нь битүүмжлэх эд хөрөнгийг тусгайлан захирамжид дурдсаны ач холбогдлыг алдагдуулна.

Хуульд заасан “мөнгө” гэдэгт бэлэн мөнгө, гадаад валютыг ойлгоно. Гадаад валютын үнэлгээг гаргахдаа Монголбанкны тухайн өдрийн зарласан ханшийг хэрэглэх нь зохилтой.

Шүүх битүүмжлэх эд хөрөнгийг шууд нэрлэн заах үүрэг хүлээхгүй. Учир нь шүүх хариуцагчийн эд хөрөнгөний талаар бүрэн мэдээлэлтэй байгууллага биш юм. Энэ тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч өөрийн үзэмжээр эд хөрөнгө буюу мөнгийг битүүмжлэх шаардлагатай болдог учир эд хөрөнгийн зах зээлийн үнэ ханшийн талаар зохих мэдлэгтэй байх шаардлагатай болж байна. Эсхүл эд хөрөнгийн үнэлгээг хариуцагчаас тодруулан холбогдох гэрээ, хэлцэл, худалдан авсан баримтыг үндэслэл болгох боломжтой. Эд хөрөнгийг үнэлэхдээ хөрөнгийн үнэлгээчнийг заавал байлцуулах шаардлагагүй.

в/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.2, 69.1.5-д заасан хариуцагчаас эд хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн тодорхой ажиллагаа явуулахыг хориглох, тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгах арга хэмжээний тухайд холбогдох захирамжийг хариуцагчид танилцуулан, энэ талаар тэмдэглэл үйлдэх хэлбэрээр хийгдэх боломжтой.

Шүүгчийн захирамжийг эс биелүүлсэн, санаатайгаар зөрчсөн, улмаар шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаанд саад учруулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг сануулах нь шийдвэр гүйцэтгэгчийг ирээдүйд гарах эрсдэлээс талуудыг хамгаалах, сэргийлэх ач холбогдолтой.

г/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.3-т заасан хариуцагчийн дансны зарлагын хөдөлгөөнийг зогсоох арга хэмжээний тухайд шийдвэр гүйцэтгэгч нь өөрийн эрх хэмжээний хүрээнд хариуцагчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх мөнгөн хадгаламж, харилцах данс дахь дансны зарлагын хөдөлгөөнийг зогсоох ажиллагааг хийхэд хангалттай.

д/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.4-т заасан нэхэмжлэлээр шаардсан хэмжээний мөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд урьдчилан оруулах арга хэмжээ нь практикт ховор тохиолддог. Гол төлөв хариуцагч хуульд заасан нэг арга хэмжээг нөгөө арга хэмжээгээр солиулахдаа өөрийн сайн дураар мөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд оруулсан байдаг. Энэ зүйлд заасан мөнгө гэдэгт бэлэн



мөнгө, хадгаламж, харилцах дансанд байгаа мөнгө, тэдгээртэй тэнцэх гадаад валютыг ойлгоно.

Эсрэг тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч нь захирамжид заагдсан мөнгө хариуцагчид бий эсэхийг нягталсны үндсэн дээр уг арга хэмжээг биелүүлнэ. Хэрэв захирамжид заагдсан мөнгө хариуцагчид байхгүй бол уг арга хэмжээг биелүүлэх боломжгүй болох тул энэ талаар тэмдэглэл үйлдэж, шүүхэд мэдэгдэхэд хангалттай.

Зургаа. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ дуусгавар болгох үндэслэл

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсэгт зааснаар шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ нь давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргасан бол түүнийг шийдвэрлэх хүртэлх хугацаанд хэвээр байна хэмээн зохицуулжээ.

Хуульд ийнхүү зохицуулсан байх боловч шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ дараах үндэслэлээр дуусгавар болж болох юм. Үүнд:

- Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авсан захирамжид гарсан гомдлыг шүүх хүлээн авч, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1.2, 171.1.3-т зааснаар тухайн захирамжийг өөрчилж, хүчингүй болгож шийдвэрлэсэн;
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.4 дэх хэсэгт зааснаар шүүгч шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах нэг арга хэмжээг өөр арга хэмжээгээр сольсон;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон зэрэг болно.

ДҮГНЭЛТ

Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ нь шүүхийн шийдвэрийг ирээдүйд бодитойгоор биелүүлэх боломжийг баталгаатай болгох зорилгоор хариуцагчид холбогдуулан авч буй албадлагын шинжтэй арга хэмжээ юм.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.1-69.1.5 дахь хэсэгт заасан шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээний үр нөлөөг дээшлүүлэхийн тулд холбогдох хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх, авсан арга хэмжээний

талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гадна холбогдох этгээд буюу хариуцагч, банк, эрх бүхий хуулийн этгээд, эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийн бүртгэл, шилжилт хөдөлгөөн хариуцсан байгууллагад мэдэгдэх, шүүхийн зүгээс дээрх захирамжийг цахим хэлбэрээр шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай юм.

Тодруулбал: Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ямар хугацаанд хэрэгжүүлэх, захирамжид заасан арга хэмжээ биелэгдэх боломжгүй тохиолдолд үүнийг шүүхэд хэрхэн мэдэгдэх, шүүхийн зүгээс шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авсан тухайгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх эрх бүхий төрийн болон орон нутгийн байгууллагад хүргүүлэхээр зохицуулалт оруулах, энэ нь цаг хугацаа хэмнэсэн, төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоог хангасан ач холбогдолтой зохицуулалт болох учиртай. Мөн уг арга хэмжээ авсан захирамжид гомдол гаргасан тохиолдолд уг арга хэмжээний биелэлтийг хэрхэх, үйлчлэл зогсох эсэхийг тодорхой болгож өгөх гэх мэт.



ШҮҮГЧИЙГ ТАТГАЛЗАН ГАРГАХ, ШҮҮГЧ ТАТГАЛЗАН ГАРАХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

*А.Түвшинтулга
Архангай аймаг дахь Захиргааны хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч*

Оршил

Шүүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцад шүүгч, шүүх бүрэлдэхүүн, тухайн шүүхийн нийт шүүгчдээс татгалзах, татгалзлыг шийдвэрлэх процесс харьцангуй тодорхой мэт боловч шүүхийн практик, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зарим нэг бэрхшээл, нарийвчлан зохицуулах шаардлагатай асуудал байна гэж үзэн практик талаас нь асуудлыг хөндөхөөр энэхүү бэсрэг өгүүллийг бичлээ.

Шүүхийн практикт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, шүүх бүрэлдэхүүн, тухайн шүүхийн нийт шүүгчдээс татгалзах, энэхүү татгалзлыг шийдвэрлэх ажиллагаанаас хамаарч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах, шүүгчээс хэрэг, маргааныг хуулийн хугацаанд шуурхай хянан шийдвэрлэх зорилт алдагдах тохиолдол цөөнгүй байдаг. Иймд шүүгчийг татгалзах гаргах асуудлыг ямар субъект, ямар тохиолдолд гаргах, шүүгч өөрөө татгалзан гарах, татгалзах хүсэлтийг шийдвэрлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндрэл үүсгэх зэрэг асуудлыг хөндөж, зарим санал, дүгнэлт өгөхийг зорив.

Нэг. Эрх зүйн зохицуулалт

Шүүгчийг татгалзан гаргах, шүүгчийн татгалзалтай холбоотой хүсэлтийг шийдвэрлэх журмын талаар хууль эрх зүйн бусад актад дараах байдлаар зохицуулсан. Тухайлбал, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д “Шүүгч шүүн таслах ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал байгаа бол өөрөө татгалзан гарах, эсхүл хэргийн оролцогчдод мэдэгдэж, тэдгээрийг татгалзах хүсэлт гаргах боломжоор хангана.” гэж заасан.

Улмаар процессын хуулиудад тухайлбал, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 85 дугаар зүйл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4 дугаар зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91, 92, 93 дугаар зүйлүүдэд тухайлан зохицуулжээ.

Нөгөөтээгүүр Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.4-т шүүхийн үйлчилгээ шуурхай, хүртээмжтэй байх зарчмыг тодорхойлсон. Өөрөөр хэлбэл хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх хугацаанд тухайн маргаан бүхий хэргийг бүрэн шийдвэрлэдэг байх нь аль ч шүүх, шүүгчийн үйл ажиллагаандаа баримтлах ёстой үндсэн зарчим юм.

Хууль болон Хуульчийн мэргэжлийн дүрэмд шүүгчийн татгалзан гарах үндэслэлийг заасан байх бөгөөд үүнээс өөр үндэслэлээр татгалзах, хэргийг заавал шийдвэрлэх үүргээ зөрчих ёсгүй. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийн 16.1-д “Шүүгч хуулиар хүлээсэн үүргээ бодитой, шударга, төвийг сахиж гүйцэтгэхэд саад учруулах үндэслэл бүхий эргэлзээ байвал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзаж болно.” гэжээ. Дүрмийн эл зохицуулалтын **“саад учруулах үндэслэл бүхий эргэлзээ байвал”** гэдгийг хэрхэн ойлговол зохилтой вэ? практик яаж хэрэгжүүлэх вэ гэдэг асуудал маргаантай бөгөөд чухал асуудал гэж үзэж байна.

Хоёр. Практик нөхцөл байдал

Шүүгч өөрөө татгалзах үндэслэл бүхий эргэлзээ байхгүй бол хэрэг маргааныг заавал шийдвэрлэх үүрэгтэй. Хэрвээ шүүгч хуульд заасан үндэслэлгүйгээр татгалзах нь түүний нэр хүндийг унагадаг, ёс зүйгүй явдал болох юм. Өөрөөр хэлбэл шүүгчийн нэр хүнд, шүүгчийн үүргээ хүндлэх хүндлэл буурна, бусад шүүгчид өгөх ачаалал нэмэгдэнэ, маргаантай эсвэл олон нийтийн дургүйцлийг төрүүлсэн асуудал бүхий хэргийг шийдвэрлэхээс зайлсхийх нөхцөл бүрдэх тул үндэслэлгүй татгалзлыг ашиглахгүй ёс зүйтэй байхыг шүүгчээс шаарддаг.¹

Хэргийн оролцогчид нь шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг гаргахдаа дийлэнхдээ “уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал” гэдэг үндэслэлээр татгалздаг талаар Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Хулан “Шударга шүүхээр шүүлгэх эрхийн хэрэгжилт, шүүгчийг татгалзах” сэдэвт өгүүлэлдээ: Хуульд заасан *“уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал”* гэдэгт хэргийн аль нэг оролцогчоос шүүгчийн талаар нөгөө талын оролцогчдын нөлөөнд автсан буюу автаж болзошгүй талаар тодорхой баримттай мэдээллийг гаргасан байх, уг гаргасан мэдээлэл, хүсэлт нь баталгаа нотолгоотой байх ёстой. Гэтэл шүүхийн практикаас харахад энэ үндэслэлээр гаргаж байгаа хүсэлтүүд нь хэргийн оролцогчдын эрхийг зөрчсөн, эрхийг нь хязгаарласан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн гэсэн үндэслэлээр **шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар эргэлзээтэй** гэж шүүгчийг татгалзаж байгаа нь шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх, хэрэг

¹ “Шүүх эрх мэдэл” Мэдээлэл, арга зүйн улирал тутмын эмхэтгэл (2016 он, дугаар №3)88 дахь тал “Шударга шүүхээр шүүлгэх эрхийн хэрэгжилт, шүүгчийг татгалзах” Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Хулан



хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг удаашруулах зэрэг сөрөг нөхцөл байдлыг үүсгэж байна. Өөрөөр хэлбэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг хуульд заасан үндэслэлээр хангах, хангахаас татгалзах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шүүгч өөрөө удирдах явуулах бөгөөд хүсэлтийг хангахаас татгалзаж байна гэсэн үндэслэлээр шүүгчээс татгалзах нь тухайн шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцох үр дагаврыг үүсгэж байна” гэж дурджээ.²

Шүүхийн процесст оролцдог бусад хуульчид шүүх хуралдааныг хойшлуулах, процессыг саатуулан барих тактикаас сэргийлэхийн тулд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд уг асуудлыг журамлан тогтоохыг зөвлөжээ. Энэ асуудал манай улсын тухайд шүүхийн үйлчилгээний тулгамдсан бэрхшээл хэвээр байгаа тул эндээс санаа авч хийх зүйл цөөнгүй байна.³

Хэргийг хуульд заасан хугацаанд түргэн шуурхай хянан шийдвэрлэх нь хэргийн оролцогч нарыг удаан хүлээлгэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах, хэргийн оролцогчдын шүүхийн өмнө эрх тэгш байх боломжийг хангах, шүүхийн үйлчилгээг шуурхай хүргэх, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтооход чухал ач холбогдолтой билээ.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах, шүүх хуралдаан хойшлох нь олон хүчин зүйлээс хамаарч буй, шалтгаан, нөхцөлтэй боловч түүний нэг нь шүүгч, шүүх бүрэлдэхүүн, тухайн шүүхийн бүх шүүгчдийг татгалзах талаар гаргаж буй хүсэлт түүний шийдвэрлэлтийн процессоос хамааралтай хойшлолт байдаг.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 4 дүгээр бүлгийн 4.2 дугаар зүйлийн 1-д өмгөөлөгч нь үйлчлүүлэгчийнхээ ашиг сонирхолд нийцүүлэн хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулах талаар чармайн ажиллана. 2-т өмгөөлөгч нь хувийн ашиг сонирхлоо тэргүүнд тавих, эсрэг тал эрхээ хамгаалахад нь саад учруулах, залхаах, шүүхийг мэхлэх зэргээр хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах эсхүл хойшлуулахыг хориглоно...” гэж заасан.

Хэргийн оролцогчдоос шүүх хуралдааныг хойшлуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулахын тулд хэрэгжүүлж буй ажиллагааны нэг нь шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг, тухайн шүүхийн бүх шүүгчдийг татгалзах талаар гаргаж буй хүсэлт түүний шийдвэрлэлтийн процессоос үүдэлтэй нөхцөл байдал гэж хэлэхэд зарим талаар хатуудахгүй болов уу. Гэхдээ мэдээж үнэхээр татгалзах нөхцөл бүрдсэн тэр нь үндэслэлтэй, нотлох баримттай маргаангүй нөхцөлд бол өөр хэрэг юм. Гэвч хэргийн оролцогчдоос гаргаж буй татгалзлын үндэслэл, түүний шийдвэрлэгдсэн байдлаас харахад үнэхээр

² Мөн тэнд

³ Шүүхийн хараат бус байдал /олон улсын баримт бичиг/ Уб.2019, 7 дахь тал “Өмнөтгөл” хэсэгт тухайн үеийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, доктор, профессор Н.Лүндэндорж энэ талаар тэмдэглэжээ.

үндэслэл бүхий татгалзал гаргадаг эсэх нь эргэлзээтэй байна. Тухайлбал,

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн “Шүүх хуралдаан хойшилж байгаа үндэслэл, шалтгаанд хийсэн мониторинг” хийсэн судалгаанаас үзэхэд:

Удаа дараа шүүх хуралдааныг хойшлуулж, хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан хугацаа хэтэрч байгаа үндэслэл, хугацааг улсын хэмжээнд 2019 оны 5 дугаар сарын 1-ний байдлаар судалж үзвэл нийт ажиллагаанд байгаа иргэний хэргийн 47% нь 1-60 хоног, 20% нь 61-120 хоног, 6% нь 121-150 хоног, 27% нь 151-ээс дээш хоногоор буюу иргэний хэрэг үүсгэснээс хойш 240 хоног /8 сар/ өнгөрсөн байна. /Энэ хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх 90 хоногийн хугацаа ороогүй болно.⁴

Ийнхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа хэтэрч, шүүх хуралдаан хойшилж буй шалтгаан үндэслэлийн нэг хэсэг нь хэргийн оролцогчоос үндэслэлтэй, ихэнх тохиолдолд үндэслэлгүй шүүгчээс татгалзах тухай хүсэлт, түүний шийдвэрлэлтийн байдал юм.

Тухайлбал, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдаан хойшилж буй байдал түүнд хийсэн дүн шинжилгээнээс⁵ харахад 2015 онд 7405 шүүх хуралдаан товлогдсоноос 77 хувь нь буюу 5721 шүүх хуралдаан хойшилсон байна. Нийт хойшилсон шүүх хуралдааныг хойшилсон үндэслэлд шүүгчээс татгалзах хүсэлт гаргасан үндэслэлээр 42 /0.7 хувь/ нь хойшилсон байна.

Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс 2016 оны 4 дүгээр сарын 25-ны байдлаар нийт 82 шүүгчээс татгалзсан хүсэлтийг тус дүүргийн ерөнхий шүүгч шийдвэрлэснээс 4 нь хүлээн авч үлдсэн 74 татгалзлыг хангахгүй орхиж шийдсэн байх бөгөөд гаргасан татгалзлын дийлэнх олонх нь буюу 73 нь Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1.3-т заасан *“хэргийн оролцогчтой хувийн харилцаатай, түүнчлэн уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал”* гэсэн үндэслэлээр гаргаж эл үндэслэл нь няцаагдаж шийдвэрлэгдсэн талаарх судалгаа гарчээ.⁶

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдаан хойшилж буй байдал түүнд хийсэн дүн шинжилгээнээс⁷ харахад 2018 онд улсын

⁴ <http://www.supremecourt.mn/act/view/273>, сүүлд үзсэн 2021.12.15

⁵ “Шүүх эрх мэдэл” Мэдээлэл, арга зүйн улирал тутмын эмхэтгэл (2016 он, дугаар №1), 111 дэх тал “Захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдийн шүүх хуралдаан хойшилолт 2015 он” ШЕЗ, Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэс

⁶ “Шүүх эрх мэдэл” Мэдээлэл, арга зүйн улирал тутмын эмхэтгэл (2016 он, дугаар №3), 90 дэх тал. “Шударга шүүхээр шүүллэг эрхийн хэрэгжилт, шүүгчийг татгалзах” Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Хулан

⁷ “Шүүх эрх мэдэл” Мэдээлэл, арга зүйн улирал тутмын эмхэтгэл (2019 он, дугаар №2), 55 дахь тал “Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдаан хойшилж буй байдал түүнд хийсэн дүн шинжилгээ 2018 он” ШЕЗ, Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэс, Х.Билгүүнзаяа



хэмжээнд захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдэд нийт 5273 шүүх хуралдаан товлогдсоноос 74.8 хувь нь буюу 3946 шүүх хуралдаан хойшилсон байна. Нийт хойшилсон 3946 шүүх хуралдааныг хойшилсон үндэслэлд нэхэмжлэлийг шаардлагаа нэмэгдүүлсэн, өөрчилсөн, **шүүгчээс татгалзах хүсэлт гаргасан**, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргасан, өмгөөлөгч авах хэргийн материалтай танилцах хүсэлт гаргасан үндэслэлээр 899/22.7 хувь/ үүнээс **шүүгчээс татгалзах хүсэлт гаргасан үндэслэлээр** 35/3.8 хувь/ нь хойшилсон байна. Энэ судалгаанаас харахад хойшилсон шалтгаан үндэслэлийн нэг нь “шүүгчээс татгалзах хүсэлт гаргасан” гэсэн эл үндэслэл байх бөгөөд зохих хувийг эзэлдэг болох нь ч харагдаж байна.

Харин Иргэний хэргийн анхан шатны шүүхүүд дэх шүүх хуралдаан хойшилсон үндэслэлд шүүгчээс татгалзах хүсэлт гаргасан үндэслэлээр 445/7.8 хувь/ нь хойшилсон байна.

Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн 2020 оны шийдвэрлэсэн хэргээс хуулийн хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн хэрэгт хийсэн дүн шинжилгээнээс харахад⁸ хуулийн хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн болон хуулийн хугацаа хэтэрсэн хэргийн гол шалтгаан нь шүүх хуралдаан хойшилсонтой холбоотой байна.

Хэргийн оролцогчдод хуульд заасан эрхээ эдэлж нэмэлт нотлох баримт цуглуулах, шүүгчээс татгалзах, шүүх хуралдаанд биечлэн оролцох зэрэг хүсэлт гаргаж байгаа нь шүүх хуралдаан хойшилж буй шалтгааны 56.9 хувийг эзэлж, хуулийн хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа хэтрэлт нь шүүхээс шалтгаалахгүйгээр хэргийн оролцогчдоос хамааралтай гэдгийг харуулж байна. Нийт хойшилсон шүүх хуралдааны тоо 5861 байна. Үүнээс хойшилж буй шалтгааныг үзэхэд, нэмэлт нотлох баримт цуглуулах 1483, **шүүгчээс татгалзах** 62 буюу шүүх хуралдаан хойшилсон шалтгааны 1 хувийг эзэлжээ.

Дээрх судалгаанаас харахад хэргийн хуулийн хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа хэтрэлт нь шүүхээс шалтгаалахгүйгээр хэргийн оролцогчдоос хамааралтай болох нь харагдаж байх бөгөөд ийнхүү хойшилдог шалтгаан үндэслэлийн нэг нь яах аргагүй **“шүүгчээс татгалзах”** хүсэлт гаргасан үндэслэл орж байх бөгөөд дээрх судалгаануудаас харахад багагүй хувийг эзэлдэг болох нь мөн харагдаж байна.

Мөн 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэлх хугацаанд аймгуудын захиргааны хэргийн анхан шатны шүүхийн “бүх шүүгчдээс татгалзах” хүсэлтийг шийдвэрлэсэн шүүгчдийн

⁸ “Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа хугацаа хэтэрсэн хэргийн талаар /2020 он/”ШЕЗ-ийн Хэргийн хөдөлгөөний бүртгэл, дүн шинжилгээ хариуцсан ахлах шинжээч М.Сэлэнгэ

зөвлөгөөний тогтоолоос үзэхэд⁹ захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс **“тухайн шатны шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан хүсэлт”**-ийг зөвлөгөөний тогтоолоороо шийдвэрлэсэн 32 тогтоол байна. Ийнхүү 21 аймгийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс “тухайн шатны шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан” хүсэлтийг шийдвэрлэхдээ хүсэлтийг хангаж, адил шатны өөр шүүхэд шилжүүлэхээр шийдвэрлэсэн нь ихэнх буюу 19 тогтоол гарсан байна.

Тухайн шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн тогтоолын хувьд ихэвчлэн хэргийн оролцогчоос өмнө нь ерөнхий шүүгчийг эсхүл аль нэг шүүгчийг татгалзах хүсэлт гаргасан эсхүл шүүгч өөрөө татгалзсан байх бөгөөд эцэст бүх шүүгчийг татгалзах хүсэлт гаргасан байх нь түгээмэл байна. Түүнчлэн тухайн шүүхийн бүх шүүгчдээс татгалзах хүсэлтийг анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс хангаж шийдвэрлэсэн тогтоолоос харахад тухайн хэргийн хувьд шүүх хуралдаан хэд хэдэн удаа товлон зарласан, өмнө нь шүүгч болон бүх шүүгчдээс татгалзах гаргах хүсэлт гаргаж байсан болон бусад шалтгаануудаар шүүх хуралдааныг удаа дараа хойшлуулсан талаар мөн дурджээ.

Ийнхүү бүх шүүгчийг татгалзах хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн зөвлөгөөний тогтоолын үндэслэлд ихэвчлэн *“... хэдийгээр тус шүүхийн шүүгч нар нь дээрх хэрэгтэй холбоотойгоор аливаа этгээдийн нөлөөлөлд автсан нөхцөл байдал тогтоогдоогүй боловч хүсэлт гаргагч талын ... иргэдийн шүүх эрх мэдэлд итгэх итгэлийг хадгалах, эргэлзээ, шүүхэд итгэх итгэл үнэмшлийг хүндэтгэн, дэмжих үүрэгтэй байна ...”* гэсэн нийтлэг дүгнэлт хийж хүсэлтийг хангасан байна.

САНАЛ, ДҮГНЭЛТ

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практик, энэхүү сэдвээр хөндсөн татгалзлын асуудлыг процессын хуульд нарийвчлан зохицуулах, сайжруулах шаардлагатай дараах асуудал байна. Тухайлбал,

1. ЗХШХШТХ-ийн 85 дугаар зүйлийн 85.1-д *“... татгалзан гаргах хүсэлтийг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч гаргаж болох ба энэ тохиолдолд татгалзан гаргагдаж байгаа этгээдийн тайлбарыг сонсож болно”* гэж заасан. Хуулийн эл зохицуулалтаас харахад заавал хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч бүгд давхардуулан татгалзах хүсэлт гаргахыг шаардаагүй. Хуулийн энэ зохицуулалтаар нэгэнт эдгээр субъектэд нээлттэй байдлаар эрх олгосон зохицуулалт учраас үндсэн шалтгаан нь угтаа шүүх хуралдааныг хойшлуулах л зорилгоор /зарим тохиолдолд үнэхээр үндэслэл бүхий татгалзал байхыг

⁹ Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системээс 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэлх хугацаанд аймгуудын захиргааны хэргийн анхан шатны шүүхийн “бүх шүүгчдээс татгалзах” хүсэлтийг шийдвэрлэсэн шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг шүүж үзэж уг судалгааг гаргав. (Сүүлд үзсэн: 2022-01-15)



үгүйсгэхгүй/ эхлээд хэргийн оролцогч, дараа нь тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч гэх мэтээр шүүгч, шүүх бүрэлдэхүүн, тухайн шүүхийн бүх шүүгчдээс татгалзах хүсэлт гаргах, үүнээс үүдэн хэргийн нөгөө тал шүүхийн үйлчилгээг түргэн, шуурхай авч чадахгүйд хүрэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуулийн хугацаанд явагдаж чадахгүйд хүрэх тохиолдол үүсэж байна.

2. ЗХШХШТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.1. дэх хэсэгт “Нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийг хэргийн оролцогч гэнэ.”, 17.2. дахь хэсэгт *“Нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн төлөөлөгч, өмгөөлөгч нь захиргааны хэргийн бие даасан оролцогч бус зөвхөн төлөөлүүлж, өмгөөлүүлж байгаа этгээдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалж байгаа этгээд мөн”* гэж заасан. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ч нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд гэсэн хэргийн оролцогч талууд нь тус тусынхаа ашиг сонирхлын хувьд нэгдмэл байдалтайгаар л оролцож байгаа. Түүнээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогч нэг өөр байр суурьтай, төлөөлөгч, өмгөөлөгч нь өөр байр суурьтай байх боломжгүй бөгөөд төлөөлүүлж, өмгөөлүүлж байгаа этгээдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлэн оролцож буй нь ойлгомжтой юм.

Иймд *“...татгалзан гаргах хүсэлтийг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч гаргаж болох”* хуулийн эл зохицуулалтад тодорхой хязгаарлалтыг тухайлбал хэргийн оролцогч өөрөө эсхүл хэргийн оролцогчийн өмгөөлөгч л татгалзах хүсэлт гаргаж болохоор зохицуулах шаардлагатай байна. Ийнхүү зохицуулснаар хэргийн оролцогч-төлөөлөгч-өмгөөлөгч нар тухай бүр шүүгч, шүүх бүрэлдэхүүн, тухайн шүүхийн бүх шүүгчдээс татгалзах хүсэлт гаргах замаар шүүх хуралдааныг хойшлуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах нөхцөл байдлыг багасгах боломжтой.

3. ЗХШХШТХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.1-д шүүгчийг татгалзан гаргах зургаан үндэслэлийг дурдсан бөгөөд эдгээрээс хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчөөс практикт ихэвчлэн гаргадаг хүсэлт нь 84.1.3-т заасан *“хэргийн оролцогчтой хувийн харилцаатай, эсхүл уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал”* гэсэн үндэслэл юм. Гэтэл хуулийн эл зохицуулалтын *“уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал”* гэдэг энэ нөхцөлт гипотез зохицуулалт нь яг тодорхой шалгуур, үзүүлэлт байхгүй нарийвчлан тогтоох боломжгүй буюу хэт ерөнхий байдлаар томъёолсон зохицуулалт байдаг. Хуулийн энэ хэсэгт *“үндэслэл бүхий эргэлзээ байвал”* гэж тодруулан тусгасан хэдий ч үүнийг үндэслэлтэйгээр нотолж, хүсэлт гаргах нь бараг үгүй бөгөөд гагцхүү хардах байдлаар *“та энэ хүсэлтийг хэрэгсэхгүй болгож байгаа учраас*

г.м” эргэлзээ төрж байна гэх мэт агуулгаар хүсэлтийг гаргах нь элбэг тохиолддог. Ер нь аливаа эрх зүйн хэм хэмжээний зохицуулалт хэт ерөнхий хийсвэр байх тусмаа тухайн зохицуулалтаас үүдэлтэй хүндрэл бэрхшээл үүсэх аливаа этгээд дур зоргоороо ойлгох, маргах боломжийг олгож байдаг.

Иймд ЗХШХШТХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.1.3-т заасан “.... эсхүл уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал” гэх заалтыг хасах¹⁰ шаардлагатай байна. Улмаар ямар нэгэн үндэслэлгүйгээр таамгаар хүсэлт гаргаж түүнийг нь шийдвэрлэхээс өөр аргагүйд хүргэдэг нэмэлт процесс гаргахгүй байхад чухал ач холбогдолтой юм. Хуулийн энэ зүйлийн бусад зохицуулалтын хувьд харьцангуй тодорхой буюу шүүгч өөрөө татгалзах болон татгалзан гаргах хүсэлт гаргахад түүнийг үндэслэлтэй эсэхийг шийдвэрлэхэд ч ойлгомжтой юм.

4. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нэг үндэслэлээр ээлжлэн татгалзах хүсэлтийг ихээр гаргадаг. Энэ үндэслэл нь ЗХШХШТХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.1.3-т заасан “.... эсхүл уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал” гэдэг үндэслэлээр хэргийн оролцогч өөрөө татгалзах хүсэлтийг гаргаж түүнийг шийдвэрлүүлсэн бол хэргийн оролцогчийн төлөөлөгч эсхүл өмгөөлөгч мөн ижил эл үндэслэлээрээ дахин татгалзах хүсэлт гаргах эрхгүй байхаар хуульд өөрчлөлт оруулах.
5. ЗХШХШТХ-ийн 85 дугаар зүйлийн 85.1-д “Энэ хуулийн 84.1-д заасан үндэслэлээр шүүгч,....татгалзан гаргах хүсэлтийг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч гаргаж болох ба энэ тохиолдолд татгалзан гаргах хүсэлтийг хуулийн 85 дугаар зүйлд заасан журмаар шийдвэрлэхээр зохицуулсан. Татгалзан гаргах хүсэлтийг хэрхэн шийдвэрлэх процесс журмын хувьд цаашид сайжруулах шаардлагатай хэд хэдэн зүйл байгаагийн нэг нь энэ төрлийн хүсэлтийг ямар хугацаанд шийдвэрлэх вэ гэсэн асуудал юм. Өөрөөр хэлбэл хуульд яг энэ төрлийн хүсэлтийг ямар хугацаанд шийдвэрлэх нь тодорхой зохицуулалтгүй учраас шүүхүүдэд янз бүрийн хугацаанд шийдвэрлээд явж буй. Тиймээс энэ төрлийн хүсэлтийг шийдвэрлэх хугацааг жишээ нь 3 хоногийн дотор гэх мэт байдлаар нарийвчлан зааж өгөх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ойлгомжтой тодорхой журамлагдсан байх, хэргийн оролцогчдод хүлээлт үүсгэхгүй байхад ач холбогдолтой гэж үзэж байна.

¹⁰ Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэлээдгүй шүүгч нар эл саналыг мөн гаргажээ. Захиргааны хэргийн шүүхийн шүүн таслан ажиллагаанд хэрэглэд гол хуулийг боловсронгуй болгох асуудал” судалгааны тайлангаас Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн .Уб., 209.9 дэх тал /Баян-Өлгий аймаг дахь ЗХАШШ. Санал №7. Нийслэл дэх ЗХАШШ. Санал №3. Орхон аймаг дахь ЗХАШШ. Санал №4./



6. Захиргааны хэргийн шүүхийн хувьд, шүүх хуралдааныг хуралдаан даргалагч шүүгч нээж, ямар хэрэг хянан шийдвэрлэх гэж байгааг зарлан мэдэгдэж, танхимд байгаа хүмүүст суухыг зөвшөөрснөөр шүүх хуралдаан эхэлдэг. Ийнхүү хуралдааныг нээснээс эхлээд шүүхийн шийдвэрийг танилцуулах, шүүх хуралдааныг хаах хүртэлх бүх процесс ЗХШХШТХ-ийн 89-108 дугаар зүйлийн зохицуулалтын дагуух журам, дарааллаар болдог. Шүүх хуралдааны энэ журам, дарааллын дагуу хуралдааныг даргалагч шүүгч ЗХШХШТХ-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу шүүх бүрэлдэхүүнийг зарлан, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг танилцуулж, тэдгээрийг татгалзан гаргах эрхтэйг тайлбарлаж татгалзан гаргах хүсэлт байгаа эсэхийг хэргийн оролцогчдоос тодруулдаг. Улмаар хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгчийн эрх, үүргийг тайлбарлах, /95 дугаар зүйл/, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчөөс санал, хүсэлтийг асууж шийдвэрлэх, хэрэг хэлэлцэх гээд үргэлжилдэг.

Шүүхийн практикт ЗХШХШТХ-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу шүүх бүрэлдэхүүнийг зарлан, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг танилцуулж, тэдгээрийг татгалзан гаргах эрхтэйг тайлбарлаж татгалзан гаргах хүсэлт байгаа эсэхийг хэргийн оролцогчдоос тодруулсны дараа, хэргийн оролцогч нь хүсэлт гаргах эрхтэй /ЗХШХШТХ-ийн 95, 96 дугаар зүйл/. Уг хүсэлтийг шүүгч, шүүх бүрэлдэхүүн хэрхэн шийдвэрлэснээс хамаараад хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч шүүгчээс татгалзах хүсэлт гаргах тохиолдол байдаг. Өөрөөр хэлбэл хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байгаад тань эргэлзэж шүүгчээс татгалзах хүсэлт гаргаж байна гэдэг. Ингээд цааш үргэлжлэн хэргийг хэлэлцэх боломжтой байсан шүүх хуралдаан уг татгалзлын асуудлыг шийдвэрлэхээр хойшлохоос аргагүйд хүрэх тохиолдол практикт цөөнгүй гардаг.

Иймд ЗХШХШТХ-ийн 94 дүгээр зүйл болон 84, 85 дугаар зүйлийн холбогдох хэсэгт “Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар шүүх бүрэлдэхүүнийг танилцуулан, татгалзан гаргах эрхтэйг тайлбарласны дараа шүүгчийг татгалзан гаргах хүсэлт дахин гаргахыг хориглосон заалт нэмэлтээр оруулах” шаардлагатай.¹¹ ЗХШХШТХ-ийн 84.1 болон 84.4-т “Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг танилцуулан, татгалзан гаргах эрхтэйг тайлбарласны дараа шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргахыг хориглосон заалт нэмэлтээр оруулах”

7.

¹¹ Энэ агуулгаар Баян-Өлгий, Орхон аймаг, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нар мөн санал өгсөн байдаг. Захиргааны хэргийн шүүхийн шүүн таслан ажиллагаанд хэрэглэд гол хуулийг боловсронгуй болгох асуудал” судалгааны тайлангаас Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн .Уб., 2019 он.9 дэх тал /Баян-Өлгий аймаг дахь ЗХАШШ. Санал №7. Нийслэл дэх ЗХАШШ. Санал №3. Орхон аймаг дахь ЗХАШШ. Санал №4./

8. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийн 16.1-т “Шүүгч хуулиар хүлээсэн үүргээ бодитой, шударга, төвийг сахиж гүйцэтгэхэд саад учруулах үндэслэл бүхий эргэлзээ байвал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзаж болно” Дүрмийн эл зохицуулалтын **“саад учруулах үндэслэл бүхий эргэлзээ байвал”** гэдгийг хэрхэн ойлговол зохилтой вэ? практик яаж хэрэгжүүлэх вэ гэдэг асуудал маргаантай бөгөөд чухал асуудал гэж үзэж байна. Учир нь удаа дараа хэргийн оролцогч-өмгөөлөгч-итгэмжлэгдсэн төлөөлөгч гэх мэтээр ээлжлэн татгалзах, өөр өөр үндэслэлүүд хэлж шүүгчийг цаашилбал тухайн шүүхээс татгалзах нь ч бий үүнээс үүдэн хэргийг шийдвэрлэх ажиллагаанд саад учрах, шүүх ажиллагаа явуулах боломжгүйд хүрэх ч нөхцөл үүсэж болно. Энэ тохиолдолд “шүүгч хуулиар хүлээсэн үүргээ бодитой, шударга, төвийг сахиж гүйцэтгэхэд саад учруулах үндэслэл бүхий эргэлзээ байвал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзаж болно” гэсэн зохицуулалтыг 84 дүгээр зүйлд нэмэлтээр оруулж өгөх. Мөн энэ тохиолдолд ЗХШХШТХ-ийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт заасан журмаар шийдвэрлэдэг байх. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийн 16.1-т мөн ийм агуулга бүхий зохицуулалт бий үүнийг хуульд шууд тусгаж өгөх нь эрэмбийн хувьд илүү ач холбогдолтой.
9. ЗХШХШТХуулийн 84 дүгээр зүйл 84.1-т “Дараахь үндэслэл байвал шүүгч хэрэг хянан шийдвэрлэхэд үл оролцох ба өөрөө татгалзан гарах үүрэгтэй:” гээд шүүгч өөрөө татгалзан гарах үндэслэлийг мөн эл үндэслэлээр татгалзан гаргах хүсэлтийг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч гаргаж болохоор заасан. Хэрэв шүүгч татгалзан эл үндэслэл бүрдээд татгалзан гарсан тохиолдолд тухайн хэргийг хэрхэн өөр шүүх, *татгалзлыг хэрхэн шийдвэрлэх журмыг боловсронгуй болгох замаар тухайн шүүгчийн ажиллагаанд байсан уг хэргийг бусад шүүх, шүүгчид хэрхэн хуваарилах асуудлыг мөн л нарийвчлан зохицуулах шаардлага* байна. Хэдийгээр энэ зохион байгуулалтын асуудал мэт боловч шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэхэд мөн л харгалзан үзэх нөхцөлийн нэг мөн юм.
10. ЗХШХШТХуулийн 85 дугаар зүйл 85.6. дахь хэсэгт “Ерөнхий шүүгч дангаар хэрэг хянан шийдвэрлэх явцад түүнийг татгалзсан, эсхүл тухайн шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан бол шүүгчдийн зөвлөгөөн олонхын саналаар шийдвэрлэнэ” гэж заасан. Хуулийн эл зохицуулалтад заасан “Ерөнхий шүүгч дангаар хэрэг хянан шийдвэрлэх явцад түүнийг татгалзсан” гэсэн эл үндэслэлийн хувьд тухайн шүүхийн бусад шүүгчдээс бүрдсэн шүүгчдийн зөвлөгөөн шийдвэрлэх боломжтой, энэ нь зөрчилгүй байж болох нь харагдаж байна.



Харин хуулийн эл үндэслэлийн **тухайн шүүхийн бүх шүүгчийг татгалзсан бол** тухайн шүүхийн шүүгчдээс бүрдсэн шүүгчдийн зөвлөгөөн олонхын саналаар уг татгалзлыг шийдвэрлэж болох уу? шийдвэрлэх нь хир оновчтой вэ? гэдэг асуудал үүсэж болохоор харагдаж байна. Практикт тухайн шатны шүүхийн шүүгчдийн өөрсдийн зөвлөгөөнөөр **“тухайн шүүхийн бүх шүүгчийг татгалзсан”** хүсэлтийг шийдвэрлэж, хүсэлтийг хангасан бол мөн адил шатны өөр захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлүүлэхээр шийдсэн тохиолдол байна. Мөн ЗХШХШТХуулийн 85 дугаар зүйлийн 85.3-т “Шүүгчийг татгалзан гаргах тухай асуудлыг түүнийг **байлцуулахгүйгээр** бусад шүүгчид шийдвэрлэх ба санал тэнцвэл уг шүүгчийг татгалзан гаргасанд тооцно.” Эл зохицуулалтыг хэрхэн ойлгох вэ? Өөрөөр хэлбэл тухайн шатны бүх шүүгчдээс татгалзсан байхад тухайн шүүх шүүгчдийн зөвлөгөөнөөрөө татгалзах хүсэлт үндэслэлтэй эсхүл үндэслэлгүй гэж шийдэх нь оновчтой эсэхэд эргэлзээ үүсэхээр байна.

Нөгөө талаас хуулийн эл зохицуулалтын “шүүгчдийн зөвлөгөөн гэдэг” нь өөр адил шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөн байж болох уу? эсхүл тухайн шүүхийн өөрийнх нь шүүгчдийн зөвлөгөөнийг л ойлгох уу гэдэг ч бас эргэлзээтэй байж болохоор байна.

Энэ тохиолдолд мөн хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт заасан *“Тухайн шүүхийн бүх шүүгчийг татгалзан гаргасан, эсхүл бүх шүүгч уг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуульд заасан үндэслэлээр дахин оролцох боломжгүй болсон тохиолдолд хэргийг анхан шатны өөр захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлүүлэхээр тухайн шүүхийн Ерөнхий шүүгч шилжүүлнэ.”* Эл үндэслэлээр өөр адил шатны шүүхэд шууд шилжүүлж болох уу гэсэн асуудал мөн үүсэж болохоор байна.

Хуулийн дээрх зохицуулалтын **“бүх шүүгч уг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуульд заасан үндэслэлээр дахин оролцох боломжгүй болсон”** эл агуулгыг хэрхэн ойлгох вэ? Өөрөөр хэлбэл нэгэнт тухайн шатны бүх шүүгчдийг татгалзах хүсэлт гаргаад байгаа нөхцөлд хуулийн эл үндэслэлд хамааруулж ойлгож болох уу? /*нэгэнт тухайн шатны бүх шүүгчээр шийдвэрлүүлэхгүй гэж татгалзаж буй тохиолдолд*/ гэх мэт татгалзлын асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой зарим талаар тодорхойгүй, хоёрдмол утгаар ойлгогдож болох мэт зүйл байгааг цаашид процессын хувьд тодорхой болгон хуульчлах шаардлагатай болов уу.

АВЛИГЫН ХЭРГИЙН ШҮҮХ БА ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА

*Ц.Мөнх-Эрдэнэ
Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч, судлаач*

Удиртгал

2020 оны Авлигын индексийг иргэдийн үндсэн эрхийг хангах тогтолцоо, улс төрийн тогтвортой байдал, бодлогын тогтвортой байдал, хүчирхийллийг шийдвэрлэх арга хэлбэр, төрийн үйл ажиллагааны үр дүнтэй байдал, зохицуулагч байгууллагын үйл ажиллагааны чанар хүртээмж, хууль дээдлэх байдал, авлигын хяналт гэсэн асуудлуудад үнэлгээ хийж гаргажээ. Манай Улсын хувьд 180 орноос 111 дүгээрт эрэмбэлэгджээ.

Авлигын гэмт хэрэгтэй тэмцэх улс төрийн хүсэл эрмэлзлийг дотоод болон гадаадад илтгэх нэг асуудал нь Авлигын дагнасан шүүх байгуулах асуудал байдаг тул энэ талаарх олон улсын чиг хандлага, авлигын дагнасан шүүх байгуулсан улсын сайн туршлагыг харьцуулан судлах хэрэгцээ шаардлага байна гэж үзлээ.

Авлигын шүүхийн талаарх олон улсын чиг хандлага

Авлигатай тэмцэх гэмт хэрэг гэдэг нь нэг улсын асуудал бус олон улсын хэмжээнд анхаарал татсан асуудал болсон бөгөөд 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Авлигын Эсрэг ээлжит бус чуулганаар 73/191 дугаартай тогтоол баталж улмаар 2021 оны 6 дугаар сард Авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд тулгамдаж буй асуудал, авч хэрэгжүүлэх арга хэмжээ гэсэн сэдвээр НҮБ Ерөнхий Ассамблейн ээлжит чуулганыг товлон хуралдуулж гишүүн орнуудын зүгээс өөрсдийн эрмэлзлийг илэрхийлсэн Улс төрийн тунхаглалыг гаргажээ. Энэхүү улс төрийн тунхаглалаар Авлигаас урьдчилан сэргийлэх, үр дүнтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал болон олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн гишүүн улс орнуудын оролцоог тодорхойлж "... аливаа улс орон ганцаараа авлигатай үр дүнтэй тэмцэх боломжгүйг ойлгох хэрэгтэй учир нь авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх гэдэг нь цогц ойлголт бөгөөд үндэстэн дамнасан авлига, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд олон улсын түвшинд хамтаараа хариуцлагатай хандаж олон улсын хамтын ажиллагааг дэмжиж эрх зүйн харилцан туслалцааны гэрээг өргөн хүрээнд ашиглахыг..." санал болгож цаашид Олон улсын авлигын шүүх байгуулах талаарх санаачилга гаргажээ¹.

¹ Anti-corruption courts.(n.d).Retrieved from U4 Anti-Corruption Resource Centre. <https://www.u4.no/topics/anti-corruption-courts/basics>,



Олон улсын авлигын шүүх

Олон улсын авлигын шүүх байгуулах саналыг дэмжигчид нь олон улсын байгууллагуудыг Олон улсын авлигын шүүхийн харьяаллыг бусад орнуудаар хүлээн зөвшөөрүүлж мөн улс орнуудад хууль эрх зүйн институцын шинэчлэл хийж авлигын дагнасан шүүх, прокурорыг байгуулуулах талаар дэмжлэг үзүүлэх боломжтой гэж үзжээ. Ингээд олон улсын авлигын шүүх байгуулах санал санаачилга мөн хөгжиж буй улсуудад авлигын дагнасан шүүх байгуулах талаарх туршлагыг цааш өгүүлье.

Олон улсын авлигын шүүхийн байгуулагдсанаар “Grand Corruption”-тай үр дүнтэй тэмцэх боломжтой юм. “Grand Corruption” гэдэг нь товчхондоо төрийн байгууллагууд төрийн өндөр албан тушаалтнуудын (төрийн тэргүүнүүд) дэмжлэгтэйгээр хувийн ашиг орлогоо нэмэгдүүлж буй авлигын хэлбэр юм. Хөгжиж буй орнуудын хууль сахиулагчид нь авлигад идэгдсэн төрийн өндөр албан тушаалтнуудын нөлөөнд байдаг учраас томоохон авлигын гэмт хэргийн эсрэг дорвитой арга хэмжээ авч тэмцэж чадахгүй байгаа учраас олон улсын түвшинд “Grand Corruption”-тай үр дүнтэй тэмцэж чадахуйц Олон улсын авлигын шүүхийг Олон улсын эрүүгийн шүүхтэй төстэй байдлаар прокурорын байгууллагын хамт байгуулах нь илүү үр дүнд хүрнэ гэж судлаачид үзэж байна.² Энэхүү санаачилгын талаар санал шүүмжлэлүүд нэлээдгүй өрнөж байгаагийн нэг нь авлигад идэгдсэн улсын төрийн тэргүүнүүд өөрсдийгөө эрсдэлд оруулж Авлигын олон улсын шүүхэд нэгдэх эсэх нь ч бас эргэлзээтэй. Энэхүү шүүх нь улс орнуудын бие даасан байдалд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай гэж үзэж байгаа ч улс орон бүрийн төлөөлөл тухайн шүүхэд орсон тохиолдолд ийм сөрөг нөлөө гарахгүй гэж үзэж байгаа юм байна. Зарим судлаачид Олон улсын эрүүгийн шүүх байсаар байхад яагаад авлигын дагнасан олон улсын шүүх байгуулах ёстой гэж гэж асуудаг ч Олон улсын эрүүгийн шүүхийн хэргийн харьяаллыг хэрэгт Ромын дүрэмд геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг байна гэж заасан байдаг учир авлигын хэргийг Олон улсын эрүүгийн шүүх харьяалан шийдвэрлэх боломжгүй юм. Ямартай ч олон улсын түвшинд авлигад идэгдсэн орнуудын өндөр албан тушаалтнуудын авлигын хэрэгт зохих хариуцлага тооцож хулгайлагдсан хөрөнгийг олж авах зорилго бүхий Олон улсын авлигын шүүх байгуулах санал санаачилга гарч буйг мэдэж байх нь зөв гэж судлаачийн хувьд үзлээ.

Үндэстэн дамнасан авлигын гэмт хэрэг түүнтэй тэмцэх талаар

2018 оны байдлаар дэлхийн эдийн засгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувийг авлига эзэлж байгаа нь үндэстэн дамнасан авлигын гэмт хэргийн цар хүрээ ялангуяа ядуу буурай орнуудад илүү өргөжиж,

² The World Needs an International Anti-Corruption Court. (n.d). Retrieved from American Academy of Arts & Sciences. <https://www.amacad.org/publication/world-needs-international-anti-corruption-court>

хөгжсөөр байгааг харуулж байна. Гэтэл хөгжил буурай улс орнуудад хууль эрх зүйн хөгжил муу, улс төрийн хүсэл эрмэлзэл сул байгаагаас улс орон бүр мөнгө угаах болон авлигын гэмт хэрэгтэй амжилттай тэмцэж чадахгүй, төрийн өндөр албан тушаалтнууд нь ял шийтгэлээс зайлсхийж улс орнууд алдагдсан хөрөнгөө буцаан авч чадахгүй байгаа юм. 2001-2007 онд үйлдэгдсэн Siemens корпорацийн үндэстэн дамнасан авлигын хэргийг ХБНГУ болон АНУ-ын хууль сахиулагчид хамтран шалгаж амжилттай шийдвэрлэж чаджээ. Мөн Бразилын Odebrecht корпорацийн үндэстэн дамнасан авлигын хэргийг Бразилын прокурорын газар илрүүлэн АНУ-ын хуулийн байгууллагатай хамтран шалгаж өөр өөр орны шүүхийн харьяалалтай ч хэргийг хэрхэн үр дүнтэй шийдвэрлэсэн нь үлгэр жишээ болсон юм. Үүний үр дүнд улс орнууд авлигын хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд оногдуулсан торгуулийг хувь тэнцүүлэн өөр өөрсдийн хуулийн хүрээнд оногдуулж, зарцаасан хөрөнгийг хураан авах зэрэг ажиллагааг хэрэгжүүлж чаджээ³. Үндэстэн дамнасан авлигын хэргийг амжилттай шийдвэрлэсэн энэхүү сайн туршлагыг гадаад улсын хуулийн сургуулиудад Case study болгон судалдаг. Эрүүгийн эрх зүйн системийн зорилго нь олон улсын хамтын ажиллагаанд суурилсан нийгэм эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэж байна. Үндэстэн дамнасан авлигын хэргүүд нь маш нарийн аргаар үйлдэгддэг бөгөөд энэ төрлийн хэргийг шалгах ажиллагаа нь ч гэсэн энгийн хэргүүдийг бодвол онцлогтой хөгжиж байна. Хуулийн этгээдийг эрүүгийн гэмт хэрэгт шалгах буюу Corporate Prosecution нь шалгагдаж буй хуулийн этгээдийн хамтын ажиллагааг үндэслэн илүү үр дүнтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулах арга юм. Үндэстэн дамнасан гэмт хэргийг илрүүлж шалгаж шийдвэрлэсэн туршлага одоогоор манай улсад байхгүй ч эдийн засаг өргөжин тэлэхийн хирээр Corporate Prosecution-ний хэрэгцээ шаардлага бий болно.

Иймд энэ төрлийн гэмт хэргүүдтэй амжилттай тэмцэж буй улсуудын сайн туршлагыг хөгжиж буй орнуудад нутагшуулан хөгжүүлэх нэг арга хэлбэр нь тухайн улсуудад авлигын дагнасан шүүх байгуулах юм.

Авлигын дагнасан шүүх байгуулсан гадаад улсуудын туршлага

Одоогийн байдлаар дэлхийн 27 улсад өөр өөрийн онцлогт тохирсон Авлигын дагнасан шүүхийг Олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр байгуулан үйл ажиллагаа явуулж байна. Авлигын дагнасан шүүх байгуулах нь тухайн улс авлигын гэмт хэргийн эсрэг ямар хэмжээнд анхаарлаа хандуулж байгааг дотоод болон гадаадад тодорхойлох нэгэн үзүүлэлт. Авлигын дагнасан шүүх байгуулах нь институцын шинжтэй өөрчлөлт байдаг учраас нийгэм эдийн засгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, шүүх эрх мэдлийн байгууллагад нөлөөлөх улс төр, эрх зүйн зүйн орчин, хуулийн байгууллагын бүтцийн онцлог орчин нөхцөлийг харгалзан үзэж дүгнэлт

³ Судлаач энд дурдсан хэргүүдийг дараагийн бүтээлдээ тусгайлан судалж, нийтлэх болно.



хийх шаардлагатай. Түүнчлэн дараах үндсэн нөхцөлүүдийг анхаарч үзэхийг олон улсын байгууллагуудаас зөвлөж байна.⁴ Үүнд

- Авлигын шүүх нь шүүх эрх мэдлийн байгууллагын бүтцэд ямар хэлбэрээр багтах,
- Бүтэц орон тооны хувьд ямар байх,
- Дагнан хянан шийдвэрлэх хэргийн харьяаллыг тогтоох,
- Авлигын дагнасан шүүх, дагнасан прокурор, авлигатай тэмцэх газрын хоорондын уялдаа холбоо зэргийг чухалчлан анхаарч үзэхийн зэрэгцээ дагнасан шүүхэд ажиллах шүүгчийг сонгох, шилжүүлэх, ажиллах нөхцөл зэргийг тусгайлан хуульчлахыг энэ төрлийн шүүх байгуулах талаар хэлэлцэж байгаа улс орнуудад зөвлөдөг байна.

Словак Улс

Ингээд Авлигын дагнасан шүүх байгуулсан зарим улсуудын туршлагыг өгүүлбэ. Манай орны хувьд Post communist улсуудын нэг болох Словак Улсын Авлигын дагнасан шүүх байгуулсан туршлагыг судлах нь дөхөм байх болов уу гэж судлаачийн зүгээс үзлээ. Словак Улс нь 5.4 сая хүн амтай анхан шатны 54, давж заалдах шатны 8 шүүхтэй бөгөөд давж заалдах шатны шүүхийн шийдвэр нь дээд шүүхээр хянагддаг. Тус улс нь 2003 онд Эрүүгийн хэргийн тусгай шүүх (Special Criminal Court) авлигын гэмт хэргийн дагнасан шүүх байгуулах тухай хуулийг баталж 2005 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ. Энэхүү шүүх нь зохион байгуулалтай гэмт хэрэг, мөнгө угаах гэмт хэрэг болон авлигын гэмт хэрэг, онц ноцтой хүн амины хэрэг (зохион байгуулалтай хүн амины хэрэг) зэрэг хэргийг харьяалан хянан шийдвэрлэдэг. Эрүүгийн хэргийн тусгай шүүхийн (Special Criminal Court) харьяалах хэрэгт хяналт тавих чиг үүрэг бүхий Тусгай прокурорын газрыг мөн байгуулжээ. Эрүүгийн хэргийн тусгай шүүх (Special Criminal Court) нь давж заалдах шатны шүүхийн статустай боловч харьяалах хэргүүдээ анхан шатны журмаар хянан хэлэлцэж гаргасан шийдвэр нь дээд шүүхээр хянагддаг онцлогтой. Одоогоор Эрүүгийн хэргийн тусгай шүүх (Special Criminal Court) нь 13 шүүгчтэй хэргийн хүнд хөнгөнөөс хамааран шүүгч дангаар эсхүл бүрэлдэхүүнтэйгээр хэргийг хянан шийдвэрлэж байна. Энэ шүүх байгуулагдсанаар эерэг үр дүн гарч байгаа гэж үздэг жишээ нь мөрдөн шалгах ажиллагааны тусгай зөвшөөрлүүдийг шүүхээс түргэн шуурхай авах боломжтой болсон гэх мэт. Мөн Эрүүгийн хэргийн тусгай шүүхийн (Special Criminal Court) шүүгч тодорхой төрлийн хэргүүд дээр ажилласнаар сайн туршлага хуримтлуулж чаддаг давуу талтай. Нөгөө талдаа хувь хүнд учирч болох эрсдэлүүдээс хамааран Эрүүгийн хэргийн

⁴ Anti-corruption courts.(n.d).Retrieved from U4 Anti-Corruption Resource Centre. <https://www.u4.no/topics/anti-corruption-courts/basics>,

тусгай шүүхийн (Special Criminal Court) шүүгчээр ажиллах шүүгчийг сонгон шалгаруулах нь амаргүй байсан учраас бусад шүүгчдийг бодвол өндөр цалин олгох хуулийн зохицуулалтыг хууль тогтоогчдоос шийдвэрлэсэн. Гэсэн хэдий ч энэ нь бусад шүүгчдээс эдийн засгийн хувьд давуу байдал эдэлж байна гэсэн улс төрийн шүүмжлэлийг дагуулж эхэлсэн бөгөөд одоогоор Эрүүгийн хэргийн тусгай шүүхийн (Special Criminal Court) шүүгчийн цалин нь бусад шүүхийн шүүгчдээс тийм ч их биш байгаа. Авлигын шүүхийн шүүгчийн цалин бусад шүүхийн шүүгчээс тийм ч их биш байгаа нь авлигын шүүхийн шүүгчээр ажиллах сонирхлыг татаж чадахгүй боловсон хүчний дутагдал үүсгэж байна. Мөн шүүмжлэгчдийн зүгээс Тусгай прокурорын газар нь төрийн өндөр албан тушаалтнуудын холбогдсон авлигын хэргүүдийг хангалттай нотлох баримт байсан ч шалгаж шүүхээр шийдвэрлүүлэхгүй зөвхөн жижиг авлигын хэргүүдийг л шүүхэд шилжүүлж Grand corruption буюу төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой авлигын гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэж чадахгүй байна гэж шүүмжилдэг. Хэргийн харьяаллыг хэргийн төрлөөр тодорхойлсон боловч онц ноцтой гэсэн хэргийн ангиллыг нэмж хуульчлахгүй бол жижиг авлигын хэргүүд хэргийн ачааллыг нэмэгдүүлж Тусгай прокурорын газрын үйл ажиллагаа илүү өргөн хүрээтэй мэт харагдаж авлигын гэмт хэргийн тоон үзүүлэлтийг хэт өндөр харагдуулж хийсвэр тоо үзүүлэлт гаргаж байна. Өөрөөр хэлбэл авлигын хэргийн дийлэнхийг жижиг хэргүүд эзэлж томоохон авлигын хэргүүд шалгагдахгүй хуулиас гадуур үлдсээр байна. Нөгөө талаар энэ нь орон нутгийн шинжтэй авлигын хэргүүдийг бууруулж томоохон авлигын хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлж чадаж байна гэж үзэх хэсэг бас байна.⁵

Украин Улс

2018 оны 6 дугаар сарын 07-нд Авлигын дагнасан шүүх байгуулах тухай хууль баталж тус шүүх нь 2019 оноос үйл ажиллагаа явуулж эхэлжээ. 2014 оны Украины Майдан хувьсгалын дараа хуулийн системийн шинэчлэлийн хүрээнд Авлигын эсрэг үндэсний товчоо (мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллага), Авлигын дагнасан прокурорын газар буюу УЕПГ-н нэг хэлтэс, Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний агентлаг буюу авлигын эсрэг бодлого боловсруулагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийн системийг хариуцах чиг үүрэгтэй, Алдагдсан хөрөнгийг буцаан төвлөрүүлэх агентлаг зэргийг цогц байдлаар байгуулсан. Эдгээр байгууллагуудыг байгуулахад Олон улсын валютын сан, Европын холбоо, Дэлхийн банк зэрэг донор байгууллагууд санхүүгийн дэмжлэгийг үзүүлсэн. Авлигын дагнасан шүүх нь анхан шатны журмаар өндөр албан тушаалтнуудын (сайд, дэд сайд, парламентын гишүүд, агентлагийн дарга, шүүгч, прокурор, улсын үйлдвэрийн газрын дарга нар) холбогдсон, эсхүл 39,500\$ түүнээс дээш үнийн дүн бүхий авлигын хэргийг

⁵ Specialized anti-corruption courts: Slovakia. (December 15, 2016). Retrieved from U4 Anti-Corruption Resource Centre. <https://www.u4.no/publications/specialised-anti-corruption-courts-slovakia>



харьяалан хянан хэлэлцдэг. Өөрөөр хэлбэл тус шүүх нь анхан болон давж заалдах шатны шүүхийн чиг үүргийг хэрэгжүүлдэг. Авлигын дагнасан шүүх нь 27 шүүгчтэй 9 нь мөрдөн шалгах чиг үүрэгтэй хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэдэг. Мөрдөн шалгах чиг үүрэг бүхий шүүгч нь дангаараа анхан шатны журмаар хэргийг хэлэлцдэг. Давж заалдах гомдлыг тус шүүхийн 11 шүүгчийн бүрэлдэхүүнтэй танхим хянан хэлэлцэж шийдвэрлэх ба хяналтын журмаар гаргасан гомдлыг дээд шүүх хянан шийдвэрлэх журамтай. Авлигын шүүхийн шүүгчийг сонгох үйл ажиллагаанд гадны мэргэжилтнүүд оролцдог онцлогтой. Олон нийтийн олон улсын зөвлөлөөр дамжуулан олон улсын байгууллагаас санал болгон томилогдсон гадаадын 6 шинжээчид шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ба шаардлагатай бол томилуулахаас татгалзах эрхтэй. Энэ нь олон улсын оролцоог хангах зорилготой “screening process” эцсийн шийдвэрийг манайхтай ижил чиг үүрэг бүхий Шүүгчийг сонгон шалгаруулах дээд хороо гаргадаг. Авлигын шүүхийн шүүгчид тавих шалгуур 5 жил шүүгчээр ажилласан байх, эсхүл 7 жил хууль зүйн эрдэм шинжилгээний ажил хийсэн байх, эсхүл 7 жил өмгөөлөгчөөр ажилласан байх, эсхүл 7 жил эдгээр ажлыг хийсэн туршлагатай байх шаардлагатай. Тус шүүхийн үйл ажиллагааны чанар нь мөрдөн шалгах болон прокурорын байгууллагаас шууд хамааралтай. Мөн хяналтын журмаар гаргасан гомдлыг дээд шүүх хянаж байгаа ч дээд шүүхийн шүүгч нь Авлигын дагнасан шүүхийн шүүгч шиг ижил шалгуурыг давж томилогдоогүй нь учир дутагдалтай гэж шүүмжлэгчид үзэж байна. Хэргийн ачаалал их байдаг тул бүрэлдэхүүний шүүгчид хүрэлцдэггүй.⁶

САНАЛ, ДҮГНЭЛТ

Дээрх судалгааны баримтуудаас дүгнэхэд үндэстэн дамнасан авлига, мөнгө угаах гэмт хэрэгтэй системтэйгээр тэмцэж алдагдсан хөрөнгийг буцаан авах зорилгоор Авлигын дагнасан шүүх, прокурор байгуулах олон улсын санаачилга гарчээ. Цаашид Олон улсын эрүүгийн шүүхтэй ижил бүтэц бүхий Олон улсын авлигын шүүх байгуулагдах төлөвтэй байна. Энэхүү санаачилгын хүрээнд эхний ээлжид улс орнуудад авлигын дагнасан шүүх байгуулагдаж одоогийн байдлаар дэлхийн 27 орон авлигын дагнасан шүүх прокурорыг байгуулаад амжилттай ажиллаж байна. Манай улсын хувьд гадаад улсаас нотлох баримт цуглуулах, мөрдөн шалгах ажиллагааг эрх зүйн туслалцааны гэрээний хүрээнд амжилттай хэрэгжүүлдэггүй нь нууц биш юм. Манай улсын хувьд үндэстэн дамнасан гэмт хэргийг харьяалан хянан шийдвэрлэж байсан туршлагагүй.

Монгол Улс нь 2015 оны байдлаар 26 улстай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг байгуулсан. Эрх зүйн туслалцааны 26 гэрээ, ялтан шилжүүлэх

⁶ Ukraine's High Anti-Corruption Court. (n.d). Retrieved from U4 Anti-Corruption Resource Centre. <https://www.u4.no/publications/ukraines-high-anti-corruption-court#why-and-how-the-hacc-was-established>,

3 гэрээг авч үзэхэд тухайн эрх зүйн туслалцааны гэрээний нэг тал буюу төв байгууллага нь тодорхойгүй байгаа учраас хууль хяналтын байгууллагууд хүсэлт даалгаврыг Гадаад хэргийн яам, Хууль зүй яам, Улсын дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын байгууллага зэрэг байгууллагуудын алинаар нь дамжуулж гадаад улсын төв байгууллагатай харьцах нь ойлгомжгүй байгаа нь хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд ихээхэн хүндрэл учруулдаг. Нийгэм эдийн засаг хөгжихийн хирээр манай улсад дэлхийн хэмжээний компаниудын хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа үүний зохистой хөгжлийг дэмжих үүднээс олон улсын чиг хандлагыг баримтлан хууль ёсыг хэрэгжүүлэхэд Авлигын дагнасан шүүх, прокурорын нэгж байгуулж институцын шинжтэй өөрчлөлт хийх нь өндөр ач холбогдолтой.⁷

Авлигын гэмт хэрэгтэй тэмцэх институцыг байгуулахдаа өөрийн орны онцлог гадаад улсын туршлагыг харьцуулсны үндсэн дээр шинэчлэл өөрчлөлт хийх нь зүйтэй. 2021 оны байдлаар Улаанбаатар хотын 6 дүүрэгт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэгт заасан Авлига, албан тушаалын нийт 96 хэргийг анхан шатны шүүхэд хүлээж авч 60 хэргийг хянан шийдвэрлэсэн байна.⁸ Энэ нь дагнасан шүүх байгуулах хэмжээнд хүрэхгүй тоон үзүүлэлт юм. Энэ нь магадгүй дагнасан прокурор байхгүйгээс шүүхэд цөөн тооны хэргүүд шилжиж ирж байх магадлалтай. Хэрэв Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг харьяалан хянадаг дагнасан прокурорын нэгж байгуулагдвал шүүхэд шилжих хэргийн тоо нэмэгдэх боломжтой. Олон улсын жишиг сайн туршлагаас дүгнэхэд АТГ-ын харьяаллын хэргийг хянах Тусгай прокурорын газар нэгж байгуулах нь авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд ач холбогдолтой. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-т зааснаар Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд Авлига, албан тушаалын гэмт хэргийг анхан шатны журмаар дагнан хэлэлцэх танхим байгуулах хууль зүйн боломжтой юм. Өөрөөр хэлбэл одоо байгаа эрх зүйн орчныг харгалзан үзэхэд нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн тусгай хэргийн танхим байгуулах тохиромжтой байж болох юм.⁹ Мөн шүүх, прокурорыг авлигын хэргийг дагнасан хэлбэрээр хянан шийдвэрлэх нэгжүүд байгуулж институцын шинжтэй өөрчлөлт хийж дагнан ажиллах боловсон хүчнийг авлигын хэрэг хянан шийдвэрлэх, нотлох баримт цуглуулах, алдагдсан хөрөнгийг буцаан авах чиглэлээр мэргэшүүлэн сургаж бэлтгэх шаардлагатай. Авлигын шүүгчийг сонгон шалгаруулахад Украин Улсын туршлагаас үзэхэд шүүгч сонгон шалгаруулах ерөнхий шалгуур үзүүлэлтүүд мөн тусгай зарим шалгуур тавьж ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг авч олон нийтийн буюу төрийн бус байгууллагуудын саналыг харгалзан үзэж сонсгол хийх нь хамгийн тохиромжтой нэр дэвшигчийг

⁷ Эрх зүйн туслалцааны гэрээ: Хууль зүй, дотоод хэргийн яам.(n.d). Retrieved from https://mojha.gov.mn/newmojha/?page_id=1609,

⁸ www.shuukh.mn

⁹ Монгол Улсын шүүхийн тухай хууль



сонгоход ач холбогдолтой байж болно. Мөн авлигын шүүхийн шүүгчийн цалин бусад шүүгчдээс өндөр байх шаардлагатай Словак Улсын туршлагаас харахад цалин хөлс хангалттай их биш байгаа нь учирч болох улс төрийн дарамт шахалт, бусад эрсдэлээс шалтгаалан авлигын шүүгчээр ажиллах боловсон хүчний хомсдол үүсэхэд хүргэх талтай юм. Хэргийн харьяаллыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой зааж хуульчилж өгөхгүй бол үнийн дүнгээс үл хамаарах хэлбэрийн шинжтэй жижиг авлигын хэргүүдийг харьяалуулах нь шүүгчдийн хэргийн ачааллыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Олон улсын байгууллагуудаас Авлигын шүүх нь хараат бус төвийг сахисан шийдвэр гаргахаас бус олон нийтийн хүлээлтэд нийцүүлсэн хийсвэр шийдвэр гаргаж болохгүйг анхааруулсаар байна.

Эцэст нь дүгнэхэд Авлигын гэмт хэргийг дагнасан байдлаар хянан шийдвэрлэх системийн шинжтэй өөрчлөлт нь эрүүгийн эрх зүйн системд байгаагүй томоохон өөрчлөлт бөгөөд гол нь нийгэм эдийн засгийн хөгжилд түлхэц үзүүлж бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжинэ гэдэгт эргэлзэхгүй байна. Олон улсын туршлагыг бид шууд хуулбарлах гэдэг ойлголтоос салж өөрт тохирох хамгийн сайн хувилбарыг боловсруулж, амжилттай хэрэгжүүлж чадсанаар бүс нутагтаа шүүхийн манлайллыг үзүүлэх боломжтой юм.

ГЭМТ ХЭРГИЙН ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААНЫ ТУЛГУУР ЗОХИЦУУЛАЛТ БА ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ АРГА ЗҮЙ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

*Г.Ганбаатар
Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч*

Товч агуулга

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь гэмт хэрэг үйлдэгдсэн цаг үеэс хойш тухайн гэмт хэргийн ангилал, оногдуулах ял шийтгэлийн төрөл, хэмжээ зэргийг үндсэн шалгуур болгон “тусгайлан тогтоосон хугацаа өнгөрсөн” тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэхгүй, эрүүгийн хариуцлагад татахгүй, түүнчлэн зарим гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх эсэх зэрэг асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой эрүүгийн эрх зүйн зохицуулах зүйлийн чухал бүрэлдэхүүн хэсэг байдаг.

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэм хэмжээ бол хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүйгээс бусад гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох шалгуур, үндэслэл, журмыг хоёрдмол утгагүйгээр туйлын тодорхой байдлаар нэг мөр хуульчлан тогтоосон. Энэ бол гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны үндсэн тулгуур хэм хэмжээ мөн. Тус зохицуулалтын утга агуулга, үзэл санаа, зорилго чиглэлийн хувьд өмнөх Эрүүгийн хуулиуд дахь зохицуулалтуудаас илт ялгаатай бөгөөд нийгмийн зүй ёсны шаардлага, эрүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэх шинэ бодлого, үзэл баримтлалын бодит илэрхийлэл болсон билээ.

Гэвч 2015 оны Эрүүгийн хууль 2017.07.01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээс өмнө удаа дараа нэмэлт өөрчлөлт оруулсан. Тухайлбал, 2017.05.11-ны өдөр 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулснаас гадна дахин 7 хоногийн дараа буюу 2017.05.18-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар: Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно...” гэсэн өөрчлөлт нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зохицуулалттай эсрэгцэх гэхдээ зарчмын ба фундаменталь биш зөвхөн хэлбэрийн төдий “зөрчилдөөний шинж” хийгээд хууль зүйн алдаатай байдал үүсгэжээ.

Тухайн тохиолдолд “нэг харилцаа”-нд үйлчлэх эсрэгцэх 2 хэм хэмжээ нэгэн цагт нэгэн зэрэг шууд үйлчлэхгүй буюу үнэний шинжийг агуулахгүй, нэг



нь үнэн, нөгөө нь худал, гурав дахь утга байхгүй тухай Логикийн хуулиудын үндэслэгээ, мөрдлөгөөг баримтлан хууль зүйн зөв, оновчтой үндэслэгээ хийх зайлшгүй шаардлагатай.

Хууль хэрэглэхэд зөрчилдөөн бүхий тохиолдол үүссэн бол хуулийн тулгуур, нарийвчилсан зохицуулалт, зорилго, зарчим тэдгээрийн утга агуулга, мөн чанарт үндэслэх нь хууль хэрэглээний алтан дүрэм гэж үздэг. Тийм учраас, гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох үндэслэл, журмыг тогтоосон Эрүүгийн хуулийн тулгуур ба зөрчилдөөн үүсгэсэн зохицуулалтын аль нь хууль хэрэглээнд шууд үйлчлэх хүчин чадалтай болохыг хууль тайлбарлах онол, арга зүй болон зөрчилдөөн шийдвэрлэх дүрмийн хүрээнд хууль эрх зүйн хангалттай бөгөөд оновчтой үндэслэлээр нотолж, хуулийг зөв тайлбарлан хэрэглэх ёстой. Харин “зөрчилдөөний шинж бүхий байдал” үүссэн гэдгээр шалтаглан хуулийг хэрэглэхээс татгалзах, хуулийг буруу тайлбарлан хэрэглэх ёсгүй болно.

Хуулийг зөв тайлбарлан хэрэглэнэ гэдэг нь хууль тайлбарлах арга, техникийг ашиглан хуулийн утга агуулгад рационал үндэслэл, нотолгоотойгоор анализ, синтез хийж, үзэл санаа, зорилго, зарчим, тухайн салбар эрх зүйн хөгжлийн дэвшилтэт үзэл онол, хандлагад хамгийн сайнаар тохируулан тодотгож ойлгох, ойлгуулахыг хэлнэ.

Иймд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны талаарх Эрүүгийн хууль дахь тухайн хоёр хэм хэмжээний аль нь үндсэн тулгуур хийгээд Эрүүгийн хууль хэрэглээнд хүчин төгөлдөр шууд үйлчлэл үзүүлэх талаар хууль зүйн хүрээнд харьцуулсан шинжилгээ, тайлбар, дүгнэлт хийж, үзэл бодлоо мэргэжил нэгт нөхөдтэй хуваалцах, олон талаас нь хэлэлцэхийг эрмэлзэв.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны тулгуур зохицуулалт

Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний чиг үүрэг, зохицуулалтын аргын тусгай шалгуураар Эрүүгийн хуулийн аливаа хэм хэмжээ буюу эх бичвэрийн утга агуулга тодорхой, ойлгомжтой, нарийвчлагдан системчлэгдсэн бөгөөд шууд үйлчлэх хатуу нөхцөл бүхий императив буюу заавал биелэгдэх хүчин чадалтай байх шаардлага онцгойлон тавигддаг.

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй:” гэсэн хэм хэмжээ¹ бол гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох шалгуур, үндэслэл, журмыг хоёрдмол утгагүйгээр туйлын тодорхой байдлаар хуульчлан тогтоосон үндсэн тулгуур бөгөөд шууд үйлчлэх, заавал биелэгдэх хүчин чадалтай хэм хэмжээ мөн. Үндэслэл:

1. Эрүүгийн хуульд гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хуульчлан тогтоохдоо “гэмт хэрэг үйлдсэн цаг үеэс хойш тодорхой хугацаа өнгөрсөн

¹ Эрүүгийн хууль (2015), 1.10 дугаар зүйл, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2016 он №07/916

байх” цаг хугацааны хязгаарыг үндсэн шалгуур болгож, хэрэв тухайн тодорхой хязгаар бүхий буюу хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн бол яллагдагчаар татахгүй, харин тухайн хөөн хэлэлцэх хугацааных нь дотор гэмт хэрэг үйлдсэн этгээдийг яллагдагчаар татсан буюу мөрдөн байцаалтын ажиллагааг эхлүүлсэн л бол тус хөөн хэлэлцэх хугацаа цааш дахин үргэлжлэн тоологдохгүй болохыг хоёрдмол утгагүйгээр туйлын тодорхой байдлаар нэг мөр тусгайлан тогтоосон.

Эрүүгийн хуулийн түүхэн эх сурвалжуудад² “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн эрүүгийн хариуцлагад татах хүртэл тоолох”-ыг хоёрдмол утгагүйгээр нэг мөр тусгайлан тогтоосон байдаг.

Тухайлбал: 1926 оны шүүх цаазын бичгийн 28 дугаар зүйл, 1929 оны шүүх цаазын бичгийн 24 дүгээр зүйлд “аливаа гэмт явдал үйлдсэн хүн мэдэгдсэн үгүй явсаар дор дурдсан хугацааны дотор гэм /тийм гэмт явдал/ үл гаргаваас ялыг үл хэлэлцэнэ” гэж, 1934 оны шүүх цаазын бичгийн 8 дугаар зүйлд “гэмт хэрэг үйлдсэнээс хойш дор дурдсан хугацаа өнгөрсөн бол шүүх цаазын ёсоор хөөн байцааж үл болно” гэж, 1942 оны Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлд “гэмт хэрэг үйлдсэнээс хойш дор дурдсан хугацаа өнгөрсөн бол Эрүүгийн хуулийн ёсоор хөөн шийтгэж үл болох буюу он удаж мэдэгдээгүй хэрэгт үзэж, он улирсан явдлыг хэрэглэнэ” гэж, 1961 оны Эрүүгийн хуулийн 36 дугаар зүйл, 1986 оны Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйл, 2002 оны Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлд “гэмт хэрэг үйлдсэнээс хойш дор дурдсан хугацаа өнгөрвөл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй:” гэж тус тус утга агуулга ижил байдлаар зохицуулсан.

Тус түүхэн эх сурвалжуудад, хөөн хэлэлцэх хугацааны тулгуур зохицуулалтаас тусад нь “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн үеэс анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно” гэсэн хуульчилсан тайлбарын шинжтэй хэм хэмжээ байгаагүй нь хөөн хэлэлцэх хугацааны тулгуур зохицуулалтын утга агуулга нь тодорхой, нэг мөр бөгөөд маргаангүй болохыг бодитой илэрхийлсэн гэж үзнэ.

“Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дор дурдсан хугацаа өнгөрвөл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй” гэснийг:

- “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн гэмт хэрэг үйлдсэн этгээд яллагдагчаар татагдсан (ял сонсгосноор) үе хүртэл тоолох ёстой”,
- “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулах хүртэл буюу шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол гарах хүртэл тоолох ёстой”

² Б.Баярсайхан нар (2011), Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009), Хууль зүйн үндэсний хүрээлэн.



гэсэн 2 өөр утга агуулгаар тайлбарлан ойлгож, хэрэглэх хандлага байсан байх боловч өргөн агуулгаар нь хэрэглэх нийтлэг практик, онолын тайлбар байжээ.³

Тодруулбал, эрүүгийн хариуцлагад татах гэдэг нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс өргөн утга агуулгатай асуудал тул гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэм буруутайд тооцож, ял шийтгэл оногдуулсан анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолох утга агуулгаар тайлбарлагдан, Эрүүгийн хууль хэрэглээний практикт хэвшиж тогтсон⁴ ойлголт байсан билээ.

Харин 2015 оны Эрүүгийн хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг “гэмт хэрэг үйлдсэн үеэс эрүүгийн хариуцлагад татах хүртэл тоолох” өмнөх Эрүүгийн хуулийн хуучин зохицуулалтыг бүрэн шинэчилж, “гэмт хэрэг үйлдсэн үеэс яллагдагчаар татах хүртэл тоолох”-оор илүү нарийвчлан тогтоосон нь зарчмын хувьд өмнөх хуучин зохицуулалтаас илтэд ялгаатай бөгөөд Эрүүгийн хуулийг шинэтгэх талаарх төрийн бодлого, зохицуулалт, түүний хэрэгжилтийн бодит илэрхийлэл болсон.

Эдүгээ ихэнх улс орнууд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг “хэзээнээс эхлэн аль үе хүртэл тоолох” талаарх Эрүүгийн хуулийн бодлого, зохицуулалтаа улам бүр нарийвчилж, гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс эхлэн тоолж, харин мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлснээр цааш тоолохгүйгээр шууд зогсох (гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авснаар; сэжигтэн эсхүл яллагдагчаар татсанаар; яллах дүгнэлт үйлдсэнээр; яллагдагчийг шүүхэд шилжүүлснээр гэх мэт) утга агуулгаар хуульчлах болсон нь тус салбар эрх зүйн хөгжлийн нийтлэг хандлага болжээ.

Тухайлбал, Герман, Итали, Испани, Швед, Норвеги, Польш, Болгар, Румын, Турк, Швейцар, Бразил, Эстони, Мехик зэрэг 30 шахам оронд гэмт хэрэг үйлдсэн үеэс эхлээд уг хэргийг мөрдөж эхлэх үе хүртэлх хугацааг авч үздэг.⁵

2015 оны Эрүүгийн хуулиар тийнхүү гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг “гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс яллагдагчаар татах хүртэл тоолох”-оор тогтоосон тухайн шинэчлэлийн бодлого, үзэл санаа, зохицуулалтын утга агуулга нь гэмт хэрэгт оногдуулах эрүүгийн хариуцлагын зорилго, хэрэгжилтийг бодитой бөгөөд гарцаагүй хангах, мөн улс, нийгмийн үнэт зүйлс, нийтлэг эрх ашигт ноцтой хохирол, хор уршиг учруулсаар буй нуугдмал гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд үүссэн тулгамдсан

³ Т.Дэндэв, БНМАУ-ын эрүүгийн эрх зүй дэх ял шийтгэлийн тухай асуудал, УБ., 1975, 151-155-р тал

⁴ Монгол Улсын Дээд шүүхийн 2010.07.02-ны өдрийн “Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийг шүүхийн практикт хэрэглэх тухай” тогтоол. Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл (1959-2010), 2015, УБ., 1074-р тал

⁵ Д.Баярсайхан. Харьцуулсан Эрүүгийн эрх зүй. УБ., 2012. 181-р тал

асуудал, олон нийтийн зүгээс тавьж буй зүй ёсны шаардлага хийгээд орчин цагийн Эрүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэхэд чиглэгдсэн дэвшилтэт бодлого, шийдэлд хамаарч байна.

Мөн манай Улс нэгэнт нэгдэн орж, соёрхон баталсны хувьд Олон Улсын хэм хэмжээгээр хүлээсэн үүргийн хүрээнд зарим тодорхой төрлийн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа үл хэрэглэх эсхүл хөөн хэлэлцэх урт хугацаа тогтоох үүргээ биелүүлэх ёстой тул гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааных нь дотор яллагдагчаар татсан л бол эрүүгийн хариуцлагыг гарцаагүй хангахаар зохицуулсан нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны бодлого, зохицуулалтаа Олон Улсын хэм хэмжээ⁶, Эрүүгийн эрх зүйн хөгжлийн жишиг, хандлагатай уялдуулахад чиглэсэн “алхам” болсон гэж үзэх үндэслэлтэй юм.

2. 2015 оны Эрүүгийн хуулийн төслийн эх бичвэр, үзэл баримтлалд “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааных нь дотор яллагдагчаар татсан” л бол хөөн хэлэлцэх хугацааг дахин үргэлжлүүлж тоолох утга агуулга, үндэслэл байгаагүй, хуульчлагдаагүй.

Хуулийн эх бичвэрийг тухайн хуулийн утга агуулга, үзэл санааг тодорхойлох хамгийн үндэслэлтэй нотолгоо гэж үздэг.

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр анх баталсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн эх бичвэрт: “Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй:” гэж зааснаас гадна мөн зүйлийн 2 хэсгийн эх бичвэрт⁷: “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно. Яллагдагчаар татсанаар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зогсооно” гэж тодотгон тусгасан нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 хэсэгт заасан хэм хэмжээний утга агуулга, үзэл санааг тодотгож тайлбарласан хууль зүйн шинжийг бодитой илэрхийлсэн гэж үзэх бүрэн үндэслэлтэй.

Нэгэнт хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн шинэ хуулиар “өмнөх Эрүүгийн хуулиуд дахь эрүүгийн хариуцлагад татах хүртэл тоолох” зохицуулалтыг “яллагдагчаар татах хүртэл тоолох”-оор илүү нарийвчлан тогтоосон нь тогтоогдож байх тул тухайн тайлбарын шинжтэй хэм хэмжээнээс үл хамааран яллагдагчаар татагдсан (ял сонсгосноор) үе хүртэл тоолох утга агуулга, үндэслэл, журамд эргэлзээ, маргаан үүсэхгүй болно.

Мөн Эрүүгийн хууль дахь хөөн хэлэлцэх хугацааны эх бичвэрээс давж үйлчлэх утга бүхий 2017.05.18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн⁸: “Мөрдөн байцаалтын явцад Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрвөл энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.2-т заасан үндэслэлээр

⁶ Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн 29 дүгээр зүйл. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=206492&showType=1>

⁷ Эрүүгийн хууль (2015), 1.10 дугаар зүйл. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2016 он №07/916

⁸ 2017.06.20 “Төрийн мэдээлэл” эмхэтгэл №23 /980/



хэрэгсэхгүй болгоно” гэх хэм хэмжээ, тус хэм хэмжээний хэрэгжилтийг хангах зорилго, үзэл санааны хүрээнд Эрүүгийн процессын хуулийг дагалдах хуулийн журмаар 2017.05.18-ны өдөр өөрчлөлт оруулсан “Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 хэсэг дэх: “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно...” гэсэн хэм хэмжээг тус тус нэгэн зэрэг хүчингүй болгосон нь Эрүүгийн хуульд дахь хөөн хэлэлцэх хугацааны эх бичвэр, үзэл санаа батлагдсан цагаасаа хууль зүйн хүчин төгөлдөр болохыг эргэлзээгүйгээр давхар нотолсон.

3. “Хөөн хэлэлцэх хугацааны хэм хэмжээ”-ний тулгуур зохицуулалтыг тодорхойлох шалгуурт “зайлшгүй хэрэгжих процесс”-ын үндэслэл, баталгаатай эсэх асуудал багтана.

“Зайлшгүй хэрэгжих процесс”⁹ бол материаллаг хуулийн хэрэгжилтийг бодитой хангах буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатууд хэрэгжих агуулга, хэлбэр, дарааллыг нарийвчлан, зөв журамлахад хамаарах зарчмын шинжтэй асуудал юм.

Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа”-ны дотор яллагдагчаар татсан л бол хөөн хэлэлцэх хугацааг цааш дахин үргэлжлүүлэн тоолохгүй байх хэм хэмжээ нь Эрүүгийн процессын хуулийн давхар үндэслэл, баталгаатай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2, 32.5 дугаар зүйлийн 1.5, 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т тус тус заасан хэм хэмжээний утга агуулга, үндэслэл нь: Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй буюу эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татахгүй, “гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан” бол эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгоно, харин Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөөн хэлэлцэх хугацааных нь дотор яллагдагчаар татсан л бол хөөн хэлэлцэх хугацаа цааш дахин үргэлжлэн тоологдохгүйгээр шууд зогсох буюу Эрүүгийн хуульд дахь хөөн хэлэлцэх хугацааны тулгуур зохицуулалтын утга агуулга, үзэл санааг давхар нотолж буй хууль зүйн үндэслэл, нотолгоо болно.

4. Өмнөх 1926, 1929, 1934, 1942, 1961, 1986, 2002 оны Эрүүгийн хуулиудын хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг анхан шатны шүүхийн шийдвэр хүртэл тоолох утга агуулга, үндэслэлийг илэрхийлж байсан тул Эрүүгийн хуульд “эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрсөн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх”

⁹ Due process

зохицуулалттай байсан¹⁰, харин 2015 оны Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл хуульчлагдаагүй нь 2015 оны Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар: “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа”-ны дотор яллагдагчаар татсан л бол хөөн хэлэлцэх хугацаа цааш дахин үргэлжлүүлэн тоологдохгүй буюу шууд зогсох үндэслэл, утга агуулгыг болон хөөн хэлэлцэх хугацааны шинэ ба хуучин Эрүүгийн хуулийн зохицуулалтын зарчмын ялгааг мөн нотлон илэрхийлнэ.

Тулгуур зохицуулалттай эсрэгцэх зөрчилдөөний шинж бүхий хэм хэмжээ

Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно...” гэсэн хэм хэмжээ нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны тулгуур бөгөөд нарийвчилсан зохицуулалт болох Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэм хэмжээний хүчин чадлыг үгүйсгэх үндэслэлгүй бөгөөд батлагдсан цагаасаа Эрүүгийн хуулийн хүчин төгөлдөр үйлчлэлгүй болохыг дараах шалгуур, үндэслэлийн хүрээнд дүгнэж байна.

Шалгуур 1. Хууль зүйн болон бодит байдлын алдаа

Хууль тогтоох эрх мэдэл нь Үндсэн хуулийн хэл, хил хязгаар буюу Үндсэн хуулиар тогтоосон, баталгаажуулсан нийтлэг эрх ашиг, үнэт зүйлс, зарчим, бусад цогц хэмжээсийн утга агуулга, шалгуур шаардлагын хүрээнд хэрэгжих ёстой.

Дворкин: Эрх зүй бол интегрити. Интегрити нь нэг талаар “эрх зүй бол зарчмын хувьд авцалдаатай” гэдгийг хадгалж, хууль тогтоомж бүтээхийг эрх зүйг бүтээгчдээс шаарддаг, нөгөө талаар “эрх зүйг мөн л ийм авцалдаатай гэж харж сахиулах”-ыг эрх зүй гэж юу вэ гэдгийг шийдвэрлэх хариуцлага хүлээгчдээс шаарддаг. Эхнийхийг хууль тогтоомж дахь интегритийн зарчим, хоёрдахийг шүүн таслан ажиллагаа дахь интегритийн зарчим гэж нэрлэсэн¹¹.

Аквинис: Хуулийн хүч чадал нь түүний зүй ёсны эсэхээс хамаарна. Хэрэв хууль нь нийтийн сайн сайханд бус харин хууль тогтоогчийн эрх хэмжээнээс гадуур батлагдсан бол, эсхүл нийгэмд үүрэг, хариуцлагыг тэгш бусаар хуваарилсан бол ийм хууль нь зүй бус...¹²

Хууль бүтээх ажиллагааны алдаа: В.М.Баранов “Хууль бүтээх ажиллагааны нийгэм ба хууль зүйн тааламжгүй үр дүнг үүсгэсэн алдааг хууль тогтоох байгууллагын шударга төөрөгдлийн улмаас хийсэн буруу

¹⁰ Эрүүгийн хууль (2002)-ийн 72 дугаар зүйл. Төрийн мэдээлэл, 2002 он, №5

¹¹ О.Мөнхсайхан. Эрх зүйн философи, УБ., 2022. 140-142-р тал

¹² О.Мөнхсайхан. Эрх зүйн философи, УБ., 2022. 34-35-р тал



үйлдэл”. А.Б.Лисюткин “Эрх зүйн хэм хэмжээ бүтээх субъектийн урьдчилан төлөвлөсөн болон урьдчилан төлөвлөөгүй үйлдлээр нөхцөлдсөн өндөр чанартай эрх зүйн акт батлах, үр нөлөөтэй ажилд саад тотгор болсон сөрөг үр дагавар юм” гэж үзсэн байдаг.¹³

Хууль тогтоомжийн тухай хууль¹⁴-д хууль тогтоомжийн төсөл санаачлах, боловсруулахаас эхлэн батлах үйл явцад хууль зүй, бодит байдлын алдаа гаргахгүй байхад чиглэгдсэн шалгуур, шаардлага, үндэслэл, журмыг нарийвчлан зохицуулсан.

2017.05.18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэм хэмжээ, 2017.05.18-ны өдөр Эрүүгийн процессын хуулийг “дагалдах хууль”-ийн журмаар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан өөрчлөлтийг хэлэлцэн батлах явцад үүссэн хууль эрх зүйн маргаан, зөрчилдөөн бүхий асуудлууд: тухайлбал,

- Эрүүгийн хуулийн 1.10-т заасны дагуу нэгэнт л ял сонсгон, эрүүгийн хэрэг үүсгэсэн бол цаашаа хэргийг ердийн журмаар шалгахаар зохицуулагдсан, гэхдээ мөрдөн байцаалтын шатанд хөөн хэлэлцэх хугацаа зогсдоггүй байдлаар хэргийг шалгаж дуусгах, хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгох зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт оруулах тухайд холбогдох томъёолол¹⁵,
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан санал дээр дахиад ажил...Ингэж болохгүй. Хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг хэргийг нь түдгэлзүүлж байгаад олж авсан цагтаа хэзээ ч хамаагүйгээр шийтгэж байх ёстой...Ингэж хуулиар гэмт хэрэг үйлдэхийг зөвшөөрч болохгүй¹⁶,
- Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулиар...хөөн хэлэлцэх хугацааг бүр мөсөн байхгүй болгож...байна¹⁷,
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн саналын томъёололтой хамтдаа Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл буюу хөөн хэлэлцэх хугацаа нь дагаж нэмэлт, өөрчлөлт орж байгаа. Яагаад ингэж орж байгаа вэ гэхээр хөөн хэлэлцэх хугацаа бүх төрлийн

¹³ Т.В.Кашанина. Хууль зүйн техник (монгол орчуулга), УБ., 2016, 137-р тал.

¹⁴ Хууль тогтоомжийн тухай хууль. Төрийн мэдээлэл, 2015, № 25

¹⁵ Улсын Их хурлын 2017 оны хаврын ээлжит чуулганы хууль зүйн байнгын хорооны 04 дүгээр сарын 25-ны болон 05 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлүүд. <http://parliament.mn/n/qeou> 200-р тал, <http://parliament.mn/n/byoo> 3-р тал, Улсын Их хурлын 2017 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл. <http://parliament.mn/n/усоо> 145-р тал

¹⁶ Улсын Их хурлын 2017 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл. <http://parliament.mn/n/усоо> 145-р тал

¹⁷ Улсын Их хурлын 2017 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс <http://parliament.mn/n/joo0> 46, 49, 51, 85-86-р тал /

хэрэг дээр тодорхой хугацаанд зогсох, тасрах гэсэн ийм ойлголтууд байдаг¹⁸,

- Энэ хөөн хэлэлцэх хугацааны асуудал маш нарийн журамлагдахгүй бол яг энэ зохицуулалтаар шийдэгдэж, бүрэн дүүрэн зохицуулж чадаж байна уу үгүй юу гэдэг ийм асуудал байгаа...Ер нь нарийн судалгаа шинжилгээ хийж, хэрвээ онгорхой цоорхой үлдсэн бол бөглөж таглах арга хэмжээгээ сайн авахгүй бол болохгүй¹⁹,

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн төслийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хэм хэмжээний хэрэгжилтийг хангахын тулд тус хуулийг дагалдуулан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай санал, дүгнэлт²⁰, мөн Эрүүгийн ба Эрүүгийн процессын хууль, эрх зүйн онолын үндэс, түгээмэл зарчим, нийтлэг практик жишиг зэргийг харьцуулан судлахад тухайн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хэм хэмжээ болон Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан өөрчлөлт нь зарим талаар хууль зүйн бодлого ба техник, бодит байдлын алдаатай болох нь үгүйсгэгдэхгүй байна. Үндэслэл:

1. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг дэх “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно...” гэсэн хэм хэмжээ нь “Эрүүгийн хуулиас давж үйлчлэх” утга агуулга бүхий Эрүүгийн процессын хэм хэмжээнд үйлчлэх зорилго, үзэл санааны хүрээнд тус процессын хуулийг дагалдаж гарсан хэм хэмжээ байх тул Эрүүгийн хуулийн хүчин төгөлдөр үйлчлэл үзүүлэх үндэслэлгүй.

1.1. Эрүүгийн хуулийн хүчин төгөлдөр үйлчлэлийг үгүйсгэх буюу Эрүүгийн хуулиас давж үйлчлэх Эрүүгийн процессын зохицуулалт байх ёсгүй.

2015.05.18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт²¹: “Мөрдөн байцаалтын явцад Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрвөл энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.2-т заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгоно” гэсэн зохицуулалтын утга, агуулга нь мөрдөн байцаалтын хугацааг шууд тогтоох биш харин эсрэгээр “хөөн хэлэлцэх хугацаа”-г яллагдагчаар татсанаас хойш “угсруулан” үргэлжлүүлж тоолох, улмаар хэргийг хэрэгсэхгүй болгох “санаан зорго”-ын шинжтэйгээр хуульчлагдсан байх тул Эрүүгийн хуулиас давж үйлчлэх үндэслэлгүй.

¹⁸ Улсын Их хурлын 2017 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс <http://parliament.mn/n/joo050-51,86-88-p> тал

¹⁹ Улсын Их хурлын 2017 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс <http://parliament.mn/n/joo090-p> тал

²⁰ Улсын Их хурлын 2017 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс <http://parliament.mn/n/joo047,83-p> тал

²¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017), “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2017, №23 /980/



Эрүүгийн хууль бол материаллаг суурь хууль, харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх (эрүүгийн процессын) тухай хууль бол Эрүүгийн хуулийн хэрэгжилтийг нэг мөр, шударгаар хангахад чиглэгдсэн процесс ажиллагааны дэг журмын цогц бөгөөд Эрүүгийн хуулиар тусгайлан зохицуулах харилцааг Эрүүгийн процессын хуулиар зохицуулах үндэслэл, журам огт байдаггүй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүр зохих агуулга, хэлбэр, дараалал, цаг хугацааны хүрээнд явагдах ёстой ба энэ нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг үргэлжлүүлэн тоолох үндэслэл, утга агуулга биш гагцхүү Эрүүгийн хуулиар тусгайлан тогтоосон хөөн хэлэлцэх хугацааны үндэслэл, журмын хүрээ хязгаарт хатуу захирагдах ёстой. Энэ бол Эрүүгийн ба эрүүгийн процессын эрх зүйн онол, зарчим, бодлого, зохицуулалтын мэдээжийн буюу үл маргах асуудал болно.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох үндэслэл, журмыг хоёрдмол утгагүйгээр нарийвчлан тогтоосон Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэм хэмжээний эх бичвэр, бодлого, үзэл санааны хүрээнд хөөн хэлэлцэх хугацааг “угсруулан” үргэлжлүүлж тоолох үзэл санаа, үндэслэл, журам огт байгаагүй, хуульчлагдаагүй.

Мөн Эрүүгийн процессын эрх зүйн онолын үндэс²² болон Эрүүгийн процессын хуулийн түүхэн эх сурвалжууд: 1926, 1929, 1935, 1949, 1963, 1994, 2002 оны хуулиуд²³-с үзэхэд ч мөрдөн байцаалтын хугацаа бол Эрүүгийн хуулиар тогтоосон гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг зөрчихгүйгээр, түүнд захирагдмал байдлаар хэрэгжих “тусдаа хугацаа”, харин мөрдөн байцаалтын хугацааны зохицуулалт дотор Эрүүгийн хууль дахь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтаас давж үйлчлэх буюу “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг үргэлжлүүлэн тоолох үндэслэл, журам”-ыг огт хуульчлах ёсгүй байдаг.

Тодруулбал, Эрүүгийн процессын хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг үргэлжлүүлэн тоолохыг тогтоох хууль зүйн бодит үндэслэлгүй, харин Эрүүгийн хуулиар тогтоосон хөөн хэлэлцэх хугацааных нь дотор гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлэх, мөрдөн шалгах, хянах буюу хянан шийдвэрлэх тодорхой хугацааг ялгаа заагтайгаар нарийвчлан зохицуулах ёстой байдаг гэсэн үг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2, 32.5 дугаар зүйлийн 1.5, 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан хэм хэмжээ нь Эрүүгийн хуулиар тогтоосон гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтын хэрэгжилтийг “зөв, шударга процесс”-

²² Ж.Бямбаа, Ж.Эрхэсулан, Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал, УБ., 2018, Д.Баярсайхан, Эрүүгийн процессын эрх зүй, УБ., 2014 номоос дэлгэрүүлж үзнэ үү.

²³ Б.Баярсайхан нар, Монгол Улсын байцан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009) УБ., 2012 номоос дэлгэрүүлж үзнэ үү.

оор хангахад чиглэгдсэн буюу Эрүүгийн процессын хууль гагцхүү Эрүүгийн хуулийн хамаарах зохицуулалтад захирагдмал шинжийг нотолж байгаа болохоос гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн процессын хуулиар тогтоосон утга агуулга, үндэслэл огт биш болно.

Иймд Эрүүгийн процессын хуульд “хөөн хэлэлцэх хугацаа”-г мөрдөн байцаалтын шатнаас дахин угсруулж буюу үргэлжлүүлэн тоолох утга агуулга бүхий зохицуулалт оруулсан нь хууль эрх зүйн хүрээнд огт хүлээн зөвшөөрөгдөхгүй, харин “хууль зүйн болон бодит байдлын алдаа”-тай шийдэлд хамаарах үндэслэлтэй байна.

1.2. Хуулийн хүчин чадал, бүхэллэг байдал буюу нийцэл, зохицлын шинжийн хувьд Эрүүгийн материаллаг ба процессын хэм хэмжээний хүчин чадлын эрэмбэ, нийцэл, зохицол илтэд зөрчигдсөн.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны тулгуур, нарийвчилсан зохицуулалт нь гагцхүү Эрүүгийн хууль учраас тус хуулийн зохицуулалтаас давж үйлчлэх бус харин түүний хэрэгжилтийг шударгаар хангах нь Эрүүгийн процессын хуулийн чиг үүрэг тул Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтад захирагдмал буюу Эрүүгийн хуулийг дагалдаж гарах, нэмэлт өөрчлөлт оруулах хууль бол Эрүүгийн процессын хууль байх ёстой.

Гэтэл 2017.05.18-ны өдөр Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно...” гэсэн хэм хэмжээ нь:

- 2017.05.18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг дэх ²⁴ Эрүүгийн хуулийг ноцтой зөрчсөн утга агуулга бүхий процессын хэм хэмжээний хэрэгжилтийг хангах зорилго, үзэл санааны хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг батлагдах явцад “дагалдах хууль”-ийн журмаар батлагдсан ²⁵, мөн
- тус Эрүүгийн процессын болон түүнийг дагалдах Эрүүгийн хуулийн өөрчлөлт нь бүхэлдээ Эрүүгийн эрх зүйн онол, Эрүүгийн хуулийн зохицуулалт, нийтлэг жишигт огт нийцэхгүй тул Эрүүгийн хуулийн “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа”-ы талаарх тулгуур зохицуулалтын хүчин чадал, шууд үйлчлэлийг үгүйсгэх үндэслэл болж огт чадахгүй бөгөөд батлагдсан цагаасаа хууль хэрэглээнд хүчин төгөлдөр үйлчлэл үзүүлэх үндэслэлгүй болно.

²⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017), “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2017, №23 /980/

²⁵ Улсын Их хурлын 2017 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс <http://parliament.mn/n/jооо 47, 83-р тал>



1.3. 2017.05.18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн тухайн хэм хэмжээ нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөөн хэлэлцэх хугацааны тулгуур зохицуулалтын хэрэгжилтийг нэг мөр хангах процессын тулгуур баталгаа буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2, 32.5 дугаар зүйлийн 1.5, 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан зохицуулалтыг давж үйлчлэх хүчин чадалгүй.

Материаллаг хуульд процессын хууль захирагдах, нийцэх ёстой. Дэгийн болон нотолгооны журам, түүнд оруулах нэмэлт өөрчлөлт болон аливаа журам нь энэхүү Дүрэмд нийцэх ёстой.²⁶

Эрүүгийн процессын хэм хэмжээ харилцан зөрчилдөөн бүхий тохиолдолд Эрүүгийн хуулийн тулгуур зохицуулалтад нийцсэн, түүний хэрэгжилтийг нэг мөр, шударгаар хангахад чиглэгдсэн нарийвчилсан зохицуулалт нь хууль зүйн давуу хүчин чадалтай байх тус шалгуур шаардлагыг 2017.05.18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг дэх тухайн хэм хэмжээ огт хангаагүй гэж үзнэ.

1.4. Эрүүгийн хуулиас давж үйлчлэх тухайн процессын хэм хэмжээ ба түүний хэрэгжилтийг хангах зорилго, үзэл санаа бүхий Эрүүгийн процессын хуулийн дагалдах хэм хэмжээ буюу Эрүүгийн хуулийн 1.10 дугаар 2 дахь хэсэгт оруулсан тухайн өөрчлөлтийн хооронд хууль зүйн нийцэл, зохицлын хамааралт шинжгүй, харин дотоод зөрчилдөөнтэй, уялдаа холбооны авцалдаагүй болох нь тодорхой байна.

Энгийнээр үлгэрлэвэл: Эрүүгийн хөнгөн эсхүл хүнд гэмт хэрэг үйлдсэн хүнийг Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөөн хэлэлцэх хугацааны дотор яллагдагчаар татсан, дахин хөөн хэлэлцэх хугацааг тоолох ёсгүй.

Гэвч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “мөрдөн байцаалтын явцад Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрвөл энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.2-т заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгоно” гэх Эрүүгийн хуулиас давж үйлчлэх хэм хэмжээний дагуу мөрдөгч хөөн хэлэлцэх дахин үргэлжлүүлж тоолоод “хөөн хэлэлцэх хугацаа дууссан” гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон, харин тус Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэм хэмжээний хэрэгжилтийг хангах зорилго бүхий Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно...” гэх

²⁶ Олон Улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн 51 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг. Төрийн мэдээлэл, тусгай дугаар, II боть. 2005, 353 дахь тал

зохицуулалтаар өмнөх мөрдөн байцаалтын шатанд хөөн хэлэлцэх хугацаа дууссанаар хэрэгсэхгүй болгосныг дахин хүчингүйд тооцож, улмаар хөөн хэлэлцэх хугацааг дахин үргэлжлүүлж тоолох гэх зэргээр тус Эрүүгийн процессын хэм хэмжээ, түүнд үйлчлэх дагалдах хэм хэмжээ бүхэлдээ Эрүүгийн материаллаг хуулийн тулгуур зохицуулалтыг зөрчсөн төдийгүй дотоод зөрчилдөөнтэй болох нь илэрхий байна.

1.5. Дээд эрэмбийн материаллаг хэм хэмжээг зөрчсөн, дотоод зөрчилтэй, утгагүй бөгөөд хууль бус үр дүнд хүргэх хийсвэрлэлийн шинжтэй Эрүүгийн процессын хэм хэмжээ, түүний дагалдах хэм хэмжээ бүхэлдээ Эрүүгийн ба Эрүүгийн процессын хуулийн хүчин төгөлдөр үйлчлэлтэй байх бодит үндэслэлгүй.

Тодруулбал, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг дэх тухайн хэм хэмжээ нь Эрүүгийн хуулийг илтэд зөрчсөн утга агуулга бүхий Эрүүгийн процессын хуулийн хэм хэмжээний хэрэгжилтийг хангах зорилго, үзэл санааны хүрээнд тус процессын хэм хэмжээг дагалдаж гарсан хэм хэмжээ байх тул тухайн Эрүүгийн процессын хэм хэмжээний шинж, бүтцийн хүрээнд хамааралт шинжийг агуулсан, харин материаллаг хэм хэмжээний шинж, хүчин чадалгүй гэж үзэх үндэслэлтэй болно.

2. 2017.05.18-ны өдөр тус тус баталсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тухайн хэм хэмжээ, түүний хэрэгжилтийг хангах зорилго, үзэл санааны хүрээнд Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно...” гэсэн өөрчлөлтийн “цаад санаа” нь хуучин Эрүүгийн хууль дахь хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг буцаан сэргээхэд чиглэгдсэн болохыг үгүйсгэх боломжгүй боловч тийнхүү хуульчлахдаа хууль зүйн бодлого ба техник, зохицуулалтын хувьд алдаа гаргасан гэж үзэхээр байна.

2017.05.18-ны өдөр тус тус баталсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэм хэмжээ, тус хэм хэмжээний хэрэгжилтийг хангах зорилго, үзэл санааны хүрээнд дагалдах хуулийн журмаар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан өөрчлөлт нь бүхэлдээ Эрүүгийн ба Эрүүгийн процессын эрх зүйн онолын үндэс, нийтлэг жишиг, хууль бүтээх хууль эрх зүйн үндэс, түгээмэл жишигт хүлээн зөвшөөрөгдөхгүй төдийгүй хууль зүйн бодит үндэслэл, судалгаанд тулгуурласан шинжгүй болох нь илэрхийлэгдэж байх тул хууль зүйн ба бодит байдлын алдаатайд тооцогдох үндэслэл бүрдсэн.



Мөн 2020.01.10-ны өдрийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар²⁷: 2017.05.18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг дэх "Мөрдөн байцаалтын явцад Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрвөл энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.2-т заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгоно" гэснийг "Гэмт хэрэг үйлдсэнээс хойш Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тухайн хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хугацаа өнгөрсөн бол мөрдөн байцаалтын хугацааг сунгаж болохгүй...гэж, харин 2020.01.10-ны өдрийн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар²⁸: 2017.05.18-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг дэх "Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно..." гэснийг "Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно" гэж тус тус өөрчлөлт оруулсан буюу анхны утга агуулгыг бүхэлд нь хүчингүй болгосон нь 2017.05.18-ны өдөр батлагдсан тухайн Эрүүгийн процессын хэм хэмжээ, түүний дагалдах хэм хэмжээ буюу Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан өөрчлөлт нь бүхэлдээ батлагдсан цагаасаа хууль зүйн алдаатай байсныг давхар нотолсон баримт болно.

3. 2017.05.18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2017.05.18-ны өдөр Эрүүгийн хуулийн 1.10 дугаар 2 дахь хэсгийн өөрчлөлтөд үүссэн тухайн хууль эрх зүйн буюу бодит байдлын алдааг мушгин гуйвуулж зөвтгөх замаар хэрэглэх үндэслэлгүй.

Мөн Олон Улсын эрх зүйн эх сурвалж²⁹-д зааснаар, хэрэв бодит байдлын ба эрх зүйн алдаа нь гэмт хэргийн заавал байх субъектив талыг үгүйсгэснээс бусад тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх хууль зүйн үндэслэл болохгүйг баталгаажуулсан байдаг.

Иймд Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дэх "гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно..." гэсэн хэм хэмжээ нь батлагдсан цагаасаа одоог хүртэл хуулийн хүчин төгөлдөр үйлчлэлтэй байгаа Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "хөөн хэлэлцэх хугацааг тоолох тулгуур бөгөөд нарийвчилсан зохицуулалт"-ын хүчин төгөлдөр үйлчлэлийг үгүйсгэх буюу давж үйлчлэх үндэслэлгүй бөгөөд хууль хэрэглээнд хууль зүйн бодит үйлчлэл үзүүлэхгүй болно.

²⁷ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах туай хууль (2020), Төрийн мэдээлэл, 2020, № 7, 1109

²⁸ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2020), Төрийн мэдээлэл, 2020, № 7, 1109

²⁹ Олон Улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн 32 дугаар зүйл, Төрийн мэдээлэл, тусгай дугаар, II боть. 2005, 341 дэх тал

Шалгуур 2. “Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ шууд үйлчлэх хатуу нөхцөл бүхий императив хэм хэмжээ” байх шалгуур шаардлага

Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг дэх: “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно...” гэсэн хэм хэмжээ тус шаардлагыг огт хангахгүй. Үндэслэл:

1. Хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг утгажуулж, амьд үйлчлэлтэй болгож буй үндсэн шинж бол “хугацааны хязгаар” бөгөөд хугацааны хязгааргүй л бол шууд үйлчлэлгүй, утгагүй хийсвэрлэл болно.

Эрүүгийн хуулиар тусгайлан хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй гэж тогтоосноос бусад тохиолдолд “гэмт хэрэг үйлдсэн цаг үеэс хойш тодорхой хугацааны шалгуур, хязгааргүй”-ээр гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох хууль зүйн үзэл баримтлал, үндэслэл 2015 оны Эрүүгийн хуульд огт байдаггүй бөгөөд энэ нь мэдээжийн буюу үл маргах асуудал юм.

2. 2015 оны Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацааг яллагдагчаар татсанаас хойш дахин “үргэлжлүүлж” тоолох эх бичвэр, үзэл санаа, анхнаасаа байгаагүй буюу тийм байдлаар хуульчлагдах бодит үндэслэлгүй бөгөөд тийм үндэслэл, утга агуулгатай мэт мушгин гуйвуулж, санаан зоргоор буруу тайлбарлах, хуулийг буруу хэрэглэх боломжгүй.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг “гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс яллагдагчаар татах хүртэл тоолох”-оор тогтоосон нь 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчлэгдсэн бодлого, зохицуулалтын утга агуулга, үзэл баримтлалын бодит илэрхийлэл болох тул Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 ба 2 дахь хэсгийн хэм хэмжээ өөр хоорондоо огт уялдаа холбоогүй гэж үзнэ.

Мөн 2017.05.18-ны өдөр тус тус баталсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, тус процессын хэм хэмжээний хэрэгжилтийг хангах дагалдах хуулийн журмаар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан өөрчлөлт нь бүхэлдээ Эрүүгийн ба Эрүүгийн процессын эрх зүйн онолын үндэс, нийтлэг жишиг, хууль бүтээх хууль эрх зүйн үндэс, процедур, түгээмэл практикт огт хүлээн зөвшөөрөгдөхгүй төдийгүй тухайн хэм хэмжээг бүхэлд нь нэгэн зэрэг хүчингүй болгосон нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 ба 2 дахь хэсгийн хэм хэмжээ өөр хоорондоо огт уялдаа холбоогүй буюу тус хэсэг бүр нэгэн зэрэг дараалан үйлчлэх үндэслэлгүйг давхар нотолсон.

3. Эрүүгийн хууль, эрх зүйн онолын үндэс, Эрүүгийн хуулийн түүхэн уламжлал, нийтлэг жишиг³⁰, 2015 оны Эрүүгийн хуулийн үзэл баримтлалын

³⁰ Б.Баярсайхан нар (2011), Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009), Хууль зүйн үндэсний хүрээлэн.



хувьд ч гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолоход Эрүүгийн хуулиар тусгайлан тогтоосон “хугацааны шалгуур буюу хязгаар”-гүйгээр, түүнчлэн хөөн хэлэлцэх хугацааг “угсруулан” үргэлжлүүлж тоолох хууль зүйн бодит үндэслэл огт байхгүй болно.

4. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг дэх тухайн хэм хэмжээ нь Эрүүгийн хуулийг илтэд зөрчсөн утга агуулга бүхий Эрүүгийн процессын хуулийн хэм хэмжээний хэрэгжилтийг хангах зорилго, үзэл санааны хүрээнд тус процессын хэм хэмжээг дагалдаж гарсан хэм хэмжээ болох нь тогтоогдсон учраас Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ, онол, зарчимд огт үндэслэгдээгүй, харин Эрүүгийн процессын хэм хэмжээний шинж, бүтцийн хүрээнд хамааралт шинжийг агуулсан гэж үзнэ.

5. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг дэх тухайн хэм хэмжээ нь хэрэгжих Эрүүгийн процессын зохицуулалт, баталгаа огт байхгүй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2, 32.5 дугаар зүйлийн 1.5, 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан зохицуулалт нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн тухайн зохицуулалтад хууль зүйн үйлчлэлгүй бөгөөд хамааралгүй.

6. Мөн “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолох”-ын утга агуулгыг шинжлэхэд утга агуулга нь хийсвэр бөгөөд утгагүй, гажуудсан үр дүн рүү чиглэсэн байна:

6.1. Тухайн үйлдсэн гэмт хэрэг нь ямар ангиллынх, мөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш ямар хугацаа өнгөрсөн эсэх нь тус тус огт хамааралгүйгээр аливаа гэмт хэрэг үйлдэгдсэн бүх тохиолдолд заавал эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж, ял оногдуулна.

Тодруулбал, гэмт хэрэг үйлдсэнээс хойш урт, богино хугацаа өнгөрсөн эсэхээс үл хамааран үйлдэгдсэн гэмт хэрэг бүрт заавал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж, улмаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх ба тухайн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа дууссан бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй, мөн хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан бол эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтууд огт үйлчлэхгүй, хамааралгүй буюу шууд үгүйсгэгдэнэ гэсэн үг.

6.2. Гэмт хэрэг үйлдсэнээс хойш урт, богино хугацаа өнгөрсөн эсэхээс үл хамааруулан тийнхүү ял оногдуулсан анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц хөөн хэлэлцэх хугацаа дууссанд тооцогдож холбогдох хэргийг нь хэрэгсэхгүй болгох уу, ялаас чөлөөлөх үү, ялыг нь эдлүүлэх үү, “яах

ёстой вэ” гэдэг асуудлын шийдэл зөвхөн таамаглалд л хамаарна, харин хууль зүйн бодит үндэслэл, нотолгоо гаргах боломжгүй.

Тодруулбал, ял оногдуулсан анхан шатны шүүхийн шийдвэр нь давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргах хугацаа дууссанаар эсхүл давж заалдах гомдол, эсэргүүцлийг хэлэлцсэн Давж заалдах шатны шүүхийн магадлал сонсгосноор тус тус хүчин төгөлдөр болмогц шүүхээс оногдуулсан тухайн ялыг эдлүүлж дуусгах ёстой юу, ялаас чөлөөлөөд байх уу гэдгийг шийдвэрлэх хууль зүйн зохицуулалт байхгүй гэсэн үг.

6.3. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг дэх “утга агуулга нь хийсвэр бөгөөд утгагүй, гажуудсан үр дүн рүү чиглэсэн” тухайн хэм хэмжээг санаан зоргоор хэрэглэх нь Эрүүгийн хуулийн зорилго, бодлого, зарчим, зохицуулалтыг бүхэлд нь үгүйсгэж, амьд үйлчлэлгүй болгох сөрөг үр дагавар дагуулахаар байна. Энэ бол Эрүүгийн хууль, эрх зүйн онолын үндэс, түгээмэл зарчим, практикт огт хүлээн зөвшөөрөгдөхгүй, мэдээжийн буюу үл маргах асуудал болно.

Шалгуур 3. Дээд хүчинтэй хууль нь дагалдан гарсан хэм хэмжээнээс давуу хүчинтэй-Lex superior derogat legi inferiori.

Эрх зүйн хэм хэмжээний зөрчилдөөнийг даван туулахад эрх зүйн номлол болж хэвшсэн “зөрчилдөөний дүрэм” чухал ач холбогдолтой. Тэдгээр дүрэм нь бүр эртний Римийн үеэс мөрдөгдөж эхэлсэн байдаг.³¹

Олон Улсын шүүхийн дүрэм³²-д: Шүүх нь эрх зүйн хэм хэмжээг тогтоох туслах чанарын арга хэрэгсэл болгон ... олон улсын түгээмэл эрх зүйгээр мэргэшсэн янз бүрийн улс үндэстний мэргэжилтнүүдийн номлолыг үндэслэж болохыг зөвшөөрсөн.

Олон Улсын эрх зүйн эх сурвалжид “Дүрэм болон дэгийн болон нотолгооны журмын хооронд зөрчилдөөн гарвал дүрэм давуу хүчинтэй байна”³³ хэмээн материаллаг ба процессын шинжтэй хэм хэмжээний хооронд зөрчилдөөний шинж үүсвэл материаллаг хэм хэмжээ давуу хүчинтэй болохыг баталгаажуулсан.

Хууль хэрэглэхэд зөрчилдөөн бүхий тохиолдол үүссэн бол материаллаг хуулийн тулгуур буюу нарийвчилсан зохицуулалт, зорилго, зарчим тэдгээрийн утга агуулга, мөн чанарт үндэслэх нь хууль хэрэглээний “алтан дүрэм” гэж үздэг.

Эрүүгийн хуулийн тулгуур хэм хэмжээг ноцтой зөрчсөн утга агуулга бүхий Эрүүгийн процессын хуулийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан

³¹ Г.Эрдэнэбат, Эрх зүйн хэм хэмжээний зөрчилдөөн, эрүүгийн эрх зүйн жишээн дээр. Эрх зүй сэтгүүл. УБ., 2-3/2007, 110-116-р тал

³² Олон Улсын шүүхийн дүрмийн 38 дугаар зүйлийн 1. (d), Төрийн мэдээлэл, тусгай дугаар, II боть. 2005, 312 дахь тал

³³ Ромын дүрмийн 51 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг. Төрийн мэдээлэл, тусгай дугаар, II боть. 2005, 354 дахь тал



хэм хэмжээний хэрэгжилтийг хангах зорилго, үзэл санааны хүрээнд Эрүүгийн процессын хуулийг “дагалдах хууль”-ийн журмаар батлагдсан үндэслэл, утга агуулгаараа Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг дэх “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно...” гэсэн хэм хэмжээ нь батлагдсан цагаасаа Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэм хэмжээний хүчин чадалд нөлөөлөх үндэслэлгүй, Эрүүгийн процессын хэм хэмжээний шинж, бүтцийн хүрээнд хамааралт шинжийг агуулсан болох нь тогтоогдсон.

Мөн 2017.05.18-ны өдөр нэгэн зэрэг батлагдсан Эрүүгийн процессын хуулийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тухайн хэм хэмжээ бүхэлдээ Эрүүгийн эрх зүйн онол, Эрүүгийн хуулийн зохицуулалт, нийтлэг жишиг, легитим шалгуурт нийцэхгүйг нотолсон хууль зүйн шалгуур, үндэслэлийн хүрээнд Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг нь зарчмын, фундаменталь зөрчилдөөний шинжтэй биш зөвхөн хэлбэрийн төдий бөгөөд хууль зүйн алдаатай байгааг анхаарах нь зүйтэй.

Иймд Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэм хэмжээ бол Эрүүгийн хуулийг илтэд зөрчсөн утга агуулга бүхий Эрүүгийн процессын хуулийн хэм хэмжээ, түүний хэрэгжилтийг хангах зорилго, үзэл санааны хүрээнд тус процессын хэм хэмжээг дагалдан гарсан хэм хэмжээ буюу Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг дэх тухайн өөрчлөлтөөс ямагт давуу хүчинтэй, дээд эрэмбийн хэм хэмжээ мөн.

Шалгуур 4. Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй

Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ шууд үйлчлэх хатуу нөхцөл бүхий императив хэм хэмжээ байдаг учраас төсөөтэй хэрэглэхийг хориглодог.

Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг дэх “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно...” гэсэн хэм хэмжээ:

- Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэм хэмжээтэй өөр хоорондоо эсрэг тэсрэг бөгөөд шууд уялдаа холбоогүй,
- Эрүүгийн хуулийг илтэд зөрчсөн утга агуулга бүхий Эрүүгийн процессын хуулийн хэм хэмжээний хэрэгжилтийг хангах зорилго, үзэл санааны хүрээнд тус процессын хэм хэмжээг дагалдаж гарсан буюу Эрүүгийн процессын хэм хэмжээний шинж, бүтцийн хүрээнд хамааралт шинжийг агуулсан,
- Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг заасан хэм

хэмжээний хүчин чадлыг үгүйсгэх үндэслэлгүй, мөн утга агуулга нь хийсвэр бөгөөд утгагүй, гажуудсан үр дүн рүү чиглэсэн болох нь хууль зүйн зохих шалгуур, үндэслэлээр тус тус тогтоогдсон байх тул гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны тулгуур бөгөөд нарийвчилсан зохицуулалтыг үгүйсгэж эсхүл эсрэг тэсрэг хэм хэмжээг нэгэн зэрэг дараалуулах замаар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болтол “угсруулан” үргэлжлүүлж тоолох байдлаар төсөөтэй хэрэглэх үндэслэлгүй.

Түүнчлэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны талаарх Эрүүгийн шинэ ба хуучин зохицуулалт илтэд ялгаатай байсаар атал хүчингүй болсон өмнөх хуулийн зохицуулалтын утга агуулгатай адилтган ойлгох, буруу тайлбарлах, төсөөтэй хэрэглэх бодит боломжгүй болно.

Шалгуур 5. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх зарчмын үйлчлэл, хүрээ хязгаар

Эрүүгийн хуулийн зохицуулалтын амин сүнс нь гэмт хэрэг ба ял шийтгэл байдаг учраас эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим хэлбэрэлтгүй, гуйвалтгүйгээр хатуу чанд мөрдөгдөх ёстой.

Гэмт хэрэг болон түүний төлөө ял шийтгэх асуудлыг зөвхөн тухайн үед хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар тодорхойлдог.

Гэмт үйлдлүүд нь үргэлжилсэн, удааширсан байдлаар эсхүл таслан зогсоогдсоноор төгссөн бол тухайн төгссөн үеэс хөөн хэлэлцэх хугацааг эхэлж тоолохоос гадна хэрэв тухайн төгсгөл нь шинэ хууль үйлчилж эхэлсэн үед дууссан бол шинэ хуулийг хэрэглэдэг. Энэ нь Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэж байгаа асуудал биш.

Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх буюу буцаан хэрэглэхгүй зарчим Олон Улсын эрх зүйн эх сурвалж болон Эрүүгийн эрх зүйгээр хүлээн зөвшөөрөгдсөн боловч гэмт хэргийн хувьд Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх эсэхийг шийдвэрлэх үндсэн шалгуур, хүрээ хязгаар гэж бий.

Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх гэдэг нь шинээр хүчин төгөлдөр болсон хэм хэмжээг түүнийг хүчин төгөлдөр үйлчилсэн үеэс өмнө үйлдсэн гэмт хэргийг шийдвэрлэхэд хэрэглэхийг хэлдэг.

Олон Улсын эрх зүйн эх сурвалжид: Хэрэг үйлдэх үед нь дотоодын хууль буюу олон улсын эрүүгийн эрх зүйгээр эрүүгийн гэмт хэрэгт эс тооцож байсан ямар нэг үйлдэл буюу эс үйлдлээр хэнийг ч гэмт хэрэгтэн гэж буруутгаж болохгүй түүнчлэн гэмт хэрэг үйлдэх үед хэрэглэж байснаас илүү ял шийтгэл оногдуулж болохгүй ³⁴ гэж заасан нь гэмт хэргийн хувьд Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх эсэхийг шийдвэрлэх үндсэн шалгуур, хүрээ хязгаар нь

³⁴ Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон Улсын пактын 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн мэдээлэл, тусгай дугаар, II боть. 2005, 17-р тал



гагцхүү гэмт хэргийн шинж, ял шийтгэл болох нь эргэлзээтэй асуудал биш байдаг.

Тодруулбал, хуучин Эрүүгийн хууль үйлчилж байх цаг хугацаанд үйлдэгдсэн “гэмт хэрэг”-ийн хувьд шинэ Эрүүгийн хуулиар гагцхүү оногдуулах ял шийтгэл нь хөнгөрсөн³⁵ эсхүл “гэмт хэрэгт тооцохгүй болсон” тохиолдолд тухайн Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх нь зайлшгүй, харин эсрэг тохиолдолд буцаан хэрэглэхгүй гэж ойлгоно.

Мөн Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэнэ гэдэг нь тухайн гэмт хэргийн хувьд Эрүүгийн шинэ ба хуучин хуулийг холимог байдлаар хэрэглэх үндэслэл, утга агуулгыг огт илэрхийлдэггүй тул хэрэв тухайн гэмт хэрэгт шинэ Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэсэн л бол тухайн гэмт хэрэгт гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэх зэрэгт хамаарах бүхий л асуудал гагцхүү шинэ Эрүүгийн хуулийн зохицуулалтын хүрээнд шийдвэрлэгдэх ёстой.

Тодруулбал, 2002 оны Эрүүгийн хууль үйлчилж байх цаг хугацаанд үйлдэгдсэн гэмт хэрэгт ял шийтгэл хөнгөрсөн үндэслэлээр 2015 оны Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэсэн атлаа холимог байдлаар буюу 2002 оны Эрүүгийн хууль дахь хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг хэрэглэх үндэслэлгүйгээс гадна Эрүүгийн шинэ ба хуучин хууль дахь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох үндэслэл, журам илтэд ялгаатай тогтоогдсон учраас адилтган дүйцүүлэх, төсөөтэй болон буцаан хэрэглэх үндэслэлгүй.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг дэх “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно...” гэсэн хэм хэмжээ нь Эрүүгийн хуулийг илтэд зөрчсөн утга агуулга бүхий Эрүүгийн процессын хуулийн хэм хэмжээний хэрэгжилтийг хангах зорилго, үзэл санааны хүрээнд тус процессын хэм хэмжээг дагалдаж гарсан буюу Эрүүгийн процессын хэм хэмжээний шинж, бүтцийн хүрээнд хамааралт шинжийг агуулсан төдийгүй Эрүүгийн хуулийн хүчин төгөлдөр үйлчлэлгүй, мөн утга агуулга нь хийсвэр бөгөөд утгагүй, гажуудсан үр дүн рүү чиглэсэн болох нь хууль зүйн зохих шалгуур, үндэслэлээр тогтоогдсон тул Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх үндэслэл, журамд хамааралгүй болно.

Шалгуур 6. Эргэлзээтэй үед сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх зарчим -In dubio pro reo

Аливаа нэг гэмт үйлдэхүйг үйлдсэн гэж шүүхээс ял шийтгэл онооход тавигдах нэгэн чухал шаардлага бол уг хэргийг үйлдсэн нь үнэн гэсэн

³⁵ Ял шийтгэл хөнгөрсөн гэдэг нь хуучин Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинж нь шинэ Эрүүгийн хуулиар өөрчлөгдсөнөөс оногдуулах ял шийтгэл хөнгөрсөн, эсхүл гэмт хэргийн шинж нь өөрчлөгдөөгүй ч оногдуулах ял шийтгэл хөнгөрсөн аль ч тохиолдлыг хамааруулан ойлгоно.

үнэмшил оршин байгаа зөвхөн тийм тохиолдолд л боломжтой болдог нөхцөл юм.³⁶

Гэмт хэргийг яв цав нарийн тодорхойлох бөгөөд төсөөтэй байдлаар нь хэрэглэж болохгүй. Хоёрдмол агуулгатай тохиолдолд тодорхойлолтыг мөрдөн байцаалт, шүүх ажиллагаанд байгаа буюу гэм буруутай гэж тооцогдсон хүнд ашигтай байдлаар тайлбарлана.³⁷

Эрүүгийн хуулийг тайлбарлах, хэрэглэхэд гарсан эргэлзээ гэдэг нь гэмт хэргийн шинж буюу гэм буруугийн хэлбэр, гэмт үйлдлийн шинжийн хүрээ хязгаарт үүсэж болох нь нийтлэг боловч таамаглал, хуулийг төсөөтэй хэрэглэхээс ангид, гагцхүү Эрүүгийн хуулийн эх бичвэр, зарчим, гэмт хэрэг зүйлчлэлийн ба нотолгооны онолын үндэслэл, холбогдох нотлох баримтад бодитой үндэслэгдсэн байх ёстой.

Нэгэнт Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг дэх “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно...” гэсэн хэм хэмжээ нь Эрүүгийн хуулийг илтэд зөрчсөн утга агуулга бүхий Эрүүгийн процессын хуулийн хэм хэмжээний хэрэгжилтийг хангах зорилго, үзэл санааны хүрээнд тус процессын хэм хэмжээг дагалдаж гарсан буюу Эрүүгийн процессын хэм хэмжээний шинж, бүтцийн хүрээнд хамааралт шинжийг агуулсан төдийгүй Эрүүгийн хуулийн хүчин төгөлдөр үйлчлэлгүй, мөн утга агуулга нь хийсвэр бөгөөд утгагүй, гажуудсан үр дүн рүү чиглэсэн болох нь хууль зүйн зохих шалгуур, үндэслэлээр тогтоогдсон тул эргэлзээтэй үед ашигтай шийдвэрлэх зарчимд огт хамааралгүй болно.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны тулгуур бөгөөд нарийвчилсан, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хэм хэмжээг зөв тайлбарлаж зөв хэрэглэх нь хуульд захирагдах зарчмын утга агуулга мөн.

ТОВЧ ДҮГНЭЛТ

“Ардчилал гэдэг бол зөвхөн бодлого болж хувирсан хүсэл биш, энэ бол хүслийг ил болгох хэрэгсэл. Ардчиллын онолын цөм асуудал бол хүмүүс өөрсдийн захирагдах дүрэм, журмыг гаргахад оролцох явдал. Ардчилал бол нийтэд тулгарч байгаа асуудлыг хамтдаа эргэцүүлэх чуулган”.³⁸

Ардчилсан Үндсэн хуулийн сургаалд нийцсэн шийдвэр гаргах онолын максимум, нийгмийн үнэт зүйлсийн тэнцвэрийн сүлжээг дээд зэргээр ихэсгэхэд зайлшгүй гэсэн утгаар ард түмний төлөө тус тусын үүрэг, хариуцлага хүлээдэг суурь бүтэц буюу шударга ёсны тогтолцоог бий болгодог.³⁹

³⁶ Э.Хильгендорф, Д.Чанцалдулам. Германы эрүүгийн эрх зүйн ерөнхий анги. УБ., 2015. 25-р тал

³⁷ Олон Улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. Төрийн мэдээлэл, тусгай дугаар, II боть. 2005, 337-р тал

³⁸ Адам Свифт, Улс төрийн философи, УБ., 2016 номоос дэлгэрүүлж үзнэ үү.

³⁹ Улс төрийн либерализм, УБ., 2016 номоос дэлгэрүүлж үзнэ үү.



Ардчилсан нийгэмд олон ухаалаг ба ухаалаг бус үзэл байх нь гайхах зүйл биш.

Цаг хугацааны урсгалаар хууль эрх зүй, хууль ёс, шударга ёсонд хандах үзэл, хандлага өөрчлөгдөн хөгжсөөр байна.

Хуулиуд бол эрх мэдэлтэй хэсгийн ашиг сонирхолд үйлчлүүлэхээр хиймлээр бүтээсэн зүйл биш гэдэг нь эргэлзээгүй бөгөөд олон түмний олноо түгсэн ухаалаг оюуны хүч, хүсэл зоригийн илэрхийллийг хүлээн зөвшөөрч улс төрийн идеал болгох нь эдүгээ түгээмэл хандлага болов.

Хуулиуд эрх зүйт, шударга, амьд үйлчлэлтэй байх нь чухал. Хууль нь Үндсэн хуульт ёс, эрх зүйт төр, зүй ёс, шударга ёсны онолын үзэл баримтлал, шалгуур шаардлага, олон түмний ба төрийн хүсэл зоригийн зохистой давхцалыг олсон нөхцөлд тухайн хуулийг эрх зүйт, шударга хууль гэж ойлгож болно.

Хуулиуд, түүний хэм хэмжээний агуулга зарим талаар бүрхэг, хууль зүйн алдаа, зөрчилдөөн бүхий нөхцөл байдал үүссэн байгаа нөхцөлд зөвхөн “Хууль бол хууль” гэсэн механик арга, хандлагын хүрээнд хуулийг ойлгож, хэрэглэх боломжгүй.

Үндсэн хуулиар шүүх эрх мэдлийг гагцхүү шүүхэд олгосон учраас шүүхийн эрх хэмжээ, чиг үүрэг нь гагцхүү хуулийг зөв тайлбарлаж, зөв хэрэглэхэд оршдог.

Шүүхийн шийдвэр нь материаллаг хуулийг хэрэглэх үндсэн дээр гардаг, тухайн харилцаанд оролцож буй субъектуудад хэрэглэж буй хуулиа тайлбарлан өгч буй акт, өөрөөр хэлбэл казуаль (тухайн казус буюу маргаанд оролцогчдод өгч буй) тайлбар мөн.⁴⁰

Казуаль тайлбар гэж эрх зүйн хэм хэмжээг тухайн тохиолдолд буюу хэрэг, маргаанд хамааралтайгаар тайлбарлахыг хэлдэг ба хууль хэрэглэхийн тулд түүнийг ойлгох, ойлгохын тулд түүнийг тайлбарлах шаардлагатай болдог.⁴¹

Хуулийг тайлбарлаж хэрэглэнэ гэдэг нь “хуулийн хэл, хил хязгаарын хүрээнд хуулийн утга агуулгыг хянаж, задлан шинжилж тодорхойлно” гэсэн үг. Тус чиг үүрэг нь гагцхүү “хуулийн утга агуулга юу ярьж, юуг илэрхийлж, юуг шаардаж байна вэ, хууль тогтоогч ямар зорилготой байсан бэ, хууль ямар зорилготой байсан бэ” гэдгийг хууль эрх зүйн онол, практик, хууль тайлбарлах нийтлэг дүрэм, арга зүйн хүрээнд бодитой нээн илрүүлж, хамаарах олон талт үнэлэмж, үндэслэл, нотолгооны огтлолцол, тэнцвэрийг зөв танин мэдэж, хуулийн утга агуулгыг гуйвуулахгүйгээр чанд сахиж, зөв хэрэглэхэд чиглэгдсэн байх ёстой.

Энэ бол хуулийг шинээр зохиож, бүтээж байгаа хэрэг биш харин “хуулийн цаадах бодит хууль”-ийн үндэс, үзэл санаа, мөн чанар, зарчим тэдгээрийн утга агуулга, шууд үйлчлэлийг хуулийн хүлээн зөвшөөрөгдөхүйц аргумент, мэдлэг, үндэслэл, нотолгоогоор танин мэдсэн буюу хуулийн хамгийн сайн тайлбараар нээж, тодотгосон гэж зохистойгоор ойлгох нь зөв болно.

Тус нийтлэлээр зөвхөн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны тулгуур зохицуулалттай эсрэгцэх хууль зүйн алдаа, зөрчилдөөний шинж бүхий асуудлын хүрээнд бус харин аливаа хуулийг зөв хэрэглэхэд хууль тайлбарлах онол, арга зүйн цогц мэдлэг, ур чадвар хамгийн чухал болохыг тодотгох, мөн хууль хэрэглээний “алтан дүрэм”, материаллаг ба процессын хэм хэмжээний хүчин чадал, эрэмбэ, эрх зүйн зөрчилдөөнийг даван туулах эрх зүйн номлол буюу “Зөрчилдөөний дүрэм”, хууль бүтээх ажиллагааны явцад үүсэн бодит байдлын ба хууль эрх зүйн алдаа, түүний хууль хэрэглээнд үүсгэж болох сөрөг үр дагавар зэрэг хууль тайлбарлах онол, арга зүйн хүрээнд цаашид нарийвчлан судлах зарим асуудлуудад мэргэжил нэгт нөхдийн анхаарлыг хандуулах, үзэл бодлоо олон талт өнцгөөс харилцан чөлөөтэй илэрхийлэх, хуваалцахыг хүсэн эрмэлзсэний учир дүгнэлтийг зөвхөн санаа өгөхүйц, товч байдлаар бичиглэв.



ЗАМ ТЭЭВРИЙН ГЭМТ ХЭРГИЙН ЗҮЙЛЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Б.Батаа

*Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн
хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
судлаач, хууль зүйн магистр*

Оршил

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч ... гагцхүү хуульд захирагдана.” гэж, мөн хуулийн Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй.” гэж тус тус зааснаас үзвэл манай улс нь зөвхөн бичмэл хуулийг хэрэглэх иргэний эрх зүйн бүлийн улс орон болох нь тодорхой байна.

Иргэний эрх зүйн бүлийн улс орны эрх зүйн тогтолцооны нэг гол шинж нь Эрүүгийн хуулийг төрөлжүүлэн нэгтгэсэн байдаг бөгөөд аливаа гэмт хэргийн шинжийг урьдаас хуульчлан тогтоодог онцлогтой. Өөрөөр хэлбэл, зөвхөн бичмэл эрх зүйд тулгуурлах ба шүүхийн жишиг буюу урьд хэрхэн яаж шийдвэрлэж байсан шүүхийн практик нь эрх зүйн эх сурвалж болдоггүй.

Материаллаг эрүүгийн эрх зүйн онолд гэмт хэргийг зүйлчлэх асуудал онцгой байр суурь эзлэх бөгөөд тодорхой онол, арга зүй, үе шаттайгаар гэмт хэргийн шинжийг үйл баримттай харьцуулан шалгаж, тохирох хэм хэмжээг сонгож хэрэглэх нь онолын хийгээд практикийн ач холбогдолтой байдаг.

Манай улсын эрх зүйн тогтолцоонд ямар үйлдэл, эс үйлдэхүйг, эсхүл тодорхой үйлдэл, эс үйлдэхүйн улмаас ямар хохирол, хор уршиг учирсныг гэмт хэрэгт тооцохыг зөвхөн хууль тогтоогч гагцхүү Эрүүгийн хуулийн тусгай ангид хуульчлан тогтоодог билээ.

Тэгэхээр хууль тогтоогчийн үзэл санаа, хуулийн өөрчлөлтийг сайтар ойлгож, хуулийг нэг мөр зөв ойлгон хэрэглэх асуудал бол гэмт хэргийг зүйлчлэх онолын ойлголт болохын зэрэгцээ практикт хэн нэгнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ял халдах эрх зүйн үндэс болох юм.

Иймд тодорхой төрлийн гэмт хэргийн шинжийг хууль тогтоогч өөрчлөн тогтоосонтой холбогдуулан гэмт хэрэг зүйлчлэлийн зарим асуудал шүүхийн практикт хөндөгдөж байгааг хуульч, судлаачийн үүднээс энэхүү нийтлэлдээ онолын болон практикийн талаас нь дэлгэн харуулахыг зорив.

Нэг. Гэмт хэрэг зүйлчлэлийн үндсэн ойлголт

Гэмт хэргийг зүйлчлэх ойлголт нь эрүүгийн эрх зүйн онол болон шүүхийн практикт: нэг талаас, аливаа гэмт явдал нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тодорхой төрлийн гэмт хэргийн шинжийг бүрэн хангаж байгааг тогтоох логик үйл ажиллагаа; нөгөө талаас, хүн, эсхүл хуулийн этгээдийн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйд хууль зүйн дүгнэлт өгч байгаа эрх зүйн үнэлэлт гэсэн агуулгаар тайлбарлагдана.¹ Энэхүү хоёр талт агуулга нь гэмт хэрэг зүйлчлэлийн онолын салшгүй хэсэг болдог.

Эрүүгийн хэргийг шинжлэн судалж, гэмт хэргийг зөв зүйлчлэн шийдвэрлэх замаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангаж, хэргийн бодит байдлыг үндэслэлтэй тогтоож, Эрүүгийн хуулийг нэг мөр, нэгдмэлээр тайлбарлан зөв хэрэглэхэд гэмт хэрэг зүйлчлэлийн онол чухал үүрэг гүйцэтгэдэг тул Эрүүгийн эрх зүйн онол болон хууль хэрэглээний практикт онцгой ач холбогдолтой.

Гэмт хэрэг нэг бүрийг зөв зүйлчлэн шийдвэрлэх арга зүй, мөн шүүхийн практикт нэг мөр хэрэгжүүлэх чиглэлийг тодорхойлон боловсруулах, үйл баримтад зөв дүгнэлт өгөх логик үндсийг бүрдүүлэх зорилго бүхий хууль зүйн шинжлэх ухааны цэгцтэй мэдлэгийн эрэмбэ дараалал бүхий тогтолцоог “гэмт хэрэг зүйлчлэлийн онол” гэж ойлгож болно.²

Хуульчид гэмт хэрэг зүйлчлэлийн үндсэн ойлголт, шинж, бүтэц, агуулга, арга зүйн талаар системтэй мэдлэг эзэмшихгүйгээр аливаа гэмт явдлыг гэмт хэрэг мөн эсэхийг танин мэдэх, улмаар зөв зүйлчлэх боломжгүй бөгөөд гэмт хэргийн шинжийг зөв таньж чадаагүйн үр дагавар нь нэг бол хохирогчийн зөрчигдсөн эрх нь сэргээгдэхгүй үлдэх, эсхүл хэн нэгэн хүн, хуулийн этгээдийг хэлмэгдүүлэн ял халдаах эрсдэл бий болдог.

Гэмт хэргийг зөв зүйлчлэх явдал нь хүний эрх, эрх чөлөөтэй салшгүй холбоотой бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бүхий л үе шатанд зайлшгүй анхаарах чухал асуудал болдог. Тодруулбал, мөрдөгч гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн аваад шууд, эсхүл хуульд заасан мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулсны үр дүнд ямар гэмт хэрэг үйлдэгдсэн эсэх талаар хууль зүйн дүгнэлт хийж, хэрэг бүртгэлтийн хэрэг нээх эсэх саналаа прокурорт хүргүүлснээр гэмт хэрэг зүйлчлэх эхний үе шат эхэлнэ.

Гэхдээ хууль тогтоогч хэрэг бүртгэлтийн хэрэг нээх ажиллагаанд хүн, хуулийн этгээдийг холбогдуулахгүй байхаар хориглолт тогтоосон нь гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах үед ихэвчлэн нотолбол зохих байдлыг бүрэн тогтоох боломжгүй байдагтай шууд холбоотой бөгөөд хэрэг

¹ Гэмт хэрэг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс. С.Нарангэрэл. УБ. 1988. 7 дахь тал.

² Эрүүгийн эрх зүй дэх гэмт хэрэг зүйлчлэлийн онол. Б.Ганболд. УБ. 2001. 9 дэх тал.



бүртгэлтийн хэрэг нээх ажиллагааг албан ёсны бус урьдчилсан зүйлчлэл хэмээн ойлгоно.

Харин албан ёсны зүйлчлэл нь прокурор хэрэг бүртгэлтийн ажиллагааг хянаад, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэнээр анхлан хийгдэх бөгөөд хуулиар энэхүү эрхийг зөвхөн прокурорт олгожээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар прокурорын эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолд ямар гэмт хэрэг хэзээ, хаана үйлдэгдсэн, хэнийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн ямар зүйл, хэсэг, заалтад заасан гэмт хэрэгт буруутгаж /яллаж/ байгаа тухай зааж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт тухайн хүнийг гэмт хэрэг үйлдсэн болохыг нотолж буй нотлох баримтын жагсаалт, тэдгээр нотлох баримтын мэдээллийн агуулгыг нэг бүрчлэн тусгасан байх хууль зүйн шаардлагыг шинэчлэн хуульчилсан юм.

Иймд прокурор аливаа гэмт үйлдэл, эс үйлдэхүйн хэлбэрийн болон материаллаг шинж чанарыг зөв таньж, гэмт хэрэгт тооцох эсэхийг анхнаасаа зөв дүгнэх нь гэмт хэрэг зүйлчлэлийн амин сүнс болохын сацуу нэг талаас гэмт хэрэгт сэжиглэгдсэн хүний эрх, эрх чөлөөг хэлмэгдүүлэн зөрчихгүй байх, нөгөө талаас хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээн хамгаалах төрийн үүрэг алдагдахгүй байхад чухал ач холбогдолтой байдаг.

Эрүүгийн эрх зүйд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл нь хуульд заасан гэмт хэргийн бүх шинжийг агуулсан хэрэг үйлдэгдсэн байх явдал болно. Энэ нь хуульгүйгээр гэмт хэрэг, ял аль алин нь байхгүй гэсэн материаллаг эрүүгийн эрх зүйн сонгодог зарчим³ билээ. Үүнийг иргэний эрх зүйн тогтолцооны⁴ улс орнууд хууль байхгүй бол ял байхгүй гэж тайлбарладаг.

Хуульчид гэмт хэргийг зүйлчлэх үе шатыг мэдсэний үндсэн дээр уг үе шат тус бүрд хийгдвэл зохих үйл ажиллагааг бүрэн гүйцэд, чанартай хийж гүйцэтгэх нь гэмт хэргийн зүйлчлэл зөв болох нэн чухал нөхцөл мөн.⁵ Үүнд:

- 1) Хэргийн бодит нөхцөл байдлыг тогтоох;
- 2) Хэргийн бодит нөхцөл байдалд тохирох Эрүүгийн хуулийн тусгай ангийн хэм хэмжээг сонгох;
- 3) Хэргийн бодит нөхцөл байдал ба сонгон авсан хэм хэмжээний хоорондын нийцэл тохироог шалгах, эдгээр болно.

Гэмт хэрэг зүйлчлэх үе шат нь хэргийн бодит нөхцөл байдлыг

³ Латинаар: nullum crimen, nulla poena sine lege

⁴ All countries compared for Government > Civil law system (nationmaster.com) CIVIL LAW SYSTEM-ийн улс орнууд: Албани, Андорра, Ангол, Аргентин, Аруба, Австри, Азербайжан, Бельги, Боливи, Босни-Херцеговин, Бразил, Болгар, Чили, БНХАУ, Колумби, Коста-Рика, Куба, Чех, Конго, Дани, Доминикан, Зүүн Тимор, Эквадор, Египет, Эстони, Финланд, Франц, Герман, Грек, Гватемал, Гвиней, Гвиней-Бисау, Хаити, Унгар, Исланд, Индонез, Итали, Япон, Йордан, Латви, Ливан, Ливи, Люксембург, Мексик, Монтенегро, Марокко, Мозамбик, Нидерланд, Норвег, Парагвай, Перу, Польш, Португал, Катар, Румын, ОХУ, Серб, Словак, Словени, Испани, Швед, Швейцар, Сири, Турк, Украин, Эмират, Узбекистан, Вьетнам зэрэг.

⁵ Гэмт хэрэг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс. С.Нарангэрэл. УБ. 1988. 42 дахь тал.

тогтоохоос эхэлнэ. Энэ үе шатанд гэмт хэргийг зүйлчлэх гэж буй прокурор, шүүгч хэргийн объектив үнэнийг, өөрөөр хэлбэл, хэргийн бодит нөхцөл байдлыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж бэхжүүлсэн нотлох баримтад үндэслэн бүх талаас нь бүрэн дүүрэн хөдөлбөргүй тогтоосон байх шаардлагатай. Мөн энэ хүрээнд хэргийн нөхцөл байдлын хууль зүйн учир холбогдлыг тодорхой болгох нь нэн чухал. Жишээ нь, материаллаг буюу хуульд гэмт үйлдэл, эс үйлдэхүйн улмаас тодорхой хохирол, хор уршиг учирсан байхыг шаардсан гэмт хэрэг байвал ямар хохирол, хор уршиг учирсан болохыг үйл баримтын хүрээнд нэг бүрчлэн тогтоох учиртай.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн хэм хэмжээг сонгон авах нь хууль хэрэглэх үйл ажиллагааны үндсэн үе шат юм. Энэ үе шатанд хуульчид Эрүүгийн хуулийн хэм хэмжээг сонгон авахдаа төрийн мэдээлэл сэтгүүлд хэвлэгдсэн эх бичмэлийг заавал магадлах ёстой бөгөөд эрүүгийн хуулийн тухайн зүйлд нэмэлт, өөрчлөлт орсон эсэхийг сайтар анзаарч, бас анхаарч дүгнэлт хийх явдал онцгой чухал.⁶

Эцэст нь, тогтоогдсон хэргийн бодит нөхцөл байдал ба сонгон авсан хэм хэмжээний хоорондын нийцэл тохироог шалгах үе шатанд хуульчид юуны түрүүнд тухайн сонгон авсан гэмт хэргийн үндсэн шинжийг тодорхойлж, эрх зүйн зөрчлийн хэв шинжийг тогтооно. Дараа нь гэмт хэргийн үндсэн шинжийг тайлбарлах, мөн бусад өрсөлдөх хэм хэмжээтэй харьцуулах ажиллагаа хийгдсэнээр зүйлчлэл тохирсон эсэхийг шалгах үйл явц дуусна.

Энэ бүхнийг системтэй, цэгцтэй мэдлэгээр тодорхой дараалал, хууль зүйн техник, арга зүйн дагуу логик дүгнэлт хийж аливаа үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэрэг мөн эсэх, ямар гэмт хэргийн шинжийг бүрэн хангаж буй болохыг зөв тогтоох онолын мэдлэг болон практик ур чадварын нэгдлийг гэмт хэрэг зүйлчлэлийн үндсэн ойлголтын хүрээнд авч үздэг.

Хоёр. Гэмт хэргийн үндсэн шинж ба зүйлчлэл

Прокурор, шүүхээс гэмт хэргийг зүйлчлэхдээ аливаа болж өнгөрсөн үйл явдлыг нотлох баримтад тулгуурлан тодорхойлоод, тухайн үйл явдал нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ямар гэмт хэргийн үндсэн шинж (объектив болон субъектив талын шинж)-ийг бүрэн хангаж байгаа эсэхэд оюун /логик/ болон хууль зүйн /субсунц/ дүгнэлт өгөх шаардлагатай байдаг. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн зүйлчлэл нь нийгэмд тодорхой хэлбэрээр илрэн гарсан үйл явдалд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан аль нэгэн гэмт хэргийн үндсэн шинж байгаа эсэхийг шалгасны үндсэн дээр хууль зүйн дүгнэлт өгөх логик ажиллагаа юм.

⁶ Гэмт хэрэг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс. С.Нарангэрэл. УБ. 1988. 43 дахь тал.



Тухайн үйл явдал нь гэмт хэргийн үндсэн шинж буюу гэмт хэргийн бүрэлдэхүүний бүх талын шинжийг бүрэн хангасан тохиолдолд гэмт хэрэгт тооцогдож, гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хууль ёсны үндэслэл бий болдог. Харин тухайн гэмт хэргийн үндсэн шинжийг хангаагүй тохиолдолд хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжээр нь алгасуулан зүйлчлэх боломж онолын хувьд ч байхгүй, хууль хэрэглээний практикт ч байгаагүй. Гэмт хэргийн үндсэн шинжийг хангаагүй нөхцөл байдлыг гэмт хэрэгт үйлдсэн гэм буруутайд тооцсон давж заалдах шатны шүүхийн магадлалыг Монгол Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын Хяналтын шатны шүүх хуралдааны 2020 оны 10 дугаар сарын 09-ний өдөр хянан хэлэлцсэн 557 дугаар тогтоолд:

Эрүүгийн хууль нь нийтлэг үндэслэл, зарчмуудыг тусгасан ерөнхий анги, тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүн, ялын төрөл, хэмжээг тогтоосон тусгай анги гэсэн хоёр хэсгээс бүрддэг нэгдмэл, төрөлжсөн хууль юм.

Уг хуулийн тусгай анги нь бүлэг, зүйл, хэсэг, заалтаас бүрддэг бөгөөд тухайн гэмт хэргийн үндсэн буюу ердийн бүрэлдэхүүн, хүндрүүлэх ба онцлон хүндрүүлэх шинж, оногдуулах ялын төрөл, хэмжээг хуульчлан тогтоодог тул үүнд зааснаас өөр үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцдоггүй билээ.

Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн ердийн бүрэлдэхүүн буюу 1 дэх хэсгийн диспозицэд “Авто тээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол...” гэж зааснаар авто тээврийн ослын улмаас бусдын бие махбодод хүндэвтэр гэмтэл учирсан тохиолдолд л гэмт хэрэгт тооцохоор хуульчлан тогтоосон байна.

Хуулийн энэхүү зохицуулалтаар зам тээврийн ослын улмаас хүний эрүүл мэндэд хөнгөн гэмтэл, эсхүл бусдын эд хөрөнгөнд хохирол учруулсныг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх хууль зүйн боломжгүй юм.

хэмээн хууль зүйн дүгнэлт хийсэн байна.

Тодруулбал, гэмт хэргийн үндсэн шинжийг хангасан гэмт үйлдэл, эс үйлдэхүйн хувьд л тухайн гэмт хэргийн хүндрүүлэх шинжийг хангасан эсэхийг шалгах хууль зүйн үндэслэл бүрдэнэ. Хэрэв гэмт хэргийн үндсэн шинжийг хангаагүй тохиолдолд тухайн гэмт хэргийн хүндрүүлэх, онцдон хүндрүүлэх бүрэлдэхүүнийг шалгах шаардлагагүй, зүйлчлэл хийх ямар ч боломжгүй. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн үндсэн шинжийг нь хангасан эсэхийг шалгалгүйгээр тухайн гэмт хэргийн хүндрүүлэх, онцлон хүндрүүлэх шинжээр нь алгасуулан зүйлчилдэггүй.

Харин хэм хэмжээний системчлэлийн хувьд зэрэгцээ бүрэлдэхүүнтэй гэмт хэргийн зүйлчлэл хийх хууль зүйн техник ялимгүй ялгаатай. Учир нь,

хууль тогтоогч зарим зүйлийн хэд хэдэн хэсэгт тухайн гэмт хэргийн өөр өөр диспозицыг зэрэгцүүлэн хуульчилсан байдаг. Мөн зарим хүндрүүлэх шинжийн хувьд хамаарах үндсэн шинжийг хууль тогтоогч ялган заасан тохиолдолд тухайн зүйлийн хэсэг, заалтыг алгасуулан зүйлчлэх тохиолдол бий болдог.⁷

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1-т “Дараах тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж болохгүй:” гээд уг зүйлийн 1.1 дэх заалтад “гэмт хэргийн шинжгүй;” гэж заасан тул аливаа үйлдэл, эс үйлдэхүй нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан аль нэгэн гэмт хэргийн үндсэн шинжийг агуулаагүй бол мөрдөгч, прокурор, шүүгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох үүрэгтэй.

Эрүүгийн хуулийн Хоёрдугаар бүлэг /Гэмт хэрэг/-т гэмт хэргийн ойлголт, шинжийн талаар тодорхойлсон бөгөөд тус бүлгийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг (хэлбэрийн бүрэлдэхүүнтэй) гэмт хэрэгт тооцохоор, мөн зүйлийн 2 дахь хэсэгт зөвхөн тусгай ангид заасан тохиолдолд гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас тодорхой хохирол, хор уршиг учирсныг (материаллаг бүрэлдэхүүнтэй) гэмт хэрэгт тооцохоор тус тус ялгамжтай авч үзсэн байна.

Ийнхүү ялгамжтай хуульчилсан үндсэн шалтгаан нь эрүүгийн эрх зүйн онолын хувьд хэлбэрийн болон материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэргийг ялгаатай авч үздэгтэй шууд холбоотой. Ялангуяа хохирол, хор уршигийн хэр хэмжээнээс хамаарч гэмт хэрэгт тооцох, эс тооцох асуудал хөндөгдөх учир материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэргийн хувьд Эрүүгийн хуулиар тухайн гэмт хэргийн үндсэн шинжид ямар хохирол, хор уршиг учирсан байхыг хууль тогтоогч шаардсан байгааг заавал олж харах, мөн хэргийн нөхцөл байдал буюу бодит үйл баримттайгаа харьцуулан дүгнэх нь чухал юм.

Гэмт үйлдэл, эс үйлдэхүй нь Эрүүгийн хуулийн тусгай ангид тогтоож өгсөн “хэргийн бүрэлдэхүүн”-ийг хангасан байх шаардлагатай юм. Хэргийн бүрэлдэхүүн нь **хуулиар үгчлэн батлагдсан хэм хэмжээ** буюу тодорхой нэг гэмт хэргийн хуулиар тогтоож өгсөн урьдач нөхцөл юм.⁸ Аливаа хэргийн бүрэлдэхүүн буюу гэмт хэргийн үндсэн шинжийг Эрүүгийн хуулийн тусгай ангид тусгайлан заах бөгөөд хэргийн бүрэлдэхүүн нь хангагдаагүй үед хүндрүүлэх бүрэлдэхүүн огт хөндөгдөхгүй байхаар системчлэгдсэн байдаг. Түүнээс биш гэмт хэргийн гарчгийг нь барьж, хүндрүүлэх бүрэлдэхүүнээр нь зүйлчилдэг онол болон практик огт байхгүй билээ.

⁷ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.2, 20.7, 22.4, 24.5 дугаар зүйлд заасан гэх мэт гэмт хэргүүдийг зэрэгцээ бүрэлдэхүүнтэйгээр хуульчилсан байна.

⁸ Германы эрүүгийн эрх зүйн ерөнхий анги. Удиртгал. 2015 он. Э.Хилгендорф, Д.Чанцалдулам 27 дахь тал



Тухайлбал, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт явдал нь гэмт хэрэг болох уу, эсхүл зөрчил байх уу гэдэг нь Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийг зөрчсөн ослын улмаас учирсан хохирол, хор уршгийн хэр хэмжээнээс шууд хамааралтай байна. Гэхдээ зөвхөн үндсэн шинжид заасан хохирол, хор уршгийн хэр хэмжээг харгалзана. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар жолооч замын хөдөлгөөний дүрэм зөрчсөний улмаас осол гаргаж, хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан тохиолдолд гэмт хэрэгт тооцогдохоор байна. Хууль тогтоогч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндсэн шинжийг хангасан гэмт хэргийн хүндрүүлэх шинжийг 2 дахь хэсэгт, онцлон хүндрүүлэх шинжийг 3 дахь хэсэгт тус тус хуульчилж, харин тус зүйлийн 4 дэх хэсэгт зөвхөн 3 дахь хэсгийн хувьд хамаарах тусгайлсан хүндрүүлэх шинжийг хуульчилсан байна.

Гурав. Хууль тогтоогчийн үзэл баримтлал ба шүүхийн практик

Засгийн газраас 2015 онд Улсын Их Хуралд өргөн барьсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулгад “Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 18 төрлийн үйлдэл, эс үйлдэхүйг эрэмбэлэн давхардал, хийдлийг арилгахаар, урьд тусгаж байгаагүй 45 төрлийн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг шинээр, харин 182 төрлийн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг өөрчлөн найруулж тусгасан болно.” гэж дурдсан байх боловч ердийн бүрэлдэхүүн буюу үндсэн шинж нь өөрчлөгдсөн гэмт хэрэг тус бүрээр үндэслэл, тайлбар хийгдээгүй байна.

Онолын хувьд хууль тогтоогч гэмт хэргийн шинжийг өөрчлөн тогтоохдоо зарим тохиолдолд нэг гэмт хэргийг нөгөө гэмт хэрэгт нэгтгэх, эсхүл нэг гэмт хэргийг хэд хэдэн гэмт хэрэг болгон задлах, эсхүл тодорхой төрлийн гэмт хэргийн зарим шинжийг өөр гэмт хэрэгт хамааруулах зэргээр хуульчилдаг. Жишээлбэл, 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 181 дүгээр зүйлд заасан танхайрах гэмт хэргийн зарим шинж нь гэмт хэрэгт тооцогдохгүй болсон байхад зарим шинж нь өөр өөр төрлийн гэмт хэргүүд рүү шилжсэн байсан билээ. Тодруулбал, тус зүйлийн 181.2.1 дэх заалт дахь догшин авирлаж буюу хүний биед хөнгөн, хүндэвтэр гэмтэл учруулсан үйлдэл нь 2015 оны Эрүүгийн хуулийн Арван нэгдүгээр бүлэг рүү, харин 181.2.5-д заасан бүлэглэж танхайрсан үйлдэл нь 2015 оны Эрүүгийн хуулийн 20.16 дугаар зүйл рүү тус тус шилжиж эрүүжсэн байдаг.

Хэрэв тодорхой төрлийн гэмт хэргийн шинж тусгай ангид заасан аль ч гэмт хэрэг рүү шилжээгүй тохиолдолд гэмт хэрэгт тооцохгүй болсон гэж ойлгож болно. Хууль тогтоогч тодорхой төрлийн гэмт хэргийн ердийн эсхүл хүндрүүлэх болон онцлон хүндрүүлэх бүрэлдэхүүнийг өөрчлөх замаар тухайн гэмт хэргийн зарим шинжийг үгүйсгэх буюу гэмт хэрэгт тооцохгүй болохыг эрүүгийн эрх зүйн онолд эрүүгүйжүүлэх гэдэг. Зарим гэмт хэргийн

нийгмийн аюулын шинж чанар, тухайн төрлийн харилцааны онцлог, шинэ тутам үүссэн нөхцөл байдал зэргээс хамааран хууль санаачлагч болон хууль тогтоогчид зарим үйлдлийг эрүүжүүлэх шаардлагагүй гэж үзэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах нь бий. Үүний нэг тод жишээ бол 2002 оны Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 215.1 дэх хэсэгт заасан тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн үндсэн шинжийг 2015 оны Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт өөрчлөн тодорхойлсноор өмнө нь эрүүжиж байсан диспозицийн зарим хэсэг нь гэмт хэрэгт тооцогдохгүй болсон явдал юм.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас эрхлэн гаргасан МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ: Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/; Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/, Сургагч багш нарт зориулсан гарын авлагын 273-274 дэх тал⁹-д дээр дурдсан гэмт хэргийн өөрчлөлттэй холбоотой тайлбарыг хүснэгтээр тусгажээ.

2015 оны Эрүүгийн хууль	2002 оны Эрүүгийн хууль	Шинэлэг байдал, өөрчлөлт
27.10 дугаар зүйл: 1.Авто тээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол...	215 дугаар зүйл: 215.1. Жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдын бие махбодод хүндэвтэр гэмтэл, эсхүл үлэмж хэмжээний хохирол учирсан бол...	- Энэхүү гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнээс “үлэмж хэмжээний хохирол учирсан” гэсэн шинжийг хассанаар зөвхөн хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учирсан тохиолдолд гэмт хэрэгт тооцохоор болсон.

Тус гарын авлагад тусгасан дээрх хүснэгтээс үзвэл, уг хуулийн төслийг боловсруулсан ажлын хэсгийн гишүүд “жолооч зам тээврийн осол гаргасны улмаас бусдын эд хөрөнгөд хохирол учруулсан үйлдлийг дангаар нь гэмт хэрэгт тооцохгүй болсон” хэмээн тайлбарласан байна.

Түүнчлэн, хуульч, судлаачийн хувиар санал, дүгнэлтээ хүргэж буйн хувьд нэмж хэлэхэд, миний бие 2014 онд Хүний эрхийн Үндэсний Комиссыг төлөөлөн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан. Ажлын хэсгийн хуралдаанд 2002 оны Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлд заасан гэмт хэргийн үндсэн шинжийг өөрчлөх

⁹ 2017 онд хэвлэгдсэн тус гарын авлагын Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын хэсгийг тус хуулийн төслийг боловсруулах, Хууль зүйн байнгын хороон дээр хамгаалах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан Б.Батцэрэн, Э.Амарбат, Я.Жавхлан, Б.Гантуяа, Г.Оюунболд, С.Гантулга нар хамтран боловсруулсан бөгөөд Б.Батцэрэн (Улсын дээд шүүхийн шүүгч), Г.Эрдэнэбат (Улсын Ерөнхий прокурорын орлогч), Б.Энхбаяр (Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд), П.Сайнзориг (Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга) нар хянан тохиолдуулжээ.



асуудал хөндөгдсөн. Ажлын хэсгийн гишүүдийн олонх “Зам тээврийн осол бол болгоомжгүй гэмт явдал. Гэтэл эд хөрөнгийн хохирлын хэмжээг үндэслэн гэмт хэрэгт тооцож байгаа нь буруу. Өндөр үнэтэй машин унаж явсан хүн гэмт хэргийн хохирогч болдог, харин хямд үнэтэй машин унаж явсан хүн иргэний нэхэмжлэгч болдог байж таарахгүй. Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хүнийг хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхаж болохгүй гэж заасан байдаг. Иймд авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн үндсэн шинж буюу бүрэлдэхүүнээс үлэмж хэмжээний хохирол учирсан бол гэсэн материаллаг диспозицийг хасах нь зүйтэй.” хэмээн санал нэгдсэн байдаг юм.

Шүүхийн шийдвэрийн цахим сан¹⁰-аас 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 05 дугаар сарын 10-ны хооронд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 2.4 дэх заалтаар зүйлчлэгдсэн хэргээр хайлт хийж үзэхэд нийт 31 шийдвэр бүртгэгдсэн байгаагаас 15 шийтгэх тогтоол¹¹-оор хүний эрүүл мэндэд хүндэвтэр болон түүнээс илүү хохирол учраагүй байхад зөвхөн их хэмжээний хохирол учирсан гэх хүндрүүлэх шинжээр нь зүйлчилж, нийт 15 хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцжээ.

Дээрх тогтоолуудыг нэг бүрчлэн шүүж үзвэл, тодорхойлох хэсэгт 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 215 дугаар зүйлийн 215.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн үндсэн шинж хэрхэн өөрчлөгдсөн, 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн үндсэн шинжийг хэрхэн хангасан талаарх хууль зүйн дүгнэлт байсангүй.

Харин Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 281 дугаар цагаатгах тогтоолоор жолооч замын хөдөлгөөний дүрмийн заалт зөрчсөний улмаас бусдын эд хөрөнгөд их хэмжээний хохирол учирсан байгаа нь дангаараа хэргийн бүрдэл хангахгүй гэж үзээд хэргийг “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, шүүгдэгчийг цагаатгасан шийдвэр гаргасныг Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 501 дугаар магадлал¹²-аар хүчингүй болгохдоо “Хууль тогтоогчоос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10

¹⁰ Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)

¹¹ Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 147 дугаар, 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 52 дугаар, 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 57 дугаар, 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 81 дүгээр, 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 134 дүгээр шийтгэх тогтоолууд, Төв аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 57 дугаар, 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 453 дугаар шийтгэх тогтоолууд, Дорнод аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 15 дугаар шийтгэх тогтоол, Говь-Алтай аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 14 дүгээр шийтгэх тогтоол, Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 168 дугаар, 2021 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 491 дүгээр шийтгэх тогтоолууд, Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 80 дугаар, 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 716 дугаар шийтгэх тогтоолууд, Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 599 дүгээр шийтгэх тогтоол

¹² Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)

дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.4 дэх заалтад авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийг их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол хүндрүүлэхээр хуульчилсан.” гэж дүгнэсэн болно.

Шүүхийн практикаас, энэ гэмт хэргийн үндсэн шинжийг хэрхэн ойлгох, нэг мөр хэрэглэх талаар харилцан адилгүй шүүхийн шийдвэрүүд гарсан, мөн бид гэмт хэрэг зүйлчлэлийн онол, арга зүйн талаар нэгдмэл ойлголтгүй байгаа нь тус тус харагдаж байна.

САНАЛ, ДҮГНЭЛТ

Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх бөгөөд Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгч гагцхүү хуульд захирагдах онцгой үүрэгтэй билээ. Ялангуяа, гэмт хэргийн шинжийг хууль тогтоогч хэрхэн хуульчилсныг нэг мөр зөв ойлгон хэрэглэх нь хүний эрх, эрх чөлөөтэй салшгүй холбоотой амин чухал асуудал юм.

Хэрэв шүүхийн практикт шийдвэрлэж байгаачлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн үндсэн шинжийг хангасан эсэхийг үл харгалзан “бусдад их хэмжээний хохирол учирсан” гэх хүндрүүлэх шинжээр нь гэмт хэрэгт тооцох боломжтой гэж үзвэл согтуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөний дүрэм зөрчиж осол гаргасан жолооч тус зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад зааснаар, харин тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл эрхээ хасуулсан хүн тээврийн хэрэгсэл жолоодон осол гаргавал мөн хэсгийн 2.2 дахь заалтаар тус тус эрүүгийн хариуцлага хүлээх, ял шийтгүүлэх бодит эрсдэл бий болсон гэж дүгнэхэд хүргэнэ.

Иймд шүүгч гагцхүү хуульд захирагдах Үндсэн хуульчилсан үүргийн дагуу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжийг хангаагүй ч их хэмжээний хохирол учирсан гэдгээр гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй шүүхийн практикийг нэг мөр болгох үүднээс Монгол Улсын дээд шүүх онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор албан ёсны тайлбар гаргах, эсхүл сургалт зохион байгуулах зэргээр тодорхой арга хэмжээ авах нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна.



ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ГУРАВДАГЧ ЭТГЭЭДИЙН ОРОЛЦОО, ТҮҮНИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Э.Мөнхдаваа

*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш*

Оршил

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хэргийн оролцогчийн эрх зүйн байдлыг зөв тодорхойлох нь хэргийг үндэслэлтэй зөв шийдвэрлэхэд болон хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчигдөхөөс сэргийлэх зэрэг чухал ач холбогдолтой байдаг.

Гуравдагч этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулж буй гол зорилго нь гуравдагч **этгээдэд** зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах боломж олгох төдийгүй, процессын ажиллагаагаар дахин нэг процесс үүсгэхгүйгээр хэргийг бүх талаас нь бүрэн дүүрэн хянан үзэж шийдвэрлэхэд оршдог.

Хэрэв гуравдагч этгээдээр оролцуулах шаардлагатай этгээдийг оролцуулаагүй, эсхүл оролцуулах шаардлагагүй этгээдийг гуравдагч этгээдээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулах нь процессын зөрчил болох бөгөөд ингэснээр хэрэг хянан шийдвэрлэх **ажиллагаа** удаашрах, хэргийн оролцогчдод хүнд чирэгдэл учрах, улмаар хэргийн оролцогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх зэрэг сөрөг үр дагавартай.

Иймд гуравдагч этгээдийг онолын болоод хууль хэрэглээний хувьд хэрхэн тодорхойлж хэрэглэж байгаад дүгнэлт өгөх, түүний эрх зүйн байдлыг тодорхойлох, ялангуяа бие даасан шаардлага гаргасан болон бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийн тухай ойлголт, тэдгээрийн онцлог хийгээд нийтлэг болон ялгаатай тал, гуравдагч этгээдийг татан оролцуулахад анхаарах зэрэг асуудлыг **тодорхойлоход** энэхүү өгүүллийн зорилго оршино.

I. Гуравдагч этгээд, түүнийг тодорхойлох нь

“Гуравдагч этгээд” нь хууль зүйн нэр томъёоны хувьд англи хэлэнд “Third parties” заримдаа “Third parties persons”, герман хэлэнд “Beigeladener”¹ болон “Dritte person” гэж нэрлэгддэг “гуравдагч этгээд”-ийг эрх зүйн онолд эрх зүйн харилцааны субъект мөн гэж тодорхойлдог. Өөрөөр хэлбэл энэ нь

¹ Захиргааны эрх зүйн нэр томъёоны тайлбар толь. Герман-Монгол. Улаанбаатар (2005) 94 дэх тал.

эрх зүйн харилцаанд оролцох нэг хэлбэр бөгөөд эрх зүйн харилцааны нэг чухал бүрэлдэхүүн юм.

Харин хэл зүйн талаас нь авч үзвэл “гуравдагч” гэдэг нь дэс тоо буюу тооны нэр² бөгөөд этгээд гэдгийг эзэн этгээд буюу субъект гэсэн утгаар ойлгоно. Гуравдагч этгээд гэдэг ойлголтыг иргэний болон захиргааны (2002 оны) процессын хуулиар нарийвчлан тодорхойлоогүй байсан бол 2016 онд шинэчлэн найруулсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.5 дахь хэсэгт “...нэхэмжлэлийн шаардлагад тодорхойлсон захиргааны акт, захиргааны гэрээний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг гуравдагч этгээд гэнэ...” гэж тодорхойлжээ.

Тэгвэл гадаадын болон дотоодын хууль зүйн ухааны эрдэмтэн, судлаачид гуравдагч этгээдийн талаар хэрхэн тодорхойлсныг авч үзвэл:

ОХУ-н эрдэмтэд А.К.Кац “..Гуравдагч этгээд гэдэг нь шүүхээс нэгэнт үүсгэгдсэн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд маргааны зүйлийн талаар өөрийн бие даасан эрхийг хамгаалах ба тухайн хэргийн шийдвэр нь түүний эрх үүрэгт сөргөөр нөлөөлөхөөр байвал аль нэг талтай нь холбогдсон байдлаар оролцдог хэргийн оролцогчийг хэлнэ..” гэж; проф Д.М.Чечот “..Шүүхээс үүсгэсэн хэрэгт өөрийн субъектив эрх, ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор оролцдог, нэхэмжлэгч, хариуцагчийн эрх, ашиг сонирхлоос түүний эрх, ашиг сонирхол нь өөр байгаа этгээдийг гуравдагч этгээд гэнэ..”³,

Академич С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” бүтээлдээ гуравдагч этгээдийг “...хуулиар хамгаалагдсан өөрийн эрх ба ашиг сонирхлоо хамгаалж буй этгээд. Маргааны зүйлийн талаар бие даасан шаардлага гаргасан ба бие даасан шаардлага гаргаагүй гэж ангилна. Эхнийх нь нэгэнт эхэлсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хоёр тал буюу аль нэгэнд нь нийтлэг үндэслэлийн дагуу нэхэмжлэлийг гаргаж болдог. Энэ төрлийн гуравдагч этгээд нэхэмжлэгчийн бүх эрхийг эдэлж болдог. Хоёр дахь нь хэргийн шийдвэр талуудын аль нэгний хувьд эрх, үүрэгт нь нөлөөлөхөөр байвал нэхэмжлэгч буюу хариуцагчийн талд /өөрийн санаачилгаар буюу талуудын хүсэлтээр/ оролцоно” гэж тодорхойлжээ.⁴

Хуульч, судлаач З.Мөнхжаргал “..ИХШШТХ-д заасан үндэслэл журмын дагуу үүсгэсэн иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд уг хэргийн талаар шүүхээс гарах шийдвэр, эрх, ашиг сонирхолд нь сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзэн, эрх зүйн тодорхой сонирхолтой оролцож байгаа этгээдийг гуравдагч этгээд гэнэ..”⁵ гэж тус тус тодорхойлжээ.

² Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. Уб., 1998 он. 76 дахь тал.

³ Ред.В.В.Ярков.доктор.проф. Гражданский процесс.М.1999.стр 73 дахь тал.

⁴ С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. Уб., 2008 он. 120 дахь тал. 2 дахь хэвлэл 2015 он. 114 дэх тал.

⁵ З.Мөнхжаргал. Монгол улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй. Ерөнхий анги.Улаанбаатар (2019) 121 дэх тал.



Эрдэмтэн судлаачдын тодорхойлолт, зохиол бүтээлээс үзэхэд гуравдагч этгээд нь дараах нийтлэг шинжийг агуулсан байна гэж үзэж болохоор байна. Үүнд:

- Шүүхэд нэхэмжлэгчээс гаргасан шаардлагыг үндэслэн шүүх тухайн хариуцагчид холбогдуулан хэрэг үүсгэсний дараа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эхнээс нь биш явц дунд нь шүүхийн шийдвэр гарахаас өмнө оролцдог;
- Гуравдагч этгээдийн шүүхэд гаргасан бие даасан шаардлагыг нэхэмжлэгч, хариуцагч хоёрын хоорондын маргаантай тухайн хэрэгт хамтруулан шийдвэрлэдэг;
- Гуравдагч этгээд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн нэрийн өмнөөс, өөрийн ашиг сонирхлыг хамгаалж оролцдог;
- Тухайн захиргааны акт, гэрээний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй байх.

Дээр дурдсан шинжүүдээс үндэслэн гуравдагч этгээд нь хэргийн оролцогчийн бүрэлдэхүүнд хамаарч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн шийдвэр гарахаас өмнө, өөрийнх нь эрх, ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй гэж үзэн, өөрийн шаардлагаа нэхэмжлэлтэй хамтруулан шийдвэрлэхээр шүүхэд хандаж байгаа, эрх зүйн тодорхой ашиг сонирхолтой этгээдийг ойлгож болохоор байна.

II. Бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдыг “хэргийн оролцогч”, “бусад оролцогч” гэж хуваах бөгөөд хэргийн оролцогчдын нэг нь гуравдагч этгээд юм. Учир нь нэхэмжлэгч, хариуцагч бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөн оролцдог бол гуравдагч этгээд зөвхөн иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжтой бөгөөд зорилго, эрх зүйн байдлынхаа хувь ч нэхэмжлэгч, хариуцагчаас зарим ялгаатай.

Харин гуравдагч этгээд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тухайн маргааны үйл баримт, түүний хүсэл зоригоо илэрхийлсэн байдлаас нь хамаарч “бие даасан шаардлага гаргасан”⁶ болон “бие даасан шаардлага гаргаагүй” гуравдагч этгээд гэж ангилж болно.

Нэхэмжлэгчийн үндсэн нэхэмжлэлийн шаардлагаар үүсгэсэн хэргийг шүүхээс шийдвэрлэх явцад эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн

⁶ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай УДШ-ийн 2003.05.05-ны өдрийн 11-р тогтоолын 4-т “бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд гэдэгт шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа өөрийнх нь эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр байвал төлбөр авагчийн нэгэн адил шаардлагыг бие даан тавьж буй этгээдийг ойлгоно.” гэж тайлбарлажээ.

Харин бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд, гаргаагүй гуравдагч этгээдийг УДШ болон захиргааны процессын хуулиар нарийвчлан тодорхойлоогүй байна.

гэж үзэж буй этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд маргааны үйл баримтын талаар бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдээр оролцдог. Иймд бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд нэхэмжлэгчийн болон хариуцагчийн шаардлагаас агуулгын хувьд өөр шаардлага тавьж буй этгээд юм. Тодруулбал “Бие даасан шаардлага” нь нэхэмжлэлд тавигдах бүх шаардлагыг хангах бөгөөд түүний шаардлага нь тухайн хэргийн улмаас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор нэхэмжлэгч, хариуцагч нарын хүсэл, сонирхлоос хамаарахгүйгээр бие дааж шүүхэд гаргасан “нэхэмжлэл” гэж ойлгож болохоор байна.

Жишээлбэл: Нэхэмжлэгч А-аас “...Баянзүрх дүүргийн Засаг даргын 2020.02.03-ны өдрийн 22 дугаар захирамжаар миний эзэмшлийн газартай давхцуулан Б-д олгосон хэсгийг хүчингүй болгуулах..” тухай нэхэмжлэлийн шаардлага гаргасан. Хэрэв шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хангасан тохиолдолд Б-ийн газар эзэмших эрх зөрчигдөж болзошгүй тул шүүхээс Б-ээг гуравдагч этгээдээр татсан. Гэтэл гуравдагч этгээдээр татагдсан Б нь нэхэмжлэгч А-д анх дүүргийн Засаг дарга газар олгосон 2018 оны 11-р захирамж нь анхнаасаа илт хууль бус тул илт хууль бус болохыг тогтоолгож өгнө үү..” гэсэн шаардлагыг гаргасан. Энэ тохиолдолд гуравдагч этгээд Б-ийн шаардлага нь бие даасан шаардлага болно.

Харин тэдгээрийн эрх зүйн байдлын хувьд бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд нь нэхэмжлэгч талын бүх эрх, үүргийг эдэлж оролцдог бол бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийн хувьд хариуцагч талын нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, эвлэрхээс бусад эрхийг эдэлж, үүргийг хүлээдэг, нэхэмжлэгч талын нэхэмжлэлээ өөрчлөх, нэхэмжлэлээ ихэсгэх, багасгах, татгалзахаас бусад нэхэмжлэгчийн эрхийг эдэлж, үүргийг хүлээдгээрээ эрх зүйн байдлын хувьд ялгаатай байна.⁷ Гуравдагч этгээдээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даасан шаардлага гаргаж байгаа тохиолдолд тэрхүү шаардлага нь нэхэмжлэлийн бүх шаардлагыг хангасан байвал зохино.⁸ Тиймээс түүний гаргасан шаардлагыг шүүх хүлээн авч гуравдагч этгээдээр татах захирамж гаргаснаар хэргийн оролцогч болох бөгөөд гаргасан шаардлагыг нэхэмжлэгч, хариуцагч нарт гардуулах, тайлбар, нотлох баримт гаргах боломжийг олгоно.

Иймд шүүхээс гуравдагч этгээдийн бие даасан шаардлага болон нэхэмжлэгч, хариуцагч нарын хооронд үүссэн эрх зүйн маргааныг тус тусад нь шийдвэрлэнэ. Харин бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдийг хамтран нэхэмжлэгчээс ялгах шаардлагатай. Хамтран нэхэмжлэгчид

⁷ ЗХШШТХ-ийн 22.3, 22.4.

⁸ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, Улсын дээд шүүх, Ханнс зайдлын сан, Улаанбаатар хот, 2009 он.



нэхэмжлэлийн шаардлага адил бол бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдийн хувь түүний шаардлага өөр байна.⁹

Хэдийгээр тухайн маргаан нь хэргийн оролцогчидтой холбоотой боловч хэлэлцэж буй маргааны зүйл, шаардлага, үндэслэлээс өөр асуудлыг тусгасан шаардлага гаргаж буй этгээдийг тухайн хэрэгт гуравдагч этгээдээр татан оролцуулах шаардлагагүй. Тэрээр тухайн асуудлаар бие даасан нэхэмжлэл гаргаж шүүхээр шийдвэрлүүлэх боломжтой. Тийм дээ ч захиргааны процессын хуульд “..**үндсэн нэхэмжлэлийн шаардлагаар үүссэн маргааны үйл баримтын талаар бие даасан шаардлага гаргасан.**”¹⁰ гэж тодотгожээ.

Бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд өөрийн санаачилгаар, өөрийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог бөгөөд түүний тавьсан шаардлагыг шүүх хүлээн авч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч болохыг баталж шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж гаргана.

Хэрэв гуравдагч этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахаас татгалзсан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид хэргийн оролцогч давж заалдах гомдол гаргах боломжийг 2016 оны шинэчлэн найруулсан захиргааны процессын хуулиар олгосон нь Үндсэн хуульд заасан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн тохиолдолд шүүхэд гомдол гаргах, шүүхийн шийдвэрт давж заалдах эрхийг улам баталгаажуулсан байна.¹¹

ЗХШШТХ-ийн 22.1 дэх хэсэгт “..гуравдагч этгээдийг тухайн этгээдийн хүсэлтээр, эсхүл шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна..” гэж зохицуулснаар түүнийг эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах боломжийг олгосон байна. Шүүх гуравдагч этгээдийн энэ эрхээ эдлэх баталгааг хангах үүднээс захиргааны хэрэг үүсгэсний дараа гуравдагч этгээдийг оролцуулах¹² эсэх асуудлыг шийдвэрлэхээр зохицуулжээ.

Гуравдагч этгээдийн гаргасан шаардлага нь бие даасан буюу нэхэмжлэгч, хариуцагчийн байр суурийн аль нэгийг дагалдан дэмжигч биш болохыг өмнө дурдсан бөгөөд түүний эрх зүйн байдлын эдгээр онцлогийг харгалзан захиргааны хэргийн шүүх түүний бие даасан шаардлагатай

⁹ Гэвч практикт бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд нь ихэвчлэн нэхэмжлэгчийн талд зогсох нь элбэг байдаг.

¹⁰ ЗХШШТХ-ийн 22.1.

¹¹ ЗХШШТХ-ийн 122.1.Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч энэ хуулийн 14.6, 32.6, 54.2, 61.1, 65.1, 111.3, 119.6, 123.7 дахь хэсэгт заасан болон гуравдагч этгээдийг оролцуулахаас татгалзсан тухай шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд бичгээр гарсан өдрөөс нь хойш долоо хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.

¹² ЗХШШТХ-ийн 56.1.6.шаардлагатай бол гуравдагч этгээдийг оролцуулах захирамж гаргах;

холбоотой асуудлыг тусад нь шийдвэрлэж шийдвэртээ зориуд ялгамжтай¹³ тусгаж байх нь зүйтэй.¹⁴

Хэрэв гуравдагч этгээдийн гаргасан бие даасан шаардлагад анхан шатны шүүх дүгнэлт өгөөгүй,¹⁵ эсхүл шийдвэрлээгүй орхигдуулсан тохиолдолд тухайн шүүхийн шийдвэр хүчингүй болох, анхан шатны шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаах зэрэг үндэслэл болно.

III. Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийг оролцуулах боломжийг олгосон бөгөөд тэрээр шүүхээс гарах шийдвэр нь түүний эрх зүйн байдлыг дордуулах буюу сөргөөр нөлөөлж болзошгүй бол бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийн хувиар оролцуулж болно. Өөрөөр хэлбэл тухайн этгээд маргааны зүйлийн талаар бие даасан шаардлага байхгүй боловч шүүхээс гарах шийдвэр түүний ашиг сонирхлыг хөндөж байдаг учраас тэрээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэг бол нэхэмжлэгчийг, нэг бол хариуцагчийг дэмжиж оролцдог. ЗХШШТХ-ийн 22.1 дэх хэсэгт “..эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа гэж үзсэн гуравдагч этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна...”¹⁶ гэж зохицуулжээ.

Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд бол хэргийн оролцогчийн аль нэгтэй нэгэн адил хүсэл зорилго, шаардлагатай байгаа этгээд боловч практикт ихэвчлэн хариуцагчтай ашиг сонирхол нэг байдаг.

Жишээлбэл: төрийн албан хаагчийг ажлаас чөлөөлж түүний оронд өөр этгээдийг ажилд авсантай холбоотой маргаанд ажлаас чөлөөлөгдсөн этгээдийг нэхэмжлэлийн шаардлагатай холбогдуулан шүүхээс нэхэмжлэгчийн оронд ажилд орсон этгээдийг бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр шүүх татан оролцуулах шаардлага гарна. Энэ тохиолдолд бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд болон хариуцагч буюу ажил олгогч захиргааны байгууллагын ашиг сонирхол нэг юм.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийг шүүхийн санаачилгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулж болдог бол¹⁷ иргэний хэрэг

¹³ ЗХШШТХ-ийн 107.3.Тодорхойлох хэсэгт нэхэмжлэлийн шаардлага, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн тайлбар, иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг тусгана.

¹⁴ “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрх зүйн байдал” Захиргааны хэргийн шүүх 8-р цуврал, гарын авлага, Улаанбаатар (2006) 24 дэх тал.

¹⁵ ЗХШШТХ-ийн 121.3.7.шүүх нэхэмжлэлийн болон гуравдагч этгээдийн бие даасан шаардлага, түүний зарим хэсэгт нь дүгнэлт өгөөгүй, эсхүл шийдвэрлэлгүй орхигдуулсан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн бол.

¹⁶ 2002 оны ЗХШТХ-д 21.1-д “..гуравдагч этгээдийг шүүгч захирамж гарган захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж болно.” гэж зохицуулсан нь гуравдагч этгээдийг оролцуулах эсэх нь шүүгчийн бүрэн эрх байсан бол 2016 оны ЗХШШТХ-ийн 22.1-д хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна.” гэж шууд үүрэгжүүлсэн агуулгаар зохицуулсан нь онцлог болжээ.

¹⁷ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.1.Үндсэн нэхэмжлэлийн шаардлагаар үүссэн маргааны үйл баримтын талаар бие даасан шаардлага гаргасан, эсхүл эдгээрийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь



хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдийг шүүхийн санаачилгаар бус зөвхөн уг этгээдийн өөрийнх нь, эсхүл зохигчийн хүсэлтээр бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийн хувиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулдаг байна.¹⁸

IV. Гуравдагч этгээдийг оролцуулах шалгуур

Нэг. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.1.Үндсэн нэхэмжлэлийн шаардлагаар үүссэн маргааны үйл баримтын талаар бие даасан шаардлага гаргасан, эсхүл эдгээрийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа гэж үзсэн гуравдагч этгээдийг тухайн этгээдийн хүсэлтээр, эсхүл шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна...” гэж заасан боловч **“бие даасан шаардлага”** гэдэгт юуг ойлгохыг нарийвчлан тодорхойлоогүй байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гуравдагч этгээдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй тохиолдолд шүүхээс түүнийг бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр татаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах явцад гуравдагч этгээдээр татагдсан этгээд бие даасан шаардлага гаргах эрх нээлттэй.

Хэдийгээр шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхнаас нь бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр татан оролцуулсан тохиолдолд хэрэгт цугларсан нотлох баримтаас хамаарч бие даасан шаардлага гаргах эсэх нь түүний сонголт буюу эрх бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад “бие даасан шаардлага” гаргавал түүний эрх зүйн байдал өөрчлөгдөж байгаа тул бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдээр татан оролцуулах тухай шүүгчийн захирамж гаргаж эрх зүйн байдлыг өөрчилж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах нь гуравдагч этгээд өөрийн гаргасан шаардлагаа шийдвэрлүүлэхийн тулд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдлэх эрхээ бүрэн хэрэгжүүлэх, шүүхийн шийдвэрээр маргаантай асуудлыг нэг мөр хянан шийдвэрлэх зэрэг ач холбогдолтой.

Гуравдагч этгээд нь бие даасан шаардлага нэрийн дор орон сууцны төлбөр гаргуулах, албадан нүүлгэх,¹⁹ зардлыг нөхөн төлүүлэх, хохирол шаардах гэх мэт шаардлагыг гаргаж, үүнийгээ бие даасан шаардлага гэж үзсэн тохиолдолд хэрхэх вэ, энэ нь бие даасан шаардлага мөн үү?

хөндөгдөж байгаа гэж үзсэн гуравдагч этгээдийг тухайн этгээдийн хүсэлтээр, эсхүл шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна.

¹⁸ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.3.Шүүхээс гарах шийдвэр маргааны зүйлийн талаар бие даасан шаардлага гаргаагүй этгээдийн эрх, үүрэгт сөргөөр нөлөөлөхөөр байвал шүүхийн шийдвэр гарахаас өмнө уг этгээдийн өөрийнх нь, эсхүл шүүхийн санаачилгаар болон зохигчийн хүсэлтээр бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийн хувиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж болно.

¹⁹ Зоригтбаатар Э, “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь гуравдагч этгээдийн эрх зүйн байдал” магистрын дипломын ажил, Улаанбаатар (2010) 34 дэх тал.

Жишээлбэл: “Ц” ХХК-аас Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн 2015.06.30-ны өдрийн 61 тоот дүгнэлт, 2015.08.17-ны өдрийн Барилга угсралтын ажлыг зогсоох тухай 405 тоот актыг илт хууль бус болохыг тогтоолгох..” тухай нэхэмжлэлийн шаардлагыг Захиргааны хэргийн шүүхэд гаргасан.

Гэтэл гуравдагч этгээдээр татагдсан “Н” ХХК-аас дээрх дүгнэлт, актын улмаас манай компани барилгын ажлыг цаг хугацаандаа баригдаагүйн улмаас учирсан хохирол 700 сая төгрөгийг хариуцагчаас гаргуулах..” тухай бие даасан шаардлага гаргасан.²⁰

Дээрх тохиолдолд гуравдагч этгээдийн гаргасан шаардлагыг бие даасан шаардлага гэж үзэн Захиргааны хэргийн шүүх хамтад нь шийдвэрлэх үү, эсхүл гэм хор, хохирлын асуудал нь иргэний шүүхээр шийдвэрлэх асуудал гээд хохирлоо жич нэхэмжлэх эрхтэй гэж үзэн хүлээн авахаас татгалзах уу.

Гэм хор, хохирлын талаарх шаардлага гаргах эрх нь ЗХШШТХ-ийн 106.6-д заасны дагуу зөвхөн нэхэмжлэгчид байгаа бөгөөд харин гуравдагч этгээдийн хувьд тийм боломж байхгүй байна. Тиймдээ ч дээрх тохиолдол бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдийн бие даасан шаардлагыг шүүх шийдвэрлэхдээ ЗХШШТХ-ийн 54.1.5-д заасны дагуу нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд гэж үзэн хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байна.

Тэгэхээр шүүхээс гуравдагч этгээдийг татан оролцуулахдаа тухайн маргааныг хянан шийдвэрлэснээр гарах шүүхийн шийдвэрийн эрх зүйн үр дагавар нь нэхэмжлэгч, хариуцагчаас гадна бусад этгээдийн хувьд эерэг юм уу сөрөг байдлаар шууд тусгахаар бол түүнийг гуравдагч этгээдээр татан оролцуулах ёстой байна.²¹

Гуравдагч этгээдийн бие даасан шаардлага нь тухайн хэрэгт хамтатган шийдвэрлэх нь бодит үнэнийг тогтоох, хэрэг хянан шийдвэрлэх хэмнэлтийн зарчимд нийцсэн, шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг хангах боломжтой эсэхийг харгалзан үзэж байх шаардлагатай.

Шүүх гуравдагч этгээдийг тодорхойлохдоо нэхэмжлэлийн шаардлагад дурдсан захиргааны шийдвэр, үйл ажиллагааны улмаас тухайн этгээдийн “хууль ёсны” эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж буй эсэхийг анхаарна. Зүгээр л эдийн засгийн шинжтэй, эсхүл нийгмийн, хувь хүний үзэл бодол, улс төрийн, шашны гэх мэт “хуулиар хамгаалагдаагүй” ашиг сонирхол нь гуравдагч этгээдийг тодорхойлох шалгуур болохгүй. Харин тухайн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь нийтийн эсвэл хувийн эрх зүйн байх нь ач холбогдолгүй.²²

²⁰ Шүүхийн цахим сан. <http://new.shuukh.mn/zahirgaanhan/5090/view>.

²¹ Банзрагч Г, “Захиргааны процессын эрх зүй” Улаанбаатар, (2019) 94 дэх тал.

²² Мөн тэнд 95 дахь тал.



Тухайн этгээд бие даасан шаардлага гаргаснаар түүнийг шүүхээс бус, тэрээр өөрийн санаачилгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох сонирхол байгаа тул түүний бие даасан шаардлага, үндэслэл, шаардлагын цаашдын үр дагавар, ач холбогдлыг сайтар шалгасны үндсэн дээр бие даасан шаардлага мөн эсэхийг тогтоох нь ач холбогдолтой. Хэрэв тухайн бие даасан шаардлага нь үндсэн нэхэмжлэл болон хариуцагчийн сөрөг нэхэмжлэлийг дэмжсэн агуулгатай байвал гуравдагч этгээдийн энэ шаардлага нь бие даасан шаардлагын шинжийг агуулахгүй юм. Дээрх тохиолдолд “Н” ХХК-ийн гаргасан бие даасан шаардлага нь нэхэмжлэгчийн байр суурийг дэмжсэн агуулгатай байсан тул шүүх хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байна.

Хоёр. Шүүх тухайн маргаан бүхий захиргааны шийдвэр, үйл ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй, тухайн маргаантай шалтгаант холбоо буюу хамаарал бүхий этгээдийг нотлох баримтын хүрээнд цэгнэн үзсэний үндсэн дээр гуравдагч этгээдээр татан оролцуулах эсэх асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй.

Гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж буй эсэхийг нь үндэс болгон тухайн нэхэмжлэлийн шаардлагын төрлөөс шалтгаалж шүүхээс “заавал татан оролцуулах шаардлагатай” гуравдагч этгээд, шүүх “цэгнэн үзсэний үндсэн дээр” оролцуулах гуравдагч этгээд гэж ангилж болно.²³

Заавал татан оролцуулах шаардлагатай гуравдагч этгээд нь шүүхээс гарах шийдвэр түүний хувьд эрх зүйн шууд үр дагавартай байдаг. Тухайлбал тендерийн үнэлгээний хорооны шийдвэрийг хүчингүй болгуулах шаардлага бүхий нэхэмжлэлтэй хэрэгт тендерт шалгарсан этгээдийг, газар давхардуулан олгосон маргаан, төрийн албан хаагчийг ажлаас чөлөөлж түүний оронд өөр этгээдийг томилсонтой холбоотой чөлөөлөгдсөн этгээдийн ажилд эргүүлэн томилуулах шаардлага бүхий нэхэмжлэлтэй хэрэг маргаанд түүний оронд ажилд томилогдсон этгээдийг заавал татан оролцуулах шаардлагатай гуравдагч этгээд гэж үзнэ.

Харин цэгнэн үзсэний үндсэн дээр оролцуулах гуравдагч этгээдийн тухайд түүний хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй байвал шүүх түүнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулна. Тухайлбал компанид ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн дарга татгалзсантай холбоотой тухайн хуулийн этгээд ЗХШ-д хандан “даалгах” нэхэмжлэл гаргажээ. Гэтэл тухайн газарт амьдран сууж байгаа малчин иргэд ийм зөвшөөрлийг уг газар олгохыг даалгах шийдвэр шүүхээс гаргах нь бид нарын эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлнө гэж үзэн тухайн

²³ Эрдэнэцогт А, “Монгол улсын Захиргааны процессын эрх зүй” Улаанбаатар, (2014) 184 дэх тал.

ЗХШ-д хандвал, шүүх энэ тохиолдолд уг иргэдийг гуравдагч этгээдээр оролцуулах эсэхийг “цэгнэн” үзэх шаардлага гарч байна.

Энэ тохиолдолд шаардлагатай бол зохих хэлэлцүүлэг хийх, талууд болон гуравдагч этгээдээр оролцох шаардлага гаргасан этгээдийн тайлбарыг сонсох, нотлох баримтыг үнэлсний үндсэн дээр гуравдагч этгээдээр татан оролцуулах эсэхийг нягт, нямбай шалгаж шийдвэрлэх шаардлагатай. Хэрэв гуравдагч этгээдийг татан оролцуулалгүй шийдвэрлэсэн тохиолдолд тухайн татагдан оролцох байсан этгээдийн эрх, ашиг сонирхол хожим зөрчигдсөн болох нь илэрхий байвал зөрчигдсөн этгээд тухайн маргааныг шийдвэрлэсэн шүүхэд шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянуулах хүсэлт гаргах боломжтой.²⁴ Энэхүү боломжийг шинэчлэн найруулсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулсан нь оновчтой бөгөөд шинэлэг зохицуулалт болсон юм.

Бусад этгээдээс хүсэлт гаргаагүй боловч нэхэмжлэлийн шаардлагад тодорхойлсон үйл ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь эерэг юм уу сөрөг байдлаар хөндөгдөж болзошгүй тохиолдолд тухайн этгээдийг шүүх гуравдагч этгээдээр татан оролцуулах үүрэгтэй. Хэрэв тухайн маргааны үйл баримттай гуравдагч этгээд хамааралгүй болох нь тогтоогдвол түүнийг оролцуулах шаардлагагүй.

Шүүх нэхэмжлэлийг хүлээн авсан даруйд нэхэмжлэлийн шаардлагын агуулга, үндэслэл, түүнд хавсарган ирүүлсэн баримтаас тухайн нэхэмжлэлд үндэслэн хариуцагчийн гаргасан захиргааны актыг шийдвэрлэхэд аль нэг “гуравдагч” этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй, эсхүл уг маргааныг бүрэн цогцоор нь эцэслэн шийдвэрлэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөр хэн нэгэн этгээдийн оролцоог зайлшгүй хангах шаардлагатай нь тодорхой байвал хэргийн оролцогчдын болон өөрийн нь хүсэлтээр, эсхүл тэдгээрийг хүсэлт гаргахыг хүлээлгүйгээр²⁵ шүүх өөрийн санаачилгаар уг этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдээр татан оролцуулах нь иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нийтийн захиргааны хууль бус шийдвэр, үйл ажиллагаанаас “хамгаалах” үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх юм. Дээрх нөхцөл байдалд гуравдагч этгээдийг татан оролцуулах нь илтэд тодорхой байхад түүнийг татан оролцуулах ажиллагааг удаашруулсан тохиолдолд хэргийг хуульд заасан хугацаанд

²⁴ ЗХШШТХ-ийн 131.1-д “Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр /анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоол/-ийг дараахь үндэслэлээр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж болно”. Мөн хуулийн 131.1.4-т “гуравдагч этгээдийг татан оролцуулалгүйгээр шүүхээс хэргийг хянан шийдвэрлэсэн нь шүүхийн шийдвэрт ноцтойгоор нөлөөлсөн”.

²⁵ “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2012.03.22-ны өдрийн “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хэргийн оролцогчдын эрх зүйн байдал” 02 дугаар зөвлөмж, 18 дахь тал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, Ханнс-Зайдлын сан. 2012 он, Зөвлөмж, Шүүн таслах ажиллагааны тайлан, бусад. Эмхэтгэл /анхны хэвлэл/

шийдвэрлэлгүй удаашрах, шүүх хурал удаа дараа хойшлогдох, цаашлаад талуудын тэгш мэтгэлцэх, тайлбар, нотлох баримт гаргах эрх зөрчигдөнө.

Гуравдагч этгээдийг татан оролцуулах эсэхийг ийнхүү сайтар шалгасны үндсэн дээр шийдвэрлэх бөгөөд түүнийг татан оролцуулахад олон шалгууртай байна.²⁶ Ялангуяа хүчингүй болгуулах болон даалгах шаардлага бүхий нэхэмжлэлүүд нь хоёр тийшээ үйлчлэлтэй захиргааны актад холбогдож байх тул уг актын улмаас гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж болзошгүй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.5.Нэхэмжлэлийн шаардлагад тодорхойлсон захиргааны акт, захиргааны гэрээний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь **хөндөгдөж байгаа этгээдийг** гуравдагч этгээд гэнэ.” гэж тодорхойлжээ. Гэвч хуульд гуравдагч этгээдийг ийнхүү тодорхойлохдоо хөндөгдөж байгаа этгээд гэж шууд тодорхойлох нь оновчгүй юм. Гуравдагч этгээдийг шүүхээс ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй гэсэн үндэслэлээр татдаг бөгөөд хэрэг эцэслэн шийдвэрлэгдээгүй үед гуравдагч этгээдийг ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээд гэж шууд тодорхойлох нь учир дутагдалтай бөгөөд нэхэмжлэгчийн эрх зүйн байдлыг үгүйсгэх хэлбэр болно.

Өөрөөр хэлбэл “..хөндөгдөж байгаа этгээд..” гэж тодорхойлсноор түүнд өнгөрсөн цаг хугацааны шалгуурыг тогтоожээ. Гэтэл захиргааны акт гарсны улмаас цаашид эрх, ашиг сонирхол нь зөрчигдөж болох тохиолдол олон байдаг. Иймд гуравдагч этгээдийг тодорхойлохдоо эрх, хууль ёсны ашиг сонирхол нь “..зөрчигдөж болзошгүй этгээд..”²⁷ гэж тодорхойлох нь ач холбогдолтой болов уу. Хэдийгээр гуравдагч этгээдийг шүүхээс эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж болзошгүй хэмээн татан оролцуулсан ч түүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн байх албагүй ч зөрчигдөж болзошгүй байдал нь тэдгээрийг гуравдагч этгээдийн хувиар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах үндэслэл болно.

Гуравдагч этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах нь нэг талаас маргааныг нэг мөр шийдвэрлэх зэрэг ач холбогдолтой боловч түүнийг татан оролцуулах ажиллагаа шүүх дээр удааширсан /хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 105 хоногийн хугацаа дуусаж урьдчилсан хэлэлцүүлгийн үед гуравдагч этгээдийг оролцуулсан/ тохиолдолд хэдийгээр шүүхэд гомдол гаргах Үндсэн хуульд заасан иргэн, хуулийн этгээдийн эрхийг хангаж байгаа боловч зарим тохиолдолд олон сөрөг үр дагавар практикт гарч

²⁶ Хууль зүйн ухааны доктор, өмгөөлөгч Штефан М.Штрасмайр. “Монгол улын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” шүүгчид зориулсан гарын авлага. Ханнс Зайделийн сан. Эрх зүйн боловсол академи.

²⁷ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны төлөвшил” УБ 2008 оны Хууль зүйн үндэсний төв, Дэлхийн банк “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн судалгааны тайланд /28 дахь талд/ “..гуравдагч этгээдийг тодорхойлохдоо эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн болон зөрчигдөж болзошгүй гэж ирээдүй цагийн шалгуурыг нэмж оруулах гэсэн саналыг тавьсан байна.

байна. Тухайлбал маргаан удааширснаар нэхэмжлэгчийн, эсхүл гуравдагч этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдөх, чирэгдэл учрах, зарим тохиолдолд нийтийн ашиг сонирхол, бүтээн байгуулалт зогсох гэх мэт сөрөг үр дагавар гарч болзошгүй.

Жишээлбэл: хатуу хучилттай авто зам барих төслийн концессд Г компани шалгарахад, М компани концесс шалгаруулалт шударга бус явагдсан гэж үзэн шүүхэд маргаан үүсгэсэн. Нэгэнт шүүхэд маргаан үүссэн тул тухайн концессын үнэлгээний хорооны шийдвэрийг шүүхээс эцэслэн шийдвэрлэгдэх хүртэлх хугацаагаар түдгэлзүүлсэн. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа удааширсан тохиолдолд тухайн концессын төсвийг улс буцаан татсанаар тухайн бүтээн байгуулалт зогсох,²⁸ хойшлогдох аюултай. Шалгарсан этгээд буюу Г компанийг хэрэв гуравдагч этгээдээр татан оролцуулаагүй тохиолдолд концессын зүйл биелэгдэх боломжтой тул гомдол гаргагч тал болох нэхэмжлэгчийн шүүхэд гомдол гаргах эрх, шалгарсан этгээдийг гуравдагч этгээдээр татаагүй тохиолдолд процессын зөрчил болох, талуудын шүүхэд тэгш мэтгэлцэх эрх тус тус зөрчигдөнө.

Гуравдагч этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах нь хэргийг түргэн шуурхай, нэг асуудлын талаар хоорондоо зөрчилдсөн шүүхийн шийдвэрүүд гаргахаас сэргийлэх, хэргийн шийдвэрлэлтэд ашиг сонирхол бүхий талуудын эрх ашгийг үр нөлөөтэй хангах явдал байдаг.²⁹ Ялангуяа бие даасан шаардлага гаргасан этгээдийн шаардлагыг тухайн хэрэгт хамтатган шийдвэрлэх нь бодит үнэнийг тогтоох, шүүхийн шийдвэрийн биелэлтийг түргэн шуурхай хангах боломжийг бүрдүүлэх зэрэг ач холбогдолтой.

Гэвч захиргааны процессын хуульд нэхэмжлэгч, хариуцагчийг тодорхойлсон боловч бие даасан шаардлага гаргасан болон гаргаагүй гуравдагч этгээдийг нарийвчлан тодорхойлоогүйгээс ойлголтын зөрүү үүсэж болзошгүй. Хэрэв тухайн маргаантай хамааралгүй, татан оролцуулах шаардлагагүй этгээдийг гуравдагч этгээдээр оролцуулсан тохиолдолд нэхэмжлэгч, хариуцагч уг шийдвэрт гомдол гаргах боломж байхгүй юм.³⁰ Хэдийгээр гуравдагч этгээдийг татах эсэх нь шүүхийн эрх хэмжээ боловч зарим маргаанд гуравдагч этгээдээр татах шаардлагагүй тохиолдол байна.

Жишээлбэл: Иргэн Г-д дүүргийн Засаг даргын 88 дугаар захирамжаар газар эзэмшүүлэх шийдвэр гаргасан. Г нь иргэд Д-д газраа түрээслүүлдэг. Гэтэл иргэн А нь Г-д газар олгосон Засаг даргын 88 дугаар захирамж нь миний газар эзэмших эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэн 88 дугаар

²⁸ <http://www.shuukh.mn/zahirgaahyanalt/133/view>

²⁹ Хуяг Д, "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээд оролцох нь" Хууль дээдлэх ёс сэтгүүл, цуврал 41, дугаар 1, Улаанбаатар, (2013), 49 дэх тал.

³⁰ ЗХШШТХ-ийн 122.1.



захирамжийг хүчингүй болгуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг гаргажээ. Гэтэл Г-ийн газар дээр түрээслэн амьдарч байгаа Д нь миний амьдарч байгаа газрыг хүчингүй болгуулах шаардлага бүхий нэхэмжлэлтэй хэрэгт гуравдагч этгээдээр оролцох хүсэлтийг гаргажээ. Энэ тохиолдолд газрын хууль ёсны эзэмшигч Г-ийн газар эзэмших эрх зөрчигдөж болзошгүй болохоос түрээслэгч Д-г гуравдагч этгээдээр татах шаардлагагүй юм.

- Шаардлагагүй этгээдийг гуравдагч этгээдээр татсанаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширч гурван шатны шүүхээр маргаан цааш үргэлжилсэн тохиолдолд нэхэмжлэгч хохирох тохиолдол байдаг.

Тухайлбал А компани үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл үнэн зөв бүртгэгдэх зарчим зөрчигдөж, буруу ташаа бүртгэгдсэн гэсэн нэхэмжлэлийн шаардлага бүхий маргаан дээр иргэн Т-ийн нэр дээр бүртгэгдсэн хэд хэдэн орон сууцны гэрчилгээг хүчингүй болгуулах шаардлага бүхий маргаанд мэдээж хариуцагчаар Улсын бүртгэлийн газар татагдаж гуравдагч этгээдээр Т татагдах нь тодорхой. Гэтэл гуравдагч этгээдээр татагдсан Т нь тухайн үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг бусдад барьцаанд тавьсан байлаа гэж үзвэл барьцаалагчийг шүүхээс гуравдагч этгээдээр мөн татжээ.³¹

Дээрх тохиолдолд шүүх үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ бүртгэгдсэн этгээдийг гуравдагч этгээдээр татах шаардлагатай бөгөөд харин үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг цааш нь бусдад барьцаанд тавьсан тохиолдолд барьцаалагчийг гуравдагч этгээдээр татах шаардлагагүй юм. Хэлэлцэгдэж буй маргааны зүйл нь улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгуулах тул энэ маргаанд хэдийгээр тухайн маргаантай холбоотой /хамааралтай/ мэт боловч тухайн шаардлага, үндэслэлээс өөр асуудлыг тусгасан шаардлага гаргаж буй этгээдийг гуравдагч этгээдээр оролцуулахгүй.

Тухайлбал гуравдагч этгээд Т болон барьцаалагч банк бус санхүүгийн байгууллага хоёрын маргаан нь иргэний шүүхээр шийдвэрлэгдэх барьцаа болон зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой харилцаа үүссэн тул ердийн харьяаллын шүүхээр энэхүү маргааныг шийдвэрлүүлж хохирлоо шаардах боломжтой юм.

- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар нэхэмжлэгч болон хариуцагч нар эвлэрэн хэлэлцэх боломжтой бол гуравдагч этгээдийн хувьд нэхэмжлэгч, хариуцагчтай эвлэрэх боломжгүй. Практикт гуравдагч этгээд нэхэмжлэгчтэй эвлэрэх /тохирох/ замаар нэхэмжлэгч нэхэмжлэлээ татаж, маргаан дуусгавар болсон тохиолдол гарч байсан. Ер нь шүүхээс гуравдагч этгээдийг татсанаар нэхэмжлэгч захиргаатай маргах бус эцэстээ гуравдагч этгээд нэхэмжлэгч хоёрын маргаан болж хувирах, хариуцагч

³¹ Энэхүү маргаан нь эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа тул маргааны эх сурвалжийг нууцлав.

захиргааны байгууллага идэвхгүй байр сууринаас оролцох зэрэг байдал ажиглагддаг.

Жишээлбэл: А компанид Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газраас барилгын ажлыг эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгосон. Гэтэл тухайн барилга баригдах газартай хөрш зэргэлдээ оршин суугчид А компаний барилга баригдсанаар оршин суугчдын байрны нар салхи хаасан, байрыг үнэгүйдүүлсэн, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдсөн гэж үзэж шүүхэд гомдол гаргасан. Шүүхээс гуравдагч этгээдээр А компанийг татсан. Учир нь уг тусгай зөвшөөрлийг шүүх хүчингүй болгосон тохиолдолд А компаний эрх, ашиг сонирхол зөрчигдөнө. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгч иргэдийн хүсэлтээр маргаан бүхий тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн. Ийнхүү гурван шатны шүүхээр маргааныг хянан шийдвэрлэх хугацаанд хэдийгээр А компани анхан шатны шүүхэд ялалт байгуулсан, тухайн барилга нь барилгын норм, дүрэм, журамд нийцсэн ч барилгын ажил шүүхэд маргаан үүсэх үед зогсох нь гуравдагч этгээдэд илүү хохиролтой тул нэхэмжлэл гаргасан оршин суугч иргэдтэй арга буюу тохирч зохих нөхөн олговор олгосон. Хэдийгээр нэхэмжлэгч, хариуцагч эвлэрэх боломжтой боловч энэ тохиолдолд нэхэмжлэгч иргэд болон гуравдагч этгээдээр татагдсан барилгын компани хоёр хоорондоо /нэхэмжлэл гаргаж маргасан айл бүрт 5 сая төгрөг өгсөн/ тохиролцож нэхэмжлэгч иргэд нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсанаар тухайн хэрэг дуусгавар болсон.³²

Иргэд маргах, шүүхэд гомдлоо гаргах эрхтэй боловч дээрх тохиолдолд нэхэмжлэгч шүүхэд нэхэмжлэл гаргаж, маргаан бүхий тусгай зөвшөөрлийн үйлчлэлийг түдгэлзүүлж барилгын ажлыг зогсоосноор гуравдагч этгээд болох барилгын компанид шахалт үзүүлэх, дундаас нь ашиг хүртэхийг зорилгоо болгосон нь шударга ёсонд нийцэхгүй юм. Захиргааны шүүхэд ийм төрлийн маргаан цөөнгүй гардаг бөгөөд бодит байдалд нэхэмжлэгч, гуравдагч этгээд нар ийнхүү тохиролцож маргааныг дуусгавар болгосон тохиолдлууд байдаг. Дээрх тохиолдолд маргааныг түргэн шуурхай хянан шийдвэрлэх нь хамгийн зөв шийдэл юм.

2016 онд шинээр батлагдсан Захиргааны ерөнхий хууль болон шинэчлэн найруулсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар анх удаа нийтийн ашиг сонирхлыг төлөөлж нэхэмжлэл гаргасан маргааныг Захиргааны хэргийн шүүх хүлээн авч хянан шийдвэрлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн бөгөөд нийтийн ашиг сонирхлыг төлөөлж гаргасан нэхэмжлэлтэй дийлэнх хэрэгт гуравдагч этгээд зайлшгүй татагдан оролцож байгаа бөгөөд ЗХШХШтХ-иар нийтийн ашиг сонирхлыг төлөөлж гаргасан нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзахыг хориглосон нь³³

³² Шүүхийн цахим сан. <http://www.shuukh.mn/zahirgaanhan/1535/view>.

³³ ЗХШХШтХ-ийн 20.3.Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан этгээд нь хэрэг үүсгэнээс хойш нэхэмжлэлээсээ бүрэн болон хэсэгчлэн татгалзахыг хориглоно.



дээрх жишээнд дурдсан элдэв хууль бус, хэсэг бүлэг хүний явцуу эрх ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх боломжийг хааснаараа нэн чухал ач холбогдолтой зохицуулалт болсон юм.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдийн эрх зүйн байдал нь анхаарал татсан сонирхолтой сэдэв бөгөөд түүнийг зөв тодорхойлж цааш судлах нь чухал ач холбогдолтой байна. Гуравдагч этгээдийн эрх зүйн байдлыг 2016 оны процессын хуулиар зохих онцлог бүхий зохицуулалт бий болгосон нь сайшаалтай боловч зарим зохицуулалт үгүйлэгдэж байна.

- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар нэхэмжлэгч, хариуцагчийн эрх зүйн байдлыг тодорхой зохицуулсан бол гуравдагч этгээд, түүний бие даасан шаардлага болон бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийн эрх зүйн байдлыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна. Иймд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь гуравдагч этгээд нь “...нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд, тухайн хариуцагчид холбогдуулан гаргасан, анхан шатны шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэхээс өмнө, шүүх өөрийн санаачилгаар эсхүл хэргийн оролцогч, тухайн бие даасан шаардлага гаргасан этгээдийн хүсэлтээр, маргаан бүхий захиргааны акт, гэрээний улмаас, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж болзошгүй этгээд..” гэсэн нийтлэг шинжийг өөртөө агуулсан этгээдийг гуравдагч этгээд..” гэж ойлгож болохоор байна.

Харин бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн нэрийн өмнөөс, өөрийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой оролцох бөгөөд түүний шаардлага нь нэхэмжлэгч, хариуцагчийн аль нэг шаардлагыг дэмжээгүй, бие даасан шинжтэй байдаг бол бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийн хувьд хэргийн оролцогчийн хүсэлтээр, эсхүл шүүх өөрийн санаачилгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах бөгөөд тэрээр ихэвчлэн хариуцагчийн байр суурь, ашиг сонирхолтой нэгдмэл байна;

- Иргэний процессын хуулиар гагцхүү хэргийн оролцогчийн хүсэлтээр гуравдагч этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулдаг бол захиргааны процессын хуулиар хэргийн оролцогчоос гадна шүүх өөрийн санаачилгаар гуравдагч этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулж, түүнийг өөрийн эрх, ашиг сонирхлоо хамгаалах боломжийг олгосноороо илүү дэвшилттэй зохицуулалт болсон байна.

- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгчийн сонгосон нэхэмжлэлийн төрлөөс хамаарч уг маргааныг шүүх эцэслэн шийдвэрлэхэд гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй тохиолдолд зохих хэлэлцүүлгийн үндсэн дээр талуудын тайлбар, нотлох баримтын хүрээнд тал бүрээс нь сайтар шалгасны эцэст гуравдагч этгээдийг оролцуулах эсэх асуудлыг шийдвэрлэх нь чухал ач холбогдолтой байна. Учир нь гуравдагч этгээдийг татсан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид хэргийн оролцогч гомдол гаргах эрхгүй бөгөөд гуравдагч этгээдээр татах шаардлагагүй этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулснаар, эсхүл зайлшгүй татан оролцуулах шаардлагатай этгээдийг оролцуулаагүй хэргийг шийдвэрлэсэн тохиолдолд эцэстээ хэргийн оролцогчийн эрх, ашиг сонирхол зөрчигдөнө;
- Гуравдагч этгээдээр татагдсан хэрэг маргааны хувьд хугацаан дээр онцгой ач холбогдол өгч, хэргийг шуурхай хянан шийдвэрлэх нь хэргийн оролцогчдын эрхийг хамгаалах болно. Гуравдагч этгээдийг хожим бус, анх нэхэмжлэгч шүүхэд нэхэмжлэл гаргасан үеэс гуравдагч этгээдийг татан оролцуулах эсэхийг судалж нэн даруй шийдвэрлэх, ингэснээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд талуудад анхнаасаа тэгш мэтгэлцэх боломж хангагдах болно.

Эцэст нь дүгнэхэд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах шаардлагатай гуравдагч этгээдийг татан оролцуулах нь шүүхэд гомдол гаргах, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, өөрөө өөрийгөө өмгөөлөх, шударга шүүхээр шүүлгэх, мэтгэлцэх зэрэг Үндсэн хуулиар баталгаажсан иргэний эрхийг хамгаалсан нэн чухал ач холбогдолтой бөгөөд түүнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулснаар хэргийг нэг мөр, тал бүрээс нь бүхэл нь хянах, улмаар шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх зарчим хангагдах юм.



ШҮҮХИЙГ ТОЙРГИЙН ЗАРЧМААР БАЙГУУЛАХАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ (АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ЖИШЭЭ ДЭЭР)

Г.Цэрэндэжид

Архангай аймаг дахь Захиргааны хэргийн
анхан шатны шүүхийн шүүгчийн туслах

Удиртгал

Монгол Улсын Үндсэн хууль бол шударга ёс, эрх чөлөө, тэгш байдлын төлөө хууль мөн.¹ 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн Дөчин наймдугаар зүйлийн 1-д “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд *шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно*. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэж заасан.

Ийнхүү Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд орсон заалтын хэрэгжилтийг хангах үүднээс холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэн өөрчлөх хэрэгцээ шаардлага үүссэн билээ. Улмаар 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. дэх хэсэгт “Анхан болон давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг тойргийн зарчмаар байгуулахад энэ хуулийн 14.3-т заасныг харгалзахаас гадна шүүхэд хандах иргэний эрхийн баталгааг хангах, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн байна.”, 14 дүгээр зүйлийн 14.3. дахь хэсэгт “Шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтооход түүний харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрөл, тоог харгалзан үзнэ.”, 29 дүгээр зүйлийн 29.1. дэх хэсэгт “Давж заалдах шатны шүүх нь аймаг, нийслэлийн болон захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс бүрдэнэ.”, 29.2. дахь хэсэгт “Давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно.”, 30 дугаар зүйлийн 30.1. дэх хэсэгт “Сум буюу сум дундын, дүүргийн шүүх болон аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх нь өөрийн харьяалах нутаг дэвсгэрт анхан шатны шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлнэ.”, 30.2. дахь хэсэгт “Анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно.” гэх зохицуулалтыг тусгаад байна.

¹ Чимид Б. “Үндсэн хуулийн мэдлэг” Уб., 2008 он, 36 дахь тал

Судлаачийн зүгээс шүүхийн тойргийн зарчмаар байгуулах зохицуулалт нь манай улсын засаг захиргааны нэгж, төрийн үйлчилгээний одоогийн тогтолцоотой уялдах эсэх, иргэд шүүхээр үйлчлүүлэхэд хүндрэл, бэрхшээл үүсгэх эсэх, шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад сөргөөр нөлөөлөх эсэх, энэ нь хэтдээ шүүх эрх мэдэл хүний эрхийг сахин хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэх болон иргэд төрийн үйлчилгээ авах, эрхээр хамгаалуулах нөхцөлийг баталгаатай хангах эсэх асуудлыг хөндөхөөр энэхүү сэдвийг судалсан билээ.

Хэдийгээр судалгаа хийж буй одоогийн цаг хугацаанд шүүхийг тойргийн зарчмаар байгуулаагүй байгаа авч хуулийн энэ зохицуулалтын хүрээнд шүүхийг тойргийн зарчмаар байгуулах боломжийг нээсэн бөгөөд уг судалгаанд дурдсан зарим асуудлыг анхаарах нь шүүх эрх мэдлийн шинэ сорилын үед чухал ач холбогдолтой сэдэв гэж үзлээ. Уг сэдвийн хүрээнд нэг сэдэвт ном, судалгааны материал ховор боловч хуулийн төсөлд хүргүүлсэн олон нийтийн санал, эрдэмтэн судлаачдын судалгаа, төрийн бус байгууллагын санал, дүгнэлтэд тодорхой хэмжээнд тусгагджээ. Мөн судалгааны ажлын явцад олон төрлийн санал, дүгнэлт бүхий материалаас түүвэрчлэх аргаар мэдээлэл цуглуулсан болно.

Монгол Улсын Шүүхийн тогтолцоо, шүүхийг тойргийн зарчмаар байгуулах тухай

1992 оны шинэ Үндсэн хуулиар шүүх эрх мэдлийг төрийн эрх мэдлийн бие даасан салаа болгон төлөвшүүлэх эх үндэс тавигдсан байдаг. Монгол Улсын шүүх нь хэрэг маргааныг хянан шийдвэрлэх эрх хэмжээний хувьд: а/ анхан шатны; б/ давж заалдах шатны; в/ хяналтын шатны гэсэн гурван шаттай тогтолцооноос бүрдэж² байна. Мөн дээрх тогтолцооны зэрэгцээ дагнасан шүүхийн тогтолцоо байхыг хүлээн зөвшөөрч, харин ямар нэгэн тусгай шүүх байгуулахыг хоригложээ.

Улс орнуудад “ерөнхий шүүх”, “тусгай шүүх” гэсэн ойлголт байдаг. Энэ жишгийг харгалзахын хамт төрийн эрх мэдлийн “хууль тогтоох”, “гүйцэтгэх” хоёр салаа шүүхийн тэнцвэрт байдлыг хангахын тулд Монгол Улсын шүүхийн тогтолцоог “үндсэн”, “дагнасан” гэсэн хоёр дэд хэсгээс бүрдэхээр тодорхойлж, уялдаа холбоог нь тогтоосон³ байна.

Шүүхийг тойргийн зарчмаар байгуулсан туршлага, 2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, 2021 оны Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдахаас өмнө шүүхийн тогтолцоо нь “үндсэн” ба “дагнасан” шүүхийн тогтолцооноос бүрдэх бөгөөд шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын Дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх,

² Совд Г, нар “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар” Уб, 2000, 210 дахь тал

³ Чимид Б. “Үндсэн хуулийн үзэл баримтлал” Уб, 2017 он, 123 дахь тал



сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс, дагнасан шүүхийн тогтолцоонд Захиргааны хэргийн шүүх хамаарахаар тусгасан байжээ.

2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан Шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1. дэх хэсэгт “Шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх /хяналтын шатны шүүх/, аймаг, нийслэлийн шүүх /давж заалдах шатны шүүх/, сум буюу сум дундын, дүүргийн шүүх /анхан шатны шүүх/-ээс бүрдэнэ.”, 10.2. дахь хэсэгт “Улсын дээд шүүхээс бусад шүүхийг нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны тоог харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжийг харьяалуулан эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулна.” гэж заасан.

Уг өөрчлөлтийн дагуу 2013 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн Шүүх байгуулах тухай хуулиар улсын хэмжээнд нутаг дэвсгэрийн ойр дөт байдал, шүүхийн ачааллыг харгалзан тус бүр 2-3 аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг харьяалсан дагнаж байгуулсан давж заалдах шатны 21, сум дундын 29, захиргааны хэргийн анхан шатны 20, дүүргийн эрүү, иргэний 8, нийт 78 шүүх шинээр зохион байгуулагдсан байдаг.

Гэвч хуулийн дээрх заалтыг Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн асуудлаар нэр бүхий иргэдээс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргаж, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор⁴ Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Нэг. Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Хоёр. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх; мөн хуулийн 2 дугаар зүйлийн Нэг. Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Хоёр. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, түүнчлэн Гурав. Захиргааны хэргийн анхан шатны шүүх гэсний 6, 11 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүхийн үндсэн тогтолцоо ... аймаг, нийслэлийн шүүх, ... дүүргийн шүүхээс бүрдэх ...” гэсэн заалтыг зөрчсөн болохыг тогтоож, хүчингүй болгосон билээ.

Дээрх хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар Ж.Бариаширсүрэн нарын Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь сэдэвт хэлэлцүүлэгт танилцуулсан “Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилт” судалгаанд⁵ “ ... Шүүхийн тойргийн журмаар байгуулсан нь хэдийгээр тойргийн шүүхүүд орон зайн хувьд иргэдэд ойртсон мэт боловч нийтийн тээвэр, зам харилцаа, дэд бүтэц сайн хөгжөөгүй зэргээс шалтгаалан иргэдэд эдийн засгийн зардал ихсэж шүүх иргэдээс улам холджээ ...” гэх дүгнэлт хийсэн байна.

⁴ <https://legalinfo.mn/mn/detail/10860> , сүүлд үзсэн 2021.12.01

⁵ Бариаширсүрэн Ж. нар, “Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилт” Уб., 2015, 25 дахь тал

Монгол Улсын Үндсэн хуулийн шинэчилсэн найруулга, 2000 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт, нийгмийн хөгжлөөс үүдэн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага тулгамдсаар ирсэн. Улмаар 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуулийн 19 зүйл, 30 гаруй хэсэгт өөрчлөлт оруулахыг дэмжиж баталсан билээ.⁶

Дээрх нэмэлт өөрчлөлтөөр шүүхийг тойргийн зарчмаар байгуулах асуудлаар Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1.-д “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэх заалтыг “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд **шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно.** Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэх заалтыг нэмж оруулан, өөрчлөн найруулсан байдаг.

Улмаар 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. дэх хэсэгт **“Анхан болон давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно.** Шүүхийг тойргийн зарчмаар байгуулахад энэ хуулийн 14.3-т заасныг харгалзахаас гадна шүүхэд хандах иргэний эрхийн баталгааг хангах, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн байна.”

14.3. дахь хэсэгт **“Шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтооход түүний харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрөл, тоог харгалзан үзнэ.”**, 29 дүгээр зүйлийн 29.1. дэх хэсэгт “Давж заалдах шатны шүүх нь аймаг, нийслэлийн болон захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс бүрдэнэ.”

29.2. дахь хэсэгт “Давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно.”

30 дугаар зүйлийн 30.1. дэх хэсэгт “Сум буюу сум дундын, дүүргийн шүүх болон аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх нь өөрийн харьяалах нутаг дэвсгэрт анхан шатны шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлнэ.”

30.2. дахь хэсэгт **“Анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно.”** гэх зохицуулалтыг тусгажээ.

Шүүхийг тойргийн зарчмаар байгуулах заалттай холбоотой санал асуулга, хэлэлцүүлгийн үед дараах санал, тайлбар гарч байв. Үүнд:

⁶ <https://ikon.mn/n/1qis>, сүүлд үзсэн 2021.12.01



2021.01.07-ны өдрийн УИХ-ын нэгдсэн хуралдаанд УИХ-н гишүүн Д.Тогтохсүрэн “ ... шүүх бол иргэдтэйгээ ойрхон л байвал зөв шийдвэр гаргадаг. Тойргийн журмаар их олон болоод ирэх тусмаа шүүхийн шийдвэрт янз бүрийн алдаа болох асуудал харагдаад байгаа юм. Анхан шатны шүүхийн хувьд орон нутаг дээр бол Захиргааны шүүхийг тухайлбал тойргийн журмаар байгуулж болно гэж боддог. Иргэн болон Эрүүгийн шүүхийг тойргийн журмаар байгуулахаар иргэд өөрөө чирэгдчихдэг юм⁷ ...” гэж;

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх үнэлгээнд⁸ “ ... хууль тогтоогчид ... иргэдэд үүсэх эдийн засгийн дарамт, шүүхийн үйлчилгээний хүртээмж, хууль сахиулах байгууллагуудын ажлын ачааллыг харгалзан үзэж, эдгээр байгууллагын үйл ажиллагаа, чиг үүргийг уялдуулах замаар шүүхийн тогтолцоог өөрчлөх шаардлагатай байсан нь харагдаж байна.” гэж дүгнэжээ.

Харин дээрх асуудлаар хууль зүйн ухааны доктор Ч.Өнөрбаяр “ ... Шүүхийн тогтолцоог тойргийн журмаар байгуулж болохоор төсөлд тусгаад батлагдсан ... зарим сум дундын шүүхүүд, зарим аймгийн захиргааны хэргийн шүүхүүд жилдээ арав хүрэхгүй маргаан шийддэг байсан. **Тойргийн тогтолцоог нэвтрүүлснээр шүүхийн зардал багасна**, өөр олон ахиц дэвшил гарна гэж бодож байна⁹ ...” гэж;

Хууль зүйн ухааны доктор Т.Мэндсайхан, Б.Өлзийсайхан нарын “Шүүх эрх мэдлийн үндсэн хуулийн шинэчлэл” сэдэвт илтгэлд: “ ... шүүхийг тойргийн журмаар байгуулахыг зөвшөөрсөн нь шүүн таслах ажил, шүүхийн захиргааны харьцангуй тусдаа, бие даасан, мэргэшсэн байдлыг улам хөгжүүлэх шаардлагыг бий болгоно¹⁰ ...” гэж;

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн /буцаан татсан/ Шүүхийн тухай хуулийн төслийн танилцуулгад “... **шүүхийн тогтолцоонд “тойргийн” зарчмыг нэвтрүүлэх**, шүүхийг хэрэг маргааны төрлөөр дагнан байгуулах нь **шүүхийн харилцан адилгүй ачааллыг бууруулах**, шүүх, шүүгчийг мэргэшүүлэх, мэргэшсэн шүүгчээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой¹¹ ...” гэж;

Монгол Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаярын “Хүний эрхийн үндэсний форум-2021”-д тавьсан илтгэлдээ: “ ... **шүүхийг тойргийн** болон дагналтын зарчмуудын зохистой тэнцвэрээр байгуулах нь **иргэдэд шүүхийн үйлчилгээ хүртээмжтэй, чанартай хүрэх**,

⁷ <https://vip76.mn/content/73065>, сүүлд үзсэн 2021.12.01

⁸ <https://nli.gov.mn/pdf/shth-sudalгаа.pdf>, сүүлд үзсэн 2021.12.01

⁹ <https://dnn.mn/>, сүүлд үзсэн 2021.12.01

¹⁰ ХЗҮХ “Үндсэн хуулийн эхийг баригч-Б.Чимид” ОУ-ын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл УБ, 2020 он 163 дахь тал

¹¹ <https://president.mn>, сүүлд үзсэн 2021.12.01

хүний нөөцөө зөв удирдах үндсэн нөхцөлүүдийн нэг мөн¹² ...” гэж үзсэн байна.

Нээлттэй нийгэм форумаас Шүүхийн тогтолцоо /тойргийн болон дагнасан шүүх/ судалгааг 2021 онд хийжээ. Уг судалгаанд¹³ “ ... **Шүүхийг тойргийн зарчмаар байгуулах нь шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх ач холбогдолтой ба үүний үр дүнд шүүхийн төсөв болон хүний нөөцийг зөв зохистой хуваарилах үндэс суурь бүрдэх**, шүүхийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэх, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрх хангагдах зэрэг олон талын ач холбогдолтой ... ” гэж тайлбарлажээ.

Судлаачид болон судалгааны байгууллагын хийсэн судалгаанаас үзэхэд шүүхийг тойргийн зарчмаар байгуулах асуудлыг дэмжсэн байна. Тэдгээрийн үзэж буйгаар шүүхийг тойргийн зарчмаар байгуулах нь нэгдүгээрт, шүүхийн ачааллыг тэнцвэржүүлэх, хоёрдугаарт, шүүхийн зардлыг багасгах, хүний нөөцийн менежмент сайжрах зэрэг эерэг үр дагавартай гэж тайлбарлажээ.

Энд товч тэмдэглэхэд, Монгол Улсын нэгдсэн төсвөөс УДШ-ээс бусад шүүхүүд, шүүхийн ерөнхий зөвлөлд нийтэд нь 2018 онд 48,604.8 сая төгрөг, 2019 онд 51,072.7 сая төгрөг, 2020 онд 56,310.3 сая төгрөг, 2021 онд 61,161.3 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.¹⁴ Энэ нь дунджаар улсын төсвийн 1 хувьд ч хүрэх үзүүлэлт юм. Гэтэл дэлхийн улс орнуудад шүүх эрх мэдэлд дунджаар нийт төсвийн 2.2 хувьтай тэнцэх хэмжээний төсвийг хуваарилдаг байна.¹⁵ Мөн УИХ-н 2016 оны 42 дугаар тогтоолоор улсын хэмжээнд нийт 699 шүүгчийн орон тоог баталсан байдаг.

Монгол Улсын Шүүхийн тайлангаас үзэхэд 2016 онд эрүү, иргэн, захиргааны нийт 62,216 хэргийг 520 шүүгч, 2017 онд 66.317 хэргийг 511 шүүгч, 2018 онд 73.033 хэргийг 503 шүүгч, 2019 онд 76.969 хэргийг 481 шүүгч, 2020 онд 89.635 хэргийг 518 шүүгчийн орон тоотой хянан шийдвэрлэжээ.

Үүнээс үзэхэд төрийн эрх мэдлийн бие даасан салаа болсон шүүх эрх мэдлийн байгууллагад жил бүр улсын төсвийн 1 хүрэхгүй хувийг зарцуулж байна. Энэ тохиолдолд шүүхийн зардлыг багасах үр ашгийг дурдаж шүүхийг тойргийн зарчмаар байгуулах нь хэр оновчтой вэ. Мөн шүүгчийн орон тоог УИХ-аас тогтоосон хэмжээнд хүртэл нэмээгүй байгаа энэ нөхцөлд орон нутгийн буюу хэргийн ачаалал багатай шүүхийг тойргийн хэлбэрт шилжүүлэн, нийслэл буюу ачаалал ихтэй байгаа шүүхэд шүүгчийн орон тоог шилжүүлэх боломжтой гэж үзсэн нь шүүхийн хүний нөөцийн оновчтой зохицуулалт болох эсэх нь эргэлзээтэй.

¹² <http://www.supremecourt.mn/news/705>, 2021.12.15

¹³ https://www.forum.mn/index.php?sel=project&menu_id=446&f=one&obj_id=6072, сүүлд үзсэн 2021.12.15

¹⁴ Монгол Улсын 2018, 2019, 2020, 2021 оны төсвийн тухай хууль

¹⁵ Алтансүх Ж, “Монгол Улсын Үндсэн хууль ба шүүхийн эдийн засгийн баталгаа” Хууль дээдлэх ёс сэтгүүл 2017, №2, 154 дэх тал



Түүнчлэн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.2.-т “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, **нутаг дэвсгэр**, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана.”, 1.1.3.-т “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нэгдмэл байдлыг хамгаалан бататгах нь үндэсний аюулгүй байдлыг хангах анхдагч нөхцөл мөн.”, 1.1.4.-т “Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан, **нийгмийн тогтвортой байдлыг хангасан** ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн.”, 1.1.5.-д “Монгол Улсын **төр, нийгэм, иргэний аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар** Монгол Улсын үндэсний аюулгүй байдал баталгаажна.”, 3.3.1.6.-д “Хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн байгууллагын эрх мэдлийн хяналт-тэнцлийг хангана.” гэж тодорхойлсон билээ.

Судлаачийн зүгээс шүүхийг тойргийн зарчмаар байгуулах зохицуулалтаас давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулах зохицуулалтын хувьд анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулахад дараах асуудлыг анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйлийн 2-т “Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана.”, Арван зургадугаар зүйлийн 14/-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ..., хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй ...”, Арван есдүгээр зүйлийн 1.-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Тавин долдугаар зүйлийн 1.-д “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.”, Тавин наймдугаар зүйлийн 1.-д “Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” гэж тодорхойлсон.

Улмаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн¹⁶ 3 дугаар зүйлийн 3.1.-д “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь

¹⁶ Энэхүү өгүүллийг бичих явцад Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 2006 оны хууль хүчин төгөлдөр үйлчилж байсан учир тус хуулийн зохицуулалтыг үндэслэсэн болно.

багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.”, 7 дугаар зүйлийн 7.1. дэх хэсэгт Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоо нь дараахь бүтэцтэй байна: 7.1.1.-д аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал; ... 7.1.4.-т “аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга.”, 8 дугаар зүйлийн 8.1. дэх хэсэгт “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчим баримтална.” гэж заажээ. Хуулийн дээрх зохицуулалтын агуулгаас үзвэл, Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдах бөгөөд тухайн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжиж байна.

Өөрөөр хэлбэл, төрийн эрх мэдэл хуваарилах зарчмын үндсэн дээр байгуулагдсан төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллагууд засаг захиргааны нэгж бүрт байрлаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна.

Харин шүүх эрх мэдлийн тухайд, иргэн, хуулийн этгээдэд шууд хүрч үйлчилж буй анхан шатны шүүхүүдэд аймаг, нийслэл, сум буюу сум дундын, дүүргийн шүүхүүд хамаарч, эрх мэдлийн хяналт тэнцлийг хадгалж байна. Угаас тухайн нутаг дэвсгэрт бусад төрийн байгууллагуудтай зэрэгцэн шүүх оршиж байх нь л эрх мэдлийн тэнцлийг хангахад чухал асуудал билээ.

Иймд манай орны нутаг дэвсгэрийн онцлог, түүний зохион байгуулалт, хүн амын суурьшил, төрийн үйлчилгээг хүргэж буй засаг захиргааны нэгжийн зохион байгуулалтын бүтцийг дагуулан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж буй анхан шатны шүүхийн тогтолцоо орших нь иргэдийн хувьд ойлгомжтой, төрийн үйлчилгээг хүргэхэд дөхөмтэй гэж үзэхээр байна.

Хоёрдугаарт, анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулахад өмнөх туршлагыг анхаарах, тухайн үед гарч байсан хүндрэл бэрхшээл одоо ч арилаагүй байна. Тодруулбал,

Судлаач Ж.Бариширсүрэн нарын бичсэн “Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилт” судалгаанд дурдсанаар¹⁷

Тохиолдол 1. /Иргэн/ Эрүүгийн хэргийн гэрчээр шүүх, цагдаад дуудагдаад жил орчим болж байна. Өнгөрсөн хугацаанд олон улаа дуудагдлаа, их хэцүү. Анх шүүхэд дуудагдсаныхаа дараа л Хархорины шүүхэд харьяалагдаж байгаагаар мэдсэн. Өмнө нь Зуунмодод очдог байсан нь илүү амар байсан.

¹⁷ ХЗҮХ “Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх үнэлгээний тайлан” УБ, 2018, 17-18 дах тал дам ишлэв.



Эндээс 10.000 төгрөгөөр хот хооронд унаанд суугаад хот ордог, хотоос 2000 төгрөгөөр аймаг ордог. Аймаг орох шаардлага хүн бүхэнд байгаа. Очоод ажлаа бүтээхээс гадна амьтан ах дүүтэйгээ уулзах, буцахдаа хотоос хэрэгтэй зүйлээ худалдаж авах гээд хэд хэдэн ажил амжуулаад ирдэг байсан бол одоо Өвөрхангайд хүн танихгүй, очих айлгүй болохоор гудамжинд суугаад л шүүгч, цагдаа нь хэзээ дуудахыг хүлээгээд суух нь үнэхээр хүнд байна. Хөдөөгийн бид мөнгө төгрөг муутай. Танилгүй газар чинь аяга цай хүртэл мөнгөөр авна. Хоол, буудал гэвэл бүр ч барахгүй. Хоолны зардлаас гадна замын зардал их хүндрэлтэй, бөөн ажил, нэг талдаа 20 гаруй мянга болно ..." гэж;

Тохиолдол 2. /Прокурор/ Миний хувьд хуучин тогтолцоо нь илүү давуу талтай гэж үзэж байгаа. Манай прокурорын хувьд бол Төв аймгийн 4 сум нэмээд орон тооны хувьд нэмсэн боловч зардал нэмж тусгаагүй. Гэтэл ачаалал илт нэмэгдсэн, ачааллаа дагаад зардал ч нэмэгдсэн. Иргэдийн хувьд хүндрэлтэй асуудал байгаа. Давж заалдах шатны шүүх Дарханд байрлах болсноор амьдралын боломж хэцүү иргэд бол давж заалдахгүй хаях асуудал байгаа. Энэ бол амьдралд гарцаагүй байна ..." гэж;

Тохиолдол 3 /Прокурор/ Манай ачаалал бол бараг тал хувиар нэмэгдсэн байгаа. Орон тооны хувьд нэгээр л нэмсэн. Засаг захиргааны харьяалалтай холбоотой асуудал гардаг. Тухайлбал, төв аймгийн нэг сумын цагдаа байна гэж бодоход манай аймгийнх байсан бол бид нар тухайн цагдаагийнхаа ажлын алдаа дутагдлын талаар шууд удирдлагад нь мэдэгдээд, эсхүл зөвлөлдөөд, дэмжлэг аваад явах боломжтой бол Зуунмодод байгаа удирдлагатай бол ийм байдлаар хамтарч ажиллах боломжгүй, албан бичиг явуулдаг, хугацаа алддаг" гэх тайлбарууд гаргаж байжээ.

Цаашид Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2. дахь хэсэгт "Анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно." гэж зааснаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжийг харьяалуулан анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулсан тохиолдолд иргэн, хуулийн этгээд шүүхэд хандах, шүүхээр үйлчлүүлэхэд хүндрэлтэй нөхцөл үүсгэж болзошгүй байна.

Шүүхийг тойргийн зарчмаар байгуулахтай холбоотой асуудлаар, *Нээлттэй нийгэм форум байгууллагаас хийсэн "Шүүхийн тогтолцоо, тойргийн болон дагнасан шүүх" сэдэвт судалгаанд*¹⁸ " ... 1. Баян-Өлгий, Ховд, Увс, Говь-Алтайг нэг тойрог болгох бөгөөд шүүхийн байрших газар нь Ховд аймаг. 2020 оны байдлаар дээрх дөрвөн аймгийн шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тоо нийлээд 156 байна. Тус шүүхийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй байгуулна. Ингэснээр одоо ажиллаж байгаа 6.2 шүүгчийн орон тоо, батлагдсан орон тооноос есөн шүүгчийн орон тоо хасагдана ... 3. Завхан, Архангай, Баянхонгор, Өвөрхангайг нэг тойрог болгох бөгөөд шүүхийн байрших газар

¹⁸ Нээлттэй нийгэм форум, "Шүүхийн тогтолцоо, тойргийн болон дагнасан шүүх" УБ, 2021, 101-102, 112 дахь тал

нь Архангай аймаг. 2020 оны байдлаар дээрх дөрвөн аймгийн шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тоо нийлээд 101 байна. Тус шүүхийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй байгуулна. Ингэснээр одоо ажиллаж байгаа 7.6 шүүгчийн орон тоо, батлагдсан орон тооноос есөн шүүгчийн орон тоо хасагдана ... 11. ЗХАШШ-ийг тойргийн зарчмаар байгуулах шаардлагатай бөгөөд улсын хэмжээнд зургаан шүүх байхад тохиромжтой ... ЗХАШШ-ийг дээрх байдлаар тойргийн зарчмаар байгуулснаар улсын хэмжээнд захиргааны хэргийн нийт 34 шүүгч байхад хангалттай байх ба **одоо ажиллаж байгаа 71 шүүгчээс 37 шүүгчийн орон тоо сулрах боломжтой. Эдгээр орон тоог ажлын ачаалал өндөртэй бусад шүүхэд шилжүүлэх боломж бүрдэнэ ...**” гэж үзжээ.

Хэрэв дээрх судалгаанд дурдсан байдлаар анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулбал, нэг талаар шүүхийн төсөв багасаж, ачаалал тэнцвэржиж буй мэт боловч манай орон шиг өргөн уудам нутагтай, засаг захиргааны нэгжээ даган төрийн үйлчилгээ төвлөрсөн өнөө үед алслагдсан сум, орон нутагт амьдарч буй иргэд хэд хэдэн аймгийг нэгтгэсэн шүүхээр үйлчлүүлэхэд санхүүгийн болоод цаг хугацааны хувьд хохиролтой юм. Нөгөөтээгүүр, шүүхийн ачаалал жил ирэх тусам нэмэгдэж буй өнөө үед шүүхийг тойрог болгох хэлбэрээр шүүгчийн орон тоог шилжүүлэх, шүүхийн зардлыг багасгах бус ачаалал ихтэй шүүхүүдэд шүүгч нэмж томилох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь цаашид шүүх эрх мэдлийн бие даасан байдал эергээр нөлөөлөх боломжтой.

Гуравдугаарт, анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндрэл үүсгэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа удаашрах нөхцөлийг бүрдүүлэхээр байна. Тодруулбал, улсын хэмжээнд эрүүгийн хэргийн анхан шатны 38, иргэний хэргийн анхан шатны 38, захиргааны хэргийн анхан шатны 22 шүүх үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1. дэх хэсэг Шүүхийн захиргааны үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална: 69.1.3.-т “мэргэшсэн, тогтвортой байх”, 69.1.4.-т “шүүхийн үйлчилгээ шуурхай, хүртээмжтэй байх” гэж заасан.

Одоогийн шүүхийн тогтолцоонд 2021 оны 7 дугаар сард шүүх хуралдаан хойшлолт дараах үзүүлэлттэй байна. “...иргэний хэргийн шүүх 2796 шүүх хуралдаан товлон зарласнаас 92.3 хувь нь хэргийн оролцогчоос шалтгаалан хойшилсон байна. Хэргийн оролцогч, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчөөс нотлох баримт гаргуулах хүсэлт гаргасан нь хамгийн өндөр үзүүлэлттэй байх жишээтэй. Эрүүгийн хэргийн хувьд мөн л 92.7 хувь нь хэргийн оролцогчоос шалтгаалж шүүх хуралдаан хойшилсон ... иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа 6486 хэргийн 23.2 хувь, Захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдийн



хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа 878 хэргийн 35.8 хувь нь хугацаа хэтрэлттэй ..." байна.¹⁹

Удаа дараа шүүх хуралдааныг хойшлуулж, хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан хугацаа хэтэрч байгаа үндэслэл, хугацааг улсын хэмжээнд 2019 оны 5 дугаар сарын 1-ний байдлаар судалж үзвэл нийт ажиллагаанд байгаа иргэний хэргийн 47% нь 1-60 хоног, 20% нь 61-120 хоног, 6% нь 121-150 хоног, 27% нь 151-ээс дээш хоногоор буюу иргэний хэрэг үүсгэснээс хойш 240 хоног /8 сар/ өнгөрсөн байна. /Энэ хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх 90 хоногийн хугацаа ороогүй болно.²⁰

Иргэний хэргийн шүүхийн тухайд, тойргийн зарчмаар байгуулбал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой дараах хүндрэл үүсэж болзошгүй байна. Иргэний хэргийн шүүх нь зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нараас өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болжбайгаабайдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулахыг шаарддаг. Тиймээс хэд хэдэн аймгийн газар нутгийг нэгтгэн тойргийн зарчмаар байгуулсан тохиолдолд зохигчдыг шүүхэд ирүүлэх, нотлох баримт гаргуулах болон шүүхийн журмаар өөр аймаг сумаас нотлох баримт гаргуулах захирамж, албан бичиг явуулахад баталгаат шуудангаар багадаа 10 хоногт, иргэн хуулийн этгээдээс гэрчийн мэдүүлэг авахаар дуудахад мэдэгдэх хуудас хүргүүлэх хугацаа, ирүүлсэн гэрчийн замын зардал, хоол, байрны мөнгө, өөр аймаг, суманд үзлэг хийхэд шатахуун, томилолтын зардал, шүүх хуралдаанд хэргийн оролцогч нарыг оролцуулахад тэдгээрийн шүүхэд ирэхэд боломжтой хугацаа, шүүх хуралдаан хойшилсон тохиолдол мөн дараагийн шүүх хуралдааны хугацаа зэрэг шүүхийн ажиллагаа удаашрахаар байна. Улмаар шүүхийн ажиллагаатай холбоотой хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар зардал, цаг хугацааны алдагдал хүлээхээр байна.

Захиргааны хэргийн шүүхийн тухайд, эрүү, иргэний хэргийн шүүхээс нотлох баримт цуглуулах үүргийг өөрөө гүйцэтгэдэг бөгөөд ихэнх нотлох баримтыг шүүхийн ажиллагаагаар цуглуулдаг онцлогтой. Хэрэв захиргааны хэргийн шүүх тойргийн зарчмаар ажиллах тохиолдолд өөр аймаг, сумдад томилолтоор ажиллаж нотлох баримт цуглуулах, гэрчийн мэдүүлэг авах, газрын үзлэг, хэмжилт хийх зэрэг шүүхийн оролцоотой хийгдэх ажиллагаа байнга гарахаар байна.

Жишээ нь одоогийн нөхцөлийн тухайд, Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хувьд л гэхэд, захиргааны хэрэг, маргааны онцлог, орон нутгийн онцлогоос шалтгаалж тус аймгийн 19 сум, багуудад очиж үзлэг, хэмжилт хийх, бичмэл нотлох баримт цуглуулах, даалгавар гүйцэтгэх, гэрч асуух зэрэг нотлох баримт цуглуулах ажиллагаа

¹⁹ https://judcouncil.mn/site/news_full/11399, сүүлд үзсэн 2021.12.15

²⁰ <http://www.supremecourt.mn/act/view/273>, сүүлд үзсэн 2021.12.15

хийх шаардлага байнга гардаг. Архангай аймгийн төвөөс хамгийн холын захын сумууд болох Цэцэрлэг сум 230 км, Жаргалант сум 227 км, Хангай сум 230 км зайтай бөгөөд ихэнх сум засмал замд холбогдоогүй байна.

Хэрэв захиргааны хэргийн анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж өөр ойролцоох аймагтай нэгтгэсэн тохиолдолд жишээ нь Архангай аймгийн төвөөс Өвөрхангай аймгийн төв хүртэл 256 км, Завхан аймгийн төв 546 км, Баянхонгор аймгийн төв 282 километрийн зайтай байна. Энэ нь зөвхөн аймгийн төвийн зай бөгөөд тухайн аймгуудын захын сумдын километрийн зайг гаргавал үүнээс хэд дахин хол /Өвөрхангай аймгийн төвөөс Архангай аймгийн Цахир сум хүртэл 490км, Завхан аймгийн Тэс сум хүртэл 1158км, Баянхонгор аймгийн Баянлиг сум хүртэл 480км/ зайтай байхаар байна.

Энэ тохиолдолд өөр аймгийн төвөөс нөгөө аймгийн сумдад шүүхээс тодорхой ажиллагаа хийж ажиллахад наад захын зардлаас авахуулаад шүүгч, шүүхийн захиргааны ажилтны ажиллах нөхцөл, аюулгүй байдалд ч эрсдэлтэй нөхцөлийг үүсгэж болзошгүй юм. Улсын төсөвт ч нэлээдгүй хэмжээний зардал гарах нь тодорхой байна. Нөгөөтээгүүр захиргааны хэргийн оролцогч нэг тал нь захиргааны байгууллага, албан тушаалтан байдаг, тэдгээрийг одоогийн тогтолцоонд л гэхэд газар нутгийн онцлогоос шалтгаалан шүүхэд дуудан ирүүлэх, нэхэмжлэлийн хувь гардуулах, хэргийн материалтай танилцуулах, шүүх хуралдаанд оролцуулахад хүндрэл, бэрхшээл үүсдэг. Гэтэл анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулбал хариуцагчийг шүүхэд тухай бүр дуудаж ирүүлэх, тэдгээрийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдаан болон бусад ажиллагаанд оролцуулахад хариуцагчийн ажил, үүргийн хуваарь, газар нутгийн онцлогоос шалтгаалан хүндрэл үүсэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн, шуурхай явуулахад саад учрахаар байна. Дээрх нөхцөлөөс үзвэл захиргааны хэргийн анхан шатны шүүх тойргийн зарчмаар ажиллавал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад хүндрэл үүсэх нь зайлшгүй байна.

Эрүүгийн хэргийн шүүхийн тухайд, тойргийн зарчмаар байгуулбал шүүгдэгч, хохирогчийг шүүхэд дуудан ирүүлэх, шүүх хуралдаанд прокурор оролцох, шүүгдэгчийг цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах, тэдгээрийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг болон шүүх хуралдаанд оролцуулахад мөн л хүндрэл үүсэж болзошгүй байна. Мөн уг өөрчлөлтийн улмаас цагдаа, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын байршил, бүтэц, зохион байгуулалт, орон тоо өөрчлөгдөх, түүнтэй холбоотой төсвийн зардал нэмэгдэх үр дагавар үүсэхийг анхаарах шаардлагатай.

Түүнчлэн анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулснаар одоо ажиллаж байгаа шүүгч, шүүхийн захиргааны ажилтны нийгэм, эдийн засгийн асуудал /орон байр, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн хөдөлмөрлөх, сурч боловсрох эрх г.м/ хөндөгдөхөөр байна.



ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Монгол Улсын Ардын багш, гавьяат хуульч, хууль зүйн доктор, профессор Бяраагийн Чимид багш нэгэнтээ хэлсэнчлэн, Шүүх эрх мэдэл гэдэг бол нийгэмд байнга үүсдэг маргаан, зөрчилдөөнтэй асуудлыг шударгаар хянан үзэж, хуулийг мэргэжлийн үндсэн дээр зөв тайлбарлаж хэрэглэн эрх зүйн шийдэл гаргах замаар хүний эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн ашиг сонирхол, үндсэн хуульт байгууллын ардчилсан үндсийг хамгаалах үйл ажиллагаа билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр шүүх эрх мэдлийн хүрээнд зарчмын шинжтэй хэд хэдэн өөрчлөлт орсон. Тухайлбал, шүүгчийг сонгон шалгаруулах, шүүгчийн сахилга, хариуцлага, Ерөнхий зөвлөлийн чиг үүрэг, бүтэц бүрэлдэхүүн, Шүүхийн сахилгын хороо, нийт шүүгчдийн чуулган, УДШ-ийн эрх хэмжээ зэрэг шинэ зохицуулалт хэрэгжиж эхлээд удаагүй байна. Шүүх эрх мэдэлд хамаарах дээрх институтийн зохицуулалт хэр үр нөлөөтэй, оновчтой болсон нь ирэх жилүүдэд тодорхой болох биз ээ.

Судлаачийн зүгээс шүүх эрх мэдэлд хамаарах дээрх шинэлэг зохицуулалтаас Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын Шүүхийн тухай хуульд туссан бөгөөд одоогоор хараахан хэрэгжээгүй боловч онцгой ач холбогдол бүхий “шүүхийг тойргийн зарчмаар байгуулах” зохицуулалтыг судлах нь шинэлэг гэж үзлээ. Ялангуяа анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулах нь оновчтой эсэх асуудлыг хөндөж, өнөөгийн шүүхийн практик болон иргэний эрх, төрийн үйлчилгээтэй уялдуулахыг зорьсон болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн дөчин наймдугаар зүйлийн 1.-д “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд **шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно**. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэж зааснаас үзвэл Монгол Улсын шүүхийн тогтолцоо нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тогтолцоотой /хамааралтай/ зэрэгцэн оршиж буйг харуулж байна.

Нөгөөтээгүүр, дээрх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тогтолцоог даган төрийн байгууллагууд төвлөрч, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. дэх хэсэгт “Анхан болон давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг тойргийн зарчмаар байгуулахад энэ хуулийн 14.3-т заасныг харгалзахаас гадна шүүхэд хандах иргэний эрхийн баталгааг хангах, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн байна.”,

14.3. дахь хэсэгт “Шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтооход түүний харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрөл, тоог харгалзан үзнэ.” гэж заажээ.

Шүүхийг тойргийн зарчмаар байгуулах нь шинэлэг бөгөөд зарим талаараа оновчтой зохицуулалт байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ төрийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын цөмд ард иргэд, тэдгээрийн хүсэл зоригийг тавих нь зүйд нийцэх болов уу.

Хууль тогтоогчийн зүгээс шүүхийг тойргийн зарчмаар байгуулснаар шүүхийн ачаалал тэнцвэржих, шүүхийн зардал багасах, шүүхийн үйлчилгээ иргэдэд ойртох давуу талтай гэж тайлбарлажээ. Гэвч энэ зохицуулалт нь бодит байдалд шүүхээр үйлчлүүлж буй иргэн, хуулийн этгээдэд чирэгдэл үүсгэх, шүүхийн үйлчилгээг иргэдэд ойртуулах бус холдуулах, шүүхээр үйлчлүүлж буй иргэн, хуулийн этгээдэд зардал, цаг хугацааны хохирол үүсгэж болзошгүй байна. Түүнчлэн Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.3.-т “мэргэшсэн, тогтвортой байх”, 69.1.4.-т “шүүхийн үйлчилгээ шуурхай, хүртээмжтэй байх” гэж шүүхийн захиргааны үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тусгасан байдаг.

Гэтэл анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулах нь өгүүллийн өмнөх хэсэгт дурдсанчлан шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад хүндрэл үүсгэх, үүнээс үүдэн шүүх иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээрийн зөрчигдсөн эрхийг сэргээх чиг үүргээ түргэн, шуурхай хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүсгэхээр байна.

Иймд анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулах тохиолдолд Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт заасан шалгуур үзүүлэлтэд “шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад хүндрэл үүсэх эсэх” асуудлыг харгалзан үзэх зохицуулалтыг нэмж тусгах шаардлагатай гэж үзлээ.

Эцэст нь тэмдэглэхэд, шүүх эрх мэдлийн байгууллагын тогтолцоо, бүтэц зохион байгуулалтын шинэчлэлийн үр дүн нь шүүхийн үйлчилгээ иргэдэд ойртсон байдал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түргэн шуурхай явагдаж буй эсэхээр хэмжигдэх билээ.



ШҮҮГЧИЙН САХИЛГЫН ЗӨРЧЛИЙГ ШАЛГАЖ ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛ БА ЁС ЗҮЙН ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ, ХАРИЛЦАН ХАМААРАЛ /ШУДАРГА ЁСНЫ ХЭМЖҮҮР/

О.Бадмаараг

Дотоод хэргийн их сургуулийн магистрант

Удиртгал

Шүүхийн эрхэм зорилго нь Хүний эрх эрх чөлөөг хамгаалах зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох, Монгол Улсын тусгаар тогтнол, Үндсэн хуульт байгууллыг хамгаалах, хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам, эрх зүйн ухамсар соёлыг бэхжүүлэх гэж заасан байдаг. Энэхүү зорилттой уялдуулан шүүхийн шүүгчийг өндөр боловсрол, мэдлэг чадвартай шударга, хариуцлагатай, ёс зүйтэй байх шаардлага ч нэн тэргүүнд тавигдаж иржээ. Шүүгчийн ёс зүйн болзол шалгуур, эрх зүйн байдлын онцлог, шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх харилцааг Шүүхийн хуулиар / шинэчлэн найруулсан/ тогтоосон хэм хэмжээг боловсронгуй болгож, зохих нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан нь энэ хуулийн үзэл баримтлалын нэг мөн юм. Хууль тогтоомж, ёс зүйн дүрэмд заасан энэ ойлголтын дагуу явагдах процессын үйл ажиллагаанд харгалзан үзэх үндэслэл нь ёс зүйн үндэслэл байна гэсэн санааг дэвшүүлж энэхүү сэдвийг сонгон авсан болно.

Ёс зүйн онол, сургааль, тэгш байдал, шударга ёс зэрэг ухагдахуун нь амьдралд хэрхэн хэрэгжих, нийгмийн үнэт зүйлс болохынх нь хувьд ямар байх талаар судлаачдын хандлага үзэл баримтлалын нийтлэг болон ялгаатай шинжийг харьцуулан судалж нэгтгэн дүгнэх нь сэдвийн онолын үндэслэлийг тодотгоно гэж үзсэн болно.

Үндсэн хуулийн тогтолцоо, хууль зүйн уламжлал зэргээс шалтгаалан улс орнуудын хууль, шүүхийн тогтолцоо ялгаатай ч ихэнх улсад шүүх эрх мэдэл эрх зүйт ёсны гол багана, шүүхийн бие даасан байдал ардчиллын үнэт зүйл гэдгээрээ ижил шинжтэй байна¹. Мөн түүнчлэн шүүхэд сахилгын шийтгэл хүлээлгэх хууль зүйн үндэслэл нь ёс зүйн зөрчил гаргасан байх ба түүнд сахилгын шийтгэл хүлээлгэж байгаа процесс, үр дүнг шударга байхыг нийгмийн гишүүдээс шаарддаг. Энэ нь зүй ёсны боловч сахилгын шийтгэл оногдуулах үйл ажиллагаа

¹ ENCJ Project 2013-2014, Independence and Accountability of the Judiciary, 13 June 2014, Rome 61 Evan Bell, "Judicial case management", Judicial Studies Institute Journal, 2009:2 62 "Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмууд"-ын 6.5 дахь хэсэг 63 William Davis, "The Role of Court Administration in Strengthening Judicial Independence and Impartiality" 64 Evan Bell, "Judicial case management", Judicial Studies Institute Journal, 2009:2 65 "ENCJ Project 2011-2012 Judicial Reform in Europe" report Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судалгааны тайлангийн эмхэтгэл 2015 /дам эшлэв/

нь үйл баримтад дүгнэлт хийхээс илүүтэй шүүгчийн үйл ажиллагааны ёс зүйд нь дүгнэлт өгөх учиртай. Иймийн тулд ёс зүйн онол-арга зүйн өргөн мэдлэг, хандлага шаардагдах нь зайлшгүй. Энэхүү шаардлагад нийцүүлэн сэдвийн эхний хэсгийг ёс зүйн онол-арга зүйн ойлголт, ангиллыг шүүгчийн ёс зүйн зарим ойлголтуудтай уялдуулан авч үзсэн болно.

Нэг. Ёс зүйн онол, арга зүйн ойлголт

Хүн төрөлхтний түүхэнд “ашиг сонирхол” “хүн чанар-ёс зүй” хоёр зэрэгцэн оршдог боловч харамсалтай нь эдгээр категориуд үргэлж эсрэг агуулгатай байсаар ирсэн ба цөөхөн тохиолдолд ёс зүйг баримтлан хийсэн үйлдэл нь эдийн засгийн ашиг сонирхолдоо хөтлөгдөн хийсэн үйлдэлтэй тэнцэхүйц ашгийг хүмүүст өгдөг.” гэж үзсэн² бол энэ ойлголтыг эдийн засгийн агуулгаар нь 1776 онд нэрт эдийн засагч Адам Смит “Үндэсний баялаг” бүтээлдээ³ “эдийн засгийн хүн” гэх ойлголтыг хөндөж энэ нь шинжлэх ухаан хүнийг төрөлхийн “рациональ” сэтгэлгээтэй хүн гэж үздэг бөгөөд үүнд тулгуурлан хувь хүний сайн сайхан байдлыг хамгийн их байлгах сэтгэлгээнд тулгуурладаг гэж үзсэн байдаг. Ёс зүйн ойлголтыг авч үзсэн дээрх үзэл хандлагуудыг задлан шинжилбэл “хүн үнэхээр хүйтэн сэтгэлтэй рациональ тооцоологч мөн юм гэж үзвэл бусдын төлөө өөрийгөө зориулах, золиослох тохиолдол хүн төрөлхтний түүхэнд яагаад ийм олон байдаг вэ гэсэн асуулт гарч ирнэ. Эдийн засгийн ухаан ч “хүн” гэх тодотгол байна. Аливаа зүйлд түүний мөн чанарыг тодорхойлох шинж, элемент, байдаг бол хүнд ч гэсэн мөн адил “хүн чанар” түүнд тулгуурласан “ёс суртахуун” гэсэн шинжүүд байдаг нь одоо хүртэл хүн оршин тогтнож байгаа хүчин зүйлс мөн гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна. Энэ бол ойлголтын эхлэлийн шинжтэй дүгнэлт юм.

Шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйл “Шүүхийн эрхэм зорилго” Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлж, хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, хууль дээдлэх, шударга ёсыг бэхжүүлэх, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах мөн хуулийн 50 дугаар зүйлд заасан “Шүүгчийн тангараг” зэрэг зохицуулалтад илэрч байгаа нь ажиглагдаж байна⁴.

Ёс зүйн шинжлэх ухаан нь хувь хүний ёс суртахуунлаг шинж чанарын буюу сайн чанаруудын нийлбэр цогцыг нөгөө талаас нь хүмүүсийн хоорондын харилцааны хэм хэмжээг судалдаг шинжлэх ухаан гэж үзэх нийтлэг хандлага байдаг. Ёс зүйн шинжлэх ухааныг судалсан судлаачдын бүтээл үзэл бодлыг харьцуулан үзвэл дараахь хандлагууд ажиглагдаж байна. Энэ нь түүнийг системчлэн ангилсан дараахь хэсгүүдэд хуваагдаж байна. Ёс зүйн хоёр үндсэн хэсэг нь:

² П.Кирхоф “Государственное право Германии” 1994г /дам эшлэв/

³ Адам Смит “Үндэсний баялаг” орчуулга 2011 он. 87 дахь тал.

⁴ Төрийн мэдээлэл” эмхтгэл 2021 он.



1. Үнэт чанарын ёс зүй /акеслоги/ Ёс суртахууны үнэт чанарын системийг судалдаг. Францын философич П.Лапи гол асуудал нь “сайн” ба “муу”-гийн тухай асуудал
2. Үүргийн ёс зүй /дентологи/ Ёс суртахууны хэм хэмжээ шаардлагыг судалдаг английн философич И.Бентам “Үүрэг”-ийн тухай асуудал В.Д.Росс, Э.К.Эвинг /Бие даасан ёс зүйн сургаал болгон дэвшүүлсэн гэж онол-арга зүйн хувьд тус тус ангилжээ⁵. Сэдвийн хүрээнд хийсэн онол-арга зүйн хандлага, үзэл баримтлалыг нэгтгэн дүгнэвэл Ёс суртахуун гэж: Нийгмийн ухамсрын хэлбэр бодит байдалд хандах үнэлэлт ёс суртахууны хэм хэмжээ шалгууруудын нийлбэр цогц хүмүүсийн зан үйлийг нийгмийн дотор зохицуулж байдаг зарчим, дагаж мөрдөх хэм хэмжээ, үнэлгээний түүхэн ёсоор уламжлагдсан тогтолцоог ойлгоно” гэж тодорхойлолт өгч болохоор байна.

Ёс суртахууны үндсэн зарчим, үнэт зүйлсийн тогтолцоо төлөвшиж буй болчхоод түүнээс ёс суртахууны янз бүрийн хэм хэмжээний тогтолцоо үүссэн биш, харин хүмүүсийн зан суртахууны янз бүрийн хэм хэмжээ аажим аажмаар үүсэж, өргөжин, зарим нь түүнийг төрүүлсэн түүхэн нөхцөл, цаг үеийнхээ хамт алга болж, зарим нь улам батжин шинэ агуулгаар баяжин хүчийг олж, зарим хэм хэмжээ цоо шинээр үүсэх зэргээр шалгаран хөгжсөөр нийт хүн төрөлхтний ёс суртахууны нийтлэг үнэт зүйлс, зарчмууд үүсэж буй болсон гэж үзсэн байна⁶. Ёс суртахууны зарчим нь хүмүүсийн амьдралын бодит харилцаагаар үүсэж гарсан түгээмэл шаардлага бөгөөд хүний зан байдлын ноён нуруу, чиг хандлагыг тодорхойлж ёс суртахууны нийгмийн мөн чанарыг тусгадаг хамгийн ерөнхий шаардлага болно. Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэмд шүүгчийн үйл ажиллагаанд баримтлах зарчмыг дараах агуулгаар зохицуулсан.

Хараат бус, бие даасан байх - шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ шүүгч бусдын нөлөөнд автахгүй, гагцхүү хуульд захирагдаж хууль ёсны ба үндэслэлтэй шийд гаргана.

Хууль дээдлэх - Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан албан ёсоор нийтлэгдсэн, хүчин төгөлдөр бусад хуулийг биелүүлж хэрэгжүүлнэ.

Шударга байх - зөвийг эрхэмлэн дээдэлж, ажил мэргэжилдээ үнэнч, аливаад алагчлалгүй хандан, авлигаас ангид байж, ашиг сонирхлын зөрчлөөс ямагт зайлсхийнэ.

Хүн бүрт адил тэгш хандах - шүүгч аливаа асуудалд төвийг сахисан, шударга байдлаар хандаж, хэргийн оролцогчдыг ялгаварлахгүй харилцана.

⁵ Э.Лхагвасүрэн Гадаад орнуудын Үндсэн хуулиудын шүүх” /Хууль дээдлэх ёс сэтгүүл /

⁶ Ч.Нямсүрэн “Эрх зүйн ерөнхий онол” Уб., 2002 он.

Шүүхийн нэр хүндийг өндөрт өргөх - шүүгчийн зан байдал, үйл ажиллагаа нь шүүхийн үнэнч шударга байдалд итгэх олон нийтийн итгэлийг бататган бэхжүүлэхэд чиглэнэ.

Хариуцлагатай байх - ажил мэргэжилдээ хүндэтгэлтэй хандаж, зохисгүй байдал гаргахгүй, мэргэшлийн өндөр түвшинд үйл ажиллагаа явуулахын тулд мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлэн, өөртөө болон бусдад зарчимч байдлаар хандаж, шударга бус байдалтай үл эвлэрнэ гэж заасан нь ёс зүйн үндсэн зарчмын шударга ёсны түгээмэл шаардлагад нийцэж эрх зүйн хэм хэмжээгээр хэлбэржсэн байгаа нь ажиглагдаж байна⁷.

Шударга ёсны талаар олон үзэл хандлагын хэлбэрүүд байдаг. Жишээлбэл: З.Фрейдийн үзлээр "...шударга ёс бол хүмүүс нийтээрээ ба тус бүртээ соёлын шаардлагуудад захирагдахын зайлшгүй хэрэгцээ, сэтгэл зүйн үүднээс хэлбэл анхдагч инстинктүүдээ хазаарлан барих шаардлага мөн, соёл бол хүмүүсийн анхдагч дур хүсэл, анхдагч догдлолоос янз бүрийн хар муу хүч гарч ирэхийг саатуулагч хамгаалах механизм мөн, тиймээс бодгаль эрх чөлөө бол соёлын ололт биш" гэж үзжээ⁸. Бидний үзэж буйгаар үүрэг хариуцлага, тэгш байдал, эрх чөлөө, хууль дээдлэх энэрэнгүй үзэл нь шударга ёстой харилцан уялдаж нийгмийн сайн сайнхан бүхнийг цогцлоон бүтээнэ гэж үзнэ. Тиймээс ардчилсан нийгмийн үндсэн зарчим бол "шударга ёс"-ны үзэлд тулгуурлана. Монгол Улсын Үндсэн хуульд төрийн албаны үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчмуудын нэг нь шударга ёсны зарчим байхыг хуульчлан бэхжүүлсэн байна. Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаа мөн хувь хүний итгэл үнэмшил нь нийгмийн шударга ёсны төлөө зориулагдсан шударга ёсны үйл ажиллагаа учраас шүүгч бүрийн ёс суртахуун, үйл ажиллагаа бүхэн шударга байдалд нийцсэн байх ёс зүйн шаардлагыг өмнөө тавих нь нэн тэргүүний зорилго болох нь ажиглагдаж байна.

Онол, арга зүйн хувьд шүүгчийн мэргэжлийн ёс зүй "...хүн ёсны үүднээс заавал сахиж мөрдөх шаардлагатай, бараг хууль ёсны дүрэм журмуудын нийлбэр цогц юм. Өөрөөр хэлбэл тухайн салбарт ажиллаж байгаа хүний ажлын онцлогийг илтгэн харуулж байдаг мэргэжлийн үүрэг, байгууллага, мэргэжлийн нэр хүндийн асуудал гэж тодорхойлсонтой санал нийлж байна. Иймд хүний төлөө сэтгэл гаргасан, хүнлэг, энэрэнгүй, шударга, үнэнч байх асуудал чухлаар тавигддаг болохыг судлаачид нийтлэг байдлаар хүлээн зөвшөөрсөн байна. Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэмд заасан мэргэжлийн ёс зүйн шаардлагыг дүрэмд заасан байдал, баримтлах хүрээ, мэргэжлийн ёс зүйн онолын хүрээнд ангилан үзэх нь онол-практикийн ач холбогдолтой юм. Шүүгчийн мэргэжлийн ёс зүйн шаардлагыг чиг үүргээс нь хамаарч:

⁷ Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёсзүйн дүрэм.

⁸ Г.Ганбаатар "Хуулийн засаглал шударга ёсны эрэлд" Уб хот, 2016 он.



- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тавих ёс зүйн шаардлага
- Бусад үйл ажиллагаанд тавигдах шаардлага гэж ангилж болохоор байна. Шүүгчийн мэргэжлийн ёс зүйн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тавих ёс зүйн шаардлагыг тэдгээрийн шинж чанар, хэрэгжүүлэх хэмжээ, хязгаараас нь хамаарч:
- Харилцааны хүрээнд тавигдах шаардлага /иргэд, хэргийн оролцогчтой харилцах г.м/
- Биеэ авч явах, хуульчийн соёлын хүрээнд тавигдах шаардлага
- Албаны нэр хүндээ хамгаалах хүрээнд тавигдах шаардлага гэж ангилах нь зүйтэй болов уу. Ийнхүү ангилсан нь онол-арга зүйн хувьд шууд тогтсон ойлголт бус цаашид та бүхэн боловсронгуй болгож хэрэглэнэ гэдэгт итгэж байгааг энд дурдах нь зүйтэй. Шүүгчийн мэргэжлийн ёс зүйн талаарх онол-арга зүйд тулгуурлан мэргэшлийн ёс зүйн асуудлыг судлан үзэх нь зүйтэй юм. Арга зүйн хувьд мэргэжлийн ёс зүй нь мэргэшлийн ёс зүйн асуудал болж улам нарийн, улам гүн гүнзгий агуулгыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл мэргэжлийн үүргээ биелүүлэх, албан ажлын хүрээнд хүмүүстэй харьцаж, мэргэжлийн ёс зүйг хэрэгжүүлэх үед мэргэшлийн ёс суртахуун, сэтгэл зүйн харилцаа үүсэн бий болно. Энэ нь ёс зүйн дүрмээр зохицуулагдахын зэрэгцээ ёс суртахууны хэм хэмжээний нэгдлийг хангахад чиглэгдэнэ. Мэргэшлийн ёс суртахууны нэг онцлог нь тухайн нөхцөлд өөрийн зан байдлыг ухамсартай удирдаж ёс суртахууны сонголт хийх шаардлагатай болдог⁹. Шүүгчийн мэргэжлийн ба мэргэшлийн ёс зүйн нийтлэг болон ялгагдах шинж, агуулга, ач холбогдол, харилцан уялдаа холбоог шинжлэх ухааны үндэслэлтэй судлах нь онол-практикийн ач холбогдолтой болох төлөв ажиглагдаж байна.

Одоогоор энэ талаар судалсан судалгаа шинжилгээний ажил хараахан байхгүй нь ажиглагдаж байна. Шүүгчийн мэргэшлийн ёс зүйн ойлголтын агуулгад сахилга, ёс суртахууны хариуцлагаар тодорхойлогдох ойлголтууд хамаарах нь онол-арга зүйн судалгааны энэ хэсэгт ажиглагдаж байна. Эрх зүй болон ёс зүйн хэм хэмжээнүүд нь нийгмийн харилцааг тохируулан зохицуулдаг, эрх зүйг бий болгох аргын нэг нь ёс суртахууны хэм хэмжээг хуульчлан зөвшөөрөх замаар нийгмийн амьдралд баталгаажуулан хэрэгжүүлдэг. Ёс суртахууны хэм хэмжээ нь эрх зүйн хэм хэмжээнээс удаан хугацаанд өөрчлөгддөг ба үйлчлэх хүрээ нь өргөн нийгмийн харилцааны бүх хэлбэрт үйлчилдэг. Эрх зүй ёс суртахуун хоёр нь хүмүүсийн зан үйлийг зохицуулах аргаараа ялгагдана.

Ёс суртахууны хариуцлага: Нийгмийн хариуцлагын нэг төрөл мөн бөгөөд хүн өөрт нь зайлшгүй ач холбогдолтойг ухамсарлаж байдаг. Энэ нь хүн

⁹ Ч.Нямсүрэн “Эрх зүйн ерөнхий онол” УБ хот, 2008 он.

үйлдлээ үнэлэх хүсэл зоригийн эрх чөлөөг ашиглах ёс суртахууны чадвартай болно. Ёс суртахууны хариуцлагын хэлбэр нь зэмлэл байна.

Сахилга бат: Сахилга гэдэг нь нийгмийн шаардлагаар нөхцөлдсөн хүмүүсийн хүсэл бодол үйл ажиллагааны нэгдэл нийгмийн тогтоосон журмыг сахихыг хэлнэ. Сахилга нь нийгмийн ухамсрын хэлбэрүүд тэдгээрийн дотроос хүний ёс суртахуунтай салшгүй нэгдэлтэй байдаг. Ёс зүйгүй хүн сахилгатай байж чадахгүй байж чадахгүй бөгөөд сахилгын зөрчлийн үндэс нь ёс суртахууны доголдолд оршино. Сахилгын үндсэн үүрэг нь бие хүний эрх чөлөөг хязгаарлахгүй харин хувь хүнд өөрт нь болон нийгэмд ашигтай үйл ажиллагааны журмыг тодорхойлж өгдөгт оршино. Сахилгын шийтгэл гэж сахилгын зөрчил гаргасан шүүгчид ёс зүйн дүрэмд заасан үндэслэл журмын дагуу эрхийг нь хязгаарлаж байгаа эрх зүйн хариуцлагын бие даасан төрөл юм. Дээрх онол-арга зүйд тулгуурлан үзвэл шүүгчийн мэргэжлийн болон мэргэшлийн ёс зүй нь хэрэгжүүлэх субъект, зарчим, шаардлагын хувьд ижил төстэй боловч шинж чанар, тавигдах шаардлага, үр дагаврын шинжээрээ ялгаатай ойлголт болох нь харагдаж байна. Онол-арга зүйн хэсэгт судлан үзсэн ойлголтуудын хэрэгжилт, онол-практикийн уялдаа холбоог судлах нь ач холбогдолтой юм.

Хоёр. Санал асуулгын үр дүн

Судалгаанд нийт 25 хуульч оролцсон ба эдгээрээс санамсаргүй түүврийн аргаар сонгож, санал асуулгын аргаар боловсруулан хариултыг нэгтгэн гаргасан болно. *Судалгаанд оролцогчдын насны байдлыг авч үзвэл:* 20-25 насны 25 хувь 26-35 насны 25 хувь, 35-аас дээш насны 50 хувь байх тул практикт удаан жил ажилласан дадлага туршлагатай оролцогчид ихэнх хувийг эзэлж байв.

Боловсролын байдлаар нь авч үзвэл:

-Дээд боловсролтой 100 хувь гэсэн үзүүлэлттэй байна.

Хүйсийн байдлаар авч үзвэл: Ажилласан жилээр нь авч үзвэл: 3-5 жил-25 хувь, 6-8 жил-25 хувь, 10 түүнээс дээш жил ажилласан 50 хувь байв. Судалгаанд оролцогчдоос урьдчилан боловсруулсан асуулгын аргаар дараах асуултыг тавьж хариулт авахад:

1. Таны үзэж байгаагаар шүүгчээс мэргэжлийн үйл ажиллагаандаа баримтлах нэн тэргүүний ёс зүйн зарчим юу вэ гэсэн асуултад 30 буюу 70 хувь нь харилцааны, 10 буюу 20 хувь нь шударга байх, 5 буюу 10 хувь нь хараат бус байдалтай байх гэж хариулж байгаа нь шүүгчийн мэргэжлийн ёс зүйн шударга ёсны зарчмыг илүүтэй үзсэн нь ажиглагдаж байв.
2. Шүүгчийн ёс зүйд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг та юу гэж үзэж байна вэ гэсэн асуултад судалгаанд оролцогчдоос 65 хувь нь хээл хахууль, 24 хувь нь танил тал, өмнөх харилцаа 15 хувь албан тушаалын



- байдлаар нөлөөлөх, 0,5 хувь нь хувийн эрх ашиг гэж хариулж байв.
3. Шүүгчийн үйл ажиллагаа, шийдвэрт итгэх итгэлцүүр таны үзэж байгаагаар ямар төвшинд байна вэ гэсэн асуултад 40 хувь нь сайн, 50 хувь нь дунд зэрэг, 10 хувь нь итгэлгүй гэсэн хариултыг өгч байв.
 4. Шүүгчид тавих шударга ёсны хэмжүүр таны үзэж байгаагаар гэсэн асуултад 15 хувь нь алагчлахгүй байх, 36 хувь нь гадны нөлөөнд автахгүй байх, 16 хувь нь хүнлэг байх, 15 хувь нь буцалтгүй шийдвэр гаргадаг байх, 16 хувь нь мэдэхгүй гэсэн хариултыг өгч байгаа нь мөн л шударга байх зарчмын агуулгыг ямар хэмжүүрээр хэмжих талаарх ойлголт хангалтгүй байгааг харуулж байсан.
 5. Шүүгчид авч буй ёс зүйн хариуцлага таны үзэж байгаагаар гэсэн асуултад 30 хувь нь шударга байж чаддаг, 60 хувь нь хангалтгүй, 20 хувь нь мэдэхгүй гэсэн хариултыг өгч байв.
 6. Шүүх хариуцлага хүлээлгэснээс үүдэх нийгмийн эерэг байдал таны үзэж байгаагаар гэсэн асуултад 90 хувь нь шударга ёс тогтоно, 10 хувь нь нийгмийн хөгжилд эерэг нөлөөлнө гэсэн хоёр хариултад багтаж байсан ба улс төрийн өнгө аяс агуулгаар хандах нь судалгаанд оролцогчдоос нийтлэг байсан тул хариултыг дүгнээгүй болно.

ДҮГНЭЛТ

1. Шүүгчид сахилгын хариуцлага оногдуулж, хууль, дүрмийн хэм хэмжээг хэрэглэхдээ ёс зүйн үндэслэлийг тогтоох, ёс зүйн шинжлэх ухааны ойлголт, мэдлэгт тулгуурлах нь хариуцлага бодитой байх зарчмын хэрэгжилтэд чухал ач холбогдолтой нь судалгаанаас харагдаж байна
2. Шүүгчийн мэргэжлийн ёс зүй, мэргэшлийн ёс зүйн ижил төсөөтэй шинж болон уялдах байдал, харилцан хамаарал, ялгаатай шинж байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлан тодорхойлох замаар шүүх, шүүгчийн үйл ажиллагааг зохицуулсан хууль, дүрмүүдэд нэг мөр ойлгож зөв хэрэглэх онол-арга зүйн үндэслэлийг тодорхой болгох
3. Шударга ёсны зарчим, түүнд нийцүүлэх ёс зүйн хэмжээ, хязгаар нь өргөн ойлголт болох нь ажиглагдаж байгаа ба онол-практикийн уялдаа холбоог боловсронгуй болгох судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлэх
4. Шүүгчийн мэргэшлийн ёс зүйн хүрээнд түүний мэргэшлийн түвшинг тогтоох явдал нь шүүгчийн хараат бус байдалд халдах хэрэгсэл биш хэдий ч энэ ажиллагааг хэрэгжүүлэхэд шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болголтгүйгээр харин тухайн шүүгч нь өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлсэн эсэхийг үнэлэх арга хэрэгсэл болгох нь зүйтэй юм. Ингэснээр шүүгчийг ёс зүйн шаардлагыг хангаагүй, ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэх бусад улсын туршлагыг судлах нь зүйтэй болов уу



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

01 сар

2022.01.04

Конрад-Аденауэр-Сангийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгч Виктор Франкийг хүлээн авч уулзлаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Д.Зүмбэрэлхам өнөөдөр /2022.01.04/ Конрад-Аденауэр-Сангийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгч Виктор Франкийг хүлээн авч уулзав. Уулзалтаар ардчиллыг хөгжүүлэн бэхжүүлэхэд шүүх засаглалын бие даасан, хараат бус байдлын чухлыг онцлон, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцож ярилцлаа.

2022.01.07

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн даргаар Рагчаагийн Батрагчаа томилогдлоо.

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаас тус зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн даргаар Рагчаагийн Батрагчааг томиллоо.

2022.01.13

“Шүүхийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх журам”-ыг баталлаа.

Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 71 дүгээр зүйлийн 71.1.5-д “өөрийн эрх хэмжээний хүрээнд холбогдох стандарт, дүрэм, журам батлан мөрдүүлэх”, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжилтийг хангах ажлын Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны 01 дүгээр тогтоолоор “Шүүхийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх журам”-ыг баталлаа.

2022.01.17

Шүүхийн захиргааны байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн эхэллээ.

Монгол Улсын шүүхийн захиргааны байгууллагын удирдах ажилтны сургалт зөвлөгөөн Улаанбаатар хотноо эхэллээ. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулж буй энэхүү



сургалт, зөвлөгөөнд анхан болон давж заалдах шатны шүүхийн 41 тамгын газрын дарга оролцож байгаа бөгөөд энэ сарын 17-19-ний өдрүүдэд үргэлжилнэ.

2022.01.19 ● Дорнод аймаг дахь шүүхийн тамгын газар шилдгээр шалгарав.

Анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрын 2021 оны үйл ажиллагааг үнэллээ. 2021 оны үйл ажиллагааны үнэлгээгээр тэргүүн байрыг Ц.Мөнхсайхан даргатай Дорнод аймаг дахь шүүхийн тамгын газар эзэллээ.

2022.01.26 ● Хамтын ажиллагааны Санамж бичиг байгууллаа.

Шүүхийн ерөнхий зөвлөл болон "Трансперенси Интернэшнл-Монгол" ТББ авлигын эсрэг үйл ажиллагааны хүрээнд 2022 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр Хамтын ажиллагааны Санамж бичиг байгууллаа. Тус санамж бичигт Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Д.Зүмбэрэлхам, "Трансперенси Интернэшнл-Монгол" ТББ-ын Удирдах зөвлөлийн дарга, тэргүүн Л.Төр-Од нар гарын үсэг зурав.

2022.01.27 ● Европын Холбооноос Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Аксель Никэйзийг хүлээн авч уулзлаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, хууль зүйн ухааны доктор Д.Зүмбэрэлхам Европын Холбооноос Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Аксель Никэйзийг 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр хүлээн авч уулзлаа. Элчин сайд Аксель Никэйз Монгол Улсын шүүхийн шинэтгэлийг дэмжин хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлэв. Европын холбоо Монгол Улсын Засгийн газартай 2021-2027 онд хэрэгжүүлэх шинэ түншлэлийн хөтөлбөрийг боловсруулж байгаа бөгөөд Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн асуудал тэргүүлэх чиглэлд багтсан тухай мэдээлэл өглөө.

2022.01.31 ● Шүүхийн захиргааны ажилтнуудад зориулсан сургалт боллоо.

Шүүхийн ерөнхий зөвлөл, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын /IDLO/ Канадын Засгийн газрын дэмжлэгтэй хэрэгжүүлж буй "Монгол Улсад жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх төсөл"-

02 сар

2022.02.07

тэй хамтран “Жендерт суурилсан хүчирхийлэл, түүний суурь шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг таниулах сургалтыг шүүхийн захиргааны ажилтнуудад зохион байгууллаа.

"Шүүхийн шагналын журам"-ыг шинэчлэн баталлаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны нэгдүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны 20 дугаар тогтоолоор "Шүүхийн шагналын журам"-ыг шинэчлэн баталлаа.

2022.02.16

"Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчлэл" сэдэвт хэлэлцүүлэг боллоо.

Шүүхийн шинэтгэлийн хүрээнд эвлэрүүлэн зуучлалын эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл, ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газартай хамтран “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчлэл” хэлэлцүүлгийг өнөөдөр зохион байгууллаа.

2022. 02.17

Эвлэрүүлэн зуучлагчдын сургалт эхэллээ.

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчдад зориулсан сургалт өнөөдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн байранд эхэллээ. Сургалтыг Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн дарга, Монгол Улсын гавьяат хуульч Д.Тунгалаг нээж, үг хэлэв. Тэрээр хэлсэн үгэндээ сургалтад оролцогчдын 60 гаруй хувь нь өмнө сургалтад хамрагдаж байгаагүй шинэ хүмүүс болохыг дуулгаад Японы эрдэмтэн судлаачдын хичээлийг сургагч багш нар баяжуулан зааж, онол, практик хосолсон цогц мэдлэг олгоход чиглэгдэж байгааг онцоллоо.

2022.02.18

Канад Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдтай уулзав.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, хууль зүйн ухааны доктор Д.Зүмбэрэлхам Канад Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Катрин Ивкофыг өнөөдөр хүлээн авч уулзан, харилцаа хамтын ажиллагааны талаар санал солилцов. Уулзалтын эхэнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, хууль зүйн ухааны доктор Д.Зүмбэрэлхам Монгол Улсад шүүхийн салбарт хийгдэж буй шинэчлэлийн явцын талаар товч мэдээлэл өгөөд түүнийг амжилттай хэрэгжүүлэхэд Канад Улстай зарим асуудлаар хамтран ажиллах хүсэлтээ илэрхийлэв.



- 2022.02.21** ● **Шүүхийн ахмадуудын холбооны Удирдах зөвлөлийн анхдугаар хурал болов.**
Шүүхийн ахмадуудын холбооны удирдах зөвлөлийн анхдугаар хурал болж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Шүүхийн ахмадын холбооны бүтэц, зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэж, Б.Сарантуяаг /Монгол Улсын гавьяат хуульч/ Ажлын албаны даргаар, Д.Дамдин-Одыг менежерээр тус тус томилов.
- 2022.02.25** ● **Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем ашиглах журам батлагдлаа.**
Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах, Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем ашиглах тухай журмуудыг 2022.02.24-ний өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн ээлжит хуралдаанаар хэлэлцэн баталлаа.
- 03 сар** ●
- 2022.03.03** ● **Шүүгчийг заналхийлсэн этгээдэд хариуцлага тооцов.**
Олон нийтийн сүлжээнд шүүгчийг заналхийлсэн агуулга бүхий мэдээллийг Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны иргэн Г нийтэлсэн болохыг цагдаагийн байгууллага тогтоон, тухайн мэдээллийг устгуулж, Зөрчлийн тухай хуулийн 5.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан байна.
- 2022.03.11** ● **Шүүгчийг сонгон шалгаруулах журам баталлаа.**
Шүүхийн ерөнхий зөвлөлийн ээлжит хуралдаан 2022 оны 03 дугаар сарын 10-11-ний өдөр болж, дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.
Шүүхийн тухай хуульд "Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам боловсруулж батлах, хэрэгжилтийг зохион байгуулах" чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл хэрэгжүүлэхээр заасны дагуу "Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам"-ын төслийг хэлэлцэн баталлаа.
- 2022.03.21** ● **Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарыг сургалтад хамруулав.**
Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарт зориулсан мэргэшүүлэх сургалт эхэллээ. Тус сургалтыг Шүүхийн

ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргааны хүний нөөцийн газраас 2022 оны 03 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд “Баяндөхөм” сургалтын цогцолборт зохион байгуулж байна.

- 2022.03.24** ● **“Шүүхэд албан хэрэг хөтлөх журам”-ыг баталлаа.**
Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Шүүхэд албан хэрэг хөтлөх журам”-тай танилцана уу.
- 2022.03.25** ● **Нэр бүхий 13 хүнийг шүүгчээр томилуулах саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэв.**
Шүүхийн ерөнхий зөвлөлийн ээлжит хуралдаан болж нэр бүхий 13 хүнийг шүүгчээр томилуулах саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид мэдүүлэхээр шийдвэрлэлээ.
- 2022.03.29** ● **Шүүгч Н.Баярмаа Нагояагийн Их Сургуулийн Хууль зүйн сургуульд докторын зэрэг хамгааллаа.**
Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.Баярмаа энэ сарын 25-ны өдөр Япон улсын Нагояагийн их сургуулийн докторын зэргийг “Development of Real Property Law in Mongolia: Toward a Uniform Foundation” буюу “Монгол Улсын үл хөдлөх хөрөнгийн эрх зүй: Нэгдмэл суурийг бүтээх нь” сэдвээр хамгааллаа.
- 2022.03.30** ● **Сургагч багш нарыг бэлтгэх мэргэшүүлэх сургалт явууллаа.**
Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийн захиргааны зарим ажилтнуудыг сургагч багш болгон мэргэшүүлэх хоёр өдрийн нэгдсэн сургалтад хамруулж, гэрчилгээ олголоо.
- 04 сар** ●
- 2022.04.11** ● **“Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-ыг нэгдсэн бүртгэлд бүртгүүллээ.**
Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-ыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5767 дугаарт бүртгүүллээ.



- 2022.04.21** ● **Шүүх байгуулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулав.**
Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2020.01.31-ний өдрийн 17 дугаар тушаалаар байгуулагдсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтоох асуудлыг боловсруулахад харгалзан үзэх 34 шалгуур үзүүлэлт”-ийн дагуу судалгаа хийх, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг хууль зүйн санал, дүгнэлтээ танилцууллаа.
- 2022.04.29** ● **“Гэмт хэргээс өөрийгөө хамгаалах нь” сэдвээр сурагчдад сургалт хийлээ.**
Шүүхийн ерөнхий зөвлөл Монголын хуульчдын холбоотой хамтран “Хүүхдийг гэмт хэргээс сэргийлэх нь Та бидний үүрэг” сэдвийн хүрээнд про боно өдөрлөгийг зохион байгууллаа.
- 05 сар** ●
- 2022.05.11** ● **Шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын цалинг шинэчлэн тогтоолоо.**
Шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалинг хоёр дахин нэмэгдүүлэх тухай УИХ-ын 2021 оны 03 дугаар тогтоолын 1.2 дахь хэсгийг хэрэгжүүлэх асуудаар Засгийн газар хуралдаж, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалингийн хэмжээг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэн тогтоохоор шийдвэрлэжээ.
- 2022.05.18** ● **Иргэн төвтэй шүүхийн үйлчилгээг бий болгож, хүртээмжийг нэмэгдүүллээ.**
“Иргэн төвтэй шүүхийн үйлчилгээ”-г бий болгох ажлын хүрээнд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрууд хамтран Захиргааны хэргийн шүүхийн нэгдсэн байрны гадна орц, гарцыг тэргэнцэртэй иргэдэд зориулан холбогдох дүрэм, журам, стандартад нийцүүлэн бүрэн засварлаж ашиглалтад оруулав.

06 сар

2022.06.17

Төрийн албаны зөвлөл, Шүүхийн ерөнхий зөвлөл хамтарсан уулзалт хийлээ.

"Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх салбар зөвлөл болон Төрийн албаны зөвлөлийн хамтын ажиллагаа" сэдэвт уулзалт боллоо. Уулзалтад Шүүхийн ерөнхий зөвлөл, Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүд, Ажлын албаны нэгжийн удирдлагууд оролцож, хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн юм.

2022.06.20

Шүүхийн захиргааны ажилтны холбооны IV их хурал боллоо.

Шүүхийн захиргааны ажилтны холбооны ээлжит IV их хурал 2022 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн байранд боллоо. Тус хуралд нийт шүүхийн захиргааны 87 төлөөлөгч оролцов. Хурлаар Шүүхийн захиргааны ажилтны холбооны тэргүүнээр Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын дарга Н.Батхүүг сонголоо.

2022.06.22

"Монгол Улс шүүхийн индекс 2021" судалгааны тайланг танилцуулав.

"Нээлттэй нийгэм" форум, "Оюуны инновац" ТББ хамтран хийсэн "Монгол Улс шүүхийн индекс 2021" судалгааны тайланг Шүүхийн ерөнхий зөвлөлд танилцуулж, санал солилцлоо.

Шүүхийн индекс судалгаанд шүүхийн үйл ажиллагааг шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал, шүүхийн нээлттэй, ил тод байдал, шүүхэд итгэх олон нийтийн итгэл, шүүхийн нөөц, шүүгчийн ёс зүй ба хариуцлага, шүүхийн үр нөлөөтэй үйл ажиллагаа гэсэн үндсэн 6 хэмжигдэхүүн 42 дэд хэмжигдэхүүнд хуваагдсан 132 шалгуур үзүүлэлт тус бүрээр хэмжсэн байна.

2022.06.22

ХБНГУ-ын Хууль зүйн сайд асан Херта Дойблер-Гмэлинийг хүлээн авч уулзлаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Д.Зүмбэрэлхам, гишүүн Н.Баасанжав, А.Насандэлгэр нар ХБНГУ-ын Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны яамны "Governance funds"



төслийн хүрээнд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Хууль зүйн сайд асан, профессор Доктор Херта Дойблер-Гмелин, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төлөөлөл Ц.Мөнх-Од нарыг хүлээн авч уулзлаа. Тус уулзалтаар ХБНГУ-ын Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны яамны “Governance fonds” төслийн хүрээнд “Монгол Улсын шүүхийн болон шүүгчийн бие даасан, хараат бус байдлыг сайжруулах, авлигатай тэмцэх” асуудлын талаар санал солилцов.

2022.06.23

Ханнс Зайделийн сангийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын тэргүүнтэй уулзлаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Д.Зүмбэрэлхам, гишүүн Э.Зоригтбаатар, нар ХБНГУ-ын Ханнс Зайделийн сангийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын төлөөллийг хүлээн авч уулзлаа. Ханнс Зайделийн сангийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын тэргүүн Феликс Гленк Германы туршлага хаана хэрэгтэй байгаа газар бид бүхэн ажиллахад бэлэн. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах нь нэн чухал байгаа юм байна. Энэ тал дээр хамтарч ажиллахад бэлэн байгаагаа илэрхийллээ.

2022.06.30

“ЖАЙКА”-гийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын тэргүүн Танака Шиничиг хүлээн авч уулзлаа.

Шүүхийн ерөнхий зөвлөл Японы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэг(ЖАЙКА)-ийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын тэргүүн Танака Шиничиг 2022 оны зургаадугаар сарын 29-ний өдөр хүлээн авч уулзлаа. Энэ үеэр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийн бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх чиг үүргийн хүрээнд “ЖАЙКА”-тай хамтран ажиллах саналтай байгаагаа илэрхийлэв. Түүнчлэн “Эвлэрүүлэн зуучлалын” тогтолцоог бэхжүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байгааг дурдлаа.



МОНГОЛЫН ШҮҮГЧДИЙН ХОЛБООНЫ 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

2022.01 сар

Шүүгчдийн холбооны Удирдах Зөвлөлийн 2022.01.27-ны өдрийн хурлаар энэ онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө батлагдав.

Шүүгчдийн холбоо “Ярьж буй хууль” нэвтрүүлгийн нэрээр 2022.02.09-ний өдөр оюуны өмчийн эрх авлаа.

Шүүгчдийн холбооны УЗ-ийн гишүүд, салбар хороодын тэргүүн нартай 2022.02.24-ний өдөр цахимаар уулзалтыг зохион байгуулж, холбооны цаашдын үйл ажиллагааны талаар санал солилцов.

2022.02 сар

Шүүгчдийн холбоо, АНУ-ын элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр тус улсын төрийн департаментаас зарладаг “US-Speaker-22” хөтөлбөрт хамрагдах болов.

“US-Speaker-22” хөтөлбөрийг шүүгчдийн холбооны гадаад харилцааны дэд хорооноос англи, монгол хэлээр бэлтгэж, ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга Kelly H. Busby-д хүлээлгэн өгөв.

Шүүгчдийн холбооны тэргүүн Ж.Оюунтунгалаг, гүйцэтгэх захирал М.Наранчимэг нар ШЕЗ-ийн дарга Д.Зүмбэрэлхамтай 2022 оны хоёрдугаар сарын 08-ны өдөр албан ёсны уулзалт хийв.

Шүүгчдийн холбооноос эрхлэн бэлтгэж буй “Ярьж буй хууль” ээлжит нэвтрүүлэгт “Ахмад шүүгч” Д.Наранцэцэг оролцож, “Гэрлэлт цуцлалтын маргаан дахь хүүхдийн эрх” сэдвээр Мисс, топ модель Х.Бадамгэрэлтэй ярилцлаа.

Шүүгчдийн холбооны үйл ажиллагааг идэвхжүүлэх, иргэд олон нийтэд шүүхийн үйл ажиллагааг таниулах зорилгоор мэдээ мэдээлэл, ярилцлагыг бэлтгэж, холбооныхоо сайт,



цахим хуудсаар дамжуулан хүргэхийн зэрэгцээ ТВ-9, Өлзий, Соён гэгээрүүлэх, ТВ-24 телевизээр “Ярьж буй хууль” нэвтрүүлгийг үзэгчдэд хүргэж байна.

Шүүгчдийн холбоо, Шихихутуг Их Сургуультай 2022.02.15-ны өдөр санамж бичиг байгуулж, “Ментор шип” хөтөлбөрийг хэрэгжүүлэх болов.

Шүүгчдийн холбооноос эрхлэн бэлтгэж буй “Ярьж буй хууль” нэвтрүүлэгт БГД-ийн ЭХАШШ-ийн шүүгч Ц.Эрдэнэчимэг оролцож, “Алдаатай гүйлгээ, андуурсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших” сэдвээр дуучин Quiza буюу Б.Батцэнгэлтэй ярилцав.

2022.03 сар

Шүүгчдийн холбооны Сэлэнгэ аймаг дахь салбараас санаачилсан сургалтыг ЭИХДЗШШ-ийн шүүгч Г.Давааренчин удирдан “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог, анхаарах асуудал”, “Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал” сэдвээр явуулжээ.

Шүүгчдийн холбоо 2022.03.10, 11-ний өдрүүдэд ХСҮТ, ТТАХНЭ-т урьдчилан сэргийлэх үзлэгт зуу гаруй шүүгчээ хамруулав.

Шүүгчдийн холбооноос эрхлэн бэлтгэж буй “Ярьж буй хууль” ээлжит нэвтрүүлэгт СБД-ийн ИХАШШ-ийн шүүгч Н.Оюунтуяа оролцож, “Газрын маргаан” сэдвээр МУГЖ, Маск продакшны жүжигчин Ж.Мөнхсайхантай ярилцлаа.

Шүүгчдийн холбооны Хархорин дахь салбар хороо 2022.03.31-ний өдөр “Хүний хөгжил, сэтгэл зүйн дархлаа” сэдвээр сургалт зохион байгуулж, шүүгчдээ хамруулсан байна.

2022.04 сар

Шүүгчдийн холбооноос эрхлэн бэлтгэж буй “Ярьж буй хууль” ээлжит нэвтрүүлэгт СХД-ийн ЭХАШШ-ийн шүүгч Г.Ганбаатар оролцож, “Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх” сэдвээр Монгол дахь Итали хоолны тогоочдын Холбооны Ерөнхийлөгч Г.Тэнгистэй ярилцав.

2022.04.10-ны өдрөөс эхлэн 20 орчим шүүгч цахим болон танхимаар гурван сарын хугацаатай англи хэлний сургалтад хамрагдаж эхэллээ.

Шүүгчдийн холбооноос эрхлэн бэлтгэж буй “Ярьж буй хууль” ээлжит нэвтрүүлэгт БЗД-ийн ИХАШШ-ийн Ерөнхий шүүгч Ц.Цэрэндулам оролцож, “Гэр бүлийн дундын эд хөрөнгийн маргаан” сэдвээр СЭЗИС-ийн (Ph.D), дэд профессор Г.Батхуягтай ярилцлаа.

Холбооны гишүүдийн олон нийттэй харилцах харилцаа, ярих ур чадварыг дээшлүүлэх зорилготой “Ярих ур чадвар, эфирт биеэ хэрхэн авч явах вэ?” сургалтыг 2022.04.19-ний өдөр ШЕЗ-ийн 102 тоотод зохион байгуулав.

2022.05 сар

Шүүгчдийн холбооноос эрхлэн бэлтгэж буй “Ярьж буй хууль” ээлжит нэвтрүүлэгт Увс аймаг дахь сум дундын ЭХАШШ-ийн Ерөнхий шүүгч Б.Гансүх оролцож, “Ан агнуурын гэмт хэрэг” сэдвээр МҮОНРТ-ийн сэтгүүлч Д.Бямбацэцэгтэй ярилцлаа.

Шүүгчдийн холбооны Архангай аймаг дахь салбар хороо болон ИХАШШ хамтран “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн онцлог, шинэлэг зохицуулалт” (шинэчилсэн найруулга) сэдвээр шүүгчдэд, Тамгын газрын ажилтнууддаа мэдээлэл хийжээ.

Шүүгчдийн холбооны Баянхонгор аймаг дахь салбар хороо нь тус шүүхийн тамгын газартай хамтран 80 жилийн ойн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдсан асуудлыг судлах, шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилготой илтгэлийн уралдааныг зохион байгууллаа.

Нийслэлийн ЭИХДЗШШ-ийн үйл ажиллагаатай танилцуулах өдөрлөгийг шүүгчдийн холбоо, Нийслэлийн шүүхийн Тамгын газартай хамтран 2022.05.07-ны өдөр зургаадугаар сургуулийн 10, 11 дүгээр ангийн сурагчдыг оролцуулан нийслэлийн Иргэн, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн байранд зохион байгуулав.



Шүүгчдийн холбооноос эрхлэн иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой бэлтгэж буй “Ярьж буй хууль” ярилцлагын нийт 19 дугаарыг телевизүүдийн эфирээр цацахын зэрэгцээ ШЕЗ, шүүгчдийн холбооны сайтад байршуулаад байна.

Сэлэнгэ аймаг дахь салбар хороо “Ярьж буй хууль” нэвтрүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлж, аймгийн шүүхийн Тамгын газартайгаа хамтран нэвтрүүлгийг орон нутгийн телевизээр цацаж эхэллээ.

Сэлэнгэ аймаг дахь салбар хорооны шүүгч Б.Эрдэнэхишиг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, түүний онцлог, анхаарах асуудал” сэдвээр сургалт удирдан явуулжээ.

2022.06 сар ●

“Шударга ёсны хэмжүүр” сэтгүүлийн 26 дахь дугаарыг эрхлэн гаргаж, шүүгчдийн холбооны сайтад цахимаар байршуулав.

Шүүгчдийн холбооны Архангай аймаг дахь салбар хороо, Шүүхийн Тамгын газартайгаа хамтран шүүгч, шүүхийн ажилтнуудын хүүхэд багачуудын дунд “Миний хайртай хүмүүс”-2022 гар зургийн уралдаан зарлаж, ирүүлсэн бүтээлээр зургийн цомог гаргалаа.

Шүүгчдийн холбоо нь 2022.06.23-ны өдөр АТГ-ын олон нийтийн төвийн Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй уулзалт зохион байгуулж, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд хамтран ажиллах болов.